



SHIHIHUTUG UNIVERSITY

SHIHIHUTUG

JOURNAL OF LAW AND MANAGEMENT

Ulaanbaatar
2023

ИЛТГЭЛ НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

ТУСГААР ТОГТНОЛ – УЛС ҮНДЭСТНИЙ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ОХЬ ДЭЭЖИС МӨН



Шихихутуг их сургуулийн
Судалгааны хүрээлэнгийн
захирал, Шинжлэх ухааны гавьяат
зүтгэлтэн. Доктор(Ph.D), профессор
Н.Жалбажав

Түлхүүр үгс: Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, халдашгүй дархан байдал, аюулгүй байдал, бие даасан байдал, түүний баталгаа, улс төр, эдийн засгийн бие даасан байдал, оюуны дархлаа.

Товч агуулга: Үндэсний бахархалт уламжлал, улс үндэстний үнэт зүйлс. Тусгаар тогтнолын агуулга, мөн чанар, тусгаар тогтнол улс үндэстний үнэт зүйлсийн охь дээжис болох нь. Тусгаар тогтнолын түүхэн уламжлал, сургамжын зүйлс, тусгаар тогтнолын баталгаа. Төрийн бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн үнэт зүйлс, дүгнэлт хэсэг.

Үндсэн агуулга: Эдүгээ дэлхийн нийт иргэний тоо 8 тэрбумыг давж дэлхий дээр 5000 шахам үндэс угсаатан, ястан, 190 гаруй улс, үндэстэн НҮБ-ын гишүүн буюу тусгаар улсын статустайгаар оршин тогтнож байна. Палестины улс,

загалмайтны шашны төв Ватикан хоёр НҮБ-ын ажиглагчийн статустай. Тусгаар нэг улс оронд хэдэн арваараа тоологдох үндэстэн ястнаас бүрддэг Орос, Хятад гээд улс гүрэн ч олон бий. Үнэхээр тэр олон үндэстэн ястны хэл соёл, зан заншил, ашиг сонирхол өөр өөр, оршин тогтнох орон зай, амьжиргааных нь эх ундарга, хоол хүнс, эрдэс баялаг, ус агаар нь хүртэл хязгаартайн тул зөрчилдөвч эх дэлхийдээ энх амгалан оршин тогтнохын тулд өөр хоорондоо аяыг олж эвийг сахиж зохицолдохын арга ухаан онцгой чухал бөлгөө. Оршихуйн зохицлын энэхүү арга ухаан, алаг цэцэгсийн мандлыг сэргээн тэтгэх хурын шим лугаа амин чухал ажгуу. Хэнд, аль улс үндэстэнд нь энэхүү арга ухаан түлхүү заяагдаж байна тэр үндэстэн ястны төр улсын гал голомтоос хүч чадал, мандал бадралын оч гэгээ сацарч тусгаар орон гэрийнх хана туурга нь зөрчил тэмцлийн шуурганд ч үл автах бөлгөө. Ертөнцийн эрдэмтэн мэргэд үндэстэн ястны төрөлх орон гэрээ авч явах энэхүү арга ухааныг тусгаар тогтнолын арга ухаан хэмээн тайлжээ. **“Бор гэртээ богд, хар гэртээ хаан” хэмээх монгол арга ухаан бий.** Тусгаар тогтнол нь ямар нэг харийн улс орны эрхшээл, шахалтад орохгүйгээр зөвхөн үндэсний язгуурын эрх ашиг, ард түмний хүсэл зорилгод нийцүүлэн төрийн гадаад дотоод

бодлогыг хэрэгжүүлэх боломж, энэ тухайд улс төр, эрх зүйн үндэсний болон олон улсын баталгаа бүрэлдсэн байхыг хэлдэг байна. Улсын тусгаар тогтнолын үндэс суурь нь төр, улсынхаа бүх хэрэг явдлыг өөрөө мэдэж шийдвэрлэх чадвар буюу бүрэн эрхт байдал (оросоор суверенитет, англиар sovereignty гэдэг ажгуу) болдог байна. Эрдэмтэн мэргэд энэхүү уялдаа холбоог "Улсын тусгаар тогтнол гэдэг нь ... бүрэн эрхт байдлаа хамгаалах баталгааг хангаж, хүчин чадлыг ямагт нэмэгдүүлж ард түмэн эв нэгдлээ бэхжүүлэх ойлголт мөн" гэж тодорхойлсон нь бий.

Улс орны бүрэн эрхт байдал дараах байдлаар томъёологддог байна.



Улс үндэстний тусгаар тогтнол, энх амгалан оршихуйн дархлаа ч гэж буй бөгөөд түүний цөм нь тухайн улс үндэстний соёл иргэншлийн өвөрмөц байдал, түүнийгээ хадгалан хамгаалах чадвар боломж, үндэсний ухамсар сэтгэлгээ, үндэсний бахархал, үнэт зүйлс нь болдог байна.

Төв Азийн нүүдэлчин удмын монголчууд бид цөөхүүлээ боловч ертөнцөд гайхуулах, бахархах олон сайн, сайхан үнэт зүйлстэй ард түмэн билээ. Орон гэр маань болсон эх орон маань уул, тал хосолсон, мал сүргээр дүүрэн, "хөрсөн доороо эрднэсээр бүрэн, хүний хэрэгцээ цөм бүрдсэн" уудам дэлгэр орон. Энэ бол эрэлхэг өвөг дээдсийн маань эх орныхоо төлөө урсгасан хөлс, цус нэвчсэн, үе үеийн эх оронч баатар охид хөвгүүдийн маань булш бунхан, хөшөө дурсгалаар дүүрэн онгон дагшин өлгий. Энэ бол суут богдын хүй нь цэглэж, эрийн цээнд хүрсэн алтан өлгий нь. Бид суут богдын гал голомтыг сахигчид тиймээс бид сайхан эх орныхоо

жинхэнэ эзэд нь байж туйлиас хариуцлагатай, бусад улс үндэстний манлайд нь нэр төртэй сайн сайхан аж төрөх учиртай. Монгол төрийн мэргэн сайд, бичиг номын их хүн, түүхч А. Амар: "Чингис хаан болбоос дэлхий дахин доор ямар ч улс байгуулаагүй их улсыг байгуулсан ба урьд өмнө ямар ч цаг үед гараагүй эрэлхэг хүчирхэг баатар байсан болно. Чингис хаан болбоос, Ази, Европ хоёр тивд орших олонхи ард түмний ахуй байдлыг туйлаас хувируулсан тул монгол үндэстний дотор алдартай хэмээхээр үл барам бүх дэлхий дээр ба хүн төрөлхтний дунд их алдар, их түүхт явдлыг үйлдсэн хүн тул түүний явдал түүхийг дэлхий дахины эрдэмтэн их л сонирхдог амуу" гэжээ. /А.Амар. Монголын товч түүх. УБ., 1989, т.178.

Нүүдлийн соёл иргэншлийн гол тээгчдийн нэгэн нь болсон монголчууд хүн төрөлхтний түүх, дэвшил хөгжилд үлэмж хувь нэмэртэй ард түмэн. Тухайлбал: Монголчууд буулгаж барихад тун амархан гэр хэмээх өвөрмөц дугуй оронсууц болон хасаг тэрэг бүтээсэн. Мөн тэрчлэн мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах, үндэсний хувцас оёж шидэх технологийг бий болгосон Монголчууд тэмээ, адууг тээврийн хэрэгсэл болгон ашиглаж байсан Евразийн нүүдэлчдийн нэг түүхэн гавьяа бол Ази, Европыг холбосон алдарт "Торгоны зам"-ыг тэд гаргасан бөгөөд тэр нь Өрнө, Дорнын соёлын солилцоо болон түүний харилцан холбоотой

хөгжилд өргөн боломжийг нээсэн явдал юм. Аж амьдралын нүүдлийн хэв маяг гарч ирсэн явдал анхны хөдөлмөрийн том хуваарь үүсэх нөхцлийг бүрдүүлж, цэргийн зэвсэг бүтээх болон түүнийг боловсронгуй болгох үйлст хувь нэмэр оруулсан билээ. Тэд хэлний шинэ шинэ бүлийг үүсгэхэд маш чухал үүрэг гүйцэтгэсэн.

Бидний өвөг дээдэс орчин цагийн шуудан холбоо, бараа бүтээгдэхүүний солилцооны арга технологи, цаасан мөнгөн тэмдэгт бүтээн оюуны болон биет соёлыг цогцлоон хот (Хархорин) сүндэрлүүлсэн төдийгүй эрхшээсэн олон улс үндэстний соёл иргэншлийг бүтээсэн гавьяатай.

Бидний ухаант өвөг дээдэс маань өрлөг түүхээ "Монголын нууц товчоо" хэмээх их хөлгөн судартаа мөнхөлсөн ард түмэн. Л.Н Гумилев, В.В Бартольд, Б.Я Владимирцов, Чингис хааны одонт Жак Уэторфорд абугай, Окадо Хидохиро нарын дэлхийд данстай монголч эрдэмтэн мэргэд монголчууд шиг түүхээ ингэж мөнхөлсөн ард түмэн, "МНТ" шиг түүхийн шаштир хорвоод ховор гэдгийг онцолсон нь цөөнгүй. Тухайлбал оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов: "Монголын нийгмийг байгуулсан нь" бүтээлийнхээ 6 дугаар нүүрт "Дундад зууны үед нэгч үндэстэн монголын адилаар түүхч нарын анхаарлыг татсангүй гэж хэлж болох бол бас Нууц товчооны адилаар амьдралыг тодорхой дүрслэн үзүүлсэн дурсамж

бичиг нэг ч үндэстэн үлдээсэнгүй гэдгийг тэмдэглэвэл зохино” гэжээ.

Өвөг дээдэс маань хүн төрөлхтний түүхэнд анхлан Их засаг хууль хэмээх төрийн гол хууль цаазын бичгээ бүтээсэн ард түмэн.” Их засаг хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхнээ бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн тогтооход томоохон үүрэг гүйцэтгэсэн эртний Вавилоны Хаммурабын хууль, Энэтхэгийн Манугийн хууль зэрэг алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой цааз эрхэмжийн нэн чухал баримт бичиг мөн. Учир нь энэ хуулийн зарчим, үзэл санаа зөвхөн монгол нутаг төдийгүй ертөнцийн талыг эзэгнэсэн их гүрний хэмжээнд үйлчилж байсны хувьд дэлхийн хууль цаазын түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээсэн бүлгээ” / Ж.Болдбаатар/.

Бид босоо түргэн бичиг, хоёрхон чавхдастай боловч хорвоогийн хөгжмийн бүх төрлийн аядасыг эгшиглүүлж чадах морин хуур, уудам тал нутаг шигээ уртын сайхан дуу, мөнгөн хазаарын чимээ шиг уянга, утга төгс яруу тунгалаг найраг гээд дэлхийн соёл иргэншлийн охь дээдэшт тооцогдох эрхэм нандин зүйлсийн эзэд нь болсон ард түмэн.

Монгол Улсын тусгаар тогтнол бол монголын ард түмний 2200 гаруй жилийн турш оршин тогтнохуйн эрхийнхээ төлөө хийсэн хатуу ширүүн тэмцлийн гол үр дүн, үе үеийн эх орончдын амь бие үл хайрлан урсгасан цусных нь үнэ цэнэ, Монгол Улс,

монгол төрийн ашид мөнхийн юутай ч зүйрлэшгүй үнэт зүйл болгоо.

Эдүгээгээс 800 гаруй жилийн тэртээ XIII зууны эхэн, билгийн тооллын гурав дахь жарны улаан барс жилд буюу 1206 онд Тэмүжин-Чингис Богд Онон мөрний хөвөөнөө Есөн хөлт цагаан тугаа залж, Их хуралдайг хуралдуулж, Алтайн мөнх цаст оргилоос Алтан Хянганы ногоон нарст даваа, Байгал эх далайгаас түмэн газрын Цагаан хэрэм хүртэлх Төв Азийн өргөн уудам нутагт тархай бутархай 30 гаруй овог, аймгийн хоёр зуугаад түмэн иргэдийг эрхшээж Их Монгол улсыг байгуулсныг зарлан тунхагласан нь Монголын буурал түүхийн хамгаас бахархалтай онцгой гайхамшигт содон үйл явдал болжээ. Тэнгэрээс тэтгэгдсэн суут Богд “хагацсан улсыг хамтатгаж бутарсан улсыг бүрдүүлж...”, “эсгий туургат улсаа шулуутгаж...”, энх амрыг тогтоон Монгол угсаатны туурга тусгаар төр улсыг байгуулсан нь монголчуудын тусгаар тогтнолын түүхэнд онцгой ач холбогдолтой үйл хэрэг байв.

Эзэн Чингисийн байгуулсан эзэнт гүрэн түүхийн өгсөж, уруудах их нугачаанд дотоодын зөрчил тэмцлийн уршиг гайгаар бутарч сарнисаар улмаар XVII зуунд Манжийн эрхшээлд орж 220 гаруй жил тусгаар тогтнолоо алдсан билээ. Гэвч монгол түмний эх оронч сэтгэлгээ, санаа зориг нь мохоогүй юм, Өнгөрсөн зууны эхнээс монголын ихэс дээдэс, лам хувраг,

цэрэг эрс, иргэд тусгаар тогтнолоо сэргээн мандуулах хэрэгт нэгэн санаа зоригоор босон тэмцэж 1911 оны XII сарын 29-ны билэгт сайн өдөр тусгаар улсаа тунхаглан зарлаж VIII Богдыг хаан суудалд нь залав. Харин Орос, Хятад хоёр их гүрний шахалтын дор 1915 оны Гурван улсын гэрээ гэгчээр “автономит улс” болов. 1921 онд Дамдины Сүхбаатар нар журмын нөхдийн хамт “Монгол Ардын Нам” хэмээх улс төрийн анхны хүчнийг байгуулж, эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө монгол түмнийхээ тэмцлийг манлайлав. Ардын хувьсгалын ялалт улс орны тусгаар тогтнолыг сэргээн мандуулах үйлсийн үндсийг тавьж улмаар тухайн үеийн ардчилсан үзэлт, номч мэргэн төрийн олон түшээ нарын хүчин чармайлтаар 1924 онд Анхдугаар үндсэн хуулиа баталж Бүгд Найрамдах Улсаа байгуулав. Чингэснээр Монголд хаант төр, хамжлагат ёсыг үүрд халав. Гэвч Монгол Улсын тусгаар тогтнол олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй, хоёр туйлт ертөнцийн тэмцлийн эргүүлэгт ёстой л хутганы ирэн дор байв. Ахмад үеийнхний холч мэргэн ухаан, зүйрлэшгүй их тэвчээр, хүчин чармайлт монголын ард түмний 1939 Халхын голын дайн болон 1945 оны милитаризм, фашизмыг эсэргүүцсэн бүх нийтийн тэмцэл, ялалтад оруулсан хувь нэмрийн ач буянаар Монгол улсын тусгаар тогтнолын Де Факто буюу олон улсад хүлээн зөвшөөрөх үндэс тавигдсан юм.

Учир нь 1939, 1945 оны түүхэн үйл явдал нь Манжийн ноёрхолд 200 гаруй жил нухлагдан дэлхийн хөгжлөөс ихэд хоцрогдон мартагдсан Монгол дахин өсч өндийн тусгаар тогтнолоо сэргээн өөрийгөө хамгаалах чадвартай улс орон болсныг дэлхий дахинд нотлон харуулсан юм.

Монгол Улсын тусгаар тогтнолыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд тухайн үед ЗХУ, АНУ зэрэг их гүрнүүдийн удирдлага, дэвшилт бусад улс орнуудын дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1946 онд өмнөд хөрш маань их дайнд ялсан их гүрнүүдийн шахалт, монголын бүх ард түмний санал асуулгын дүнг эрхбиш ойшоож, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд хүрсэн юм. Гэхдээ Монгол Улсын тусгаар тогтнолыг олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дахиад 20 шахам жилийн нөр их хүчин чармайлт гаргах хэрэгтэй байжээ. 1961 онд БНМАУ олон улсын хамтын нийгэмлэг – НҮБ-ын бүрэн эрхт гишүүн нь болж монголын ард түмний нөр их хичээл зүтгэл, хүчин чармайлт, хүсэл эрмэлзэл биелж монголын тусгаар тогтнолын Де юри буюу олон улсын хууль эрх зүйн баталгаа нь бий болсон билээ.

Энэ цаг үед суут богдын их гүрний гал голомт нь болсон Төр улсын маань тусгаар тогтнолын гол баталгаа нь монголын ард түмэн өөрөө мөн учир нь: улс орны тусгаар тогтнолын гол эх сурвалж нь ард

түмний эрх, эрх чөлөөг эрхэмлэгч хүсэл эрмэлзэл, харин тусгаар тогтнолыг гүйцэлдүүлэгч гол нөхцөл нь ард түмний төр улсынхаа хэргийг мэдэж шийдвэрлэх, төр цэргээ засах, хууль цаазаа хөтлөх арга ухаан, чадал чансаа нь болдог.

Улс орны тусгаар тогтнолын гол гол баталгаанууд:

- **Ардчилсан төрийн тогтолцоо.** Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн хуульт ёс, ард нийтээрээ сонгон байгуулдаг бүгд найрамдах засаглал, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хүний эрх, эрх чөлөөний баталгаажилт, иргэний нийгмийн төлөвшил нь тусгаар тогтнолын гол баталгаа нь мөн. Б.Чимид: Монгол Улсын Үндсэн хууль бол "Монгол эх орны төлөө, Монгол Улсын иргэн бидний төлөө, засаг төрийн дур зоргыг хязгаарласан шударга ёсны төлөө, Монголын ард түмний нийтлэг хүсэл, зоригийг илэрхийлсэн Улсын гол хууль" гэсэн бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 16 дугаар зүйлд "Эрхийн баталгааг хангаагүй бөгөөд эрх мэдлийг ялгаж салгаагүй аливаа нийгэмд Үндсэн хууль байхгүй" гэжээ.

Төрөл төрлийн (удам угсааны, дур зоргын, нэрхүндийн (харизматик) цэрэг-цагдаагийн) тоталитар дэглэм, дарангуйллын засаглал хэчнээн хэврэг, төр улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхэд ямар уршигтайг дэлхийн янз бүрийн бүс нутаг дорно

дахин арабын ертөнцөд өрнөсөн хэрэг явдал бэлхнээ нотолсоор байна. Монгол гэрээр зүйрлэвэл унь тооно, хана, хаалга багана, бүслүүр хошлон цөм эв номондоо байж улс гэр оршино. "Ухааны чагтага" их байвал гэрээ салхинд хийсгэчихгүй, үерт урсгачихгүй, дотроос нь нураачихгүй авч явдаг.

Тусгаар тогтнолын бусад баталгаа нь:

- Монгол улсын иргэний эрх, эрх чөлөөний нэг гол баталгаа бол хувийн өмч, түүнд суурилсан эдийн засгийн чадавх, бие даасан байдал юм. Энэ цаг үед улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бэхжүүлэх гол талбар бол эдийн засаг болж байна. Иргэдийнхээ өмчлөх эрх, өмчийн халдашгүй дархан байдлыг хангах, чөлөөт шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулалтыг дэмжих, үйлдвэрлэл үйлчилгээнд шинжлэх ухааны ололтыг шингээж хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгаа экспортын чиглэлээр хөгжүүлж өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх замаар бие даасан байдал, тусгаар тогтнолыг нь хангах нь улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бэхжүүлэх гол арга зам болж байна.
- Үндэсний эв нэгдэл, эх оронч үндэсний үзэл, хүмүүжил, ой санамж нь тусгаар тогтнолын оюуны үндэс суурь нь болой; Монгол үндэстний эв нэгдэл

нь байгал, нийгмийн хатуу ширүүн сорилыг давсан монгол хүний андын нөхөрлөлд суурилдаг. Эцэг дээдсээс маань уламжлагдан монгол хүний яс маханд шингэсэн энэхүү нөхөрлөлийг уснаас тунгалаг, гангаас бэх, эхийн сүү шиг ариун гэдэг. Монголын ард түмэн бид өөр хоорондоо төдийгүй өрөөл бусад улс үндэстэнтэй тогтоосон харилцаа холбоондоо ч үнэнч шударгын жишээ болж байдаг.

- Үндсэн хуульд суурилсан эрх зүйн тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөний эрх зүйн баталгаажилт;
- Үндэсний соёл, иргэншлийн өвөрмөц өнгө төрх, үнэт зүйлсээ хамгаалан хөгжүүлэх баталгаа;
- Боловсрол, шинжлэх ухааны хөгжил, хүн ардын эрүүл мэнд;
- Улс орныхоо хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах хүчин чадал;
- Монгол улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын нэр хүнд, байр суурь болдог байна. Учир нь тусгаар тогтнол бол зожигрол огт биш.

Дээрх баталгаанаас **тусгаар тогтнолын үндэсний болон олон улсын эрх зүйн баталгааг** онцолж байна. Учир нь олон улсын хамтын нийгэмлэг, олон улсын хүний эрхийн болон бусад түгээмэл актууд, олон улсын тавцанд улс орны эзлэх байр суурь, нэр хүнд нь төр улсын тусгаар тогтнолын гадаад орчин, гадаад хүчин зүйл нь болдог бол

төрийн байгууламж, түүний улс төр, эдийн засгийн, нийгмийн үндсийг болон иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан Үндсэн хууль, түүнд суурилсан, түүнээс салбарласан эрх зүйн тогтолцоо нь төр улсын бүрэн эрхт байдал тусгаар тогтнолын эрх зүйн дотоод хүчин зүйл, дархлаа нь болдог бөлгөө.

Төр улс нь нийт иргэний сонголтоор байгуулдаг БН засаглалтай, Үндсэн хууль хэмээх гол хуультай байх түүгээр төрийн тогтолцоогоо баталгаажуулдаг, нийгмийн суурь харилцааг зохицуулдаг, бусад бүх хууль нь гол хуулиасаа салбарласан, түүнийхээ үзэл баримтлалд нийцсэн байхыг олон улсын эрх зүйд Үндсэн хуульт ёс хэмээдэг.

Төр улсынхаа хэргийг хуулиар засан тохинуулдаг нь Монголын төр ёс, хууль цаазын олон зууны түүхэн уламжлал юм. Суут Богд Чингис хаан Хархорумыг Улсын нийслэл, худам монгол бичгийг төрийн бичиг болгож, "Их Засаг" хэмээх төрийн гол хуулийг дагаж мөрдөхийг зарлигдаж, Их хуралдай, Сэцдийн зөвлөлөөр их хэргийг хэлэлцүүлж төрийн нуруу түвшин чин шударга байхын үндсийг тавьсан билээ. Их Засаг хууль нь Их Монгол Улсын хууль цааз эрх зүйн гол эх сурвалж болох нь маргаангүй, учир нь уг хуулиар төрийн хэлбэр, дэглэм, хааны эрх мэдэл, төрийн байгууллагын зохион байгуулалт, эрх үүрэг, ажиллах журам, засаг захиргааны хуваарь, газар нутаг, байгаль хамгаалал, эзэн

албатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах ба эдлүүлэх зарчим журмыг тогтоож нийгмийн гол гол харилцааг эрх зүйн зохицуулалтад оруулж байжээ. Иймд Их Засагт төр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхийн эрх зүйн баталгааг бүрдүүлжээ. Тиймээс ч Их Засгийг Монгол төрийн бүх хууль тогтоомжийн "Эцэг хууль" хэмээн нэрлэдэг билээ. Зөвхөн төрийн ашиг сонирхолд төдийгүй монголчуудын эртнээс тогтсон ёс заншилд тулгуурласан Их Засаг хуулийн ач холбогдол нь Монгол төрийн тулгуур хууль нь байж, улс орны эрх зүйн төлөвшлийг тухайн үеийн нөхцөл шаардлагатай нийцүүлж байснаараа, Их Монгол улсын тусгаар төрийн багана нь, орших эрхийн баталгаа нь, үндэсний ой санамжийн бодит илэрхийлэл нь болж байснаар тодорхойлогдоно. Хуулийг тогтоож батлахаас гадна ягштал даган мөрдүүлж, улс гүрэн даяараа энх амгалан тогтоож чадсан, шулуун шударга, чадал эрдэмтэй, цэцэн ухаантай хүнийг хэн ч байсан итгэл хүлээлгэж төрийн хэргийг тушааж, улсыг засахад зүтгүүлэх нь "Бадрах төрийн бат оршихуйн нэг үндэс болдог" тухай мөн "Өглөө хэлснээ үдэш нь, үдэш хэлснээ өглөө нь няцагч туйлбаргүй зантан, бусдыг бүү хэл өөрийгөө захирч эс чадагч ичгүүргүй явдалтан, эд хөрөнгө, эрх мэдэлд ташаарагч шунаг зальхай, харгис, журамгүй хэнд ч болов төрийн хэрэг бүү даалга" гэсэн Их Засгийн үзэл

санаа, суут Богдын зарлиг эдүгээ төрийн алба, албан тушаалтанд үнэхээр сургамжтай юм.

Персийн түүхч Рашид Ад Дин Судрын чуулгандаа "Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэхээр Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно. Орчлонгийн ихэс ч тэдэнд хишгээ хүртээж, дэлхийн хүн ам ч тэндээ наминчлан залбирсаар, урт удаан наслан, амьдралын сайн сайхан бүхнээр жаргах болно" хэмээжээ.

Жувейни (Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх), Рашид Ад Дин (Судрын чуулган), Плано Карпини (Монголчуудын түүх), Гельн Де Рубрик (Дорно этгээдэд зорчсон минь), В.А.Рязановский (Чингис хааны Их Засаг, Монголын эрх зүй), Р.Сайшаал (Чингис хааны товчоон), Жорж Вернадский, Владимирцов Л.Н Гумилев Окадо Хидохиро зэрэг Монголын түүх, соёл, хууль цаазын эх сурвалжууд (Их засаг, Нууц товчоо, Алтан товч)-ыг судалсан өрнө дорнын мэргэдийн ном судраас үзэхэд эзэн богд Чингис хааны Их Монгол Улсын түүх бол эрх чөлөөг эрхэмлэгч эрэлхэг нүүдэлчдийн төр улсынхаа тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэхийн төлөө, ураг хойч үеийнхээ энх амгалан оршихуйн төлөө шударгуу чанд хууль цаазыг

тогтоон хосгүй баатарлагаар тэмцсэн түүх гэдгийг нэгэн санаагаар хүлээн зөвшөөрснийг түвэггүйхэн олж харах болно.

Монголчуудын хэзээний танил, "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан" бүтээлийг зохиогч Жак Уэтэрфорд абугай Монголчуудыг зөвхөн төрөлх орон гэрээ төвхнүүлсэн төдийгүй эзэн Богдын үндэслэсэн их эзэнт гүрэн дэлхийн газрын зургийг ахин шинээр үйлдэж, саланги тусгаар хаант улсуудыг нэгтгээд зогсоогүй шинэ ертөнцөд ... аргамжиж зангидаж чадсан... Монголчууд байлдан дагуулагчид төдийгүй нэгэнт эзэлсэн их гүрнээ тогтоон барихдаа ухаалаг, тасралтгүй бодлого явуулсан суу билэгтнүүд байсныг онцолсон нь санаандгүй хэрэг биш. Монголчуудын оршин тогтнохуйн энэхүү хосгүй арга ухаан суу заль нь улс үндэснийхээ ашид мөнхийн дархлааг бүрдүүлж хүн төрөлхтөн хэмээх цэцэгсийн мандлын нэгэн содноос содон өнгө төрх, сор нь болон дэлбээлэх учир тавиланг нөхцөлдүүлжээ. Тэрхүү их хувь тавилангийн ач буян цуснаас цусанд үеэс үед нэвчин түгсээр өнөөгийн даяаршлын эринд ч монгол түмний итгэл найдварын нэгэн ундарга нь болсоор байна.

Улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, бататган бэхжүүлэх нэг гол нөхцөл бол улс, үндэстнийхээ үнэт зүйлс, ялангуяа эцэг дээдэс, эзэн богд Чингисээс уламжлагдан ирсэн төрийн бодлогын үнэт зүйлсээ

төрийн бүх байгууллага, албан тушаалтан сахин биелүүлэх хэрэг мөн.

Улсын хэргийг хөтөлж, төр, цэргээ засах, хууль цаазаа тэрлэх монгол арга ухаан бол монголын төр ёсны 2000 гаруй жилийн түүх, түүний дотоод, гадаадын их эх сурвалж болох "Монголын нууц товчоо", "Судрын чуулган", "Их Засаг Хууль" зэрэгт болон суут богдын алтан сургаалд хойч үеийнхээ мөнхөд оршихуйн тусын тулд дархлагдан үлдээсэн үндэсний хорвоод хосгүй эрхэм үнэт зүйл юм.

Төрийн бодлого нь нийт иргэнээ Монгол Улс хэмээх нэгэн дээвэр туурга нь бөх, өрх гэрээ нэгтгэн зангидах, төрийн хэргийг улс орныхоо нийтлэг (язгуурын) эрх ашигт захируулан хөтлөх оюун санаа, эрх зүйн үндэс нь болсон, бодлого, үйл ажиллагаандаа эрхэмлэн сахих, чиг баримжаагаа болгох үнэт зүйлсэд тулгуурлагдах учиртай. **Монгол төрийн ийм эрхэм үнэт зүйлсэд:**

1. Эв нэгдлийн үзэл санаа :

Монголчууд бид эвтэй байхдаа хүчтэй байдгыг буурал түүх маань нотолно.

Чингис Богд: "Бие бөх болбоос ганцыг яльюу Эе бөх болбоос олныг яльюу". Жувеини: Чингис хаан хөвгүүд, дүү нартаа ямагт эв найртай байж, бие биедээ тус дэм өгч, эв эеэ бэхжүүлэхийг чармайх хэрэгтэй гэж үргэлж захиж сурган, явал эвтэй байж болдог үлгэр

жишээг таниулдаг байлаа. Сургаал, үлгэр домог (жишээ нь, Алангуа эхийн домог Н.Ж) ярьж... "Та нар багцалсан сум мэт байх ёстой...Ганц хоёроороо бол амархан хугарах сум, ийм олон болбол хэнд ч дийлдэхгүй. ..Тийм учраас та нар бие биеэ дэмжин эв найрамдалтай байх юм бол дайсан хэдий хүчирхэг ч гэсэн та нарыг ялж дийлэхгүй..." гэж мэтээр сургадаг байсныг "Дэлхийг байлдан дагуулагчийн түүх" хэмээх бүтээлдээ тэмдэглэн үлдээжээ.

Монголын үндэсний эв нэгдлийн оюун санааны чухал эх ундарга нь монголчуудын эвсэг, найрсаг аж төрдөг, үерхэл, нөхөрлөлдөө үнэнч зан чанар, ёс суртахуун юм.

2. Тусгаар тогтнолын үзэл санаа

Монгол Улсын тусгаар тогтнол, монголын ард түмэн, төрийн үнэт зүйлсийн охь манлай дээжис нь мөн. Бид төр, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэн, ач холбогдлыг сайн мэднэ. Энэ бол Монголын ард түмэн, төр засаг гадныхэний ч дарамт, шахалтгүйгээр дотоод, гадаад бодлогоо тодорхойлж хэрэгжүүлэх үндэсний хийгээд олон улсын эрх зүйгээр баталгаажсан эрх дарх билээ. Тусгаар тогтнолын эрх ашигт нийцүүлэн төрийн хэрэгт зүтгэхийн учрыг Богд Чингис хаан:

*"Алд бие мину
алжааваас алжаатугай
Ахуй төр мину бүү алдартугай
Бүтэн бие мину зовбоос зовтугай*

*Бүрэн улс мину бүү самартугай"
хэмээн сургажээ¹.*

3. Хууль дээдлэх ёс

Б.Чимид:Хууль дээдлэх ёсон засаг төр барих урлаг, хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм. "Чингис хааны од гялалзаж тэр хүмүүс тушаал, зарлигийг дагах болсноор хатуу тогтоосон засаг ёсын (хууль ёсны Н.Ж) тусламжаар тэрээр хүмүүсийг удирдан захирах болов" гэснийг санахад илүүдэхгүй. Чингисийн билэг сургаалд "хатуу чанд, яв цав байдалтай бол хамаг улс бат бэх болой"².

4. Шударга ёс

Академич С.Нарангэрэл: Ёс суртахууны нандин чанарын тэргүүн зэрэгт шударга ёс тавигдсаар ирсэн. Түүнийг хоёр дугаар зэрэгт тавьбал яах бол?

Шударга бус явдал газар авна. Хэн шударга бусыг бусдаас ичгүүр сонжуургүйгээр үйлдэнэ. Тэр нийгэм төрд тэргүүлэх байр суурийг эзэлбэл улс гүрэн ямар болдог билээ.

Эрээ цээргүй нь хойморт заларч, чадалтай нь хатавчинд суудаг... "Шударга ёсыг Монгол гэрийн тоонотой адилтгаж болно. Тооногүй гэр Монгол гэр болж чадахгүйтэй

¹ Д.Лүндээжанцангийн "Тусгаар тогтнол-улс, үндэстний үнэт зүйлсийн охь дээжис мөн" өгүүллэгийг үзнэ үү. Л.Дэжидмаа, Н.Жалбажав. Нийгмийн социал шинэчлэл ба Үндэсний аюулгүй байдал, түүний оюуны дархлааны тухайд. УБ., 2019, 139-158.

² Эрэнджен Хара-Диван, Чингис хаан түүний үлдээсэн өв. УБ., 2003. Мон судар. 15 дахь тал. Б.Чимэд. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006. 150 дахь талд.

адил аливаа хүнд авьяас мэдлэг байгаад ч шулуун шударга, ариун явахгүй бол хүний мөс чанараа алдана." Шударга ёс алдагдвал улс орон ч өөдлөн дэвжихгүй. Чингис хаан шударга удирдлага бүхий засаг төрийг цогцлоосон. Энэ тухай алдарт аялагч Марко Поло "Чингис хааны засаглал шулуун шударга, хүн ардаа энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө ирж нийлэн нэгдсээр байв" гэсэн гярхай ажиглалт хийжээ³.

Чин шударгуу буюу амьдралд шударга байх нь: Хүнд мөнх тэнгэр, газар эх, үндэс угсаа, эцэг эхээс уламжлан заяагдсан төрмөл болон хүмүүжил, боловсрол, амьдралын туршлагаар төлөвшсөн эрхэм чанар, хандлагын цул бөгөөд хүмүүний мэдлэг, итгэл үнэмшил, бие сэтгэлийн тэнхээ чадал буюу эр зоригт нь суурилан ухамсар сэтгэлгээ, үйлдэл, үйл ажиллагааных нь дотоод сэдэл, чиг хандлагыг тодорхойлогч эрхэм чанар юм.

Нийгэмд шударга ёс тогтоохын тулд:

- Монгол хүн, улсын иргэн хууль, шүүхийн өмнө үндэс угсаа, гарал үүсэл, нас хүйс эрдэм боловсрол, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь зэргээс үл хамааран тэгш байх зарчмыг тууштай баримтлах;
- Аливаа бодлого, шийдвэрт улс үндэстнийхээ нийтлэг ашиг сонирхол, үнэт зүйлсийг эрхэмлэх;

³ С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шаштир. УБ., 2014. 31 дэх тал.

- Нийгмийн баялгийн хуваарилалтын шударга ёсыг тогтоох;
- Монголын төр, бизнест авлига, хулгай, луйвраас сэргийлэн хамгаалах тогтолцоог төлөвшүүлж нутгархах, танил тал харах, улс төржих ашиг сонирхлоороо талцан явцуурхан бүлгэрхэх, онцгойрох гэсэн аливаа илрэлтэй тууштай тэмцэх;
- Төрийн хууль, тогтоомжийг дээр доргүй нэг мөр даган биелүүлэх, нийгэмд хууль дээдлэх зарчмыг тууштай хэвшүүлэн тогтоох зэргээр илрэх.

Нийгэмд шударга ёс тогтвол сайн засаглал, тогтвортой хөгжилд хүрч, хүн ардын сэтгэл зүрхэнд эе эвээ хичээх сэтгэл бадарч үндэсний эв нэгдэл бэхжих жамтай.

5. Холч, голч шинж чанар буюу "Их малгайн бараа харах ёс"

Энэ нь улс үндэснийхээ язгуур эрх ашигт нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлийг тунгаан бодож, хийг гаргаж бясалгасан "үүдэн бий болсон (болох Н.Ж) асуудлыг (үр дагаврыг Н.Ж) даамай эргэцүүлэн сэтгэж, давхар ухамсарлан бодож алсыг харсан төрийн холч (тогтвортой), голч бодлого (оновчтой Н.Ж), бодлого шийдвэр гаргах" арга ухаан юм⁴. Өндөр уул, өргөн далайг зорь, шантралгүй зүтгэвээс давна,

⁴ А.Хишигдаваа. ШУА.Философи, социологи эрхийн хүрээлэн. Монгол төрийн бодлогын үнэт зүйлсийн уламжлал, хэрэгжилт // Философи эрх зүйн судлал. XXII боть. 225-232 дахь тал.

туулна гэсэн эцэг дээдсийн утга төгс сургаальч буй. Үнэн, худлыг ялгах, алдаа оноогоо дэнслэх, бэрхшээл, зовлонд үл түүрдэх монгол хүний нугаршгүй ноён нуруу, хатан зориг нь бий. Төрдөө итгэж алтан сүлдийг нь сүслэн дээдлэх монгол арга ухаан ч бий. Энэ бүхэн Монгол төрийн бодлого холч мэргэн байх үндэс суурь нь болой.

Дүгнэлтийн оронд: Даяаршлын гэгдэх энэ цаг үед бидний цөөн монголчууд XIII зуунд тохиосон эрчмийн түрэлтийн эрин/Л.Н Гумилев/ энэ зуунд Эзэн богд Чингис хааны гал голомтод дахин тохиох учрал ерөөл бүрдэн буй гэх горьдлогыг сэтгэл зүрхэндээ битүүхэн тээх болов. Монгол Улсад ардчилал түгэн, зах зээлийн харилцаа төлөвшин, нийгэмд шударга ёсны үр соёолон, эе эвийн сэтгэлгээ төлөвшин, Монгол Улсын олон улсын нэр хүнд, байр суурь бэхжин, Монголын ард түмний авьяаслаг охид, хөвгүүд дэлхий, олимпын дэвжээнээ оюуны болон

бие бялдын хүч сорьсон уралдаан тэмцээнд манлайлж, төрийн алтан соёмбот далбаагаа мандуулж, төрийн дууллаа эгшиглүүлэн, эх орон, ард түмнийхээ алдрыг ертөнцийн чихнээ дуурсган буй нь, мөн Монгол Улсын цэрэг, цагдаагийн алба хаагчид олон улсын хамтын нийгэмлэг, НҮБ-ын далбаан дор улс түмний энх амгаланг сахиулах онц хариуцлагатай үүргийг нэр төртэй биелүүлэн ур чадвар, сахилга, зохион байгуулалт, авхаалж самбаа, золбоо хиймориороо хилийн чанад дахь анд нөхдийнхөө итгэл хүндэтгэл хүлээн буй зэрэг нь ийм гэгээн мэдрэмж, горьдлого тээх үндэс нь болж байна Монгол Улсын нийт иргэд, ахмад үе, өсвөр залуучууд, оюутан, эрдэмтэн, судлаачид, баялаг бүтээгчид бүгд эв санаагаа нэгтгэн, эх оронч үзэл, үндэсний ой санамжаа хурцлан дайчилж нэгэн зэрэг зориглон хөдөлбөөс улс, эх орон маань хөгжин цэцэглэж тусгаар тогтнол нь батжин бэхжих нь лавтай.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ



Т.Сүхбаатар

Шихихутуг их сургуулийн Клиник
сургалтын төвийн эрхлэгч

Улс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход нөлөөлөх нэг хүчин зүйл нь нь төрийн эрүүгийн бодлого байсаар ирсэн. Монгол Улсын Эрүүгийн Хуулийн /шинэчилсэн найруулга/ 1.4 дүгээр зүйлд: Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн Хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө: нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, Үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино гэж заасан.

Төрийн эрүүгийн бодлогын нэг чухал хэсэг болох эрүүгийн хуулийн энэ зорилго бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаагаас улс орон хөгжих боломж нөгцлүүд алдагдаж улс орон бүхэлдээ гэмт этгээдүүийн сүлжээ, гэмт хэргийн хүлээсэнд байгаа мэт дүр зураг харагдаж байна. Нүүрсний хулгайн хэрэг, Хөгжлийн

банкны хэрэг, авилгал албан тушаалын гэмт хэрэг, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэрэг, цахим залилан болон зам тээврийн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн зэрэг гэмт хэргүүд урьд өмнө байгаагүй их хэмжээгээр үйлдэгдэн гарч гэмт хэргийн улмаас учирч буй хохирол, хор уршиг хэдэн арван тэрбум, их наядаар тооцогдох хүртлээ өсөн нэмэгдсээр байна.

Гэмт хэрэг ийнхүү өсөн нэмэгдэж байгаагийн нэг шалтгаан нь төрөөс гэмт явдалтай хийх тэмцлийн нэг гол зэвсэг болсон Эрүүгийн Хуулийн нийгэмд үзүүлэх нөлөөлөл хүчин чадлыг зарим талаар бууруулсантай холбоотой гэж судлаачид үзэж байна. Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн Хуулийг /шинэчилсэн найруулга/ 2002 оны Эрүүгийн Хуультай харьцуулахад анхаарвал зохих асуудал цөөнгүй байна.

2015 оны Эрүүгийн Хуулийн шинэчилсэн найруулгаар 2002 оны Эрүүгийн Хуульд байсан хэргийн хөөн хэлэлцэх хугацааг буруугаар ойлгож тооцохоор заасан, "гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж 4 ангилж байсныг хөнгөн, хүнд гэсэн 2 ангилалтай болгож өөрчилсөн," гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр" гэдэг ойлголтоос "урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг", "гэмт бүлэглэл" гэдэг ойлголтуудыг хассан, гэмт хэргийн

“захиалагч” гэдэг ойлголтыг мөн хассны гадна 2017 оны ЭХХШХуульд хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх тухай заалт оруулж баталснаар албан тушаалын байдлаа урвуулж авилгал хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулах боломж олгосон зэрэг нь төрийн эрүүгийн

бодлогод гарсан алдаа болсон төдийгүй гэмт этгээдүүд хууль тогтоогчоос гаргасан дээрхи алдааг овжиноор ашиглаж улс орон хөгжих, гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх олон боломж нөгцлийг алдагдуулж, гэмт хэрэг үйлдэх арга хэлбэр, бүтэц тогтолцоо ч өөрчилжээ.

2002 оны Эрүүгийн Хууль	2015 оны Эрүүгийн Хууль
35 дугаар зүйл . Гэмт хэрэгт хамтран оролцох	3.1 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох
- Захиалагч - Зохион байгуулагч - Хатгагч - Гүйцэтгэгч - Хамжигч	- Зохион байгуулагч - Гүйцэтгэгч - Хатгагч - Хамжигч

Үүнтэй холбоотойгоор монголын нийгмийг гайхшруулж цочирдуулсан улмаар олны анхааралд орсон олон тооны гэмт хэрэг үйлдэгдэн гарч байна

УИХ-ын дарга Г.Занданшатар 2022 оны УИХ-ын намрын чуулганыг хааж хэлсэн үгэндээ: “Уул уурхай тойрсон улс төр, хууль хяналт, эдийн засгийн гэмт бүлэглэл үүссэн байна” гэж тэмдэглэн хэлсэн нь нүүрсний гэх тододолтой хэргийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа, түүнд хамрагсдын хүрээ, гэмт хэрэг үйлдсэн арга ,учруулсан хохирлын хэмжээгээр тодорхойлогдож байна.

Гэмт хэрэгт хамтран оролцохын хамгийн аюултай дээд түвшний хэлбэр болох гэмт бүлэглэл гэсэн ойлголт нэгэнт буй болоод байгааг УИХ-ын дарга хүлээн зөвшөөрч

мэдэгдсэн хэдий ч Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн гуравдугаар бүлэгт хууль зүйн энэ чухал ойлголт байхгүй байгааг харгалзан үзэж цаашид Эрүүгийн хуульд суулгаж өгөх шаардлагатай.

“Нүүрсний гэх тодоголтой” энэ хэрэгт нийслэлийн прокурорын газраас 92 хүнийг яллагдагчаар татаж яллах дүгнэлт үйлдэж 493 хавтас хэргийн материалыг нийслэлийн Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсний дагуу хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан 2023 оны 4 дүгээр сарын 17 –ний өдөр эхлэхээр товлогдоод байна.

Энэ хэрэгт яллагдагчаар татагдсан УИХ-ын гишүүд болон албан тушаалын байдлаа урвуулсан, авилгал хээл хахууль авсан нийтийн

албан тушаалтнуудад хэрхэн шудрагаар ял шийтгэл оногдуулахыг олон нийт анхааралтай ажиглаж байна.

Гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүд мэргэших хандлагатай болж байгаагийн гадна зарим тохиолдолд онц харгис хэрцгий аргаар гэмт хэрэг үйлдэж байгааг анхаарахгүй байж болохгүй.

Тухайлбал: 2021 оноос хойш нэр бүхий 5 этгээд Булган Дундговь Сүхбаатар Хэнтий Өмнөговь Хөвсгөл Завхан Орхон зэрэг аймгийн нутаг дэвсгэрт 60 удаагийн үйлдлээр бусдын орон байранд хууль бусаар нэвтэрч 1 тэрбум төгрөгийн хохриол учруулсан хулгайн гэмт хэрэг үйлджээ.

Хэргийг шалгах явцад цагдаагийн байгууллага гэмт этгээдүүдээс 17 сая төгрөг бэлнээр, 10 ширхэг мөнгөн аяга, 45 ширхэг хөөрөг, 11 ширхэг шүрэн толгой, хэт хутга, хураан авсны гадна дээрх хүмүүс гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгөөрөө амины орон сууц барьж машин худалдан авсны гадна гадаад улс руу явах виз мэдүүлсэн байсан зэргээс үзэхэд гэмт хэрэг байнга үйлдэж улмаар мэргэших хандлагатай болсныг тогтоожээ.

2015 оны Эрүүгийн хуулиар давтан гэмт хэрэг үйлдэх асуудлыг хуульчлаагүй орхигдуулсан төдийлэн зөв биш шийдэл байсан гэж үзэж болно. Давтан гэмт хэрэг үйлдэх явдал гэмт этгээдийн хувийн шинж байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлт болоод зогсохгүй ялыг

ялгавартайгаар зөв оногдуулахад нөлөөлнө.

Гэтэл бодит байдал дээр гэмт этгээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэг бүлэг зүйл, хэсэгт заасан гэмт хэргийг дахин давтан үйлдэх, аль эсвэл өөр төрлийн гэмт хэрэг дахин үйлдэх явдал гарч байна.

Хууль тогтоогч гэмт хэргийг давтан үйлдэхийг хуульчлаагүй атлаа Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.2-т " энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр түүнээс дээш удаа үйлдсэн " бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нэг нөгцөл байдал гэж заасан

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо улам бүр нэмэгдэж байгаа төдийгүй мөнгө угаах, татвар төлөхөөс зайлсхийх, бараа бүтээгдэхүүний үнийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж байгаа зэрэг нь улс орны эдийн засгийн аюулгүй байдалд сөрөгөөр нөлөөлж байгаа нөгцлийг таслан зогсоож далд эдийн засаг бүрэлдэн тогтоохын эсрэг Эрүүгийн хуулийн хүчин чадлыг ашиглаж хийх тэмцлийг хүчтэй болгох шаардлагатай байгааг үйлдэгдэн гарч байгаа гэмт хэргийн статистик мэдээ, гэмт хэрэг үйлдэж байгаа арга хэлбэр ,учруулж байгаа хохирол хор уршгаас харагдаж байна.

Гэмт хэрэг үйлдсэн л бол хариуцлага хүлээдэг байх нь нийгэмд шудрага ёсыг тогтоох чухал хүчин зүйл болдогийг дэлхийн өндөр

хөгжилтэй улсуудын туршлага хариулж байна.

Эрүүгийн хариуцлага бол гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогдсон этгээдэд төрөөс хүлээлгэж байгаа төрийн албадлагын арга хэмжээ бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүн хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохрлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилготой тул Эрүүгийн хуулийн нийгэмд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлж улс орны эдийн засгийн өсөлтөд саад учруулж, хөгжих боломжийг алдагдуулж байгаа гэмт явдалтай хийх тэмцлийг нь төрийн эрүүгийн бодлогын цөм болгож ажиллах нь чухал.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг мөрдөн шалгах явцад үйлдэл, эс үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүн байгаа эсэхийг нотлох баримтын үндсэн дээр тогтоох нь юуны өмнө хэргийн зүйлчлэлд нөлөөлөхийн зэрэгцээ цаашлаад яллагдагчаар татсан хуулийн зүйл хэсгээр шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа харгалзан үздэг зайлшгүй нэг нөгцөл болдог.

Монгол Улсын ЭХХШтХуулиар /шинэчилсэн найруулга/ 2017 оны / гэмт хэргийн бүрэлдэхүүн гэсэн ойлголтыг хасч" гэмт хэргийн шинжгүй" гэсэн заалтыг ЭХХШХуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1-д оруулсан нь тийм ч оновчтой биш томъёолол болсон гэж мөрдөгч прокурор шүүгчид үзэж байгааг дурьдах нь зүйтэй.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай ойлголт нь гэмт хэргийн объект,объектив тал, субъек, субъектив талуудаас бүрдэх бөгөөд эдгээр нь тус бүртээ үндсэн болон нэмэгдэлтэйн гадна нийтдээ 20 гаруй шинжүүдийн иж бүрдлээр тодорхойлогдож мөрдөн байцаалтаар тогтоогдсны дараа л хэргийн бодит байдал / ЭХХШтХуулийн 1.7 дугаар зүйл / эргэлзээгүй тогтоогдсон гэж ойлгож болох бөгөөд зөвхөн гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлийг зааж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болох хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх,эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болохгүй тохиолдол болгож заасан нь буруу.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн /шинэчилсэн найруулга/ хэрэглээнд тулгарч байгаа эдгээр асуудлыг харгалзан үзэж Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулж батлах
2. Хуульчид зөрчил бол гэмт хэргийн төрсөн дүү гэж ёгтлон хэлсэн байдаг нь үнэний хувьтай. Зөрчлийн тухай хуульд заасан зарим зөрчлүүд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэргийн объектив талын шинж байдлаас төдийлэн ялгагдахгүйгээр хуульчлагдсны гадна зөрчил гэмт хэргийг ялгах гол шинж нь зөвхөн хүлээлгэх хариуцлага санхүүгийн хэмжээ болоод байгаа тул Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд харьцуулсан бүтцийн шинжилгээ хийж Зөрчлийн хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага байна.
3. Монгол Улсын Засгийн Газар авиргал, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж гэмт хэрэг үйлдсэн этгээдэд

оногдуулах ялыг чангатгахад анхаарч, “5Ш” төлөвлөгөө батлан хэрэгжүүлж эхэлж байгаа нь сайшаалтай.

Гэвч Эрүүгийн хуульд заасан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх тохиолдол, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх тохиолдол зэрэг эрүүгийн эрх зүйн суурь ойлголтод үндэслэж төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлж, гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаагаа тууштай явуулах нь улс орны цаашдын хөгжилд Эрүүгийн хуулийн үзүүлэх нөлөөллийг дээшлүүлэхэд чиглэгдэх ёстой.

Ашигласан ном, материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2015 он.
2. Монгол Улсын ЭХХШтХууль 2017 он
3. Prokuror.mn сайт
4. Shuud.mn сайт

УСНЫ НӨӨЦИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД



*Шихихутуг их сургуулийн
Судалгааны хүрээлэнгийн судлаач,
багш З. Батбаяр*

Монгол улсын Үндсэн хуулийн 6.1-р зүйлд “Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” Хэмээн заасан нь усны эрх зүйн зохицуулалтын үндэс суурь болж байна. Цаашлаад Үндсэн Хуулийн 6.2-р зүйлд “Усны нөөц нь төрийн нийтийн өмч мөн” хэмээн нарийвчлан тодотгон заасан байдаг нь усны нөөцийн өмчлөлийн асуудлыг тодорхойлж буй хэрэг юм. Ус гэдэг бодис нь физик химийн чанарын хувьд хамгийн энгийн бүтэцтэй, дэлхийд хамгийн өргөн хэмжээтэй тархсан бодис боловч хүний нийгмийн оршин тогтнох үндэс болсон эдийн засаг нийгмийн усны хэрэглээг аваад үзвэл дэлхийн нийт усны нөөцийн дөнгөж 1 хувийг ашиглаж болохуйц цэнгэг ус бүрдүүлдэг нь, мөн энэхүү цэнгэг

усны нөөц нь улс орон бүрд харилцан адилгүй тархсан байдаг нь усны нөөцийн эрх зүйн зохицуулалтын өвөрмөц онцлог, хамрах хүрээг тодорхойлж байна. Усны эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээ нь дараах хэд хэдэн талтай байна. Үүнд:

1. Хүний амьд явах эрхийн үндэс болсон ундны усаар хүн амыг хангах асуудал нь ард түмний ба ЗГ-ын хооронд байгуулагдсан гэрээ гэж үздэг Үндсэн хуулийн гол амин сүнс болох учиртай. Хүний амьд явах эсэх нь, хүний нийгэм оршин тогтнох эсэх нь ундны ус, усны нөөц байгаа эсэхээс шууд хамаарах учраас Үндсэн хуулиар төрийн хүлээсэн үүргийн хамгийн чухал нь хүнийг, нийгмийн гишүүдийг ундны усаар хангах асуудал тэргүүн зэргийн ач холбогдолтой болох нь тодорхой. Мөн ус хэмээх энэ хамгийн энгийн бүтэцтэй буюу устөрөгчийн 2, хүчилтөрөгчийн 1 атомоос бүтсэн бодисыг хүн төрөлхтөн шинээр бий болгон үйлдвэрлэж чадахгүй, зөвхөн байгальд байгаа нөөцийг л ашиглах учраас хүний амьдралын, хүний нийгмийн оршин тогтнох эх үүсвэр төдийгүй нийгмийн харилцааны зохицуулалтын анхдагч объект болох нь гарцаагүй. Хүний амьд явахад шаардлагатай

агаарыг бид ногоон ургамлаас фотосинтезийн үзэгдлийн үр дүнд байнга авч байдаг бол хоол хүнсийг хавьгүй өргөн хүрээнд байгалийн бүх төрлийн нөөцүүдээс авч хэрэгцээгээ хангаж шинээр үйлдвэрлэж болдог. Харин ундны усыг шинээр үйлдвэрлэх, гаргаж ирэх боломжгүй учраас хүний амьд явах эрхийг хангах, нийгмийн оршин тогтнох анхдагч нөхцлийг хангах үүднээс Үндсэн хуульд зааж, үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт хийх нь гарцаагүй юм.

2. Хүний нийгмийн оршин тогтнох үндэс нь байгаль дэлхий бөгөөд хүрээлэн буй орчноос авч ашиглаж буй байгалийн нөөцийг авч ашигласаны үндсэн дээр л бий болдог. Гэтэл байгаль дэлхий хүрээлэн буй орчин гэж бидний нэрлэж заншсан дэлхийн бөмбөрцгийн оршин байгаа учир шалтгаан нь дэлхийн усны эргэлтийн үр дүн юм. Өөрөөр хэлбэл дэлхий дээр хүнээс үл шалтгаалан явагдаж буй бүхий л байгалийн үзэгдлүүд нь (хур тунадас, салхи шуурга, мөнх цас, цэвдэг, газрын доорх ус, гол мөрөн, хойд туйл, далай тэнгисийн хөдөлгөөн өөрчлөлт гэх мэт) дэлхийн усны эргэлттэй салшгүй холбоотой байдаг. Иймээс УС-ны талаарх эрх зүйн зохицуулалт нь бидний уух ундны ус төдийгүй дэлхийн бөмбөрцгийн оршин тогтнох

үндэс, байгалийн үзэгдлүүдийн эх үүсвэр болсон усыг байгалийн тэнцвэрт байдлыг хадгалагч, хангагч болохын нь үүднээс хамгаалах, одоо байгаа байдлыг хэвээр нь хадгалах шинжтэй байх нь гарцаагүй. Энэ хүрээнд дэлхийн улс орон болгонд ижил төстэй байдлаар гол мөрөн, мөнх цас, мөсөн гол, газрын доорх ус, цэвдэг зэргийг хамгаалах эрх зүйн зохицуулалтууд өндөр хөгжсөн байдаг ба энэ зохицуулалт нь хамгаалалтын үүднээсээ улс орнуудын дунд саланги тусдаа биш харилцаа уялдаа хамааралтай, нэгдмэл байх шаардлагатай байдаг. Учир нь бидний улс орон гэж нэрлэн хил зааг тогтоон байгаа байдал нь зөвхөн бидний тархи толгойд хийсвэрээр байгаа болохоос байгаль орчны үүднээс дэлхийн бөмбөрцгийн үүднээс аваад үзвэл бид нэг л гарагтай, нэг л дэлхийтэй билээ. Ийм учраас УС-ны эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээг олон улсын байгаль орчин, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлаар бас тайлбарлах шаардлагатай.

3. Хүний нийгэм оршин тогтноход шаардлагатай бүх төрлийн хоол хүнс, бараа бүтээгдэхүүнүүдийг хүн төрөлхтөн үйлдвэрлэдэг болсон төдийгүй үйлдвэрлэл нь нийгмийн оршин тогтнох эдийн засгийн үндэс суурь нь болж байна. Үйлдвэрлэл гэдэгт талх барихаас эхлээд байшин

барилга барьж байгуулах, алт мөнгө олборлох гэхмэтчилэн машин техник хийж бүтээх гээд хамгийн өргөн хүрээнд авч үзэж болно. Гэвч хүний нийгэмд ус ашиглахгүйгээр бүтдэг бий болдог ганц ч бүтээгдэхүүн, ганц ч шинэ зүйл байхгүй. Энгийн нэгэн өмд оёхоос авхуулаад сансрын хөлөг онгоцыг бүтээх, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхээс авхуулаад цэрэг дайны зэвсэг бүтээхэд ч хамгийн анхдагч буюу зайлшгүй шаардлагатай түүхий эд нь ус юм. Усны нөөц байхгүй бол хүн төрөлхтөн ямар ч шинэ зүйлийг бүтээж үл чадна. Ийм учраас УС-ны эрх зүйн хамрах хүрээний дараагийн нэгэн талбар нь Ус бол эдийн засаг-үйлдвэрлэлийн анхдагч түүхий эд болох тухай асуудал юм. Нэгэнт бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, байгалийн нөөцийн олборлолт хүртэл усны нөөцийг ашиглаж байж бий болох учраас УС-ыг эдийн засаг-үйлдвэрлэлийн анхдагч түүхий гэдэг талаас нь ухаалгаар зохицуулах эрх зүйн зохицуулалт зайлшгүй юм.

4. Ус нь зөвхөн хүний амьд явах үндэс болоод зогсохгүй орчин үеийн хүний нийгмийн амьдралын ая тухтай байдлыг хангагч, мөн хүний нийгмийн хөгжлийн шалгуур болоод байна. Өнөөдөр улс орнуудын хөгжлийн түвшинг тодорхойлохдоо үйлдвэрлэлийн хүчин чадал үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнээс

илүү хүний буюу тухайн нийгмийн гишүүний ая тухтай амьдрах нөхцлийг хэр хангасан байгаагаар тодорхойлдог болоод байна. Бүр тодруулбал тухайн нийгмийн гишүүнд хоногт дунджаар хэдэн литр ус хэрэглэх боломжтой байна? Ариун цэврийн байгууламжаар хангагдсан эсэх, халуун хүйтэн болон дахин ашигласан усыг ашиглах боломжтой эсэх зэрэг усны тоо хэмжээ, усны чанартай холбоотой асуудал нь хүний хөгжлийн үндсэн шалгуур болоод байгаа учраас эдгээр харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт маш чухал юм.

Нэгтгээд үзвэл усны эрх зүйн зохицуулалт нь хүний амьд явах эрхийг баталгаажуулах үүднээс Үндсэн хуулийн эрх зүйн, хүний нийгмийн оршин тогтнох үндэс болохын хувьд хүрээлэн буй орчны эрх зүйн, нийгэм эдийн засгийн хөгжлийн анхдагч эх үүсвэр болохын хувьд иргэний болон эдийн засаг бизнесийн эрх зүйн, хүний нийгмийн хөгжлийн шалгуур болохын хувьд нийтийн эрх зүйн гэсэн асар өргөн хүрээг хамарсан зохицуулалт байх ёстой.

Дэлхий нийтийн хувьд устай холбоотой эрх зүйн болон нийгмийн харилцааг нийтлэг байдлаар зохицуулах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой ойлгомжтой болгох үүднээс Усны нөөцийн нэгдсэн менежмент буюу Integrated Water Resource Management хэмээх

онолын үндэслэлийг гарган хэрэгжүүлж эхлээд 30-аад жил болж байна. УННМ гэдэг ойлголт, онолын үндэслэл анх менежментын шинжлэх ухааны арга хэрэгсэл болж гарч ирж, хөгжиж байсан бол одоо усны нөөцийг удирдах байнгын процесс, эрх зүйн зохицуулалтын арга хэрэгсэл баримтлах зарчим болж өргөжөөд байна. “Усны Нөөцийн нэгдсэн Менежмент гэдэг нь экосистемийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйн зэрэгцээ, нийгмийн хангамж болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд ус болон газар, тэдгээртэй холбоотой нөөцийн нэгдсэн менежментийг сайжруулах үйл явц юм” гэж Даян Дэлхийн Усны Түншлэл 2000 тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолт ёсоор УННМ-ийн үүднээс дараах хэмжүүрүүдийг авч үздэг.

Үүнд:

Сав газрыг бүхэлд нь хамарсан асуудлууд

УС нийгэм эдийн засгийн бараа үйлчилгээ болох нь

- Усны нөөцийн тэнцвэртэй хуваарилалт

- УННМ ба байгаль орчны менежмент

- Төв болон орон нутгийн хамтын ажиллагаа

- Оролцогч бүх талын оролцоог тэнцвэртэй байдлаар хангах

- Хөрөнгө оруулалт тогтвортой санхүүжилтын систем

Эцэст нь: УС-ны эрх зүйн зохицуулалт нь зөвхөн аль нэг салбарын зохицуулалт төдий бус харин энэ хорвоо ертөнц оршин тогтнох үндэс суурийг хамгаалж, хадгалж авч үлдэх, хүний нийгмийн хөгжил дэвшил, эдийн засаг, үйлдвэрлэлийн үндсэн бөгөөд анхдагч түүхий эдийн хангамж, хамгаалалтын асуудал, орчин үеийн эрх зүйн зохицуулалтын тэргүүлэх зорилго болсон хүний амьд явах эрхийг хангах хамгаалах асуудал юм. Ийм асар өргөн хүрээг хамарсан, хамгийн үндсэн асуудал болсон усны эрх зүй, усны нөөцийн эрх зүйн зохицуулалтыг Үндсэн Хуулийн хэмжээнд бүрэн зохицуулах санал дэвшүүлэх зорилгоор энэхүү өгүүллийг бичлээ.

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ БА БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ LEGAL STATUS OF LAWYERS AND EDUCATION REFORM



Шихихутуг их сургуулийн Нийтийн
эрх зүйн тэнхимийн эрхлэгч,
докторант Б.Мөнх-Эрдэнэ

Удиртгал

Хуульчийн мэргэжил нь бие даасан байр суурийг илтгэдэг билээ. Өнөөдөр энэ мэргэжилтэй холбоотой хүмүүст бодит, утга учиртай шинэчлэл хийх шаардлагатай цаг үе иржээ. Энгийнээр хэлбэл хуульчийн эрх зүйн байдлыг сайжруулах баталгаанд боловсролын шинэчлэл чухал үүрэг гүйцэтгэхээр харагдаж байна. Шинэчлэлийн аливаа саналыг авч үзэхийн тулд шинэчлэл хийх шаардлагатай гэж үзсэн шалтгааныг тодорхой болгох нь зүйтэй. Эрх зүйн боловсролын шинэчлэлийн үйл явцад одоо байгаа тогтолцооны алдааг иргэд олон нийт төдийгүй тухайн салбарынхан өөрсдөө хүлээн зөвшөөрснөөр эхлэл тавигддаг.

Хуулийн салбарт шинээр хуульч болохоор элсэгчдийн тоог зохиомлоор хязгаарлах нь нийгэмд сөргөөр нөлөөлж буй таагүй үр дагавар гэж Япон, Америк гэх улсуудад шүүмжлэл өрнөөд байна. Хуульчийн эрх авах хүсэл эрмэлзэлтэй байгаа хүмүүсээс шалгалт авахдаа хуульчдын тоог зохиомлоор хумих нь хуульчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн үнэ цэнийг гажуудуулж байдаг. Өөрөөр хэлбэл хуульч мэргэжлээр ажиллах нь үнэ цэнэтэй ч хуульчаар сонгогдсон цөөхөн хүмүүсийн хувьд элит, хамгаалагдсан хүрээлэл байх ёсгүй. Хуульчийн шалгалтад тэнцсэний үр дүнд бий болдог хүрээлэл,

Хураангуй: Өнөөдөр хуульчид олон талт ертөнцөд хуучирч хоцрох материаллаг хуулийн агуулгад хэт их анхаарал хандуулж, шаардлагатай өргөн хүрээний ур чадварт хангалттай анхаарч ажиллахгүй байна. Тиймээс манлайллын асуудлыг хууль зүйн боловсролын шинэчлэлийн хүрээнд оруулж ирэх нь чухал.

Түлхүүр үг: Хуульчийн эрх зүйн байдал, боловсролын шинэчлэл, хуульчийн манлайлал, хууль зүйн практик, хуульчийн мэргэжил

Гарчиг

Удиртгал

1. Хуульчийн эрх зүйн байдлыг боловсролын шинэчлэлтэй уялдуулах асуудал
2. Боловсролын шинэчлэл ба хуульчийн манлайлах ур чадвар
3. Хууль зүйн практикийн шинэ парадигмууд
Дүгнэлт /Санал/
Ном зүй

хуульч болсноор бусдаас илүү мэт мэдрэмж төрүүлдэг нь хуульчид, тэдний үйлчлүүлэгч хоёрын хооронд харилцахад төвөгтэй ялгаа зааг бий болгодог. Түүгээр ч барахгүй хуульчдын дунд өрсөлдөөн багасах эсвэл огт байхгүй болох эрсдэл дагуулдаг байна.

Хуульчийн шалгалтад тэнцсэн бүх хүмүүс заавал урт хугацааны сургалтанд хамрагдах шаардлагатай байгаа нь энэ асуудлыг улам хурцатгаж эхэлжээ. Учир нь нэг сургалтын хөтөлбөрт хуульчид заавал хамрагдах нь хууль зүйн талбарт нэгдмэл үзэл бодол, хандлагыг бий болгох эрсдэл үүсгэдэг. Бүх шинэ болон хуучин хуульчид нэгүдирдлаганд орижилхэн сурах бичгийг судлах шаардлагатай байвал хуульчдыг чадваржуулах үйл явц нь сургалтын хөтөлбөрийг боловсруулж, зааж буй хүмүүсийн хандлага, зааварчилгааг нэгтгэсэн байдлаар загварчлах аюул бий. Энэ нь ижил стандарт бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа тохиолдолд үр дүнтэй байж болох ч өөр өөр хэрэг маргаан, хүний эрхийг хамгаалах үйл хэрэг дээр ижил стандарт тогтоох эрсдэл дагуулах талтай. Тиймээс хуульчдын нэгдсэн сургалтын хувьд тодорхой стандарт, нэгдсэн бодлого баримтлахаас татгалзахын зэрэгцээ сургалтын цагийг урт байхаар тулгах нь эргээд хуульчдын эрх зүйн байдлыг дордуулах, тэдний ур чадвар, мэргэжлийн нэр хүндэт сөргөөр нөлөөлдөг.

Хуулийн сургууль бүр өөрийн

сургалтын хөтөлбөрийг бий болгох, элсэлтийн стандартыг тогтоох, багш нарын томилгоо хийх, элсэх анги тус бүрийн оюутны тоог тогтоох эрх чөлөөтэй байх ёстой бөгөөд ямар нэгэн төрийн болон хөндлөнгийн байгууллагаас заавар, зааварчилгаагүй үйл ажиллагаа явуулах нь эрх зүйн салбарт хөгжил авчирдаг төдийгүй хуульчийн эрх зүйн байдлыг баталгааг бүрдүүлдэг байна.

I. Хуульчийн эрх зүйн байдлыг боловсролын шинэчлэлтэй уялдуулах асуудал

Ирээдүйн эрх зүйн боловсролын салбарт улс орнуудын анхаарах асуудал бол олон улсын жишигт нийцсэн эрх зүйн боловсрол юм. Дэлхийн өнцөг булан бүрт байгаа хуулийн сургуулиуд, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн хүмүүс энэ хэрэгцээнд хэрхэн нийцүүлж хууль зүйн боловсролд анхаарч байгааг мэдэх шаардлага үүсжээ. Дэлхийн эдийн засагт асар их бүтээн байгуулалт өрнөж байгаа нь улс төр, эдийн засгийн суурь өөрчлөлтүүд аль хэдийн тодорхой түвшинд өөрчлөгдөх эхлэл болсон. Хятад, Энэтхэг, Бразил, Өмнөд Африк зэрэг улсууд томоохон тоглогч болж гарч ирснээр дэлхийн эдийн засгийн бүтцийг эрс өөрчилж эрх зүйн соёлд нөлөөлөл үзүүлж байгаа талаар АНУ, Европын Холбоо болон Япон зэрэг улсууд анхаарал хандуулж эрх зүйн шинэчлэл хийхийг чухалчилж байна¹. Энэхүү дэлхийн зах зээл,

¹ Legal education reform needed to prepare 21st century lawyers. November 17, 2018.

даяаршлын оршин тогтнолын өөрчлөлтийг аль ч улсын хуулийн сургуулиуд болоод хуульчид үл тоомсорлож болохгүй. Учир нь хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөл байдлын хүрээнд хуулийн багш нар, хуульчид ажиллах шаардлагатай болж байгаа юм. Өдөр тутам өөрчлөгдөж буй улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын орчин нь маргаашийн хуульчдын тулгамдсан асуудал билээ.

Нэг үндэстний хил хязгаарт хязгаарлагдсан “хуульчид голчлон дотоодын асуудалд санаа тавьдаг тул хийгдэж буй өөрчлөлтүүд нь багахан санаа зовоосон асуудал” гэж итгэлтэйгээр хэлэх боломжгүй юм. Саяхан Харвардын их сургууль бакалаврын сургалтын хөтөлбөрөө тоймлохдоо «дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч буй оюутнуудыг эх орныхоо иргэн болгон төлөвшүүлэх үүрэг хариуцлага хуулийн сургууль болгонд бий» гэжээ. Мөн доктор Ж.Клиффорд Уоллес “гадаадын хууль тогтоомжийг илүү сайн ойлгохын тулд эрх зүйн боловсролыг, тэр дундаа шүүхийн олон ургалч үзлийг илүү даяаршуулахыг дэмжих хэрэгтэй”² гэсэн байна.

Хуульчийн мэргэжил хэдэн арван жилийн өмнөх шигээ биш болсон. Өнөөдөр хуульчид олноор бэлтгэгдэж шинэ ур чадвар эзэмшиж тодорхой эрүүл өрсөлдөөнд идэвхтэй оролцох

хэрэгцээ үүсжээ. Алдарт хуульч Нани А.Палкивалагийн хэлснээр “жинхэнэ боловсролтой хүний хоёр шинж нь тодорхой сэтгэх чадвар, сониуч зан юм. Хуулийн сургууль төгссөн ч суралцах үйл явцыг үргэлжлүүлж, эрчимжүүлэх боломжийг байнга ашиглах шаардлагатай”³ гэсэн байдаг. Хуулийн боловсролыг дараагийн түвшинд хүргэхэд хувьсан өөрчлөгдөж буй цаг үеийг мэдэрдэг хуулийн сургууль болон хуульч нар байхгүйгээр хийх боломжгүй. Тиймд сайн хуульчдад эрдэм шинжилгээний ажилд тууштай оролцох нь ямар ч үргэлжилсэн сургалтаас чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хуульчийн эрх зүйн байдлын баталгаа буюу нийгэмд эзлэх байр суурийг өргөжүүлэх боломж нь эрдэм судалгааны чиглэл болон хувирсан. Мөн боловсролын олон төрлийн шинэчлэл, институцийн санаачилгыг дэмжих замаар сайн хуульчдыг бэлдэх боломжтой. Даяаршил үнэхээр зарим асуудлыг шийдвэрлэх шинэ боломжуудыг олгож байна. Боловсролын шинэчлэл нь бие даасан судалгаа хийх чадвар дээр тулгуурлаж байгааг анхаарах нь чухал.

Хуулийн сургуулиуд нь дэлхийн ирээдүйд ач холбогдолтой асуудлуудын талаар заах, хамгийн сүүлийн үеийн судалгаанд хамрагдах эрдэм шинжилгээний орон зайг хангах ёстой. Хууль зүйн их сургуулиуд болон хуульчдын

² Yves Dezalay, Bryant G. Garth. Battles Around Legal Education Reform: From Entrenched Local Legal Oligarchies to Oligopolistic Universals. India as a Case Study. 9-1-2018. 145 pp.

³ 北川善英.『法教育』の現状と法律学.

холбоо, фирмүүд, байгууллагууд хамтын ажиллагааны хөтөлбөрөөр дамжуулан даяаршлын сорилттой тулгарахын тулд өөрсдийгөө байнга шинэчилж байхаас өөр аргагүй болсон. Энэ нь багш, оюутнууд болон сургалт, судалгааны хөтөлбөрүүдийг хөгжүүлэхэд өөр өөр үр дагавартай. Дээр дурдсан дэлхийн эдийн засагт өрнөж буй үйл явцтай холбоотойгоор зарим улс дээд боловсролын дэвшилтэт тогтолцоог нэвтрүүлэх замаар хууль зүйн салбарынханд илүү их үүрэг хариуцлага хүлээлгэж байна. Шинэчлэлтэй холбоотой томоохон мэтгэлцээний хүрээнд дээд боловсролын салбарт хууль эрх зүйн боловсролын нөхцөл байдал, даяаршил нь хичээлийн хөтөлбөрт хэрхэн нөлөөлөх талаар яаралтай судлах шаардлага үүссэн. Тиймээс гадаадын хуульчид, хуулийн фирмүүдэд хууль эрх зүйн зах зээлийг нээлттэй болгох тухай маргаан өрнөж байгаа энэ үед ирээдүйн хуульчдад төдийгүй одоогийн хуульчдад зөв ур чадвар, боловсрол олгох шаардлагатай.

Хууль зүйн боловсролын дөрвөн чухал хүчин зүйл өнөө үед яригдаж байна:

1. Дэлхийн сургалтын хөтөлбөр
2. Дэлхийн хэмжээнд өрсөлдөх багш нар
3. Дэлхийн зэрэгт хүрсэн чанар
4. Дэлхий бусад улсуудтай хамтран ажиллах чадвар юм⁴.

⁴ 江口勇治「社会科における『法教育』の重要性」社会科教育研究69号（1993年）、同「社会科50年とこれからの教育改革」社会科教育研究79号（1998年）、同「アメリカの法教育の理論と実際」自由と正義2001年2月。

Эдгээр нь олон нийтийн хүлээлтэнд хүрэх ёстой.

Хэдэн арван жилийн өмнө хуулийн сургуулиуд сургалтын хөтөлбөрөө хууль эрх зүй болон өөрийн улсын хууль эрх зүйн тогтолцоотой холбоотой асуудлуудад чиглүүлж чадсан бол сайн ажиллаж чадна гэж үздэг байв. Гэхдээ өөрийн хуультай холбоотой сурган хүмүүжүүлэх, судалгаа шинжилгээний шилдэг бүтээлийг дэмжих, хууль эрх зүйн тогтолцоонд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, тэр дундаа эрх зүйт ёсыг хэрэгжүүлдэг, даяаршлын сорилтод нийцсэн нийгмийг бий болгох хэрэгцээг хангахгүйгээр боловсролын шинэчлэл, хуульчдын үүрэг оролцооны хувь нэмрийг тодорхойлох боломжгүй. Дэлхий нийтийн нөхцөл байдалд хууль гэхээсээ эрх зүйд илүү анхаарал хандуулах ёстой гэх үндэслэлийг хүлээн зөвшөөрч байгаа тул энэ үр дүнд хүрэхийн тулд ямар алхам хийх шаардлагатай вэ гэх асуултанд хариулт өгөх хэрэгтэй.

Хууль зүйн сургуулиуд нь бүх оюутнуудаа 21-р зуунд хууль эрх зүйн практикт тулгарч буй сорилтуудыг үр дүнтэй даван туулахад бэлтгэх эрх зүйн боловсрол эзэмшүүлэх үүрэгтэй. Энэ зорилгод хүрэх арга замууд дараах байдалтай байна:

1. Хуулийн сургуулиуд олон улсын болон харьцуулсан эрх зүйн хичээлээ илүү үр дүнтэй зааж онолын мэдлэг түгээх. Тухайлбал: оюутнуудад эдгээр чиглэлээр мэдлэг олж авах хэрэгцээг хангахын тулд хуулийн нэгдүгээр курст дээрх

онолын чиг баримжааг олгохоор хүчин чармайлт гаргах

2. Хуулийн сургуулиуд олон улсын болон харьцуулсан эрх зүйн голлох хичээлүүдийг заавал оруулахаар хөтөлбөртөө тусгах

3. Дээрх агуулга бүхий хичээлүүдийг бүрэн хөтөлбөрийн дагуу заах нөхцөл боломжоор хангах зэрэг⁵ болно.

II. Боловсролын шинэчлэл ба хуульчийн манлайлах ур чадвар

Шүүхийн тогтолцоонд хуульчийн мэргэжлийг цэцэглэн хөгжүүлэхийн тулд хууль зүйн тасралтгүй боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэдгийг дэлхий даяар хүлээн зөвшөөрч байна. Тасралтгүй үргэлжлэх хууль эрх зүйн боловсрол, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал нь хуульчийн ур чадварыг дээшлүүлэх үндсэн асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ үндэсний төдийгүй олон улсын хууль эрх зүйн талбарт болж буй үйл явцтай мэргэжлийн хүмүүсийг байнга хөл нийлүүлэн алхахад чухал ач холбогдолтой юм. Хуулийн мэргэжилтнүүд дэлхийн хамтын нийгэмлэгт тулгарч буй сорилтууд, орчин үед болж буй өөрчлөлтүүдийн талаар илүү гүнзгий ойлголт, мэдлэгтэй болсноор хуульчдын манлайллыг бий болгох боломж нөхцөл хангагдах болно.

Хуулийн агуулгыг чухалчлах сургалтаас гадна хөрвөх боломжтой

онолын мэдлэг, насан туршийн ур чадварт илүү их анхаарал хандуулах нь нэг шинэчлэл байх ёстой⁶. Өнөөдөр хуульчид маш олон талт ертөнцөд хуучирч хоцрох материаллаг хуулийн агуулгад хэт их анхаарал хандуулж, шаардлагатай өргөн хүрээний ур чадварт хангалттай анхаарч ажиллахгүй байна. Тиймээс манлайллын асуудлыг хууль зүйн боловсролын шинэчлэлийн хүрээнд оруулж ирэх нь хамгийн чухал.

Маргаашийн хуульчид өөрсдөө мэдлэг бий болгох, томоохон асуудлуудад дүгнэлт хийх, хиймэл оюун ухаан зэрэг технологийг илүү сайн хөшүүрэг болгож ашиглах шинэ загваруудыг бүтээж манлайллын ур чадвар, тэр дундаа цахим манлайлал эхлүүлэх хэрэгтэй болсон. Энэ нь үйлчлүүлэгчдэд илүү сайн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн үйлчилгээний төлбөрийг төлж чадахгүй байгаа нийгмийн томоохон хэсэгт чанартай сайн үйлчлэх шинэ боловсролын загварыг бий болгоход зайлшгүй үр нөлөөтэй.

Мөн хууль зүйн үйлчилгээг хүн амд аль болох үр ашигтай, хямд, хүртээмжтэй хүргэх шилдэг арга замыг олоход хуульчдын ур чадвар шаардлагатай. Сайн манлайлал, менежмент нь эцэстээ хуулийн үйлчилгээний гол тулгамдаж буй асуудлаас холдуулж, үйлчлүүлэгчдийг хууль ёсны дагуу эрүүл сэтгэлгээтэй байлгах, асуудлыг шийдвэрлэхийн тулд маргаан, шүүхийн хэлбэрийг ашиглахаас илүүтэй асуудлуудаас

⁵ 坂巻、文野、法学教育におけるコンピテンシー目標の設定に関する研究、学部と専門職大学院の比較を通して、2018年、33頁。

⁶ 佐藤、伸彦、「法教育に対する「法化」論の射程——裁判員教育との関係について、2017年、3月。

урьдчилан сэргийлэхэд үр дүнг чиглүүлэх боломжтой.

Хуулийн оюутнууд шинэ хууль эрхзүйнорчиндамжилттайхөгжихийн тулд технологийн мэдлэгтэй байх шаардлагатай. Энэ шалтгааны улмаас олон хуулийн сургуулиуд код бичих зэрэг ур чадварыг зааж эхэлсэн байна. Хуулийн салбар хуульчдыг үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн программ хангамж, шинэ мэдлэгийн бүтээгдэхүүн боловсруулахыг уриалж байна.

III. Хууль зүйн практикийн шинэ парадигмууд

Хуульчид цаашдаа илүү хурдан, хямд, илүү нарийвчлалтайгаар гаргалгаа гаргах өрсөлдөөнтэй тулгарах болно. Энэхүү шинэ орчинд өргөн хэмжээний мэдлэг, орчин үеийн онол сургаал, шүүмжлэлтэй сэтгэх чадвар чухал үүрэг гүйцэтгэнэ. Цахим харилцаа холбоо томоохон хэрэгсэл болсон нь хуульчдыг эрх зүйн харилцаагаа дахин тодорхойлж, цэгцлэх зохистой арга замыг эрэлхийлэхэд хүргэж байна. Энэхүү шинэ технологи нь асар их мэдээллийг бүх нийтэд хүртээмжтэй болгож, урьд өмнө байгаагүй хурдацтай хөгжиж, байнгын мэдлэг, мэдээллийн урсгалын байдалд оруулдаг⁷. Энэхүү зоригтой шинэ дижитал ертөнцөд урт удаан хугацаанд тогтсон хууль эрх зүйн баримт бичиг нь зөвхөн хязгаарлагдмал хэрэглэгдэх боломжтой болж хувирсан.

⁷ 教育基本法の「全面改正」案についての緊急意見書

Хуульчид байгалиасаа хуучинсаг үзэлтэй бөгөөд өнгөрсөн болон урьд өмнө тохиолдсон зүйлд анхаарлаа төвлөрүүлдэг. Тэд одоо байгаа тогтолцоонд амжилттай ажиллаж, хууль эрх зүйг нийгмийн хамгийн чухал институт гэж үздэг статусаа олж авахын тулд шаргуу ажилласан. Гэсэн хэдий ч ирээдүйн хуульчид инновацид илүү их анхаарал хандуулдаг соёлд суралцах ёстой. Ирээдүйг инноваци технологийн сэтгэлгээтэй цөөхөн хэдэн хүнд даатгах аргагүй. Хуулийн сургууль, хуулийн фирмүүд инновацийн соёлын ач холбогдлыг багш, оюутнууд, ажилчид, түншүүддээ ойлгуулах үүрэг гүйцэтгэх ёстой. Амжилтанд хүрсэн сургууль, ирээдүйн хуульчид инновацид суурилсан хууль зүйн шинэ соёлыг бий болгож, тогтвортой байлгах үүрэг хүлээх хэрэгтэй.

Хууль, хуульчийн үүрэг, үүргийн агуулгын хамаарал нь эрх зүйн боловсролын шинэчлэлийн ном зохиолд бий болсон таамаглалаар эргэлзээ төрүүлдэг болсон. Харин эрх зүйн онол сургаалыг хууль зүйн боловсролын төвд тавих нь танин мэдэхүйн чадвар, эрх зүйн шинжлэн судлалаас илүүтэйгээр дэвших боломжоор хангаж байна. Өнөөдрийн хуульчид хууль эрх зүйн үйл ажиллагааг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа гэдэгтээ сэтгэл хангалуун байж магадгүй. Гэхдээ хуульчид мэргэжлийн үүргээ биелүүлэхдээ юу хийх ёстой вэ гэдгийг дараах үедээ зөв ойлгуулах нь боловсролын шинэчлэлийн хүрээнд цаашид чухалчлах асуудал мөн.

Дүгнэлт

Хуульчийн ёс зүй нь үндсэндээ эрх зүйн үйл явц, мөн чанараас үүсдэг. Эрх зүйн боловсролын шинэчлэлийн ном зохиолд хуулийн сургууль, мэргэжлээр төгсөгчдөд буюу хуульч нарт ёс зүй, ёс суртахууныг төлөвшүүлэх талаар урам зоригтой атлаа бүрхэг сургамжуудыг өгөх нь бий. Хуулийн сургуулиуд хуулийн оюутнуудад хуулиас гадна ёс суртахууны үзэл баримтлалыг баримтлахыг заах ёстой гэдэг ч бодит байдал дээр энэ нь хэрэгжихгүй байна. Хуульчид ямар ёс суртахууны үүрэг хариуцлага хүлээхээс үл хамааран тэдний мэргэжлийн үүргийн ердийн эх сурвалж нь хууль эрх зүйн тогтолцооны агуулга, үйл явцаар тодорхойлогдож байгаа юм. Хэрэв хуульчид үйлчлүүлэгч нартаа хууль ёсны дагуу чадварлаг зөвлөгөө өгөх, өмгөөлөл үзүүлэхээс өөр ямар нэгэн илүү юу ч хийгээгүй бол тэд ёс суртахууны өндөр түвшинд хүрэх боломжтой. Өөрөөр хэлбэл хуульчдын эрх зүйн соёлыг боловсролын шинэчлэлээс гадна эрх зүйт ёсны төлөвшлөөс нь харах ёстой.

Дэлхий өөрчлөгдөж магадгүй, гэхдээ эрх зүйт ёсыг золиослохоор байвал өөрчлөлт бус зэвсэгт уриалга байх болно. Даяаршлын шинэ эрин үед хууль зүйн салбарт гарч буй өөрчлөлтүүд ийм золиослолд хүргэхгүй гэж найдаж байна. Эрх зүйн боловсролын шинэчлэлийг илүү шинэлэг, илүү өргөн цар хүрээтэй боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хийж чадна.

Эцэст нь хуулийн сургууль бүр өөрийн хамгийн том давуу тал гэж үзсэн боловсролын хөтөлбөрийн аль ч талыг чөлөөтэй боловсруулж, ашиглах боломжтой байх ёстой. Хуулийн сургууль бүр өөр бусад хуулийн сургуулийн «толин тусгал» болж өөрийгөө загварчлахыг хүсдэггүй байх ёстой. Хөтөлбөрийн зарим талыг бусдаас илүү онцолж, чадварлаг боловсролтой хуульч бэлтгэхэд шаардлагатай үндсэн сургалтын хөтөлбөрийг баримталснаар хуулийн сургууль бүр өөр өөрийн гэсэн байр сууриа олох боломжтой болдог.

Санал

1. Хуулийн салбарт шинээр хуульч болохоор элсэгчдийн тоог зохиомлоор хязгаарлах байдлаас татгалзах. Япон, Америк гэх улсуудад энэ талаар шүүмжлэл өрнөөд байна. Хуульчийн эрх авах хүсэл эрмэлзэлтэй байгаа хүмүүсээс шалгалт авахдаа хуульчдын тоог зохиомлоор хумих нь хуульчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн үнэ цэнийг гажуудуулж байна гэж үзсэн. Түүгээр ч барахгүй хуульчдын дунд өрсөлдөөн багасах эсвэл огт байхгүй болох эрсдэл дагуулдаг. Ингэснээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх нь эдийн засгийн маш үнэ цэнэтэй эрх болж өөрчлөгддөг сөрөг талтай.

2. Хуульчийн шалгалтад тэнцсэн бүх хүмүүс заавал урт хугацааны сургалтанд хамрагдах шаардлагатай байгаа нь сургалтын хөтөлбөрийн хүрээнд хууль зүйн талбарт нэгдмэл үзэл бодол, хандлагыг бий болгох эрсдэл дагуулдаг. Тиймээс заавал суух сургалтын багц цагийг багасгахаас гадна хөтөлбөр болон багш нарын тоо, хичээлийн сонголтыг нэмэгдүүлэх
3. Хуулийн сургууль бүр өөрийн сургалтын хөтөлбөрийг бий болгох, элсэлтийн стандартыг тогтоох, багш нарын томилгоо хийх, элсэх анги тус бүрийн оюутны тоог тогтоох эрх чөлөөтэй байх
4. Хуулийн сургуулиуд нь ирээдүйд ач холбогдолтой асуудлуудын талаар заах, хамгийн сүүлийн үеийн судалгаанд хамрагдах эрдэм шинжилгээний орон зайг хангах
4. Хуулийн сургуулиуд олон улсын болон харьцуулсан эрх зүйн хичээлээ илүү үр дүнтэй зааж онолын мэдлэг түгээх
5. Хуулийн сургуулиуд олон улсын болон харьцуулсан эрх зүйн голлох хичээлүүдийг заавал оруулахаар хөтөлбөртөө тусгах
6. Хуулийн агуулгад ач холбогдол хандуулахаас илүү хөрвөх боломжтой онолын мэдлэг, насан туршийн ур чадварт илүү их анхаарал хандуулах

Ном зүй

I. Ном, нэг сэдэвт бүтээл

1. Legal education reform needed to prepare 21st century lawyers. November 17, 2018.
2. Yves Dezalay, Bryant G. Garth. Battles Around Legal Education Reform: From Entrenched Local Legal Oligarchies to Oligopolistic Universals. India as a Case Study. 9-1-2018. 145 pp.
3. 北川善英. 「法教育」の現状と法律学.
4. 江口勇治「社会科における『法教育』の重要性」社会科教育研究68号(1993年), 同「社会科50年とこれからの教育改革」社会科教育研究79号(1998年), 同「アメリカの法教育の理論と実際」自由と正義2001年2月.
5. 坂巻, 文彩. 法学教育におけるコンピテンシー目標の設定に関する研究: 学部と専門職大学院の比較を通して. 2018年. 33頁.
6. 佐藤 伸彦. 法教育に対する「法化」論の射程 —裁判員教育との関係について. 2017年3月
7. 教育基本法の「全部改正」案についての緊急意見書.

II. Цахим эх сурвалж

1. https://highcourthd.gov.in/sub_pages/top_menu/about/events_files/GlobalSpeech.pdf
2. https://scholarship.law.upenn.edu/cgi/viewcontent.cgi?article=5833&context=penn_law_review
3. <https://scholarship.law.uci.edu/cgi/viewcontent.cgi?article=1020&context=ucijil>

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИАР ҮҮРЭГЖҮҮЛСЭН БОЛОН ҮҮРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ХЭМ ХЭМЖЭЭ НЬ ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЧУХАЛ ХЭСЭГ БОЛОХ НЬ



Шихихутуг их сургуулийн Хувийн
эрх зүйн тэнхимийн ахлах багш
Ё.Болормаа

ӨМНӨТГӨЛ:

Хөдөлмөрийн тухай хууль нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны ерөнхий буюу суурь хэм хэмжээг тогтоож, стандарт заалт¹ байдлаар хуульчлагдсан. Энэ нь тус салбарын онцлогтой холбоотой. Тус харилцаанд ажил олгогч, ажилтан талууд хамтран болон дангаараа, суурь хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн тус хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг нөхөн болон нарийвчилан зохицуулах зорилгоор байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг² батлан гаргах шаардлага хууль зүйн хувьд бий болдог. Энэхүү батлан гаргаж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь

¹ 2022/ Хөдөлмөрийн тухай хууль. ...илүүгүй /гэсэн заалт 21/, ...багагүй /гэсэн заалт 4/, ...доошгүй /гэсэн заалт 18/, ...үндэслэлээр /гэсэн заалт 23/ гэх мэт

² Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг өөртөө багтаасан ойлголт юм.

холбогдох хуулиар үүрэгжүүлсэн³ болон үүрэгжүүлээгүй⁴ хэлбэрээр хуульчлагдсан. Энэ нь хөдөлмөрийн хууль тогтоомжийн нарийвчилсан төдийгүй, чухал эх сурвалж болохыг тухайлсан байдлаар авч үзэхэд оршино.

Нэр томъёо,

Стандарт заалт, хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ⁵, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны бэлгийн дарамт, дарамт, хүчирхийлэл, хүний хувийн мэдээлэл

АГУУЛГА:

1. Хөдөлмөрийн тухай хуулиар үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний талаар авч үзэх нь,

2. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох талаар тухайлан авч үзэх нь,

³ Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогч заавал батлан гаргаж, мөрдсөн байвал зохих дүрэм, журам болон бусад хэлбэрээр илэрнэ.

⁴ Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогч заавал батлан гаргахыг үүрэгжүүлээгүй ч, тухайн аж ахуй нэгж байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн гаргах нь талуудын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эрх ашгийг хангахад чухал эрх зүйн акт байж болно.

⁵ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль, 4.1.10. "хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ" гэж хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо дагаж мөрдөхөөр холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн ажил олгогчоос бичгээр гаргасан баримт бичгийг;

1. *Хөдөлмөрийн тухай хуулиар үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний талаар авч үзэх нь,*

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь улсын, хувийн, холимог, иргэд хоорондын зэрэг олон салбарт, үйл ажиллагааны цар хүрээнээс хамаарч харилцан адилгүй үүсэж, өөрчлөгдөж, дуусгавар болохын зэрэгцээ зохицуулалтын нарийвчилсан аргыг шаарддаг онцлогтой. Зохицуулалтын арга нь⁶ тус салбарын харилцааг зохицуулах эх сурвалж болох хууль тогтоомжоор⁷ дамжин илэрдэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулалтын ерөнхий аргаар зохицуулах буюу хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, хөдөлмөр эрхлэлтийн салбарт нийтээр дагаж мөрдөх шинжтэй захиргааны хэм хэмжээний акт, салбар, салбар дундын хамтын хэлэлцээрээр зохицуулах нь ажил олгогч, ажилтан талуудын хувьд, салбар харгалзахгүйгээр

тоглоомын нийтлэг дүрэм, тухайлсан тохиолдолд тусгайлсан дүрэм байдлаар илэрдэг. Харин хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хөдөлмөрийн тухай хуулиар үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хэлбэрээр хуульчилсан гэж харж болох юм. Тухайлбал, үүрэгжүүлсэн заалтыг Хөдөлмөрийн тухай хуульд хуульчлагдсан байдлын хувьд авч үзвэл, ...үүрэгтэй⁸...дагаж мөрдөх үүрэгтэй⁹,...бүрдүүлэх үүрэгтэй¹⁰, ...байршуулах үүрэгтэй¹¹, ...ажлын

⁸ Тус заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд 53 байна.

⁹ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 2.4.Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй. /гэсэн заалт 1 байна/

¹⁰ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 6.3.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөлийг ажил олгогч бүрдүүлэх үүрэгтэй. Мөн 7.4. Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх үүрэгтэй. Мөн 31.6. Ажил олгогч хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд ажил олгогчоос шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. /гэсэн заалт 3 байна./

¹¹ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 6.6. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан гэж үзсэн хүн, ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. Гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. 7.3.Ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээд ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртсөн гэж үзвэл гомдлоо тухайн

⁶ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. Ажил олгогч, ажилтан

⁷ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 2.3 дахь заалт. Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.5-д зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилнэ:

2.3.1.энэ хууль;

2.3.2.Монгол Улсын бусад хууль;

2.3.3.захиргааны хэм хэмжээний акт;

2.3.4.салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;

2.3.5.хамтын гэрээ;

2.3.6.хөдөлмөрийн гэрээ;

2.3.7.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ.

2.4.Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг холбогдох талууд дагаж мөрдөх үүрэгтэй.

байраар хангах үүрэгтэй¹², ...баталж мөрдүүлнэ.¹³, ...хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.¹⁴, ...хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр

аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатны албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага...байршуулах үүрэгтэй. 33.5. Ажил олгогч хамтын гэрээ, тухайн аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэх хамтын хэлэлцээрийг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. 45.2.Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам, түүнд оруулсан өөрчлөлтийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Мөн 122.2. Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмыг шинээр баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болон хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заана.

¹² /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 43.2.3. энэ хуульд заасны дагуу хувь хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан шаардлага, стандартад нийцсэн, ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид ажлын байраар хангах

¹³ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 103.3. Ажил олгогч хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн цалин хөлсний талаар дараах хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг баталж мөрдүүлнэ.

103.3.1.ажил мэргэжлийн жагсаалт;

103.3.2.ажлын байрны тодорхойлолт;

103.3.3.энэ хуулийн 106.3-т заасантай нийцсэн хөдөлмөрийн норм, норматив;

103.3.4.цалин хөлсний журам.

122.1. Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

¹⁴ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 108.1. Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно. Мөн 109.6. Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.

зохицуулна.¹⁵, ...тогтоон мөрдүүлэх¹⁶, ...бодлого хэрэгжүүлнэ.¹⁷ гэх байдлаар илэрхийлэгджээ гэж үзэж болох юм. Эндээс холбогдох хуульд, ажил олгогч батлан мөрдүүлэхээр үүрэгжүүлсэн, дотоод хэм хэмжээг авч үзвэл, Хөдөлмөрийн тухай хуулийн 122.1. "Хөдөлмөрийн дотоод журам", 7.4. "Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам", 45.1. "Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам", 43.2.8 "Хяналтын төхөөрөмж байршуулж, ашиглах журам", 103.3. Ажил мэргэжлийн жагсаалт, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн норм, норматив, Цалин хөлсний журам, Нууцтай холбоотой журам зэрэг нь тухайн

¹⁵ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 100.2. Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. Мөн 139.1. Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

¹⁶ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 43.2.8. зайлшгүй шаардлагаар ажлын байранд хяналтын тоног төхөөрөмж ажиллуулах бол энэ тухай ажилтанд урьдчилан мэдэгдэх, ашиглах журмыг тогтоон мөрдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.15-д заасан ахуйн байранд хяналтын тоног төхөөрөмж байрлуулахгүй байх;

¹⁷ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 43.3. Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээ, ажилтнуудын тоо зэргээс шалтгаалан бие даасан байдлаар батлагдан мөрдөгдөх эсвэл хөдөлмөрийн дотоод журамд бүлэг байдлаар оруулан зохицуулагдах боломжтой.

Хөдөлмөрийн тухай хууль дахь үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь дараахь байдлаар илэрчээ гэж үзэх болох юм. Тухайлбал, ...эрхтэй¹⁸, ...баталж мөрдүүлж болно.¹⁹, ...байгуулж болно²⁰, ...баталж болно.²¹, ...тогтоож болно.²², ...олгож болно.²³,

¹⁸ Тус заалт нь Хөдөлмөрийн тухай хуульд 32 байна.

¹⁹ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 106.1. Ажил олгогч ажиллах хүчний тоог төлөвлөх, ажиллах хүчний тоог ажил, мэргэжлээр тогтоох, хийснээр цалин хөлс олгох зорилгоор хөдөлмөрийн норм, норматив баталж мөрдүүлж болно.

²⁰ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 49.3. Энэ хуулийн 49.1-д зааснаас гадна ажил үүргийн онцлогтой нь холбоотойгоор эд хөрөнгийн хариуцлагын, нууцын, сургалтын, үл өрсөлдөх зэрэг нэмэлт нөхцөлийг харилцан тохиролцож хөдөлмөрийн гэрээнд тусгах, эсхүл эдгээр асуудлаар хөдөлмөрийн гэрээнд дагалдах тусгайлсан гэрээ байгуулж болно. Мөн 14.4. Нийгмийн хоёр талт түншлэлийн хүрээнд дараах баримт бичгийг байгуулж болно:

14.4.1. салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;
14.4.2. хамтын гэрээ;

14.4.3. хууль тогтоомжид заасан бусад. /...байгуулж болно гэсэн заалт-19/

²¹ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 74.2. Аж ахуйн нэгж, байгууллагын нууц хадгалах, нууцтай харьцах журмыг ажил олгогч баталж болно.

²² /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 82.3. Хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр энэ хуулийн 82.1, 82.2-т заасан тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгохоор тогтоож болно. Мөн 109.9.Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно. /...тогтоож болно гэсэн заалт-6/

²³ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 100.1. Ажил олгогч ажилтны хүсэлтээр хувийн чөлөө олгож болно.

...тусгаж болно.²⁴, ...зохицуулж болно.²⁵, ...эвлэлдэн нэгдэх эрх²⁶ гэсэн заалтуудаас авч үзэхэд энэхүү ...ж болно гэсэн заалтууд нь...ж болохгүй ч байж болохыг бас хуулиар зөвшөөрчээ гэж үзэж болно. Практикт байгуулагдаж буй үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тухайлан авч үзвэл, Хамтын гэрээ, ...нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журам, Хувцас хэрэгсэл олгох журам, Хоол, унааны мөнгө олгох журам, Буцалтгүй тусламж олгох журам...гэх мэт. Аль ч тохиолдолд материаллаг болон процессын хэм хэмжээг тодорхой болгож байгаа нь хууль зүйн үр дагаварыг агуулна. Энэ нь талуудын хувьд хөдөлмөрлөх эрх, үүнтэй холбоотой хууль ёсны ашиг сонирхлыг хангаж, зохих түвшинд

100.2.Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. /...олгож болно гэсэн заалт-8/

²⁴ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 37.1.Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцох бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно. /ХТХ 37.1.1-37.1.11/

²⁵ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 107.2. Ажил олгогч, ажилтны төлөөлөгч харилцан тохиролцсон бол цалин хөлсийг аж ахуйн нэгж, байгууллагын болон салбар, салбар дундын түвшинд тус тус хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр зохицуулж болно. Мөн 125.4. Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан энэ хуулийн 125.1-д заасан нөхөн төлбөрийн хэмжээг индексжүүлэх асуудлыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулж болно.

²⁶ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 9.1. Ажилтан болон ажил олгогч аливаа байгууллага, албан тушаалтнаас зөвшөөрөл авахгүйгээр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо төлөөлөн хамгаалах байгууллага байгуулах, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаагаа явуулах, дүрмээ батлах, төлөөлөгчөө сонгох эрхтэй.

хөдөлмөр, нийгмийн баталгааны нарийвчилсан зохицуулалт болох юм. Хөдөлмөрийн тухай хууль нь материаллаг болон процессын агуулгатайгаас гадна процессын агуулга нь харьцангуй бага байдаг. Материаллаг төдийгүй процессын агуулгыг байгууллага дотооддоо бий болгох нь зайлшгүй зүйл.

Арваад жилийн өмнө хүний нөөцийг ажилтан авах, халах хүрээнд л ойлгодог байсан бол өдгөө бусад бүхий л нөөцийг удирдах, сайжруулах, хөгжүүлэх боломжтой чухал нөөц хэмээн харах болжээ. Энэхүү чухал нөөцийг зөв удирдахын тулд стратеги, бодлого зайлшгүй шаардлагатай. Хүний нөөцийн бодлого бол ямар ч байгууллагын гол "тоглоомын дүрэм" гэж ойлгож болно. Тоглоомын дүрмээ тодорхой болгоогүй цагт тоглогчид өөрийн дүрмээ зохиох гэх зэргээр эмх замбараагүй байдал үүсдэг.²⁷ гэжээ. Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хүний нөөцийн бодлогоос тусад нь авч үзэх боломжгүй. Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг ажил олгогч, ажилтан талууд тохирч тогтооно, дангаараа тогтооно. Практикт хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах зорилгоор батлан гаргаж, дагаж мөрдөж буй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг авч үзэхэд, материаллаг зохицуулалт нь ерөнхий бөгөөд нарийвчилсан зохицуулалт бага, хэрэгжих эсэх нь хоёрдмол утгатай, тодорхойгүй, зохицуулалтын

давхардал, хийдэлтэй, хэрхэн хэрэгжүүлэх процессын зохицуулалт тодорхойгүй, агуулгын бус, хэлбэрийн зохицуулалттай байдаг нь ажиглагддаг. Ийнхүү хэлбэрдсэн хөдөлмөрийн дотоод хэмжээ буюу байгууллага бүрт үйлчлэх эрх зүйн актууд нь тухайн байгууллагад ажиллаж буй ажилтнуудын эрхийг зөрчих, ажил олгогч, ажилтан талууд үл ойлголцох, байгууллагын соёл тогтоход асуудал үүсэх, шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалт үүсэхийг үгүйсгэх боломжгүй.

Тухайн аж ахуй нэгж байгууллагууд үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг хуульд нийцүүлэн бий болгох нь талуудад давуу болон сул талтай байх нь бий. Тухайлбал, *Үүрэгжүүлсэн эрх зүйн актын хувьд*, 122.1. "Хөдөлмөрийн дотоод журам" нь хэт ерөнхий байх /...бэлгийн дарамтад өртсөн бол байгууллагын хүрээнд хэнд хандах нь тодорхойгүй байх, өртсөн болон өртүүлсэн ажилтны нууцлал хадгалагдах нь тодорхойгүй байх мөн тухайн байгууллагын ажлын цагийг ХтХ-д зааснаар ойлгоно... гэх мэт стандарт заалтаар ойлгож болохоор заах, холбогдох журмаар тодорхойлсон үүрэг ...гэх мэт гэж задгай заагдсан байдал зэрэг/, хэт нарийвчилсан байх /...ажлаас чөлөө авахдаа хэнд хандах, хэрхэн мэдэгдэх нь тодорхойгүй байх эсвэл шат дамжлага ихтэйгээр чөлөө авах, ...заавал биечлэн, бичгээр чөлөө авах, чөлөөний хүсэлтийг

²⁷ <https://business.mn/2021/07/12/hunii-nuutsuu-sistemchlehu-arguud/>

өөрийн биеэр авчирч өгөх...гэх мэт/ Харин үүрэгжүүлээгүй эрх зүйн актын хувьд, Тухайлбал, ...Хамтын гэрээ...²⁸ нь байгууллагад санхүү мөнгөний асуудал үүсгэж болох ч, нийт ажилтнуудын ажлын бүтээмж, тогтвор суурьшил төдийгүй нийгмийн баталгааг хангахад чухал хэрэгсэл нь болдог. Дурьдсан эрх зүйн актууд нь байгууллагуудын хувьд заавал байх, байх нь зохистойн учир дурьдлаа. Байгууллагуудын хувьд дотооддоо ямар эрх зүйн актуудыг бий болгох нь харилцан адилгүй байдаг. Энэ нь тухайн байгууллагын бодлого, үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах хууль тогтоомж нь ерөнхийгөөс тусгайруу чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн тухай хууль²⁹, хөдөлмөрийн дотоод журам³⁰, Хамтын гэрээ³¹, хөдөлмөрийн гэрээ³²... байдлаар харж болно. Эдгээр эрх зүйн баримт бичиг нь хөдөлмөр эрхлэлтийн

хүрээнд түгээмэл бөгөөд бусад хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хувьд зохицуулалт нь, чөлөөтэй, нээлттэй юм. Үүрэгжүүлээгүй эрх зүйн актын цаана хөдөлмөр, нийгмийн баталгааг бий болгохтой холбоотой /ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой/ асуудал нарийвчилсан зохицуулалтгүй, тодорхойгүй байдлаар үлдэх магадлалтай. Практикт хамтын гэрээгүйгээр³³, бусад эрх зүйн актаар нийгмийн баталгааг хангах зохицуулалт хийх нь байдаг. Гэвч энэ нь эрх зүйн үр дагаварын хувьд харилцан адилгүйг анхаарах нь зүйтэй. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд нөхөн болон нарийвчилсан зохицуулалтыг үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй эрх зүйн актын хүрээнд зохицуулалт хийхгүйгээр хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой хууль ёсны ашиг сонирхол баталгаатай хангагдах боломжгүйн зэрэгцээ ажип олгогч талд ч эрх зүйн үр дагавар үүсгэх талтай. Холбогдох дотоод хэм хэмжээ нь хууль тогтоомжийн хэрэглээний хувьд нарийвчилсан эх сурвалж нь болно.

2. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг³⁴ хориглох

²⁸ /2022/ Хөдөлмөрийн тухай хууль. 4.1.7. "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажип олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог; /Энд 2 зорилго агуулагдаж буйг харж болно/

²⁹ Монгол улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж буй бүхий л субъектэд хамааралтай.

³⁰ Зөвхөн тухайн байгууллагын нийт ажилтнуудад хамааралтай. /дэг журмын тогтоох/

³¹ Зөвхөн тухайн байгууллагын нийт ажилтнуудад хамааралтай. /хөдөлмөрлөх эрх ашиг, нийгмийн баталгааг хангаж, хамгаалах/

³² Зөвхөн ажип олгогч, ажилтанд хамааралтай. /2 субъект хоорондын тухайлсан харилцааг нарийвчилсан зохицуулах/

³³ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл. 101 дэхь тал. /Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 60 орчим хувь нь хамтын гэрээ, хэлэлцээргүй байв. Энэ нь тэдгээр байгууллагад Үйлдвэрчний эвлэл байхгүйтэй холбоотой юм гэжээ./

³⁴ Холбогдох асуудлууд нь хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд харилцан адилгүй зохицуулалт шаардлагатай төдийгүй, хууль зүйн өөр өөр үр дагавартай.

талаар тухайлан авч үзэх нь,

Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ерөнхий хуульд нийцүүлэн нөхөн болон нарийвчилсан байдлаар зохицуулж болох үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний талаар авч үзлээ. Энэхүү эрх зүйн актуудын нэг болох “Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”-ыг тухайлсан байдлаар авч үзье. Энэ нь үүрэгжүүлсэн баримт бичгийн нэг бөгөөд энэ нь байгууллагын ёс зүйн зөвлөлийн онцгой харъяалалд байх төдийгүй холбогдох асуудлын талаар эрсдлийн үнэлгээ хийх, хүний хувийн мэдээллийг хамгаалах асуудлын хүрээнд, гомдол гаргагчийн нууцлалыг хадгалах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд болон өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх, тухайн ажилтны амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээллийг аливаа хэлбэрээр түгээхийг хориглох, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх хугацаанд хүчирхийлэлд өртсөн гомдол гаргагчийг хамгаалах механизмыг тухайн байгууллага бүрдүүлж ажиллах шаардлагатай. Талан Мишра НҮБ-ын Суурин төлөөлөгч /2022/, Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн

дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргазүйн зөвлөмж /2020/-д ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярьж мэдээлэх нь хүнд сэдэв тул энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн бүртгэгдсэн байдал бодит байдлаас бага байдаг. Учир нь мэдээлэл өгсөн этгээдийг хамгаалах эрх зүйн зохицуулалт сул байдагтай холбоотой. Мөн ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтын талаар Монгол улсад хууль, эрх зүйн зохицуулалт хангалттай байдаг ч хэрэгжилт хангалтгүй хэвээр байгааг иргэд, олон нийт, төр, төрийн бус байгууллага, судлаач, шинжээчид анхааруулсаар байна гэжээ. Эндээс “Ажлын байрны дарамт, бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох, арилгах, холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам”-ыг хэлбэрийн бус, агуулгын зохицуулалт хийх шаардлагатайг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжид ажлын байрны дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг зохицуулсан байдлын зөрчлийг онолын үүднээс ялгаж таних нь чухал. Энэ төрлийн хэрэг цөөн бүртгэгддэг шалтгаан нь тухайн хүний хувийн мэдээлэл, түүний нууцлалтай холбоотой³⁵ бөгөөд хохирогчид ажлаас халагдахаас, тушаал бууруулахаас, ойр дотныхон нь энэ талаар олж мэдэхээс сэтгэл нь зовж, тухайн зөрчлийн талаар

³⁵ Dobbin, Kalev 2020

мэдээлдэггүй байна.³⁶ Мэдээлдэг болгоход нарийвчилсан эрх зүйн орчныг ажил олгогчийн зүгээс бий болгох нь чухал. Холбогдох асуудлын хүрээнд эрх зүйн зохицуулалт нь, Монгол улсын олон улсын холбогдох гэрээнүүд, олон улсын конвенц, түүнчлэн Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" засгийн газрын тогтоол зэрэгт ажлын байрны бэлгийн дарамтын талаар тусгажээ. 2021 онд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага болон тархалтын байдлын судалгаа"-гаар дийлэнх ажиллагсад АББД-ын талаар мэдлэг багатай буюу юуг бэлгийн дарамт гэж ойлгох, эрх зүйн зохицуулалтуудын талаар мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.³⁷ байсантай холбоотоогоор тухайн чиглэлийн сургалтыг зохион байгуулах нь зүйн хэрэг.

АНУ-ын Иргэний эрхийн Акт (1964)-ийн 7-р хэсэгт ажлын байранд хүнийг яс үндэс, арьсний өнгө, шашин шүтлэг болон хүйсээр нь ялгаварлан гадуурхахыг хориглодог³⁸. Үүнд хүйсэнд

суурилсан дарамт хүчирхийлэл нь холбогдох хэсгийн 703-ийг зөрчсөн үйлдэл буюу хууль зөрчсөн үйлдэл хэмээн тодорхойлжээ.³⁹ АНУ-ын 1974 оны Нууцлалын Акт⁴⁰-аар хувь хүний нууцыг хамгаалдаг. Гэхдээ практикт⁴¹ ажил олгогч болон ажилтан хоёрын бэлгийн дарамттай холбоотой асуудлыг нууцлалын гэрээгээр зохицуулах тохиолдолд ч байдаг ажээ.⁴² Энэхүү нууцлалын гэрээ хохирогчийн мэдээллийг нууцлах, хохирогчид мөнгөн болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх зэргээр сайн талууд байж болох ч ⁴³ бэлгийн дарамт үйлдэгчийн үйлдлийг нуун дарагдуулах, цаашид гарах энэ төрлийн хэргийг өдөөх сөрөг талтай. ⁴⁴ гэж үзсэн байна. Төрийн захиргааны албан хаагчдын дунд ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн тохиолдолд гомдол гаргаж, асуудлаа шийдвэрлүүлэх талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох зорилготой «Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага, зан үйлийн төлөв байдлын судалгаа»-⁴⁵ гаар нийслэл,

³⁶ Холбооны дүрмийн Код 2016

⁴⁰ Privacy Act, 5 U.S.C. § 552a

⁴¹ 2017 онд олон нийтийн анхаарлыг АББД, бэлгийн дарамт сэдэвт хандуулж өгсөн үйл явдал бол АНУ-ын кино продюссер, Мирамакс компаний үүсгэн байгуулагч Харви Вейнштейнтэй холбоотой бэлгийн дарамт, хүчин, бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг юм. Шүүхээс түүнийг гэм буруутайд тооцон 23 жилийн хорих ял өгсөн ба энэ үйл явдлаас улбаалан олон алдартан, бизнесменүүдийн бэлгийн дарамттай холбоотой асуудлууд ил болжээ.

⁴² Altman 2020

⁴³ Martin 2017

⁴⁴ Altman 2020

⁴⁵ Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Төрийн албаны

³⁶ Johnson et al 2016

³⁷ ТА3-ын судалгаа 2021

³⁸ АНУ-ын Тэгш хөдөлмөрлөх боломжоор хангах Комисс 2022

орон нутгийн төрийн захиргааны байгууллагын 3000 орчим эмэгтэй албан хаагчийг хамруулжээ. Судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь «Ажлын байрны бэлгийн дарамтад нэг болон түүнээс удаа өртдөг, өртөж байсан» гэж хариулсан нь энэ төрлийн дарамтын эсрэг хууль зүйн нарийвчилсан зохицуулалт шаардлагатайг илэрхийлжээ гэж үзэж болохоор байна.

1998 онд Испаний худалдаа, үйлдвэрчний эвлэлээс зохион байгуулсан Пандоратөслийн хүрээнд Испани, Ирланд, Швед улсууд дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажлын байрны нөхцөл байдал, бэлгийн дарамттай холбоотой судалгаа хийсэн нь олон төрлийн ажил, ялгаа бүхий албан тушаалтай хүмүүсийг хамарсан томоохон судалгаа болсон төдийгүй энэхүү судалгаагаар бэлгийн дарамттай холбоотой хэргүүдийн үндэс суурь нь байгууллагын соёл, ёс зүйн дүрэм, урамшууллын системтэй холбоотой бөгөөд хууль, журмууд нь дангаараа асуудлыг шийдэхгүй байна гэсэн дүгнэлт гарчээ. Түүнчлэн уг төслийн дүгнэлтэд Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн болон Эрүүгийн хууль тогтоомжийг эхлэн харахаасаа өмнө байгууллага нь өөрийн дотоод дүрэм, журмаараа АББД-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах

нь илүү үр дүнтэй гэжээ.⁴⁶ Ийнхүү Монгол улсын хувьд ч хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хүрээнд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамттай холбоотой материаллаг болон процессын нарийвчилсан хэм хэмжээг бий болгох нь зүйтэй.

Дүгнэлт, Хөдөлмөр эрхлэлтийн харилцаан дахь суурь хууль нь хөдөлмөрийн харилцааг нарийвчилан зохицуулах боломжгүй.⁴⁷ Тиймээс тус хуулиар үүрэгжүүлсэн болон үүрэгжүүлээгүй хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг зөвшөөрсөн нь ажил олгогч болон ажилтан талуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг нөхөн болон нарийвчилан зохицуулсан эрх зүйн актуудаар илэрдэг. Энэ нь ажил олгогчоос хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон шүүхээс хэрэглэх нарийвчилсан эх сурвалж болно.

⁴⁶ Chappell & Martino 2006

⁴⁷ Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хуулиар ...ноцтой зөрчлийн улмаас ажил олгогч ажилтныг ажлаас нь халдаг. Харин ноцтой зөрчил гэдэгт ямар зөрчлийг ойлгох асуудлыг байгууллага холбогдох дотоод хэм хэмжээгээрээ нарийвчилан бий болгох шаардлага тулгардаг. Өөрөөр хэлбэл, ноцтой зөрчил гэж үзэх, үзэхгүй байх асуудал нь байгууллага бүрт өөр өөр байж болно.

зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төслийн хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс "Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн" ТББ-тай хамтран гүйцэтгэсэн судалгааны тайлан, 2021 он.

ХҮНИЙ ГЕНЕТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЗАРИМ УЛС ОРНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Шихихутуг их сургуулийн докторант
Ц.Амарсанаа

ОРШИЛ

Генетикийн шинжилгээ нь эмнэлгийн оношилгоо, анагаах ухааны судалгааны чухал хэсэг болж байна. Хэд хэдэн үйлчилгээ үзүүлэгч, лабораториудаар дамжуулан оношилгоо, судалгааны хүрээнд өргөн олон нийтэд санал болгож байгаа төдийгүй хэрэглэгчдэд шууд генетикийн шинжилгээ хийж, амьдралын хэв маяг, өвөг дээдсийн гарал үүслийн талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэдэг. Ёс суртахууны болон хууль эрх зүйн асуудлуудыг хөндөж, генетикийн шинжилгээг хүний анагаах ухаанд онцгой бөгөөд маш маргаантай сэдэв болгосон. Сүүлийн жилүүдэд Швейцарь, Герман зэрэг Баруун Европын хэд хэдэн улсууд генетикийн шинжилгээтэй холбоотой асуудалд шууд зориулагдсан хууль тогтоомжийг баталж, хүний хувийн генетик мэдээллээр хувь хүнийг хамгаалахад анхаарлаа хандуулж байна.

Олон улсын уг хандлагань төрөөс өөрсдийн хууль тогтоомжийг батлан гаргаж байгаа нь хүний генетикийн талаарх онц ач холбогдолтой зүйл гэдэг илэрхийлж буй хэрэг юм. Энэ талаар олон улсын түвшинд хүний удмын сантай холбоотой дараах олон улсын гэрээ, тунхаглалууд байна. Тухайлбал: Нэгдсэн Үндэстний байгууллагын 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹, Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагоягийн протокол, Нэгдсэн Үндэстний байгууллагын 1997 оны Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал², Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал³, Хүний генетикийн мэдээллийн олон улсын тунхаглал⁴ Био ёс зүй ба хүний эрхийн түгээмэл тунхаглал⁵ Олон улсын томуугийн хяналт ба

¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/1271>

² 1997 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар био ёс зүйн салбар дахь цорын ганц олон улсын баримт бичиг болох "Хүний геном ба хүний эрхийн түгээмэл тунхаглал"-ыг баталсан бөгөөд уг баримт бичгийг 1998 онд НҮБ-ын Ерөнхий ассамблей дахин баталсан. Эх сурвалж: <https://unesco.mn/mn/social-human-sciences/programmes/ethics/>

³ Universal Declaration on the Human Genome-1998. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights>

⁴ International Declaration on Human Genetic Data-2003. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000136112>

⁵ Universal Declaration on Bioethics and Human Rights- 2005. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC226192/>

авах арга хэмжээний тогтолцоо гэх зэрэг олон улсын гэрээ, тунхаг бичгүүд байна.

Энэхүү судалгаанд бид Европын улс орнуудын ерөнхий зохицуулалт, түүнчлэн зарим улс орны генетикийн шинжилгээний талаарх тусгай хууль тогтоомжуудыг хамруулан авч үзлээ. Улс орнуудын хувьд генетикийн шинжилгээ, шинжилгээний хүрээнд үүрэг хариуцлагын хуваарилалт, түүнчлэн оношилгооны болон генетикийн шинжилгээний гүйцэтгэл, генетикийн дээжтэй харьцахтай холбоотой зохицуулалтыг дүн шинжилгээ хийв. Мөн генетикийн шинжилгээний үр дүнг хэрхэн хүргэх, генетикийн мэдээллийг хэрхэн хамгаалах талаар улс орон бүрд генетикийн зөвлөгөөг хэрхэн зохион байгуулдаг талаар дүгнэлт хийнэ.

ЗАРИМ УЛС ОРНЫ ГЕНЕТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

Европын холбоо

Европын холбоо нь генетикийн шинжилгээг хуулиар шууд авч үздэггүй. Зарчмын хувьд Европын парламент болон Европын зөвлөл нь «Европын Холбооны үйл ажиллагааны гэрээ»-ний дагуу гишүүн орнуудын үндэсний хууль тогтоомжид хэрэгжүүлэхийг шаарддаг удирдамжийг тогтоодог⁶. Европын генетикийн шинжилгээний ерөнхий аюулгүй байдлыг 1998

оны 98/79/ЕС удирдамжид тусгасан болно⁷. Цаашилбал, 1998 онд генийн туршилтыг патентжуулж болох нөхцөлд хамаарах биотехнологийн шинэ бүтээлийн хууль эрх зүйн хамгаалалтын тухай 98/44/ЕС удирдамжийг ЕХ-ны бүх улс орнууд хэрэгжүүлсэн⁸. Мэдээллийн аюулгүй байдлын тухайд Европын парламент болон Европын зөвлөлийн 95/46/ЕС заавар нь хувийн мэдээлэл боловсруулах үйл явцыг зохицуулдаг бөгөөд генетикийн өгөгдөлд ч мөн адил хамаарна⁹.

1997 онд Биологи, анагаах ухааныг ашиглахтай холбоотой хүний эрх, нэр төрийг хамгаалах тухай конвенцод гарын үсэг зурсан. Энэ нь «хүний нэр төр, эрх, эрх чөлөөг хамгаалах» зорилгоор биологи, анагаах ухааны ололт амжилтыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой анхны хууль ёсны хүчинтэй олон улсын гэрээ юм. Энэхүү конвенц нь урьдчилан таамаглах генетикийн шинжилгээ, зөвшөөрөл, хувийн нууцын зохицуулалт, түүнчлэн эмнэлгийн судалгаа зэрэг томоохон салбаруудыг хамардаг боловч жишээлбэл, даатгал, хөдөлмөр

⁷ Directive 98/79/EC of the European parliament and of the council of 27 October 1998 on in vitro diagnostic medical devices. Off J Eur Communities 1998; 331:1–37.

⁸ Directive 98/44/EC of the European Parliament and of the Council of 6 July 1998 on the legal protection of biotechnological inventions. Off J Eur Communities 1998;213:13.

⁹ Directive 95/46/EC of the European Parliament and of the Council of 24 October 1995 on the protection of individuals with regard to the processing of personal data and on the free movement of such data. Off J Eur Communities 1995;281:31–50.

⁶ The Treaty on the Functioning of the European Union. Off J Eur Union 2012;326.

эрхлэлт, эрүүгийн асуудлыг оруулаагүй болно¹⁰. 11-р зүйлд зааснаар хувь хүнийг удамшлын шинж чанараар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно. 11-14 дүгээр зүйлд зааснаар генетикийн шинжилгээг зөвхөн эрүүл мэндийн зорилгоор хийж, генетикийн "зохистой" зөвлөгөө өгөх ёстой.¹¹

2008 онд Европын Зөвлөлийн био-этикийн Удирдах хорооноос уг конвенцод нэмэлт протоколыг оруулсан бөгөөд уг нэмэлтээр эрүүл мэндийн зорилгоор генетикийн шинжилгээ хийлгэх, генетикийн зөвлөгөө өгөх тодорхой заалтуудын талаарх урьдчилсан мэдээлэл, зөвшөөрөл, оношилгоо, өвчний урьдач нөхцөл байдал болон тээвэрлэгчид тавигдах шаардлагыг нөхөн зохицуулсан¹².

Генетикийн үйлчилгээний чанарын баталгааг 5-р зүйлд дурдсан бөгөөд зөвхөн шинжлэх ухааны үндэслэлтэй батлагдсан «эмнэлзүйн ашиг тус» байгаа тохиолдолд генетикийн шинжилгээг хийх ёстой гэж заасан байдаг (6-р зүйл). Сонирхолтой нь, 7-р зүйлд «эрүүл мэндийн зорилгоор генетикийн

шинжилгээг зөвхөн эмчийн хяналт дор хийж болно» гэж заасан байдаг. Энэхүү шаардлага нь үндсэндээ зөвхөн эмчээр дамжуулан үйлчилгээ үзүүлэхийг шаарддаг¹³. Өнөөг хүртэл нэмэлт протоколд Франц, Исланд, Португал зэрэг ЕХ-ны гишүүн 9 улс гарын үсэг зурсан боловч зөвхөн 4 нь (Молдав, Монтенегро, Норвеги, Словени) соёрхон баталсан¹⁴.

Европын Комисс нь ЕХ-ны гүйцэтгэх байгууллагын хувьд «Европ даяар генийн шинжилгээний үйл явц, дээж авахаас эхлээд зөвлөгөө өгөх хүртэлх үйл явцыг уялдуулах» зорилгоор EuroGentest платформыг санхүүжүүлж, генетикийн лабораториуд, эрүүл мэндийн мэргэжилтнүүд болон олон нийтэд хэрэгтэй мэдээллээр хангадаг. Энэхүү веб хуудсанд итгэмжлэл, баталгаажуулалтын асуудлуудын тоймыг өгч, дадлагын удирдамж, семинар, багаж хэрэгсэл, лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог жагсаасан болно. Эмч нарын хувьд энэхүү платформ нь Европын янз бүрийн улс орнуудын ёс зүй, хуулийн баримт бичиг, Европ дахь өвчтөний эрхийн хууль тогтоомж, генетикийн зөвлөгөө өгөх зааварчилгаа зэрэг олон төрлийн эх сурвалжийг өгдөг. Мөн

¹⁰ Varga O, et al: Definitions of genetic testing in European legal documents. J Community Genet 2012;3:125-141.

¹¹ Council of Europe, T. O. Convention for the protection of Human Rights and Dignity of the Human Being with regard to the Application of Biology and Medicine: Convention on Human Rights and Bio- medicine. Eur Treaty Ser – No. 164, 1997.

¹² Varga O, et al: Definitions of genetic testing in European legal documents. J Community Genet 2012;3:125-141.

¹³ Grimaldi KA, et al: Personal genetics: regulatory framework in Europe from a service provider's perspective. Eur J Hum Genet 2011;19:382-388.

¹⁴ Council of Europe, T. O. Additional Protocol to the Convention on Human Rights and Biomedicine concerning Genetic Testing for Health Purposes. Counc Eur Treaty Ser – No. 203, 2008.

Европын генийн тест нь удамшлын болон генетикийн шинжилгээний талаар өвчтөнүүдэд зориулсан ерөнхий мэдээллийг агуулсан 15 өөр хэлээр цуврал ухуулах хуудас боловсруулжээ¹⁵.

Герман

2009 онд ХБНГУ-ын Холбооны парламент эрүүл мэндийн оношилгоо, удам угсаа тодорхойлох салбар, мөн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн салбарыг багтаасан Хүний генетикийн шинжилгээний тухай хуулийг (GenDG) баталсан. Энэ нь генетикийн шинжилгээ, генетикийн шинжилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох, удамшлын шинж чанараар ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх зорилготой юм. "Хүний нэр төрийг хамгаалах, хувь хүний өөрийгөө тодорхойлох эрхийг хангалттай мэдээллээр хангах" төрийн үүргийг эхэн хэсэгт тусгажээ.

ХБНГУ-д оношилгооны генетикийн үзлэгийг индексийн хүний бичгээр болон мэдээлэлтэй зөвшөөрлийн үндсэн дээр ямар ч эмч хийж болно. Гэсэн хэдий ч урьдчилан таамагласан генетикийн үзлэг, генетикийн зөвлөгөөг хүний генетикийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтнүүд эсвэл тусгайлан бэлтгэгдсэн эмч нар хийх ёстой. 3-р зүйлд зааснаар «генетикийн шинжилгээ» гэж генетикийн шинжилгээнд чиглэсэн аливаа үзлэг эсвэл жирэмсний эрсдэлийн үнэлгээний арга хэмжээ

гэж тодорхойлсон.

Биологийн дээжийн генетикийн шинжилгээг зөвхөн хариуцсан эмч эсвэл «хариуцсан эмчийн томилсон хүн, байгууллага» генетикийн шинжилгээний явцад зөвшөөрдөг. Гадаадаас шууд хэрэглэгчдэд зориулсан шинжилгээ авсан өвчтөнүүдийг торгууль ногдуулахгүй¹⁶.

Генетикийн шинжилгээнд зориулж авсан биологийн дээжийг зөвхөн анхны зорилгоор ашиглаж болох бөгөөд дараа нь шууд устгах ёстой.

Оношилгооны үр дүнг тодорхойлсны дараа шинжилгээнд хамрагдсан хүнд генетикийн зөвлөгөө өгөх шаардлагатай бөгөөд энэ нь хууль ёсны шаардлага юм. Урьдчилан таамаглах болон ургын (пренатал) генетикийн шинжилгээний хувьд шинжилгээний өмнө болон дараа нь генетикийн зөвлөгөө авах шаардлагатай. Холбогдох шинжилгээний үр дүнг зөвхөн хариуцлагатай эмч эсвэл генетикийн зөвлөх өвчтөнд шууд мэдэгдэнэ. Шинжилгээ хийх эрх бүхий хүн, байгууллага байсан бол үр дүнг зөвхөн түүнийг захиалсан этгээдэд мэдээлж болно. Генетикийн шинжилгээ, шинжилгээний хариуг хариуцагч эмнэлгийн ажилтан 10 жилийн дараа хадгалж, устгах ёстой¹⁷.

¹⁶ Borry P, et al: Legislation on direct to consumer genetic testing in seven European countries. Eur J Hum Genet 2012;20:715–721.

¹⁷ German Federal Parliament. Human Genetic Examination Act (Genetic Diagnosis Act –

¹⁵ German Federal Parliament. Human Genetic Examination Act (Genetic Diagnosis Act – GenDG), 2009.

Швейцарь

2004 оны Хүний генетикийн шинжилгээний тухай Холбооны хууль нь Швейцарь дахь генетикийн шинжилгээний эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. ХБНГУ-ын GenDG нь зорилго, хамрах хүрээний хувьд энэхүү хуулийн агуулгатай маш төстэй байдлаар баталсан. Энэ нь хүний нэр төр, хувийн шинж чанарыг хамгаалах, чанарын баталгааг хангах, удамшлын мэдээллийг зүй бусаар ашиглах, генетикийн шинжилгээ хийхээс зайлсхийхэд чиглэгддэг. Энэхүү хууль ёсны мэдэгдэл нь эрүүл мэндийн оношилгоо, удам угсаа тодорхойлох, түүнчлэн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн асуудалд генетикийн шинжилгээ хийх үндсэн удирдамжийг агуулдаг¹⁸.

Генетикийн шинжилгээ, түүнчлэн оношилгооны генетикийн шинжилгээний дарааллыг хууль ёсны зөвшөөрлийн үндсэн дээр ямар ч Швейцарын эмч хийж болно. Гэсэн хэдий ч урьдчилан таамаглах туршилтын тухайд зөвхөн генетикч эсвэл тусгайлан бэлтгэгдсэн эмнэлгийн эмч үүнийг зохион байгуулахыг зөвшөөрдөг. Түүнчлэн Швейцарьт генетикийн дээжийг зөвхөн анхны зориулалтаар нь ашиглаж, дараа нь устгадаг.

ХБНГУ-тай харьцуулбал шинжилгээний хариуг генетикийн зөвлөгөө өгөх замаар индексжүүлсэн хүнд мэдээлэх ёстой. Урьдчилан таамаглах болон ургын (пренатал) GenDG), 2009.

¹⁸ Federal Assembly of the Swiss Confederation. Federal Act on Human Genetic Testing, 2004.

генетикийн шинжилгээний хувьд шинжилгээний өмнө болон дараа нь генетикийн зөвлөгөө өгөх шаардлагатай.

Уг хуулийн шинэчилсэн найруулгад боловсруулагдаж байгаа бөгөөд энэ хүрээнд шууд генетикийн шинжилгээ хийхтэй холбоотой зохицуулалтууд хийгдэж байна. Тухайлбал, эмч, эм зүйч нь биеийн тамир, үндэс угсаа зэрэг шинж тэмдгүүдийн генетикийн шинжилгээнд хамрагдана. Цаашид мөн удамшлын бус генетикийг (жишээ нь, хавдрын шинж чанарыг) оруулах ёстой¹⁹.

Франц

Францад иргэний эрх зүйн байдлыг Иргэний хуулиар тодорхойлогддог бөгөөд үүнд «Хүний генетикийн шинж чанарыг шалгах, түүний генетикийн хурууны хээгээр хүнийг таних» тусгай бүлэг байдаг (зүйл 16-10-аас 16-12). Францын Нийгмийн эрүүл мэндийн хуулийн дагуу генетикийн өвчнийг оношлох, хөгжиж буй өвчин үүсгэж болзошгүй нэг буюу хэд хэдэн генийн шинж чанарыг тодорхойлох шинжилгээний зорилготой байх ёстой. Харин «мэдээлэл олж авах» зорилгоор генетикийн шинжилгээ хийхийг хориглодог²⁰.

Нэмж дурдахад, 2011 оны шинэчилсэн Францын Био-этикийн

¹⁹ Federal Assembly of the Swiss Confederation. Revision of the Federal Act on Human Genetic Testing, 2016.

²⁰ Borry P, et al: Legislation on direct-to-consumer genetic testing in seven European countries. Eur J Hum Genet 2012;20:715–721.

тухай хуульд Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн нөхцөлөөс гадуур генетикийн шинжилгээ хийхийг хориглож, холбогдох шийтгэл, нэг жил хорих, 15,000 еврогийн торгууль ногдуулахыг Францын эрүүгийн хуульд тусгасан.

Францад ерөнхийдөө генетикийн шинжилгээг зөвхөн эрүүл мэндийн болон шинжлэх ухааны судалгааны зорилгоор ашиглахыг зөвшөөрдөг. Зөвхөн ахлах эмч нар удамшлын шинжилгээг захиалж болох бөгөөд индексжүүлэгчээс бичгээр мэдээлэл өгөх зөвшөөрөл авах үүрэгтэй. Гэсэн хэдий ч шинж тэмдэггүй эсвэл урьдчилан таамаглах шинжилгээг зөвхөн Францын эрүүл мэндийн байгууллагууд зарлаж, хүлээн зөвшөөрсөн олон талт багууд захиалж болно. Эдгээр багуудад генетикч эсвэл өвчний эмч, генетикийн зөвлөх, сэтгэл зүйч багтдаг.

Геномын ДНХ нь генетикийн шинжилгээ хийсний дараа дор хаяж 10 жил хадгалагдах ба хугацааны талаар тодорхой зохицуулалтгүй байна. Шинжилгээ өгсөн тухайн хүн хэдий ч хүссэн үедээ дээжийг устгахыг хүсэх эрхтэй байдаг.

Францад генетикийн зөвлөгөө өгөх нь бүх төрлийн генетикийн шинжилгээнд заавал байх ёстой бөгөөд шинжилгээ өгөхөөс өмнө захиалагч эмч эсвэл эмчтэй хамтран ажилладаг генетикийн зөвлөхөөр хийлгэх ёстой. Захиалга өгсөн эмч эцэст нь үр дүнг хүлээн авч, уулзалтын үеэр өвчтөнд энэ талаар мэдэгдэх үүрэгтэй. Генетикийн

мэдээлэл агуулсан бүх бичиг баримтыг ихэвчлэн лаборатори, клиникт өвчтөний файлд хадгалдаг бөгөөд хариуцах биологич, эмч нар хариуцдаг. Эцэст нь генетикийн мэдээллийг дор хаяж арван жил хадгалах бөгөөд зарчмын хувьд генетикийн оношийг албан ёсны хяналтын тайланд харуулахыг зөвшөөрдөг.²¹

Нидерланд

Нидерланд дахь мэргэжлийн эмнэлгийн стандарт, өвчтөний эрхийг Нидерланд Иргэний хуульд заасан байдаг. Иргэний хуулийн нэг хэсэг болох Нидерландын эмчилгээний гэрээний тухай хууль нь өвчтөний эрх зүйн байдлыг тогтоосон ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүх гэрээний харилцаанд хамаардаг.

Нидерланд оношилгоо, урьдчилан таамаглах генетикийн шинжилгээг ямар ч эмчийн захиалгаар хийлгэж болно. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид аливаа эмнэлгийн оношилгоог эхлүүлэхийн өмнө эмнэлгийн эмчилгээний гэрээний тухай хуулийг танилцуулж санал болгож буй эмчилгээ, өөр хувилбар, урьдчилан таамаглал, эрсдэл, болзошгүй гаж нөлөөний талаар бүрэн дүүрэн мэдээллээр хангах ёстой байдаг.

²¹ Franziska Rössler · Johannes R. Lemke: Legislation on Genetic Testing in Different Countries. 2018, vol 21, pp 34.

Нидерландын хүн амын үзлэгт хамрагдах тухай хуулийн үндсэн дээр хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, түүнчлэн эмчлэх боломжгүй, урьдчилан сэргийлэх боломжгүй өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх генетикийн шинжилгээг тодорхой этгээдийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэгчдэд шууд санал болгож, хэрэгжүүлдэг. Шинжлэх ухааны үндэслэлгүй, мэргэжлийн эмнэлгийн практикийн стандартад нийцээгүй эсвэл шинжлэх ухааны үндэслэлгүй гэж үзвэл хуулийн 7-р зүйлд заасны дагуу Сайд нь уг шинжилгээний үйл ажиллагааг хүчингүй болгодог²².

Нидерландад генетикийн шинжилгээний хүрээнд олж авсан генетикийн дээжийг хугацаагүйгээр хадгаладаг. Харин удамшлын мэдээлэлд уг зохицуулалт нь хамаатай боловч клиник практикт генетикийн өгөгдөл нь тухайн гэр бүлийн 3 үеийн туршид хадгалагддаг байна.

Нидерландын хуулиар оношилгоо, урьдчилан таамаглах төстийн талаар генетикийн зөвлөгөө өгөх талаар зохицуулаагүй байна. Эмнэлгийн гэрээний тухай хуульд өвчтөний нууц мэдээллийн талаар ерөнхий зохицуулалтыг тусгасан ч генетикийн мэдээллийг ашиглах тусгайлсан зохицуулалтыг тусгаагүй

бөгөөд өвчтөний зөвшөөрөлгүйгээр генетикийн шинжилгээний хариуг эмч нар ашиглах боломжтой байдаг.

Их Британи

Их Британийн үндсэн хууль нь бичмэл баримт бичигт агуулаагүй боловч парламентаас баталсан хууль тогтоомж, шүүхээс гаргасан шийдвэрийн үр дүнд олон зуун жилийн турш оршин тогтнож ирсэн нийтлэг хуулиас олж болно²³. Гэвч одоо генетикийн шинжилгээтэй шууд холбоотой ямар ч дүрэм олдохгүй байна. Энэ сэдвийг хэсэгчлэн хөндсөн ихэнх хуулиуд нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, тухайлбал, эмнэлгийн хэрэгсэл, зар сурталчилгаа эсвэл ерөнхийдөө мэдээллийн хамгаалалтад зориулагдсан байдаг. 2010 онд хүний генетикийн шинэ хөгжлийн талаар засгийн газарт зөвлөгөө өгч байсан Хүний генетикийн комисс нь «Хэрэглэгчид болон тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах» зарчмын нэгдсэн тогтолцоонд зарим удирдамжийг тогтоож, лабораторид туршилт хийх сайн дурын магадлан итгэмжлэлийн схемийг боловсруулсан. Харин Их Британийн Засгийн газар төсвөө танах, шинэчлэх ажлын хүрээнд Хүний генетикийн хороог татан

²² Van der Maas PJ: Evaluatie Wet op het bevolkingsonderzoek, Evaluation Act on population screening. ZorgOnderzoek Ned, 2000.

²³ Courts and Tribunals Judiciary. The justice system and the constitution. <https://www.judiciary.gov.uk/about-the-judiciary/the-judiciary-the-government-and-the-constitution/jud-acc-ind/justice-sys-and-constitution/>

буулгажээ²⁴.

Гэсэн хэдий ч Нэгдсэн Вант улсын эмнэлзүйн практикт зөвхөн зөвлөх эмч нар генетикийн шинжилгээ хийдэг. Оношилгооны болон урьдчилан таамаглах туршилтын хооронд албан ёсны ялгаа байхгүй боловч эмч нар ерөнхийдөө клиник генетикийн үйлчилгээгээр урьдчилан таамаглах шинжилгээг захиалах боломжтой байдаг.

2004 онд биологийн дээжийг ашиглахтай холбоотой Их Британийн Хүний эдийн тухай хууль батлагдсан. Энэхүү хуульд зааснаар донорын хууль ёсны зөвшөөрөлгүйгээр хүний аливаа эд эсэд генетикийн шинжилгээ хийсэн нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцогдоно²⁵.

Генетикийн дээжийг эмч, өвчтөн хоёрын харилцан тохиролцсон хугацаанд хадгалдаг бөгөөд генетикийн зөвлөгөө өгөх талаарх тусгайлсан зохицуулалт байдаггүй. Хэрэв зөвлөгөө өгөх тохиолдолд заавал генетикч өгөхийг шаарддаггүй.

Португал

Португал нь хүний эрх, био анагаахын тухай Европын конвенцод ямар ч тайлбаргүйгээр гарын үсэг зурж, соёрхон баталсан бөгөөд Португалийн Үндсэн хуульд

заасны дагуу конвенц нь үндэсний хууль тогтоомжоос «дээд хүчтэй» байдаг. 2005 оны № 12/2005 дугаар Хувийн генетикийн мэдээллийн тухай үндэсний хууль тогтоомжид эрүүл мэндийн мэдээлэл нь генетикийн оношилгоонд тусгайлан зохицуулалт хийсэн. Үүний зэрэгцээ удамшлын өвчтэй эсвэл тодорхой удамшлын өвтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчмаас гадна ажил олгогчид хүний генетикийн мэдээллийг авах зохицуулалтыг тусгасан.

Хуулийн дагуу оношилгооны генетикийн шинжилгээ нь «эрүүл мэндийн бүхий л үйлчилгээнд баримтлах ерөнхий зарчмуудыг» дагаж мөрдөх ёстой. Урьдчилан таамагласан генетикийн шинжилгээг бичгээр болон мэдээлэлтэй зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн эмнэлгийн генетикч захиалж болно. Эмчлэх магадлал бага, бүрэн эмчлэх боломжгүй, хүнд шатанд орсон нөхцөлд сорилтын өмнөх сэтгэл зүйн болон ерөнхий дүгнэлт өгөх ёстой²⁶.

Генетикийн дээж авахын өмнө цуглуулах зорилго, хадгалах хугацааг багтаасан индексжүүлэгчийн хууль ёсны зөвшөөрлийг баримтжуулсан байх ёстой. Португал нь «холбогдох мэргэжилтнүүдийн бүрдсэн эмнэлгийн багийн дэмжлэггүйгээр» үндэсний болон гадаадын лабораториудад генетикийн шинжилгээ хийхээс татгалзах

²⁴ Genomeweb: UK Budget Cuts Whack Genetics Commission. <https://www.genomeweb.com/sequencing/uk-budget-cuts-whacks-genetics-commission>, 2010.

²⁵ Human Tissue Authority. Human Tissue Act, 2004.

²⁶ EuroGentest. Patient Rights in the EU – Portugal. Eur Ethical-Legal Pap № 13 2008.

талаар генетикийн шинжилгээний санал, гүйцэтгэлийг зохицуулах засгийн газрын үүргийг тодорхой өгсөн байдаг. Үүний үндсэн дээр засгийн газар генетикийн шинжилгээ хийдэг. Португалийн бүх лабораториудын магадлан итгэмжлэл, баталгаажуулалт, тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулдаг²⁷.

Дээрх хуульд генетикийн шинжилгээний аливаа үр дүнг зөвхөн индексжүүлсэн хүнд эмчийн зөвлөгөөний хүрээнд өгнө гэж заасан байдаг. Эмнэлгийн бүртгэлийг зөвхөн өвчтөний эмчилгээг хариуцдаг эмчээс авах боломжтой бөгөөд зөвхөн өвчтөний бичгээр өгсөн зөвшөөрлөөр эрүүл мэндийн мэдээллийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрдөг. Эрүүл мэнд, удамшлын мэдээллийг хадгалахдаа төрөлжүүлэн ангилж нууцын баталгааг хангах ёстой байна²⁸.

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын холбооны муж бүрд генетикийн шинжилгээний талаар өөр өөр тусгай журам байдаг. Оношилгооны шинжилгээг эмч бүр захиалж болох ч хууль эрх зүйн орчин харилцан адилгүй байдаг. Хувийн компаниуд янз бүрийн биологийн дээжийг ДНХ-ийн шинжилгээ хийлгэхийг хориглосон

холбооны хууль байхгүй тул генетикийн шинжилгээг далд байдлаар явагдаж байгаа. Албан бус генетикийн шинжилгээнээс хориглох, хязгаарлах нөхцөл нь муж улсуудад харилцан адилгүй байдаг ба аль мужид амьдарч байгаагаас хамаарч дээжийг хаана шинжилж, дүгнэлт гаргах зэрэг нь муж улсын хуулийг хэрхэн тайлбарлаж байгаагаас хамаарч байна²⁹.

АНУ-д ДНХ-ийн дээжийг зөвхөн төлбөр төлсөн тохиолдолд л хадгалдаг. Хэрэв төлбөр төлөөгүй тохиолдолд генетикийн дээжийг боловсруулсны дараа шууд устгадаг. 1996 оны Эрүүл мэндийн даатгалын тухай хууль нь эмнэлгийн мэдээллийг хуваалцахыг хязгаарлаж, «Эрүүл мэндийн хамгаалагдсан мэдээлэл» гэж тодорхойлох замаар өвчтөний хувийн нууцыг хамгаалахад чиглэгддэг. 2013 онд АНУ-ын Конгрессоос 2008 онд баталсан Генетикийн мэдээллийг ялгаварлан гадуурхахгүй байх тухай хуулийн дагуу «Эрүүл мэндийн даатгал гаргагчид болон ажил олгогчдын хувь хүний генетикийн мэдээлэлд нэвтрэх эрхийг хязгаарлах, түүнчлэн генетикийн ялгаварлан гадуурхахыг хориглох» зорилгоор 2013 онд Хувийн нууцын дүрмийг өөрчилсөн³⁰.

²⁹ Strand NK: Shedding privacy along with our genetic material: what constitutes adequate legal protection against surreptitious genetic testing? AMA J Ethics 2016;18:264–271.

³⁰ Feldman EA: The genetic information nondiscrimination act (GINA): public policy and medical practice in the age of personalized medicine. J Gen Intern Med 2012;27:743–746.

²⁷ The Portuguese Prime Minister, de SL Law № 12/2005 of 26 January, Personal genetic information and health information, 2005.

²⁸ EuroGentest. Patient Rights in the EU – Portugal. Eur Ethical-Legal Pap № 13 2008.

1966 оны Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь иргэдийн хүсэлтээр Холбооны баримт бичигт хандах боломжийг олгосон АНУ-ын анхны хууль юм. Уг хуульд холбооны мэдээллийн санд бүртгэгдсэн оролцогчдын геномын мэдээллийн талаар тусгайлсан зохицуулалтгүй байна. Хүний геномын судалгааны үндэсний хүрээлэн нь геномын мэдээлэл агуулсан хэд хэдэн мэдээллийн санг хөтөлж, өөрсдийн судалгааны мэдээлэлд зөвхөн судлаачдын хүсэлтээр хандах боломжийг олгодог тусгай мэдээлэл солилцох бодлогыг бий болгосон.

2013 онд АНУ-ын Дээд шүүх хууль сахиулах байгууллага гэмт хэргээр баривчлагдсан бүх сэжигтнээс ДНХ-ийн дээж авч болно гэсэн дүрмийг гаргасан бөгөөд «Алба хаагчид ноцтой гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй үндэслэлээр баривчлагдаж, сэжигтнийг хорих газарт авчрах үед. Цагдан хоригдож, баривчлагдсан хүний ДНХ-ийн хацрын арчдас авч, шинжилгээ хийх нь хурууны хээ авах, гэрэл зураг авахтай адил цагдаад захиалга өгөх хууль ёсны журам юм»³¹.

Бүгд найрамдах Хятад ард улс

БНХАУ нь 2017 оны байдлаар үндэсний ДНХ-ийн мэдээллийн санд 68 сая орчим дээжийн мэдээллийг бүртгэн ашиглаж байгаа бөгөөд энэ нь нийт хүн амын /1 млрд 384,350 сая хүн амтай/ 4,912 % орчим хувийг

эзэлж байна. “Генетик мэдээллийн үндэсний сан” Хятад дахь хүний наймааг таслан зогсооход маш чухал үүрэг гүйцэтгэснийг дурджээ. 2009 оны 4-р сараас хойш 39000 гаруй хүн худалдсан хэргийн тохиолдлыг ДНХ-ийн шинжилгээгээр шийдвэрлэсэн байна.

Үүнээс гадна ДНХ-ийн шинжилгээний үр дүнд сураггүй алга болоод олдсон, орон гэргүй тэнэмэл, асрах хүнгүй 1400 хүүхдийн эцэг, эхээс харьцуулах дээж авч ДНХ-ийн шинжилгээ хийж хүүхдийг эцэг, эхэд нь буцааж олж өгсөн байна.

Генийн мэдээллийн үндэсний сан бүрдсэнээр Хятадад хүүхэд худалдаалах гэмт хэрэг ихээхэн буурсныг Хятадын нийгмийн аюулгүйн албаны яамны Хүн худалдаалахын эсрэг тэмцэх албаны захирал ЧенШику мэдэгдсэн байна³².

Оросын холбооны улс

ОХУ-д шүүх ДНХ-ийн адилтгах шинжилгээг анх 1980-аад оны дунд үеэс хийж эхэлсэн ба ДНХ-ийн мэдээллийн сангийн бүртгэлийн системийг боловсруулах ажил 1990-ээд оны дундуур хийгдсэн боловч санхүүгийн бэрхшээлийн улмаас хэрэгжилт нь хойшлогдсоор Төрийн ДУМ нь “Холбооны улсын геномын бүртгэлийн тухай” хуулийг 2008 оны 12 сарын 9-нд баталсан бөгөөд 2009

³¹ Supreme Court of the United States. *Maryland v. King*, 133 S. Ct. 1958, 2013.

³² Перепечина И.О. “Федеральный закон о государственной регистрации в Российской Федерации”; “Вестник криминалистики”; 2010., Вып 1(33) с. 16- 22.

оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ⁵.

ОХУ нь анх 2009 онд "ДНХ-ийн мэдээллийн сан"-ийн хуулиа баталж санд одоогийн байдлаар нийт 300000 орчим дээжийн ДНХ-ийн мэдээлэл бүртгэсэн байгаа нь нийт хүн амын /147 сая хүн амтай/0,2% орчим хувийг хамруулсан байх жишээтэй³³.

Хүснэгт 1. Зарим улс орнуудын генетикийн шинжилгээний талаарх зохицуулалтын харьцуулалт

Улс	Генетикийн шинжилгээг хэн захиалах талаар		Генетикийн шинжилгээ дууссаны дараа ДНХ хадгалах хугацаа
	Анхан шатны оношилгоо	Урьдчилсан оношилгоо	
Герман	Ямар ч эмч	Анагаах ухааны генетикч эсвэл мэргэшсэн эмч	Хадгалахыг зөвшөөрөхгүй, гэхдээ тусдаа зөвшөөрөл авсан тохиолдолд хийж болно
Швейцарь	Ямар ч эмч	Анагаах ухааны генетикч эсвэл мэргэшсэн эмч	Хадгалахыг зөвшөөрөхгүй, гэхдээ тусдаа зөвшөөрөл авсан тохиолдолд хийж болно
Франц	Зөвлөх эмч	Олон талт баг	Хамгийн багадаа 10 жил
Нидерланд	Ямар ч эмч	Ямар ч эмч	Хугацаагүй
Их Британи	Зөвлөх эмч	Зөвлөх эмч	Харилцан тохиролцсоны дагуу
Португал	Ямар ч эмч	Анагаах ухааны генетикч	Хуулиар зохицуулаагүй
АНУ	Ямар ч эмч	Ямар ч эмч	Хуулиар зохицуулаагүй
Хятад	Анагаах ухааны генетикч	Анагаах ухааны генетикч	Хугацаа тодорхойгүй
Орос	Анагаах ухааны генетикч	Анагаах ухааны генетикч	Хугацаатай болон хугацаагүй

³³ Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2018, Цуврал 69, Дугаар №4, х.178.

ДҮГНЭЛТ

Дэлхийн улс орнуудыг хууль зүйн орчны харьцуулан үзвэл генетикийн шинжилгээнд хандах ёс зүйн хандлага, хууль эрх зүйн үндэслэл нь ялгаатай байна. Олон оронд генетикийн шинжилгээний гол хууль эрх зүйн асуудлууд тодорхойгүй зохицуулагдаагүй хэвээр байна³⁴.

Генетикийн харьцуулсан судалгаанаас авч үзвэл генетикийн шинжилгээг зөвхөн эмчийн захиалгаар хийх боломжтой гэдгийг харуулж байна. Ихэнх улс орнууд ч гэсэн урьдчилан таамаглах генетикийн шинжилгээг зөвхөн мэргэшсэн эмч нараар хязгаарладаг. Энэ нь оновчтой хууль зүйн зохицуулалт байгаа боловч оношилгоо, туршилт дууссаны дараа генетикийн шинжилгээний дээжийг устгах, хадгалах, ашиглах, шилжүүлэх зэрэг зохицуулалт өөр өөр байгаа болон зарим улсад зохицуулалт орхигдуулсан нь учир дутагдалтай байна.

Дээрх улс орнуудын зохицуулалт ялгаатай, зарим харилцааг зохицуулаагүй орхигдуулсан байдал нь генетикийн шинжилгээнд нэгдсэн тодорхой хандлага тогтоогүй байгааг илэрхийлж байна. Хэдийгээр олон улсын гэрээ, конвенц батлагдан улс орнууд нэгдэн орж байгаа ч улс орны өөрийн онцлогоос хамаарч харилцан адилгүй зохицуулж байна. Үүнээс дүгнэн үзвэл дараах нөхцөл байдлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Генетикийн шинжлэх ухаан хурдацтай хөгжихийн зэрэгцээ хуулийн зохицуулалтын хэрэгцээ шаардлага бий болж байна. Мөн генетикийн шинжилгээний мэдээллийг ашиглах, цуглуулах, шилжүүлэх харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах хэрэгцээ шаардлага бий болж байна.
2. Генетикийн шинжилгээний үйл ажиллагааг нэгдсэн стандарт буюу хэн захиалах, хэн шинжилгээ хийх, хэн дүгнэлт гаргах зэргийг журамлах. Мөн шинжилгээний процедурыг тодорхой болгож шинжилгээ, оношилгоо өгч байгаа хүнд зөвлөгөөг хэрхэн өгөх, хэзээ зөвшөөрөл авах зэргийг тодорхой болгох шаардлагатай байна.
3. Генетикийн сан буюу банкны эрх зүйн байдлыг дотоодын хуульд тусган зохицуулах хэрэгцээтэй байна. Уг сангийн аюулгүй байдлын хамгаалалтыг нарийвчлан анхаарах шаардлагатай. Аюулгүй байдлыг хангах нэг арга зам нь хуульд тухайн зөрчил, гэмт үйлдлийн хариуцлагыг өгөх явдал юм.
4. Мөн шинжилгээ өгөгч этгээдийн эрх зүйн байдлыг нарийвчлан тусгах хэрэгцээтэй бөгөөд үүний цаана хүний эрхийн маш том ухагдахуун хадгалагдаж байгааг орхигдуулж болохгүй юм. Энэ утгаараа био-ёс зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх нь маш чухал зүйл бөгөөд хүний эрхийг хангах томоохон механизм бүрдэх юм.

³⁴ Grimaldi KA, et al: Personal genetics: regulatory framework in Europe from a service provider's perspective. *Eur J Hum Genet* 2011;19:382.

НОМ ЗҮЙ

Ашигласан материал

1. Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2018, Цуврал 69, Дугаар №4
2. The Treaty on the Functioning of the European Union. Off J Eur Union 2012
3. Directive 98/44/EC of the European Parliament and of the Council of 6 July 1998 on the legal protection of biotechnological inventions. Off J Eur Communities 1998
4. Varga O, et al: Definitions of genetic testing in European legal documents. J Community Genet 2012
5. Council of Europe, T. O. Convention for the protection of Human Rights and Dignity of the Human Being with regard to the Application of Biology and Medicine: Convention on Human Rights and Biomedicine. Eur Treaty Ser – No. 164, 1997.
6. Grimaldi KA, et al: Personal genetics: regulatory framework in Europe from a service provider's perspective. Eur J Hum Genet 2011.
7. Council of Europe, T. O. Additional Protocol to the Convention on Human Rights and Biomedicine concerning Genetic Testing for Health Purposes. Counc Eur Treaty Ser – No. 203, 2008.
8. German Federal Parliament. Human Genetic Examination Act (Genetic Diagnosis Act – GenDG), 2009.
9. Borry P, et al: Legislation on direct to consumer genetic testing in seven European countries. Eur J Hum Genet 2012.
10. Federal Assembly of the Swiss Confederation. Fedral Act on Human Genetic Testing, 2004.
11. Federal Assembly of the Swiss Confederation. Revision of the Federal Act on Human Genetic Testing, 2016.
12. Franziska Russler · Johannes R. Lemke: Legislation on Genetic Testing in Different Countries. 2018, vol 21.
13. Van der Maas PJ: Evaluatie Wet op het bevolking- sonderzoek, Evaluation Act on population screening. ZorgOnderzoek Ned, 2000.
14. Human Tissue Authority. Human Tissue Act, 2004.
15. EuroGentest. Patient Rights in the EU – Portugal. Eur Ethical-Legal Pap № 13 2008.
16. The Portuguese Prime Minister, de SL Law № 12/2005 of 26 January, Personal genetic information and health information, 2005.
17. Strand NK: Shedding privacy along with our genetic material: what constitutes adequate legal protection against surreptitious genetic testing? AMA J Ethics 2016.
18. Feldman EA: The genetic information nondiscrimination act (GINA): public policy and medical practice in the age of personalized medicine. J Gen Intern Med 2012.
19. Supreme Court of the United States. Maryland v. King, 133 S. Ct. 1958, 2013.

20. Grimaldi KA, et al: Personal genetics: regulatory framework in Europe from a service provider's perspective. *Eur J Hum Genet* 2011.
21. Перепечина И.О "Федеральный закон о государственной регистрации в Российской Федерации"; "Вестник криминалистики"; 2010., Вып 1(33) с.

Цахим хуудас

1. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights>
2. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000136112>
3. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC2226192/>
4. <https://www.genomeweb.com/sequencing/>
5. <https://www.legalinfo.mn/law/details/1271>
6. <https://unesco.mn/mn/social-human-sciences/programmes/ethics/>
7. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/universal-declaration-human-genome-and-human-rights>
8. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000136112>
9. <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC2226192/>
10. <https://www.judiciary.gov.uk/about-the-judiciary/the-judiciary-the-government-and-the-constitution/jud-acc-ind/justice-sys-and-constitution/>
11. <https://www.genomeweb.com/sequencing/uk-budget-cuts-whacks-genetics-commission>

НУТАГ ДЭВСГЭРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА МОНГОЛ
УЛСЫН ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Шихихутуг их сургуулийн Нийтийн
эрх зүйн тэнхимийн багш, докторант
Э.Анхбаяр



Шихихутуг их сургуулийн
Удирдахуйн ухааны тэнхимийн
багш, докторант Г.Гантөгс

Улсын нутаг дэвсгэр гэдэг нэршил латин хэлний territorium гэсэн үгнээс уг гаралтай бөгөөд өдгөө улсын нэг салшгүй шинж төдийгүй улсыг нутаг дэвсгэргүйгээр төсөөлөхөө больсон байна¹. Манай улсын хувьд үндэсний аюулгүй байдал гэдэгт Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ² гээд үндэсний язгуур ашиг сонирхолд Монгол Улсын тусгаар тогтнол, **нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал**, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана³ гэж тодорхойлсон байна. Өөрөөр

хэлбэл төр улс оршино гэдэг нь газар нутаг эзэмшинэ гэсэн үг бөгөөд “газар нутаг”, “төр” гэсэн хоёр ойлголтыг адилтгах явдал түүхэнд цөөнгүй байсан ба одоо ч байсаар байна. Иймээс нутаг дэвсгэр нь төрийн нэгэн салшгүй шинж мөн”⁴ гэдгийг харуулж байна. Нөгөөтэйгөөр Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхолд **нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал** багтана гэж бэхжүүлэн өгсөн нь улсын тусгаар тогтнолын салшгүй хэсэг бол нутаг дэвсгэр гэдгийн илэрхийлэл юм. Нутаг дэвсгэр нь тодорхой улсын бүрэн эрхэд хадгалагдаж буй хил хязгаар бүхий дэлхийн бөмбөрцгийн нэг хэсэг мөн. Түүний бүрэлдэхүүнд хуурай болон усан гадаргуу, газар, түүний хэвлий, агаарын орон зай, түүнтэй адилтгах бусад объект

¹ Лүндэндорж.Н., Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар., 2022 он., 50 дэх тал

² <https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>

³ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он., 3 дугаар зүйл

⁴ Лүндэндорж.Н., Төрийн онол., УБ., 1997., 34 дэх тал

багтана. Энэ нь үндэсний хийгээд олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажиж, хүлээн зөвшөөрөгдсөн байх бөгөөд дэлхийн хийгээд улс үндэстний газрын зурагт хил хязгаарыг нь тэмдэглэсэн байдаг. Улсын нутаг дэвсгэр улсын хилээр хязгаарлагдана⁵. Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг үндэсний болон олон улсын эрх зүйгээр хамгаалдаг байна⁶. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээ нь 1565 мянган км, дэлхийд 17 дугаар байранд ордог. Хойд талаараа ОХУ-тай 2700 км, өмнөд талаараа БНХАУ-тай 4300 км нутаг дэвсгэрээр хиллэдэг далайд гарцгүй улс⁷.

Манай улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг бол нутаг дэвсгэр түүний аюулгүй байдал юм. Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаар судлахын тулд нэн түрүүнд газрын тухай мөн түүний эрх зүйн зохицуулалтыг судлах шаардлага үүснэ. Тэгвэл газар гэдэг нь газрын гадаргуу түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхарга гэж тодорхойлж болно. Мөн газар нь байгалийн нөөцийн үндсэн төрлийн нэг, хөдөө аж ахуйн үйлдвэрийн гол хэрэгсэл болно⁸. Газар нь өргөн утгаар хүн төрөлхтний иргэншил, соёлын оршин амьдрах орон зайг

хамаарах бөгөөд дээрх болон доорх баялгаа багтаасан ойлголт боловч Монгол Улсын хуульд “газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий зохих орон зайн давхаргыг хэлнэ”⁹ Монгол Улсын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь үндэсний язгуур ашиг сонирхол, Монгол Улсын тусгаар тогтнолын салшгүй хэсэг гэж тусгасан байна. Манай улс 1990 онд нийтийн болон хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, улмаар эдийн засгийн эрх зүйн шинэтгэлийг тасралтгүй гүнзгийрүүлсээр ирсэн. Эрх зүйн шинэтгэлийн үр дүнд өнөөдөр газрын харилцааны салбарт Газрын тухай хууль /2002/, Ашигт малтмалын тухай хууль /2006/, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль /2002/, Газрын төлбөрийн тухай хууль /1997/, Газрын хэвлийн тухай хууль /1988/ зэрэг хуулиуд холбогдох дүрэм, журмууд үйлчилж байна.¹⁰ Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн. Харин газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ. Газрын хэвлий нь ашиглаж байгаа эсэхээс үл хамааран бүхэлдээ улсын нэгдмэл

⁵ Лүндэндорж.Н., Төрийн онол., УБ., 2005 он., 39 дэх тал

⁶ Лүндэндорж.Н., Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар., 2022 он., 51 дэх тал

⁷ Нарангэрэл.С., Монгол улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг., 2021 он., 274 дэх тал

⁸ Нарангэрэл.С., “Эрх зүйн эх” толь бичиг., УБ., 2001 он., 103 дахь тал

⁹ Газрын тухай хууль., 2002 он, гуравдугаар зүйл
<https://advocate.mn/news/73/single/428>

санг бүрдүүлдэг¹¹ байна. Монгол Улс нь газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын **сан нэгдмэл байх** зарчмыг баримталдаг бөгөөд Монгол Улсын хилийн доторх бүх **газрыг** өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл санд хамааруулдаг байна. Улсын нутаг дэвсгэр нь нэгдмэл цул бөгөөд халдашгүй дархан байх нь улсын эрхт байдлын салшгүй дархан байх нь улсын бүрэн эрхт байдлын салшгүй хэсэг учраас үндэсний төдийгүй олон улсын эрх зүйн хамгаалалтад байна. Бусад улсын зүгээс болон дотооддоо түүнийг өөрчлөх, бусниулах аливаа оролдлогоос хамгаалах үүргийг төр хүлээдэг¹².

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилт тавьсан байна. Иймээс манай улсын өнөөгийн газрын нэгдсэн сангийн тухай болон эрх зүйн зохицуулалт, удирдлагын тогтолцоог судалж үзье. Газрын нэгдмэл санг газар ашиглалтын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан хөдөө аж ахуйн газар, хот, тосгон, бусад суурины газар, зам, шугам сүлжээний газар, ойн сан бүхий газар, усны сан бүхий газар гэж ангилан авч үздэг байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаардаг бол хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтэц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаардаг байна. Харин нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарахаар зохицуулсан байна.

Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрээс Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2-т заасан¹³ тэг гортигоор хязгаарлагдана. Нийслэл хот, түүний дагуул хот нь бүсчлэл бүхий эдэлбэр газартай байна. Нийслэл хотын дагуул хотын эдэлбэр газар нь бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн дагуул хотын

¹¹ Газрын хэвлийн тухай хууль, 1988 он /Энэ хуулийн гарчигт 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

¹² Лүндэндорж.Н., Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2022 он., 51 дэх тал

¹³ <https://legalinfo.mn/mn/detail/16230779072091>

эдэлбэр газарт газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрын төлбөрийг дагуул хот байрлаж байгаа аймаг, сумын төсөвт төвлөрүүлнэ. Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаардаг болойнсан бүхий газартой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газрыг хамруулаад усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, гол, мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газар хамааруулан хуульчилсан байна.

Мөн газрын нэгдмэл сан нь түүний ангилал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь болон газар ашиглалтын зориулалтаас үл хамааран нэгдмэл удирдлагатай байх ёстой. Иймээс газрын нэгдмэл сангийн талаар захиргааны байгууллагын чиг үүргийг судалж үзвэл: Засгийн газар нь Газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх болон газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх, журмыг тогтоох эрхтэй байхад Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын нэгдмэл сангийн тайланг

Засгийн газарт танилцуулах үүрэг хүлээдэг байна. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэхээр хуульд заасан байна. Харин аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн газрын нэгдмэл сангийн тайланг жил бүр хянан нэгтгэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, дээд шатны Засаг дарга, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнах үүрэгтэй байна. Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина. Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана гэх мэтээр хуульчилсан байгаа боловч **өнөөгийн нөхцөл байдалд газрын хууль нь хүчин төгөлдөр мөрдөж буй 60 гаруй хууль, 200 орчим захиргааны хэм хэмжээний акттай зэрэгцэн үйлчилж**

байгаагаас 7 давхардал, 29 зөрчил, 25 хийдэл үүсэж, эрх зүйн зохицуулалтгүй ойлгомжгүй байдлууд бий болоод байна. Иймээс хуулийг боловсронгуй болгох замаар эрх зүйн оновчтой зохицуулалтыг бий болгож, газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад¹⁴ байгаа. Судлаачдын хувьд газрын багц хуулийг шинэчилснээр дараах үр дүнгүүд гарна гэж дүгнэсэн байна. Тухайлбал Газрын тухай хуулиар Монгол Улсын газрын сан нэгдмэл байх зарчим хэрэгжих боломжтой болно гэж дүгнэсэн байна. Мөн бодит судалгааг харахад Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 156411575 га газрын 72.9 хувийг хөдөө аж ахуйн газар, 0.6 хувийг хот, тосгон бусад суурины газар, 0.3 хувийг зам, шугам сүлжээний газар, 9.1 хувийг ойн сан бүхий газар, 0.4 хувийг усны сан бүхий газар, 16.7 хувийг улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна. **2021** оны газрын нэгдмэл сангийн тайлангийн дүнгээр хөдөө аж ахуйн газар 61.8 мянган га газраар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 38.6 мянган га, зам, шугам сүлжээний газар 2.4 мянган га, ойн сан бүхий газар 0.7 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 20.0 мянган гагаар тус тус нэмэгдсэн байна. Усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байгаа бөгөөд газрын эрхийн төрлөөр 2019 оны үзүүлэлттэй харьцуулахад **өмчлөлийн газар**

68.1 мянган га болж 2.2 мянган га газраар өссөн дүнтэй байна. Улсын хэмжээнд 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 1151476 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ 41430-аар өссөн байна. Монгол Улсын нийт хүн амын тоотой газар өмчилсөн иргэдийн тоог харьцуулахад 19.8 хувь байх бөгөөд өмнөх оны хувьтай харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй өмчилсөн 67.4 мянган га газрыг 653161 иргэнд, аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж, 29.31 га газрыг 312 иргэнд, аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар 1.63 га газрыг 50 иргэнд, газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдаж 60.74 га газрыг 61 иргэнд худалдаж тус тус өмчлүүлээд байна¹⁵.

Газрын нэгдсэн сангийн тайлангуудаас харахад өмчлөлийн газар жилээс жилд өсөж байгаа харагдаж байна. Энэ нь нутаг дэвсгэрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэхийг судлах нь зүйтэй байна. Үүний тулд эхлээд газар өмчлөх эрхийн уламжлал, шинэчлэлийг нарийвчлан судлах шаардлага үүсэж байна. Иймээс газар өмчлөлийн асуудлыг төр эрх зүйн түүхэн талаас нь нь судалж үзвэл: Хүннүхэмээх Монгол угсаатны улс байгуулагдсанаар Монгол төрийн

¹⁴ <https://mncud.gov.mn/a/1221>

¹⁵ Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан, 162 дах тал

түүх эхэлсэн¹⁶ гэж үздэг. Тэгвэл Хүннү гүрний эзэн хаан Маодунь шаныю "Газар бол улсын үндсийн үндэс мөн" гэж зарлиг буулгаж байжээ. Мөн Чингис хаан төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүст газар нутгийг хувь өмч болгон өгч байгаагүй, харин эзэмшүүлэх онцгой эрх олгож байсан тухай "Сорхон – ширад нутаг дархалж, мэргэдийн газар сэлтээр ургийн урагт хүртэл нутаг орноо эзэмшсүгэй"¹⁷ хэмээсэн байна. Мөн Газрын талаарх өв уламжлалыг цааш судлахад Эзэн Чингисийн "Их засаг хууль"-д малын бэлчээрийг онцгойлон үзэж түүнийг сүйтгэх явдлаас хамгаалахыг чухалчлан зааж байжээ. Халхын үйсэнд бичсэн цааз эрхэмжийн бичиг"-т мод хатгасан газарт мэдэж байж бууваас гурван ёст буй. Эс мэдэж бууваас нэгэн морь ав гэсэн нь тухайн үедээ газрын харилцааны өвөрмөц зохицуулалт байсан бол 1921 онд ардын хувьсгал ялснаар газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын хувьд газрыг улсын өмч, нийтийн хүртээл болохыг анх удаа хуульчилсан байна. Тухайлбал ".....тус улсын бүх газар шороог үүнээс хойш гадаад, дотоодын хүмүүс миний хэмээн түрэмгийлэн эзлэхийг үүр зогсоохоор"¹⁸ эрх зүйн зохицуулалт хийгдэж байжээ. Уг эрх зүйн зохицуулалт нь 1924 онд

¹⁶ Дашням.И., Монгол улсын төр эрх зүйн түүх., УБ., 2011 он., 24 дэх тал

¹⁷ Болдбаатар.Ж., Лүндээжанцан.Д., "Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал.", УБ., 2011 он., 90 дэх тал

¹⁸ 1921 оны 5 дугаар сарын 21-ний өдөр баталсан Ардын түр засгийн газрын 19 дүгээр тогтоол

батлагдсан "БНМАУ-ын анхдугаар үндсэн хуульд тусгалаа олсон байна. Тухайлбал: "БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар нь уурхай хийгээд ой мод, ус тэдгээрийн баялгууд нь ардын мэдэгд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно"¹⁹ гэж бэхжүүлсэн байна. Мөн "Олноо өргөгдсөний арван нэгдүгээр он дөрвөн сарын 21 бөгөөд европын 1921 он таван сарын 21-ний өдөр Монгол улсын хэмжээт цаазат ардын засгийн эрхлэх товчооны гишүүд хуралдаж зөвлөлдөн тогтоосон 19-р тогтоолд: Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино"²⁰ гэж тусгаж байсан байна. БНМАУ-ын анхдугаар үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор засгийн газраас гарч байсан зарим эрх зүйн зохицуулалтуудыг судлахад 1926 онд "Ард олны дотор бие, биесийг нутаг бэлчээр, евөлжөө бууц зэргээр гачигдуулан хохироож, маргаан будилаан үүсгэн, илүү нутаг эзэрхэх явдал гарч байгааг зогсоон гагцхүү, олон онд нутаглаж, хүн мал идээшсэн, хөрөнгө малын олон цөөнд тохируулан аль бололцоот бууц бэлчээрийг нутгийн эрх баригчдаас зүй зохисоор заан олгуулж байх"²¹ гэсэн зохицуулалт хийж байсан бол улмаар 1928

¹⁹ 1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар үндсэн хууль

²⁰ Газрын харилцааны хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл., УБ., 2018 он., 175 дахь тал

²¹ "Газар бэлчээрийг эдлэх тухай" Засгийн газрын эрхлэх товчооны 1926 оны 227 дугаар тогтоол

онд "Олон ардууд эрх биш өөр өөрийн нутгийн хязгаар нутаг дотор нутаглавал зохих, шалтгаангүйгээр бусад хошууны нутагт нүүдэллэн орохыг хязгаарлах, хэрэв хил тодорхойгүй бол түүнийг шинэчлэн тодорхойлох, ган зуд тохиолдох үед өөр өөрсдийн захиргааны байгууллагаар уламжлан урьдаас зөвшөөрүүлж байх"²², 1935 онд "Тус улсын харьяат нар, улсын ба хоршоо, аж үйлдвэр, олон нийтийн байгууллагууд бэлчээр усыг үнэ төлбөргүй, хугацаагүй эдлэх бөгөөд гадаадын харьяат нарт түрээсээр эдлүүлэх"²³ тухай эрх зүйн зохицуулалтууд хийгдэж байжээ. 1940 онд батлагдсан БНМАУ-ын 2 дахь удаагийн үндсэн хуульд "Бүх газар, ой мод, ус тэдгээрийн баялаг улсын өмч буюу ард түмний хөрөнгө мөн" гэж заан анхдугаар үндсэн хуулийн заалтыг хэвээр бататгасан байна. 1942 онд Газар эдэлбэрийн тухай хууль гарч түүнд газар эдэлбэрийн эрхийг хувийн аж ахуйтнуудын хөдөлмөрийн газар эдэлбэрийн эрх, Артель ба олон нийтийн газар эдэлбэрийн эрх, Улсын аж ахуйтан ба станц, аж үйлдвэр, албан байгууллагын газар эдэлбэрийн эрх гэж ангилсан байдаг. 1960 онд батлагдсан БНМАУ-ын гурав дахь Үндсэн хуульд өмнөх үндсэн хуулийн /1940 оны / заалтыг бататгасны дээр "Хөдөө аж ахуйн

нэгдэлд газрыг үнэ төлбөргүй, байнга эдлүүлнэ" гэж хэм хэмжээ тогтоожээ. Үүний зэрэгцээ "газрын нэгдсэн сангийн ангиллыг бий болгож, газар эзэмшигчид, тэдний эрх үүрэг, газар олгох авах журам, газрын бүртгэл, хяналт, газар зохион байгуулалт, маргааныг шийдвэрлэх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тухай эрх зүйн зохицуулалт"²⁴ бий болсон байна.

Дээрх судалгаанаас газар өмчлөх эрхийн түүхэн уламжлалууд нь газар нутгийн аюулгүй байдлыг эрхэмлэн сахиж байсан байна.

Иймээс одоо байгаа тусгаар улс оршин буй биз. Өөрөөр хэлбэл Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, **хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг** хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс гэдгийг түүхийн аль ч үед чухалчилж байсан уламжлалтай байна. Манай улсын нэрт судлаач эрдэмтэн Б.Чимид багшийн минь хэлснээр: Монгол улс Эзэн Чингисийн үндэслэсэн төрт ёс, соёл, иргэншлийн олон зууны түүхтэй, 1 сая 564,1 мянган ам км нутаг дэвсгэртэй мөнх хөх тэнгэрийн орон билээ"²⁵. Нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг газрын нэгдсэн сангийн бодлогоороо хамгаалах нь зүйтэй. Энэ сайхан орны минь "Төрийн шинжийг бүрдүүлж байгаа **нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг эрх**

22 Засгийн газрын 1928 оны 6 дугаар

сарын 29-ний өдрийн 20 дугаар хурлын тогтоол

23 Улсын бага хурлын тэргүүлэгчид, Сайд нарын зөвлөл 1935 оны 9 дүгээр сарын 25-нд бэлчээр усыг эдлэх тухайн дүрэм

24 1971 онд БНМАУ-ын АИХ-ын тогтоолоор баталсан БНМАУ-ын газар эдэлбэрийн хууль

25 Чимид Б., "Үндсэн хуулийн мэдлэг", УБ., 2008 он., 33 дахь тал

мэдэл бол төр улс орших үндэс мөн. Аль нэг шинжийг нь алдвал төр улс оршихуйн болон хууль зүйн үндэсгүй болно”²⁶

Газрын эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх эрх зүйн зохицуулалтуудыг судалж үзвэл: Иргэнд газар өмчлүүлэх гэж Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэнд өмчлүүлж болохоор заасан газраас хуульд заасан хэмжээ, бэлзол, шаардлага, журам, нөхцөлөөр иргэний өмчлөлд шилжүүлэхийг²⁷ ойлгоно гээд Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч байхаар зохицуулсан бөгөөд бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болохоор хуульчилсан байна. Газар өмчлөгч гэж тухайн газрыг захиран зарцуулах эрх бүхий этгээдийг ойлгож болно. Өөрөөр хэлбэл газар өмчлөл нь тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгах²⁸ боломж юм. “Эрх зүйн харилцаанд өмчлөгч нь өмчлөгч биш этгээдээс халдашгүй шинжтэй олон давуу эрхтэйгээр оролцох бөгөөд өөрийн эрхээ хуулиар хориглоогүй бүхий л арга замаар хэрэгжүүлнэ”²⁹ “Үл

ходлох эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг төрөөс баталгаажуулж гэрчилгээ олгоно³⁰. Иргэнийг газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь бусад этгээд аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглодог³¹ байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийг харж, дүгнэхэд иргэн газар өмчлөх эрхээ бодитоор нь эдэлж байгааг илэрхийлэх боловч үүний цаана манай улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал давхар хөндөгдөж байгаа учраас газар өмчлөх эрхийн уламжлал сэтгэлгээний чиг хандлагыг сайн судалж, газар өмчлөх эрхийн зохицуулалтыг түүхэн уламжлалтай нь уялдуулан газрын багц хуулиудад тусгах мөн нутаг дэвгэрийн аюулгүй байдлыг хангахын тулд газрын сэнгийн нэгдмэл бодлого удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох Монгол улсын газрын сан нэгдмэл байх зарчмын хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлох нь зүйтэй байна.

²⁶ Лүндэндорж., Төрийн онол., УБ., 2005 он., 37 дахь тал

²⁷ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он., 3 дугаар зүйл

²⁸ Нарангэрэл.С., “Эрх зүйн эх” толь бичиг, УБ., 2001 он., 104Т дахь тал

²⁹ Цэрэнжээ.Ц., “Өмчийн эрх зүй., УБ., 2000 он., 27 дахь тал

³⁰ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 22 дугаар зүй

³¹ <https://www.legalinfo.mn/law/details/346>

ХОНГ-КОНГИЙН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (2020), ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР



Хуульч, хууль зүйн доктор
М.Хатанзориг

Оршил

Нэг. Бээжин-Хонг Конгийн сонирхлын зөрчил ба Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ хууль

Хоёр. Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ хуулийн эрх зүйн үндэслэл: Бээжинд ийм эрх бий юү?

Гурав. Хууль хэрэгжиж эхэлсний дараах эмпирик үр дагаварын тойм

Дүгнэлт

Оршил

Хонг-Конгийн (цаашид "Хо.К" гэж товчилно) Конгресс 2020 оны 6-р сарын 30-ны өдөр "Хонг-Конгийн тусгай захиргааны бүс дэх үндэсний аюулгүй байдлыг хангах тухай БНХАУ-ын хууль (G.N. (E.) 72 of 2020)"¹-ийг (цаашид "ҮАБТХ"

гэж товчилно) хүлээн зөвшөөрч албажуулсан.² Тус өдрийн 23.00 цагаас эхлэн үйлчилсэн эл хуулийг Бээжин – Хо.К-ын улс төрийн зөрчлийг хүчээр намжаах хууль зүйн арга хэрэгсэл хэмээн ойлгож болно. Хо.К-ын хууль зүйн бие даасан тогтолцоонд Бээжингээс хүчтэй нөлөөлснөөр тус бүс дэх хууль сахиулах, шүүх байгууллагын удирдлага, үйл ажиллагааны журмыг өөрчлөх; эрх зүйт ёсыг үл хэрэгсэх; улмаар иргэний ба улс төрийн эрхүүдийг ноцтой хязгаарлах явдал олон гарлаа. Монгол Улсын хувьд стратегийн өндөр ач холбогдолтой БНХАУ-аас Хо.К-д тулгаж батлуулсан; аюулгүй байдлын харилцааг зохицуулсан уг хуулийн агуулга, хууль зүйн үндэслэлийг тодруулах нь хөрш улсынхаа бодлого хэрэгжүүлэх хууль зүйн арга, тактикийг ойлгоход нэмэр болно. Мөн энэ хуулийг батлан хэрэгжүүлсэн явдал нь эрх зүй ба аюулгүй байдлын уялдаа хамаарлыг илэрхийлэхэд ач холбогдолтой. Уг өгүүллийг (1) Хо.К-ын ҮАБТХуулийн агуулга, (2) Бээжингээс Хо.К-д тус хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл, (3) хууль хэрэгжсэний үр дагаварыг тодруулах зорилгоор; шинжлэх ухааны судалгааны онолын

гарчиг: "中華人民共和國香港特別行政區維護國家安全法"

¹ Англи гарчиг: "The Law of the People's Republic of China on Safeguarding National Security in the Hong Kong Special Administrative Region"; Хятад

² Хо.К-ын Засгийн газрын тэргүүн Керри Лемийн соёрхон баталсан хуулийн сонордуулга: <https://www.gld.gov.hk/egazette/pdf/20202444/es220202444136.pdf>

ба эмпирик арга зүйд тулгуурлан бэлтгэв.

Нэг. Бээжин-Хонг Конгийн сонирхлын зөрчил ба Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ хууль

Бээжин – Хо.К-ын сонирхлын зөрчлийн тойм

25 жилийн өмнө Хо.К Хятадад эргэн ирсэн явдал нь "эх оронтойгоо буцаж нийлэх" их үйл бөгөөд, шинэ эриний эхлэл болох ёстой байлаа. Гэвч тэр даруй эх газар [-ын Хятад] хийгээд [Хо.К] хотын хоорондох харилцаанд зөрчилдөөн цахилж, Хятад улс хүчирхэгжихийн хэрээр Хо.К-од үзүүлэх нөлөөллөө нэмэгдүүлэв. Ингэснээр [иргэдийн] эрх чөлөөг бууруулж, олон нийтийн эсэргүүцлийг өдөөн хотын тусгааршлыг улам дэвэргэв.³ Эдийн засаг, эрх зүйн тогтолцоо, олон нийтийн зан суртахууны хувьд эх газрын Хятадаас ихээхэн ялгаатай болсноос гадна коммунист намын бодлоготой шууд зөрчилдөх иргэний ба улс төрийн эрхүүдийг (тухайлбал жагсаал цуглаан хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох) Хо.К-ын захиргааны нэгж дотроо баталгаажуулан эдлүүлж буй нь хоорондын зөрчилдөөнийг хурцатгах гол шалтгаануудын нэг.

1997 онд Хонг-Конгийг Британиас Хятадад шилжүүлэхэд "нэг улс-хоёр систем" гэгдэх нөхцөлөөр тус

хот өөрийн гэсэн Үндсэн хууль, эрх зүйн бие даасан тогтолцоотой байх талаар талууд тохиролцсон. Тавин жилийн хугацаанд Хятадын социалист дэглэм Хо.К-д үйлчлэхгүй ба Британы колонд байх үеийн практик, иргэний ба улс төрийн эрхүүдийг хүлээн зөвшөөрөхөөр Хятад-Британийн хамтарсан тунхаглалд заажээ.⁴

Нэг талаас Бээжингийн коммунист үзэл баримтлалтай эрс тэрсэлдэх ардчиллын аспектиуд буюу түүнийг хэрэгжүүлэгч Хо.К-ын харьцангуй бие даасан байдлыг аль болох богино хугацаанд хүчингүй болгох; нөгөө талаас Хо.К-ын эрх, эрх чөлөөгөө хамгаалж эх газрын Хятадын социалист дэглэм, бодлогоос ангид байх зөрчилдөөнтэй ашиг сонирхлууд хэд хэдэн үйл явдлаар⁵ тодорхой илэрхийлэгдсэн. Үүнээс тодруулбал, 2019 оны Хо.К-ын олон нийтийн эсэргүүцлийн үндсэн шалтгаан нь Хо.К-ын гэмт хэрэгт сэжиглэгдэж буй иргэдийг эх газрын Хятадад шилжүүлэн өгөхийг хэд хэдэн нөхцөлд хүлээн зөвшөөрсөн хуулийн төсөл байв. Ингэснээр Хо.К-ын эрх зүйн тогтолцооны бие даасан байдлыг

⁴ Sino-British Joint Declaration. 3 дугаар зүйлийг харах.

⁵ Хятадын 2005 оны "Салан тусгаарлалтын эсрэг хууль"-ийн дараах Хо.Конгийн санаа зовнил; 2013 оны эх газрын Хятад эмэгтэй Хо.К эрэгтэйтэй гэрлээгүй л бол тус хотод аялах буюу хүүхэд төрүүлэхийг хориглосон явдал; Бээжингээс Хо.К-ын сонгуулийн тогтолцоог зөвхөн жагсаалтаар тодорхойлсон нэр дэвшигчдээс сонгох хэлбэрээр хязгаарласан ба улмаар 2014 оны олон нийтийн эсэргүүцлийн жагсаал өрнөсөн; 2017 онд ардчилсан дэглэмийг дэмжигчдийг шоронд хорьсон; 2019 оны сэжигтэн шилжүүлэх хуулийн төслийг Хо.К-ын иргэд хүчтэй эсэргүүцсэн гэх мэт.

³ Тесса Вонг (BBC-ын Азийн дижитал сэтгүүлч). Хятад, Хонг-Конгийн хоорондох сэтгэл түгшээсэн таван асуудал. 2022-07-27. (<https://www.bbc.com/news/world-asia-china-61809659>)

ноцтой хэмжээнд сулруулах; улс төрийн эсрэг үзэлтнүүдийг Бээжинд залхаан цээрлүүлэх, хэлмэгдүүлэх эрсдэл бүрдэх боломжтой. Үүний улмаас Хо.К-ын иргэд хурц хэлбэрийн эсэргүүцэл үзүүлж хэд хэдэн хүний амь нас хохирсон. Хэдий хуулийн төслийг татаж авсан ч БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жинпин салан тусгаарлалтын эсрэг хүчтэй сануулга өгч "... Хятадыг задлан хуваах ямар ч оролдлого 'биеийг нь няц дарж, ясыг нь үйрүүлэх' үр дагаварт хөтөлнө" хэмээж байсан юм.⁶

Хо.К-ын Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ хуулийн⁷ онцлог

Хо.К-од нөлөөллөө лавшруулах Бээжингийн чармайлтын дараагийн ажиллагаа нь 2020 оны 06-р сард батлагдсан Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (цаашид "ҮАБТХ" гэж товчилно) мөн. 66 заалт бүхий тус хууль батлагдах хүртлээ бүхэлдээ нууцлагдсан тул олон нийтэд санал бодлоо илэрхийлэх, шаардлагатай бол эсэргүүцэл үзүүлэх боломж олгоогүй. Мөн батлагдсан өдрийнхөө 23.00 цагаас⁸ хүчин төгөлдөр үйлчилж эхэлжээ. Агуулгын хувьд салан тусгаарлах, хорлон сүйтгэх, гадаадын хүчний байгууллагатай хуйвалдахтай холбоотой өргөн хүрээний харилцааг⁹ гэмт хэргийн шинжтэйд

тооцохоор болсон.

Уг хууль Бээжинд Хо.К-ыг удирдах өргөн хүрээний эрх мэдлийг урьд өмнө байгаагүй хэмжээгээр олгосон юм. Голлох зохицуулалтыг дурдвал:

- Салан тусгаарлах, хорлон сүйтгэх, гадаадын хүчний байгууллагатай хуйвалдах зэрэг гэмт хэргүүдийг хорих ялын дээд хэмжээгээр шийтгэнэ¹⁰;
- Хятадын нийгэм, улс төрийн системд хохирол учруулахыг оролдох, Хо.К-ын дотоод захиргааны тогтолцоог нураахыг оролдох зэрэг шинэ гэмт хэргүүдийг тодорхойлсон;¹¹
- Нийтийн тээврийн бүтцийг гэмтээх нь хорлон сүйтгэх ажиллагаанд тооцогдоно;
- Гэм буруутайд тооцогдсон этгээд нийтийн албан тушаал хашиж болохгүй;
- Компаниуд уг хуулиар гэмт хэргийн субъектэд тооцогдож, торгуулах боломжтой;
- Шүүхэд давж заалдахаар эх газрын Хятадад хандаж болох боловч Бээжингийн мэдээлснээр "маш цөөн тооны" гомдлыг л хүлээн авна;
- Хо.К Бээжингээс томилсон зөвлөх бүхий,¹² өөрийн гэсэн үндэсний аюулгүй байдлын хороог ажиллуулах үүрэгтэй.¹³ ҮАБТХуулийн §14-т зааснаар "ямар ч институт, байгууллага,

⁶ <https://www.bbc.com/news/world-asia-china-49317695>

⁷ Хо.К-ын Засгийн газраас нийтэлсэн Англи орчуулга: [https://www.elegislation.gov.hk/fwddoc/hk/a406/eng_translation_\(a406\)_en.pdf](https://www.elegislation.gov.hk/fwddoc/hk/a406/eng_translation_(a406)_en.pdf)

⁸ Хо.К Британаас Хятадад шилжүүлэгдсэний 23 жилийн ойн өдрөөс 1 цагийн өмнө.

⁹ ҮАБТХуулийн III бүлгийг үзэх.

¹⁰ ҮАБТХуулийн §20 зүйлээс эхлээд III бүлгийн зохицуулалт эл харилцаанд үйлчилнэ.

¹¹ ҮАБТХуулийн §22.

¹² ҮАБТХуулийн §15.

¹³ ҮАБТХуулийн §§12, 13.

хүн тус хорооны үйл ажиллагаанд саад болохыг хориглосон;

- Хо.К-ын Ерөнхий сайд (chief executive) төв Засгийн газрын хүсэлтээр тус бүс дэх аюулгүй байдалтай холбоотой бүхий л мэдээллийг гаргаж өгнө;
- Цагдаагийн газрын дотор үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай тасаг ажиллуулна. Даргыг нь шууд Ерөнхий сайд томилох бөгөөд тус тасага аюулгүй байдлыг хангах хэмжээний хүчин чадалтай байх ёстой. Мөн эл тасаг Хо.К-оос гаднах бүсээс (тухайлбал Бээжингээс) тусгай мэргэжлийн ажилтнуудыг авч ажиллуулж болно. Тасгийн үүрэг нь (бүрэн эрх нь) мэдээлэл цуглуулах, тагнах, харьяаллын хэргээ мөрдөн шалгах, мөн "шаардлагатай бусад чиг үүрэг"-ийг хэрэгжүүлнэ¹⁴;
- Үндэсний аюулгүй байдалтай холбоотой хэргийг тухайлан шийдвэрлэх прокурорын хэлтэстэй байна. Эрхлэгчийг нь аюулгүй байдлын хорооны зөвшөөрлөөр томилно¹⁵;
- Хо.К-ын Ерөнхий сайд (chief executive) үндэсний аюулгүй байдалтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх шүүгчдийг томилох эрхтэй байна. Ингэснээр шүүхийн хараат бус байдлыг алдагдуулсан;
- Бээжингээс хууль тайлбарлах эрх мэдлийг өөртөө шилжүүлэн

авсан¹⁶ ба Хо.К-ын шүүхийн болон албаны байгууллагууд эл эрхээ алдаж буй. Хэрэв Хо.К-ын ба Бээжингийн хууль хоорондоо зөрчилдвөл Бээжингийн хуулийг дагаж мөрднө;

- Зарим хэргийг хаалттайгаар хянан шийдвэрлэнэ;
- Хууль зөрчсөн байж болзошгүй хэмээн сэжиглэгдсэн этгээдүүдийг тагнах, чагнах төхөөрөмж ашиглах боломжтой;
- Гадаадын төрийн бус байгууллага хийгээд мэдээллийн агентлагуудын хяналт, зохицуулалтыг чангатгасан;
- Хо.К-ын иргэдээс гадна гадаадын иргэн, дамжин өнгөрөгч, хотын нутаг дэвсгэрээс гадна байгаа этгээдэд ч уг хууль үйлчилнэ.

69

Хоёр. Үндэсний аюулгүй байдлын тухай шинэ хуулийн эрх зүйн үндэслэл: Бээжинд ийм эрх бий юу?

1997 онд Британиас эх газрын Хятадад тус хотыг буцаан шилжүүлэхдээ 1984 оны Хятад-Британийн хамтын тунхаглалд заасны дагуу Хо.К-ыг өөрийн гэсэн Үндсэн хуультай ижилтгэхүйц суурь хуультай байх буюу Британы засаглалын үед төлөвшсөн тогтолцоогоо хадгалж үлдэх нөхцөлийг тогтоосон. Тухайлбал, тус тунхаглалын¹⁷ §3.2-т "... Хо.К-

¹⁶ ҮАБтХуулийн §65-д уг эрхийг Хятадын Ардын Конгрессийн байнгийн хороонд хадгалагдана хэмээн заажээ.

¹⁷ НҮБ-ын бүртгэлийн дугаар: 23391. Бүртгэлтэй гарчиг: Joint Declaration on the question of Hong Kong.

¹⁴ ҮАБтХуулийн §17.6.

¹⁵ ҮАБтХуулийн §18.

ын тусгай захиргааны бүс батлан хамгаалах, гадаад харилцаанаас бусад салбарт бие даасан байна” хэмээн заажээ.

Тунхаглалд Хятадаас Хо.К-ын хязгаарлагдмал бие даасан байдлыг хүлээн зөвшөөрөхдөө тус улсын Үндсэн хуулийн §31-ийг үндэс болгосон. Эл зүйлд: “Төрөөс шаардлагатай бол тусгай захиргааны бүс байгуулж болно. Тусгай захиргааны бүсийн тогтолцоо тодорхой тохиолдлуудад Иргэдийн Конгрессээс баталсан хуулийн дагуу хязгаарлагдаж болно” хэмээн заасан байна. Гэвч Хо.К-ын ҮАБТХуулийг тус хотод баталж мөрдүүлсэн нь уг зохицуулалтад шууд үндэслээгүй, эсрэгээрээ Хо.К-ын өөрийн хууль зүйн тогтолцоонд тулгуурласан байна. Өөрөөр хэлбэл Бээжингээс Хо.К-ын хязгаарлагдмал автономийг ҮХ-ийн §31-д зааснаар хязгаарласан хууль зүйн шинжийг аюулгүй байдлын шинэ хууль агуулаагүй юм.

Хэдийгээр Хо.К-ын суурь хуулийн §18-д: “үндэсний хууль тогтоомж (Бээжингээс баталсан)” тус бүсэд үйлчлэхгүй, өөрсдийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхээр заасан боловч мөн зүйлд “... энэ хуулийн III дугаар хавсралтаар жагсаасан [үндэсний] хуулиуд тус бүсийн хууль тогтоомжиор батлагдах буюу тунхаглагдах байдлаар хэрэгжинэ” хэмээн заажээ.¹⁸ Уг жагсаалт дахь хуулиудыг Үндэсний Иргэдийн

Конгрессийн Байнгын Хороо нь Хо.К-ын Тусгай Захиргааны Бүсийн Суурь Хуулийн Хороотой **зөвлөлдсөний эцэст өөрчилж болно.**¹⁹ Өөрөөр хэлбэл Бээжингийн ийм хууль батлуулан мөрдүүлэх эрх Хо.К-ын суурь хуульд шууд бусаар тусгагдсан гэсэн үг. ҮАБТХууль батлагдах үеийн Ерөнхий сайд Керри Лемийн тус хуулийг Хо.К-д мөрдүүлэх тухай 2020 оны L.N. 136 дугаартай “Үндэсний хуулийн тунхаглал”-д ч уг зохицуулалтыг үндэс болгосон байна.

Дурдсан суурь хуулийн §23-д Хо.К өөрийн гэсэн Үндэсний аюулгүй байдлын тухай хуультай байж болохоор тусгасан ба 2003 онд ийм хууль батлах анхны оролдлогыг хийсэн ч олон нийтийн эсэргүүцлийн улмаас төслийг буцаан татсан ба эсэргүүцлийн хөдөлгөөн нь Хууль зүйн консулын гишүүн Жеймс Тиенийг огцруулах үндэслэл болсон. Тус төсөлд ч мөн салан тусгаарлах, эх орноосоо урвах зэрэг тодорхой хэргүүдэд цагдаа нарын бүрэн эрхийг (нэгжих, саатуулах, орон байранд нэвтрэх гэх мэт) ямар нэг зөвшөөрөл шаардалгүй хэрэгжүүлэх боломжтой байхаар тусгасан байв.²⁰ Ийм ч учраас 2020 оны хуулийг олон **нийтэд танилцуулалгүйгээр** буюу

¹⁸ Хо.К-ын Суурь хуулийн §18-ын 3 дугаар догол мөр.

²⁰ Хо.К-ын Засгийн газраас мэдээлсэн төслийн Англи орчуулга: <https://www.info.gov.hk/gia/general/200304/16/0416201.htm>

²¹ Энэ оролдлогын онцлог нь цаг хугацааны хувьд тухайн үед SARS вирус дэгдээд байсан нь ковидын үетэй төстэй нөхцөл байдлыг үүсгэсэн байв.

¹⁸ https://www.basiclaw.gov.hk/filemanager/content/en/files/basiclawtext/basiclaw_full_text.pdf

эл хуулийн эсрэг эвлэлдэн нэгдэх боломж олголгүйгээр баталсан байна.

Гурав. Хууль хэрэгжиж эхэлсний дараах эмпирик үр дагаварын тойм

Тус хуулиар Бээжингийн нөлөөг Хо.К-д ихээр нэмэгдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, шүүхийн буюу эрх зүйн бие даасан тогтолцоонд ноцтой уршиг учруулах зэрэг олон үр дагаварыг үүсгэв. Энэ талаар Нэгдсэн Вант Улс, Европын Консул, НАТО зэрэг олон талууд "Хятад улс Хо.К дахь эрх зүйн ёсыг устгаж буй" талаар мэдэгдэл гаргаж НВУ, Канад, Тайван зэрэг улсууд иргэдээ Хо.К-д жуулчлахын эсрэг анхааруулж байв.²² ²³ Уг хуулийг батлагдсан даруйд хуулийн зохицуулалт, ял шийтгэлээс эмээсэн ардчилсан эсэргүүцлийн хөдөлгөөнүүд үйл ажиллагаагаа зогсоож буй талаараа мэдэгдсэн. Тухайлбал 2014 оны "Шүхрийн хөдөлгөөн"-ий удирдагчдын нэг

Жошуа Вон "Энэ хууль дэлхийн урьд өмнө мэддэг байсан Хо.К-ын төгсгөлийг илэрхийлэх боллоо" хэмээгээд "Демосисто" ардчилсан хөдөлгөөнөөс гарч буйгаа илэрхийлсэн байна.²⁴

Хууль хүчин төгөлдөр болмогц "Хо.К-ын тусгаар тогтнол" хэмээх бичигтэй далбаа барьсан иргэдийг баривчилж эхэлсэн ба тус хотын цагдаагийн газраас энэ талаараа твиттерт мэдээлсэн байна. НВУ-аас (Нэгдсэн Вант Улс) Хо.К-ын иргэдийн визний хугацааг сунгахаас гадна 3 сая гаруй иргэдэд Британы паспорт авах боломжийг олгосон ба хувь шинжээчид, зарим улсын төрийн албан хаагчид уг хууль Хятадыг эдийн засгийн давуу бус нөхцөл байдалд оруулах талаар анхааруулжээ. Тухайлбал Хо.К-ын улс төр судлаач асан Брайн Фон "Хо.К-оор дамжуулан бусад улсын технологи, албан ёсны харилцаа тогтоож байсан боломжоо Хятадын улс төрийн хүчин алдах" талаар үндэслэл дэвшүүлсэн бол Британы Гадаад харилцааны нарийн бичгийн дарга Малколм Рифкинд "Хо.К-ын асуудлыг нухацтай хөндвөл Хятадуудад Ахилесийн өсгий²⁵ бий" хэмээн тодотгоод "Хятадууд төлөвлөж буй зүйлээ гүйцэтгэлээ гэхэд эдийн засгийн асар өндөр ач холбогдолтой Хо.К-ыг Хятадын тогтолцоонд татан оролцуулж чадахгүй. Хоосон хальстай л үлдэнэ" хэмээн мэдэгдсэн байна.²⁶

²² Английн Засгийн газраас тус хуулийн талаар үнэлгээ хийж, иргэддээ анхааруулга өгсөн байдал: <https://www.gov.uk/government/publications/china-country-policy-and-information-notes/country-policy-and-information-note-hong-kong-national-security-law-china-june-2022-accessible#consideration-of-issues>; BBC-д нийтэлсэн өгүүлэл: <https://www.bbc.com/news/world-asia-china-53234255>;

²³ НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга Женс Штөптенберг: "Хо.К дахь ҮАБт Хууль тус бүсийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлж буйгаас ... Хятадууд бидний дундын үнэт зүйлс болох ардчилал, эрх чөлөө, эрх зүйт ёсыг хүлээн зөвшөөрдөггүй нь тодорхой байна" хэмээн мэдэгдсэн. Тэрээр АНУ-ын Батлан хамгаалах төрийн нарийн бичгийн дарга Марк Эспертэй хамтран мэдэгдэл хийсэн. <https://www.reuters.com/article/us-china-hongkong-security-nato-idUSKBN2411JP>

²⁴ <https://www.bbc.com/news/world-asia-china-53231158>

²⁵ Ноцтой сул тан

²⁶ <https://www.theguardian.com/world/2020/jun/11/>

2022 оны эхээр НВУ-аас төлөөнд сууж байсан Хо.К-ын Дээд шүүхийн шүүгч нар Роберт Рийд, Патрик Ходж нар шинэ хуулиар бий болсон заналхийллийн улмаас шүүгчийн албанаас татгалзаж буйгаа зарласан. Apple daily зэрэг хэд хэдэн ардчилсан үзэл бүхий чөлөөт хэвлэл хаалгаа барьжээ.²⁷ Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг онцгойлон хязгаарласнаар шинэ хуулийн үр дүнд Хо.К-ын хязгаарлагдмал тусгаар тогтнол бодит байдал дээр 1987 оны хамтын тунхаглалд зааснаас хавьгүй эрт дуусгавар болох эрсдэлд оржээ.

Дүгнэлт

Эрх зүйт ёсны зарчмын дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг тодорхойлох, аюулгүй байдлын механизмыг тодорхойлох, аюулгүй байдлаа хангах үйл ажиллагаа явуулах зэргийг хууль тогтоомжид нийцүүлэх, тулгуурлах шаардлагатай. Энэ утгаараа эрх зүй ба аюулгүй байдал нь хоорондоо салшгүй холбоотой ухагдахуун болно. Хо.К-ын суурь хуульд өөрсдийн гэсэн үндэсний аюулгүй байдлын тухай хуультай байж болохоор заасан нь үзэл баримтлалын хувьд бие даасан байдал, тусгаар байдлаа суурь хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ хүрээнд, эх газрын Хятадаас хараат бусаар өөрсдөө хамгаалах боломжийг олгож байсан. Гэвч тус

заалтын (§23) үзэл санааг зөрчиж эх газрын Хятадын хуулийг хэрэгжүүлж болох үндэслэлд (§18) тулгуурлан ҮАБтХууль баталсан нь Хятад-Британы хамтын тунхаглал, Хо.К-ын суурь хуулиар хүлээн зөвшөөрч баталгаажуулсан харьцангуй бие даасан байдлаа алдахад хүргэжээ.

Хо.К-ын ҮАБ-ын тухай шинэ хууль нь Бээжингээс тус бүсэд өөрсдийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх хүчтэй механизмыг тогтоож өгснөөр Хо.К-ын уг тусгаар байдал хэлбэрийн төдийд л үргэлжлэх эрсдлийг бий болголоо. Тус хуулийг батлах эрх зүйн үндэслэлийг буруу тодорхойлсон; Бээжинд ашигтай үндэслэлд хүчээр тулгуурласан нь уг зохицуулалтын үндэс болсон суурь хуулийнхаа үзэл баримтлал, хамгаалалтыг сулруулсан, зарим талаар зөрчсөн шинжтэй байна. Улмаар эмпирик үр дагаварын хувьд цаашид ч суурь хуулийн III хавсралтыг эх газрын Хятадаас өөрчлөхөд улам хялбар байх бодит боломж бүрджээ.

dominic-raab-urges-china-to-heed-uks-hong-kong-warnings

²⁷ <https://www.bbc.com/news/world-asia-china-52765838>

ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ



Сонгинохайрхан дүүргийн
Эрүүгийн хэргийн анхан шатны
шүүгч, Шихихутуг их сургуулийн
докторант Б.Батаа

Гарчиг

Удиртгал

1. Хөөн хэлэлцэх хугацааны үүсэл хөгжил
 2. Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа
 3. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зорилго
 4. Гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох, тоолох зарчим
 5. Олон улсын эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа
- Дүгнэлт

Удиртгал

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд эрүүгийн хариуцлага нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг

хязгаарладаг хамгийн хүнд хууль зүйн хариуцлагын хэлбэр билээ. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 4 жил гаруйн хугацаа өнгөрч байгаа боловч уг хуулийг мөрдөж эхэлсэн цагаасаа эхлэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэглэхэд хүндрэл гарсаар байна.

Түүнчлэн шинэчлэн найруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулахаар заасны дагуу анхан болон давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн шүүгч нарын санал болон Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимд ирүүлсэн асуулгад үндэслэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаарх онолын ойлголтыг сэргээх, олон улсын чиг хандлагыг дэлгэрүүлэн судлах зорилгоор энэхүү сэдвийг бэлтгэсэн болно.

1. Хөөн хэлэлцэх хугацааны үүсэл хөгжил

Дэлхийн ихэнх улсад гэмт хэрэгтэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болох тодорхой хугацааг тусгайлсан хуулиар, эсхүл Эрүүгийн хуульдаа зохицуулж өгсөн байдаг. Хөөн хэлэлцэх хугацааны институт

нь Ромын эрх зүйгээс үүсэлтэй бөгөөд Герман зэрэг Европын зарим улс орнууд Ромын эрх зүйд суурилан эрх зүйн системээ хөгжүүлсэн байдаг тул Ром-Германы гэх иргэний эрх зүйн бүлд хамаарах улсуудад хөөн хэлэлцэх хугацаа нь онолын төдийгүй зарчмын шинжтэй хэрэглэгдэх болсон байна. Тодруулбал, Ромын эрх зүйн гол эх сурвалж болох “12 хүснэгтийн хууль”-ийн “Газар, өмчтэй холбоотой харилцааны тухай” 6 дугаар хүснэгтийн 3 дахь хэсэгт “Хөдлөх эд хөрөнгийг шударга бусаар эзэмших хугацаа эд хөрөнгө олж авснаас хойш нэг жил байх бөгөөд барилга, үл хөдлөх эд хөрөнгийн шударга бус эзэмшлийн хугацаа хоёр жил байна” гэж заасан нь хөөн хэлэлцэх хугацааны талаарх эрх зүйн зохицуулалтын эхлэл болсон байна. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацааны талаарх хэм хэмжээ нь анх иргэний эрх зүйд үүссэн ажээ.

Харин нийтийн эрх зүйн бүлийн эцэг болох Англид “цаг хугацааны алдагдал нь Хааны эрх мэдлийг хязгаарлаж чадахгүй” (*nullum tempus occurrit regi*) гэсэн үзэл сургаал ноёрхож байсан учир Англи болон Саксончуудын хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд цаг хугацааны хязгаарлалт тогтоосон хэм хэмжээ бараг байгаагүй байжээ. Энэхүү сургаал нь Английн колони байсан улс орнуудад мөн нөлөөлж, эрх зүйн системд нь хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Хөөн хэлэлцэх хугацааг

хязгаарлагдмал ашиглах Английн бодлогыг 1652 оноос эхлэн АНУ-д хүлээн зөвшөөрөхөө больж, 1790 онд Холбооны ихэнх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцох хуулийг баталжээ. Тэр цагаас хойш АНУ-д хөөн хэлэлцэх хугацааны талаарх эрх зүйн хэм хэмжээг хөгжүүлсээр ирсэн юм. Өнөөдөр тус улсын ихэнх муж улсад гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны хязгаарлалт тогтоодог боловч онц хүнд зарим гэмт хэрэгт уг хугацааг тооцдоггүй хэвээр байна.

Хүн төрөлхтөн гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг ял завшуулах зорилгоор хөөн хэлэлцэх хугацаа гэсэн ойлголтыг бодож олоогүй юм. Цаг хугацааны хязгаар тогтоохгүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэчнээн их сунжирдаг, үндэслэлгүйгээр хойшилдог, үүнээс болж бодит үнэнийг тогтооход хүндрэл учирдаг болохыг тэд биеэр үзсэн, харсан, туулсан учир хөөн хэлэлцэх хугацааг хүлээн зөвшөөрч, цаг хугацаа алдагдсаны улмаас бодит үнэн бүдгэрч байснаас цөөн тохиолдолд хэн нэгэн ял завших нь илүү дээр гэж үзсэн болохоор өнөөдөр дэлхийн бүх улсад ихэнх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолж байна.

Манай улсын эрүүгийн эрх зүйн хөгжил нь ЗСБНХУ-ын эрүүгийн эрх зүйтэй салшгүй холбоотой бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг Германы эрх зүйн системээс харьцангуй өөрөөр авч үзсэн байдаг. Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хариуцлагад

татаж болохгүй, шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй гэсэн ялгаатай хугацаагаар тооцож ирсэн байна. Энэ талаар түүхэн уламжлалын талаарх дараагийн сэдэвт тодорхой тусгагдах болно.

Дэлхий дахинд, ялангуяа эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацаа тогтоох ёстой гэсэн үзэл санааг дараах үндэслэлүүдэд тулгуурлан хөгжүүлж ирсэн байна. Үүнд:

- Үйл баримт бүдгэрдэг
- Нотлох баримтын чадамж сулардаг
- Бодит үнэнийг тогтоох зарчим алдагддаг
- Ялын зорилго биелэхгүй болдог
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжирдаг
- Эрүү шүүлтийн эрсдэл нэмэгддэг
- Ялаас гадуурх төрийн дарамт

2. Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа

Тодорхой хугацаа өнгөрсний дараа гэмт хэрэгтнийг яллах боломжгүй болгодог гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хуулийн зорилго, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хязгаарлах замаар гэмт хэрэгтэй тэмцэх, шалгах, нотлох үүрэг бүхий төрийн үйл ажиллагааг хариуцлагатай болгох хууль зүйн хариу арга хэрэгсэл гэж ойлгож болно. Хэрэв ийм хууль үгүй бол гэмт хэрэг гарснаас хойш хэчнээн хугацаа өнгөрсөн ч эрүүгийн хэрэг

үүсгэх, ял шийтгэл оногдуулах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх мэдэл төрд хадгалагдсаар байх болно. Иймд төрөөс хэн нэгнийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах эрх мэдлийг зохих хэмжээнд хязгаарлах замаар хариуцлагатай төр бий болгох гэсэн хүн төрөлхтний оролдлого нь эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацаа тогтоох үндэслэл болсон байдаг. Эрүүгийн хууль, эсхүл тусгайлсан хуулиар гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойших тодорхой хугацааг тодорхойлсон байдаг бөгөөд төр энэ хугацаанд л эрүүгийн хэрэг үүсгэх эрх мэдэлтэй байна. Хэрэв тухайн хугацаа өнгөрсний дараа прокурор эрүүгийн хэрэг үүсгэсэн бол иргэний эрх зүйн бүлийн ихэнх улс оронд яллагдагч болон түүний өмгөөлөгч тухайн хэргийг хэрэгсэхгүй болгуулах тухай хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй байдаг.

Нөгөө талаас, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш өнгөрсөн хугацаанаас хамааран хуучирсан буюу үйл баримт нотолгоо нь бүдгэрсэн гэмт хэрэгт хилсээр яллагдахаас хүн бүрийг сэргийлдэг хууль гэж үзэж болно. Хөөн хэлэлцэх хугацааг олон улсын эх сурвалжуудад англиар "The statute of limitations" буюу үгчлэн орчуулбал хязгаарлалтын дүрэм гэсэн агуулгатай томъёолсон нь тохиолдлын хэрэг биш бөгөөд нэг талаас, төрийн яллах эрхийг хязгаарлах, нөгөө талаас, мөрдөн

шалгах ажиллагааг дуусгавар болгох гэсэн агуулгатай нь шууд холбоотой.

Хөөн хэлэлцэх хугацааг үг зүйн талаас нь авч үзвэл: Монгол хэлний товч тайлбар тольд «хөөх» хэмээх үг нь үлдэх, илгээх гэсэн утгатай, "хэлэлцэх" хэмээх үг нь 1/харилцан ярилцах, 2/олноор буюу бусдын хамт хэлэх гэсэн утгыг агуулна, "хугацаа" хэмээх үг нь үйл ажилд өдөр хоног цаг болзож хэмжээлсэн хэмжээ гэсэн утгыг тус тус илэрхийлдэг гэж тайлбарласан бол Монгол хэлний их тайлбар тольд «хөөх» хэмээх үг нь үлдэх, илгээх, "хэлэлцэх" хэмээх үг нь 1/харилцан ярилцах, зөвшилцөх, 2/олноор болон бусдын хамт хэлэх ярих, "хугацаа" хэмээх үг нь 1/орчлонгийн бүх юмс, үзэгдэл, цаг хугацаа, орон зайн дотор үйл ажиллагааны явагдах цагийн үргэлжлэх хэмжээ, 2/секунд, минут, цаг, өдөр, сар, жилээр нэгж болгосон цаг тооны хэм гэсэн утгыг тус тус илэрхийлдэг хэмээн үг тус бүрээр нь тодорхойлон тайлбарлажээ.

Харин дээрх нэр томъёог утга, агуулгын хувьд хууль зүйн эрдэмтэн, судлаачид өөрийн бүтээлдээ дараах байдлаар тайлбарласан байна. Тухайлбал, Академич Ж.Амарсанаа нарын "Хууль зүйн тайлбар толь" бүтээлд "эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааг хуульд заасан тодорхой хугацаа өнгөрч хуулиар тодорхойлсон нөхцөл байдал бий болсон нөхцөлд эрүүгийн хариуцлага буюу шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх үгүйсгэгдэх нөхцөл байдал" гэж, академич С.Нарангэрэл

"Монголын эрх зүйн эх толь бичиг" бүтээлдээ "хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн эрх зүйд эрүүгийн эрх зүйн институтын нэг, хэрэв шүүн таслах ажиллагаанаас зайлсхийгээгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хугацаа" гэж тайлбарласан бол хууль зүйн шинжлэх ухааны доктор Г.Совд "Эрүүгийн хуулийн тайлбар" бүтээлдээ "гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй (хөөн хэлэлцэх) хугацааг хуульчилсан явдал бол гэмт хэрэг үйлдсэнээс хойш уг этгээдийг илрүүлж, эрүүгийн хариуцлагад таталгүй удаан хугацаа өнгөрсөн үед хуульд заасан болзол бүрдсэн нөхцөлд хэрэг хуучирсан буюу хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэх нь хууль ёсны үндэслэл юм. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш илрэхгүй хуульд заасан хугацаа өнгөрч гэмт хэрэг хуучирсан тохиолдолд эрүүгийн хариуцлагад татаж болдоггүйн шалтгаан гэвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ямар ч зорилгогүй болсон байдаг" гэжээ.

Түүнчлэн, доктор Г.Гантөмөр нарын "Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа" бүтээлд "Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь үйлдэгдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан хийсэн гэмт хэргийн ангилал, шийтгэсэн ялын төрөл хугацаагаар харгалзан ялгамжтай тогтоосон, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон хуулийн

хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болох хугацааг хэлнэ” гэж тодорхойлсон байна.

Манай улсын хувьд 1961 оны Эрүүгийн хуульд анх “хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн томъёоллоор хуульчлагдсан бөгөөд сүүлд 2015 оны Эрүүгийн хуульд мөн энэхүү нэр томъёог ашигласан байдаг. Үг зүйн хувьд энэ нь товч бөгөөд маш оновчтой томъёолол болсон хэмээн судлаачийн хувьд үзэж байгаа болно. Учир нь, хөөх буюу “гэмт этгээдийг эрж олох”, хэлэлцэх буюу “зөв бурууг шүүн тунгаах”, хугацаа буюу “цаг тооны хэмжүүр” гурвын нийлэмжээс “гэмт хэрэг үйлдсэн хэн нэгнийг эрж олох, шүүхийн өмнө авчирч олны өмнө шүүн тунгаах боломжтой хугацаа” гэсэн логик дүгнэлт шууд урган гарна.

ОХУ болон пост коммунист улсуудын эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хариуцлагад татах хугацаа гэсэн агуулгаар тодорхойлж ирсэн бөгөөд хууль зүйн үр дагавар нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх байв. Онолын хувьд эрүүгийн хариуцлагад татах гэдэг нь ял сонсгож яллагдагчаар татах ажиллагааг хэлдэг боловч практикт хөөн хэлэлцэх хугацаа нь яллагдагчаар татах болон гэм буруутай эсэхийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд төдийлөн хязгаарлалт болдоггүй бөгөөд зөвхөн эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болгон хэрэглэх хандлага хэвээр

хадгалагдсаар байна.

Хөөн хэлэлцэх хугацааны үүсэл хөгжлийн үүднээс авч үзвэл дундад зууны үед хөөн хэлэлцэх хугацааг ял халдааж болохгүй хугацаа гэсэн агуулгаар авч үзэх хандлага түгээмэл байсан юм. Учир нь, позитивист буюу норматив хэм хэмжээний онолоор эрх олгосон буюу үүрэг бий болгосон хэм хэмжээг материаллаг, харин үйл ажиллагааг журамласан хэм хэмжээг процессын гэж төрөлжүүлдэг. Иймд бичмэл хуулийн системд хөөн хэлэлцэх хугацааг тоолох, зогсоох, түдгэлзүүлэх, тасалдах буюу дахин шинээр тоолохтой холбоотой хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийг хэрэглэх эрх бүхий субъектэд эрх, үүрэг бий болгосон материаллаг хэм хэмжээ гэж үзээд Эрүүгийн хуульд тусгаж ирсэн уламжлалтай юм. Харин орчин цагт эрүүгийн хэрэг үүсгэх төдийгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй хугацаа гэсэн утга санаагаар процессын шинжтэй болж хувьсан өөрчлөгджээ. Жишээ нь, иргэний эрх зүйн бүлийн улс орнуудын сонгодог төлөөлөл болох ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг “яллаж болохгүй хугацаа”, “мөрдөн шалгах ажиллагаа явуулж болохгүй хугацаа” гэсэн хоёр өөр нөхцөлөөр ялгаатай тоолдог болсон. Хэрэв яллаж болох хугацаа нь өнгөрсөн бол хэнийг ч яллагдагчаар татахгүй, шүүх хуралдаан хийхгүй, ял шийтгэл оногдуулахгүй.

3. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зорилго

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А(XXI) тоот тогтоолоор батлагдсан, Монгол Улс 1968 оны 01 дүгээр сарын 05-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Баривчлагдсан болон эрүүгийн хэрэгт буруутгагдсан ямар ч хүнийг шүүхэд даруй шилжүүлэх бөгөөд хэн боловч хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй." хэмээн баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах үр дүнтэй хууль зүйн арга хэрэгсэл нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа юм.

Иймээс гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны хамгийн чухал зорилго нь хэн нэгнийг удаан хугацаанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дарамтад байхаас хамгаалахад оршино. Бодит байдал дээр цаг хугацаа өнгөрөх тусам үйл явдлууд мартагдаж, нотлох баримтууд алдагдаж, ялангуяа нийгмийн хор аюул бүдгэрч, эрүүгийн хариуцлагын зорилго биелэхгүй, эсхүл ял шийтгэл нь утга учиргүй болдог нь хуулиас үл хамаарах нийгмийн үзэгдэл билээ. Түүнчлэн, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэгт холбогдсон хэн нэгнийг хамгаалахад шаардлагатай гэрч байхгүй болох, нотлох баримтууд тодорхой

хугацаа өнгөрсний дараа бүрдэх боломжгүй болдог тул Засгийн газар буюу хууль сахиулагчийн мөрдөн шалгах ажиллагаа эцэс төгсгөлгүй үргэлжлэхийг зөвшөөрөх ёсгүй гэсэн либерал онолдээр суурилсан байдаг. Шүүгдэгч хэдий гэм буруутай байсан ч эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, тухайлбал эдийн засаг, нийгмийн хүчин зүйл нь ач холбогдолгүй болж хувирах нь ч түгээмэл байдаг. Эдгээр хүчин зүйлсийн зарим нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашрахад нөлөө үзүүлдэг хэдий ч шүүх хуралдаанд яллах чиг үүргийг төрийн нэрийн өмнөөс прокурор хэрэгжүүлдэг учир төрийн эрх мэдлийг хязгаарлах хөөн хэлэлцэх хугацааны зорилгыг санах нь зүйтэй.

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зорилго нь хүний өөрийгөө хамгаалах, өмгөөлөх заяамал эрхтэй нягт холбоотой бөгөөд цаг хугацаа өнгөрөх тусам нотолгооны чадамж суларч, гэрч, хохирогч зэрэг хүмүүсийн хэргийн талаарх ой санамж бүдгэрч, үйл баримтыг бүрэн бодитой тогтоох боломж хязгаарлагдаж болох эрсдэлтэй үед эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхад оршино. "Цаг хугацаа өнгөрөх тусам хэн нэгнийг гэм буруутайг нотлох баримтууд сулрахын зэрэгцээ нөгөө талаас гэм буруугүйг нотлох баримтууд ч аажмаар устаж байдгийг хууль тогтоогчид хүлээн зөвшөөрч, хуулиар хязгаарлалт тогтоосон

нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх боломжит хугацаа юм.”

Иймд олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцоор баталгаажсан өөрт холбогдох хэргээ түргэн шуурхай шалгуулах, боломжит богино хугацаанд хэргээ шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны зорилго, хууль зүйн үндэслэлийг тодорхой болгодог гэж үзэх нийтлэг чиг хандлага бий болоод байна. Ийнхүү хөөн хэлэлцэх хугацаа тогтоож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болох хугацааны хязгаар бий болгосноор гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхэд үр нөлөөтэй хөшүүрэг болдог нь төрд буюу олон нийтэд тустай гэж үздэг болжээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хугацааны хязгаарлалт нь өнөө үед үндэстэн дамнасан болон зохион байгуулалттай гэмт хэрэг, албан тушаал, эдийн засгийн гэх мэт гэмт хэргээс үүдэлтэй олон нийтийн шахалт шаардлагаас илүү дарамтыг хууль сахиулагч, прокурорт учруулж байна гэж үзэх эрдэмтэд ч бас байдаг. Гэхдээ хуульч, эрдэмтдийн олонх нь хууль сахиулах болон прокурорын байгууллагын хүний нөөцийн чадамж, санхүүгийн хязгаарлагдмал байдал зэрэг техникийн шинжтэй хүндрэл нь хөөн хэлэлцэх хугацааны зорилгыг үгүйсгэх үндэслэл болохгүйг цохон тэмдэглэжээ. Харин улс орнууд хууль сахиулах болон прокурорын

байгууллагын чадамжийг сайжруулах замаар мөрдөн шалгах хугацааны үргэлжлэлийг багасгах ёстой гэж үзсэн байдаг.

Хуулиар тогтоосон хугацааны хязгаарлалтын бас нэгэн зорилго нь мөрдөх ажиллагааг хурдан шуурхай болгоод зогсохгүй гэмт хэрэгт холбогдсон хэн боловч илүү нотолгоотой баримтаар хэргээ шийдвэрлүүлэх хууль ёсны баталгаа болдогт оршино. Гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй тохиолдолд зарим нэгэн хуучирсан гэмт хэрэгт нотолгооны чадамж суларсан баримтаар хэн нэгнийг яллах буюу хүний эрхийн суурь баталгааг доройтуулах эрсдэлтэй гэж хүний эрхийн хуульчид үздэг. Нөгөө талаас, эрдэмтэн судлаачдаас эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацаа тогтоохыг эсэргүүцэх үндэслэл гаргаагүй байгаа боловч оновчгүй буюу мөрдөн шалгах төвөгтэй ажиллагаа шаардах тодорхой төрлийн гэмт хэрэгт хэт богино хугацаа тогтоох нь ял шийтгэлийн тодорхой байдлыг бууруулж, шударга ёсны зарчмыг алдагдуулж, улмаар тухайн төрлийн гэмт хэргийг зохих хэмжээгээр өдөөх хүчин зүйл болохыг дурдсаар байна. Нийтийн эрх зүйн бүлийн зарим хуульчид “хөөн хэлэлцэх хугацаанаас өөр нэг боломжит хувилбар бол шударга ёс, олон нийтийн эрх ашгаас шалтгаалсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэрэгт яллах ажиллагааг явуулах эрхийг прокурорт, шүүхээр

хэлэлцэх эсэх эрхийг шүүхэд олгох явдал юм" гэж үздэг. Гэсэн хэдий ч энэхүү үзэмжийг хэрэгжүүлэх нь улс төрийн ашиг сонирхол, хэсэг бүлэг хүмүүсийн хүсэл эрмэлзэлд хөтлөгдөх эрсдэлтэй байдаг тул төдийлөн хэрэгжүүлсэн улс орон одоогоор алга.

4. Гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох, тоолох зарчим

Гэмт хэрэг гарсан талаар хууль сахиулах байгууллагад мэдэгдсэнээс эхлэн тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажиллагаа эхлэх боловч хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг төгссөн цаг мөчөөс тоологдоод эхэлчихсэн байдаг тул гэмт этгээдийг аль болох хурдан шуурхай илрүүлж, нотлох баримтыг олж тогтоон яллагдагчаар татах нь төрийн тодруулбал, Засгийн газрын үүрэг байдаг.

Гэвч зарим хүнд, эсхүл зохион байгуулалттай гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааран гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлж, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа удаашрах тохиолдол цөөнгүй гардаг. Иймд хууль сахиулагч болон прокурорууд хөөн хэлэлцэх хугацаатай уралдан ажиллах шаардлага үүсдэг. Энэ эрсдэлийг бууруулах гол арга зам нь хууль тогтоогчоос гэмт хэрэг тус бүр дээр бодитой бөгөөд ялгамжтай хугацаа тогтоох явдал юм. Хүнд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг улс орнуудад харилцан адилгүй өөр

өөрөөр тогтоосон байдаг. Ихэнх улс оронд хөнгөн гэмт хэрэгт нэг жилээс таван жилийн хооронд хугацааны хязгаарлалт тогтоодог бөгөөд жижиг гэмт хэрэг буюу зөрчлийн хувьд үүнээс ч богино хугацаатай байдаг. Зарим улсад хөнгөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа нь дуусаагүй байхад эрүүгийн хэрэг үүсгэсэн ч түүнээс хойш нэг жилийн дотор хэргээ шүүхэд шилжүүлээгүй бол яллах үндэслэлгүй болдог.

Ерөнхийдөө улс орнуудад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоодог нийтлэг шалгуур байна. Үүнд, эрүүгийн хуулиар хамгаалагдсан үнэт зүйл, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, түүнийг нөхөн сэргээх боломж бололцоо, тухайн хэрэгт оногдуулж болох ялын төрөл, хэмжээ хамаарна. Гэхдээ сүүлийн үед хэрэг хянан шийдвэрлэх боломжит хугацааг харгалзан үзэх хандлага бий болж байна. Ялангуяа, үндэстэн дамнасан зохион байгуулалттай болон эдийн засгийн шинжтэй, эсхүл албан тушаалтан оролцсон хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг илүү урт тогтоох болжээ. Түүнчлэн, хөөн хэлэлцэх хугацаа үл хамаарах гэмт хэргүүдийг эрүүгийн хуульд тусгайлан тогтоосон байдаг. Зарчмын хувьд бүх насаар хорих, эсхүл цаазаар авах ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байхаар хуульчлах нь хандлага түгээмэл байна. Мөн хүн хулгайлах, барьцаалах, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл зэрэг гэмт хэргийг

хөөн хэлэлцэх хугацаагүй болгосон улс орон ч байна. Зарим улсад эх орноосоо урвах гэх мэт үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байдаггүй.

Хөөн хэлэлцэх хугацааг тогтоох хүчин зүйл нь тухайн улс орны эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил зэргээс хамааран харилцан адилгүй байх боловчихэнхдээ ялын бодлоготойгоо уялдуулах уламжлалт хандлага түгээмэл байна. Гэтэл бодит байдал дээр оногдуулах ял шийтгэл нь хүнийг алах гэмт хэргээс бага боловч хор уршиг нь нийт ард иргэдэд сөрөг нөлөө үзүүлдэг, шалгах ажиллагаа нь нэлээд хугацаа шаарддаг, эсхүл эрх мэдлийн нөлөөллөөс шалтгаалан хожуу илэрдэг хэргүүд цөөнгүй байдаг. Иймд процесс ажиллагааны болон субъектийн онцлогийг харгалзан хөөн хэлэлцэх хугацааг уртасгах чиг хандлага шинэ тутам гарч байгаа бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг тогтоохдоо дараах шалгууруудыг цогцоор нь авч үздэг болсон байна.

ШАЛГУУР

- Олон улсын эрх зүй
- Хамгаалагдсан үнэт зүйл
- Хохирол, хор уршиг, нөхөн сэргээгдэх боломж

ШАЛГУУР

- Ялын бодлого
- Гэмт хэргийн ангилал
- Гэмт хэргийн төрөл

ШАЛГУУР

- Эрүүгийн нөхцөл байдал
- Шинэ тутам гэмт хэрэг
- Хэрэг хянан шийдвэрлэх боломжит хугацаа

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэх, зогсоох зэргээр прокурор хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, шүүхийн өмнө гэмт этгээдийг яллах эрх хэмжээгээ хадгалж үлдэх боломжтой байдаг. Жишээ нь: яллагдагч оргон зайлсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлж болно. Харин яллагдагчаар татагдвал зохих хүн хаана байгаа нь тодорхойгүй, эсхүл тухайн улсад байхгүй үндэслэлээр эрэн сурвалжлах ажиллагааг эхлүүлсэн бол түүнийг олдох хүртэл хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлдэг. Зарим улсын хуульд гадаад улсаас нотлох баримт олж авах шаардлагатай тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох буюу түдгэлзүүлэх зохицуулалт бас байдаг.

Дэлхийн эрүүгийн процессын загвар хуульд тусгаснаар хэн нэгэн гэмт хэрэг үйлдсэн болох нь хангалттай нотлогдож яллагдагчаар татагдсан бол хөөн хэлэлцэх хугацааг зогсоохоор тусгасан бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэх болон яллагдагчаар татах ажиллагааг цаг хугацааны хувьд нэг цэгт аваачсан байдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг гарсан болох нь тогтоогдохоос гадна түүнийг хэн үйлдсэн болох нь нотлогдсон үед эрүүгийн хэрэг үүсгэх бөгөөд эзэнгүй эрүүгийн хэрэг гэсэн ойлголтыг халсан байна. Манай улсын хувьд 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөн эрүүгийн хэрэг үүсгэх болон яллагдагчаар татах

ажиллагааг нэгтгэсэн боловч хөөн хэлэлцэх хугацаа зогсох талаар Эрүүгийн хуульд зөрүүтэй хуульчилснаас үүдэн хэрэглэхэд төвөгтэй байдал үүссэн. Энэ талаар энэ сургалтын 2 дугаар сэдвийн хүрээнд авч үзэх болно.

5. Олон улсын эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа

Олон улсын эрх зүйн хүрээнд хөгжсөн, ялангуяа дэлхийн II дайны дараа эрх зүйн баримт бичгийн хувьд баталгаажсан салбар болох олон улсын эрүүгийн эрх зүй юм. Энэхүү салбар эрх зүй нь хүн төрөлхтний эсрэг болон дайны үеийн гэмт хэргийг голчлон авч үзэж эхэлсэн бөгөөд үндэстэн дамнасан, эсхүл үндэстэн дотроо боловч олон хүний эсрэг чиглэсэн гэмт явдлыг олон улсын шинжтэй гэмт хэрэгт хамааруулан тайлбарласан байдаг. Олон улсын эрүүгийн эрх зүйн суурь баримт бичиг нь Олон эрүүгийн шүүхийн Ромын дүрэм бөгөөд уг хууль нь материаллаг болон процессын хэм хэмжээг нэгтгэн системчилснээрээ нэлээд өвөрмөц болсон төдийгүй иргэний эрх зүйн бүлийн улс оронд материаллаг болон процессын тус тусад нь системчлэх ёстой гэсэн уламжлалт сэтгэлгээг халсан гэж үзэж болно.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 29 дүгээр зүйл (Хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх)-д Олон улсын эрүүгийн шүүхэд харьяалагдах хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар

хуульчилсан байна. Энэхүү хэм хэмжээ нь дэлхийн II дайнаас үүдэлтэй бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2391 (XXIII) дугаар тогтоолоор 1968 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталж, 1970 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенцын 1 дүгээр зүйлд *"Үйлдсэн цаг хугацаанаас хамаарахгүйгээр дор дурдсан гэмт хэрэгт аливаа хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй."* гээд мөн зүйлийн (b)-д *"...дайны үе болон энхийн үед үйлдсэн байсан хамаарахгүйгээр хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг..."* гэсэн заалтаас шууд хамааралтай. Тус конвенцын 2 дугаар зүйлд *"1 дүгээр зүйлд дурдсан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэн тохиолдолд энэхүү Конвенцын заалт нь гэмт хэрэг үйлдэгч буюу түүний хамсаатнаар оролцсон, уул гэмт хэргийг үйлдэхэд бусдыг шууд тухирсан буюу гэмт хэргийг гүйцэд үйлдсэн эсэхийг харгалзахгүйгээр хэрэг үйлдэх зорилго бүхий хуйвалдаанд оролцсон төрийн эрх барих байгууллагын төлөөлөгчид болон хувь хүнд, түүнчлэн эдгээр гэмт хэргийг үйлдэх бололцоо олгосон төрийн эрх барих байгууллагын төлөөлөгчдөд хамаарна."* гэсэн нь хүн төрөлхтний эсрэг болон дайны гэмт хэрэгт эрх мэдлээ ашиглан оролцсон бүх шатны төрийн албан

хаагчид хамаарах ёстойг харуулж байна.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 29 дүгээр зүйлд "Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоож, яллагдагч шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн бол хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлэхээр дотоодын хууль тогтоомждоо заана." хэмээн хуульчилсан нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалгах, нотлох баримт бүрдүүлэх ажиллагаанд цаг хугацаа их шаарддаг болохыг илтгэнэ.

Олон эрх зүйгээр улс орнуудын дотоодын эрх зүйн хэмжээг зохицуулдаггүй боловч шаардлагатай тохиолдолд зарим төрлийн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг боломжит урт хугацаагаар тогтоож өгөхийг шаардсан жишээг Авлигын эсрэг конвенцоос харж болохоор байна. Ер нь бол хүн төрөлхтний эсрэг болон дайны гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байхыг, мөн үндэстэн дамнасан зохион байгуулалттай болон авлига албан тушаалын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг илүү уртаар тогтоож өгөхийг олон улсын эрх зүй шаардаж байгаа бөгөөд бусад гэмт хэргийн тухайд олс орнууд өөрийн орны эрүүгийн нөхцөл байдалд тохируулан тогтоох боломжийг нээлттэй үлдээжээ.

Дүгнэлт

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны үүсэл хөгжил нь эхэндээ нотлох чадвар нь суларсан баримтаар хэн нэгэнд ял оногдуулж хэлмэгдүүлэх вий, эсхүл ял оногдуулах нь угаас утгагүй, эрүүгийн хариуцлагын зорилго алдагдсан үед ял шийтгэх шаардлагагүй гэсэн үзэл баримтлалаар үндэслэлээ тайлбарлан хэрэглэж ирсэн боловч орчин цагт хэн боловч өөрт холбогдох хэргээ боломжит богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг хангах баталгаа болгон тайлбарлаж, төрөөс хэн нэгнийг удаан хугацаанд мөрдөн шалгаж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дарамтад байлгахаас сэргийлэх зорилго агуулах болжээ. Тодруулбал, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийддэг материаллаг шинжтэй байсан бол одоо улс орнууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болох эсэхийг шийдвэрлэх процессын хэм хэмжээ болгон хэрэглэх хандлага нэмэгдсээр байна. Гэхдээ материаллаг хэм хэмжээ гэж үзэж байгаа бол гэм бурууг хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлэн эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг, харин процессын хэм хэмжээ гэж үзвэл гэм буруутай эсэхийг үл харгалзан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд зогсоодог байх ёстой. Тухайн төрийн үйл ажиллагаанаас үл хамаарах хүчин зүйлийн улмаас

мөрдөн шалгах ажиллагаанд саад тулгарвал хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох буюу түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгаж өгснөөр гэмт этгээд зориудаар зайлсхийх, цаг хугацаа хожих, ял завших зэрэг сөрөг үр дагавраас сэргийлдэг.

Эцэст нь, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг төгссөн цаг мөчөөс эхлэн тоолж, эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах ажиллагаа хийгдсэнээр зогсоох нь хамгийн шударга зохицуулалт гэж үзэх боломжтой боловч прокурорууд үндэслэл муутай, эсхүл хангалтгүй нотлох баримтаар хүн, хуулийн этгээдийг яллагдагчаар татаж хөөн хэлэлцэх хугацааг зориудаар зогсоох ажлын ашиг сонирхлыг нь тогтоон барих бололцоо байхгүйг дурдах нь зүйтэй. Хэрэв эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах ажиллагааг нотлох баримт бүрдүүлэх, шүүхийн өмнө яллах үүрэгтэй субъектээс салгаж, хөндлөнгийн тал үл харах шүүхийн хяналтад оруулбал ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх боломжтой.

Ном зүй

1. Эрүүгийн хууль, 2002
2. Эрүүгийн хууль, 2015
3. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
5. Баярсайхан Б, нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011
6. Баярсайхан Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011
7. Гантөмөр Г, Амарсайхан О. Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа. УБ., 2004
8. Жанцан С. Гэмт хэргийн олонлог. УБ., 1990
9. Нарангэрэл С, Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ., 1997
10. Совд Г, БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ., 1973
11. Совд Г. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2005
12. Эрдэнэбулган Ж, Золбоо Т нар. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль. УБ., 2021
13. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа /Тулгамдаж буй асуудал/ Судалгааны тайлан. Судлаач Г.Халиунаа нар. 2021 он. Улаанбаатар хот
14. Statute of Limitation in Federal Criminal cases: An Overview. Congressional Research Service. November 14, 2017.
15. Олон улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм <https://legalinfo.mn/>

- law/details/1217?lawid=1217&sword
16. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2391 (XXIII) дугаар тогтоолоор 1968 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталж, 1970 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенц <https://legalinfo.mn/mn/detail/1225>
 17. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц https://www.legalinfo.mn/law/?cat=29&_name=%D0%9C
 18. Авлигын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц <https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>
 19. Limitation on prosecution-at what point can a crime no longer be prosecuted? - Criminal Law Germany <https://www.google.com/amp/s/criminal-law-germany.lawyer/limitation-on-prosecution-at-what-point-can-a-crime-no-longer-be-prosecuted/amp/>
 20. Criminal Statutes of Limitations - Lawinfo
 21. Time Limits for Criminal Charges: What's the Statute of Limitations | ExpertLaw
 22. The Statute of Limitations in Criminal Law: A Penetrable Barrier to Prosecution (upenn.edu)

Уучлал үзүүлэх, хүсэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын үр дагавар, маргаантай асуудлын талаарх дүн шинжилгээ



Шихихутуг их сургуулийн багш
С.Энх-Амгалан

Хураангуй: Энэхүү судалгааны ажил нь ардчилсан тогтолцоонд ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарж буй маргаантай асуудал болон үр дагаврыг судлах зорилготой. Судалгаагаар уучлал үзүүлэх эрх мэдлийн түүхэн болон хууль эрх зүйн үндсийг судалж зорилгыг тодорхойлох, шүүхийн тогтолцоо, улс төрийн байдал, олон нийтийн ойлголтод үзүүлж болзошгүй үр дагаварт дүн шинжилгээ хийнэ. Мөн уг дүн шинжилгээг Монгол болон Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын уучлал үзүүлсэн шийдвэр, тохиолдолд судалгаа хийх замаар гүйцэтгэх засаглалд олгогдсон энэхүү эрх мэдэл, хариуцлага, шударга ёсны үзэл баримтлалд хэрхэн нөлөөлж байгаа дээр суурилна. Судалгааны явцад эрх мэдлээ урвуулан ашиглахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, шударга ёсны тэнцвэртэй хандлагыг

хангахын тулд Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх үйл явцад гарч болзошгүй шинэчлэл эсвэл хязгаарлалтуудыг авч үзэх болно.

Түлхүүр үгс: Уучлал үзүүлэх эрх мэдэл, уучлал хүсэх эрх, Уучлалын институт, Үндсэн хууль, Эрх мэдлийн хяналт тэнцэл, Гүйцэтгэх засаглалын эрх мэдэл, Ерөнхийлөгч, Парламент, Шүүх, Шударга ёсны зарчим

Гарчиг

1. Удиртгал
2. Ойлголт
 - 2.1. Уучлалын төрөл
 - 2.2. Уучлал үзүүлсний дараах эрх зүйн үр дагавар
 - 2.3. Урьдчилсан уучлал дахь үйлдэгдсэн, үйлдэгдэх гэмт хэргийн асуудал
 - 2.4. Өөртөө уучлал үзүүлэх нь Үндсэн хуульд нийцэх үү?
 - 2.5. Уучлалд хамрагдах субъект хэн байх вэ?
3. Уучлал үзүүлэх нь эрх мэдлийн аль засаглалд хамаарах вэ?
 - 3.1. Ерөнхийлөгчийн үзүүлсэн уучлал нь хүчингүй болох боломжтой юу?
4. Уучлал үзүүлэхийн үнэ цэнэ
5. Шударга ёсны хүрээнд уучлал үзүүлэх, хүсэх эрхийг хэрэгжүүлэх боломж
6. Дүгнэлт
Ном зүй
Хавсралт

1. Удирдтгал

Уучлал үзүүлэх гэдэг нь нэн өвөрмөц, мөн маргаан дагуулсан эрх зүйн инситут юм. Тухайлбал уучлал гэх институтын үндсэн ухагдахууны талаарх ойлголт, ач холбогдол, засаглалын салаа мөчир болох гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн алинд хамаарах, эрх мэдэл хуваарилах онолын хувьд бусад салаа мөчир уучлал үзүүлэх эрх мэдэлд хөндлөнгөөс оролцох, хүрээ хязгаарыг нь тогтоох, хяналт тавих боломжтой эсэх?, уучлалын ач холбогдол юунд оршиж байна?, энэ эрх мэдлийг хэрэгжилт шударга ёсны зарчимд сөргөөр нөлөөлж байна уу? төрөл, хэлбэрийн хувьд ямар байдаг?, уучлалд хамрагдах субъект нь хэн байх тухайлбал Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т Монгол Улсын иргэн уучлал хүсэх эрхтэй гэж заасан нь бичвэрийн хувьд зөвхөн Монгол улсын иргэн уучлал хүсэх эрхтэй гэсэн үг үү?, энэ нь Монгол улсын эрүүгийн хуулиар, Монгол Улсын шүүхээс хариуцлага хүлээсэн хүнд хамаатай юу?, үүнээс улбаалан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний үндсэн дээр ялтан солилцоогоор шилжүүлэн авсан иргэнийг уучилж болох уу?, уучлалд хамрагдсан этгээдэд дахин уучлал үзүүлж болох уу?, уучлал үзүүлэх тохиолдолд хохирогчийн ашиг сонирхол яах вэ?, уучлал үзүүлэх эрх мэдэл өөртөө урьдчилсан байдлаар уучлал үзүүлэх боломжийг агуулж буй эсэх?, үүнтэй холбоотойгоор

уучлал үзүүлэх эрхтэй этгээд өөртөө уучлал үзүүлж болох уу?, ерөөс уучлал үзүүлснээс гарах эрх зүйн үр дагавар юу байх вэ? гэх мэт олон шийдвэрлэвэл зохих асуудлууд байна.

2. Уучлал үзүүлэх, хүсэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын ойлголт

“Уучлал” нь эрүүгийн хариуцлага хүлээлгэж эхэлсэн цаг хугацаатай зэрэгцэж яригддаг, өршөөлөөс ялгаатай нь нэг бүрчилсэн шинжтэй нэн эртний институт¹ бөгөөд эртнээс эдүгээ хүртэл хугацаанд оршоор ирсэн чухал ойлголт гэдгийг НҮБ-ийн гишүүн улс орнуудаас 186 нь уучлал үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Үндсэн хуульдаа тусгаж өгсөн² байгаагаас харж болно. Уучлал үзүүлэх “Pardon” гэдэг нэр томъёо нь Францын эртний хуульд анх хэрэглэгдсэн ба латин хэлний “Perdonare” (чөлөөлж, суллаж өгөх) гэсэн үгнээс гаралтай буюу эрх бүхий этгээдээс өгч буй буй бэлэг гэсэн санааг илэрхийлдэг байжээ³. Харин орчин үеийн эрх зүйн ойлголт нь эрүүгийн хариуцлага, болон түүнээс гарах эрх зүйн үр дагаврыг албан ёсоор хүчингүй болгож буй

¹ Лүндэндорж.Н. Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар. УБ., 2022. х.572

² Галбаатар.Л. Өршөөл болон уучлал үзүүлэх асуудлаарх Үндсэн хуулийн зохицуулалтын харьцуулсан судалгаа:Монгол Улсын нөхцөл байдал. Профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдаан. <https://legaldata.mn/b/306>

³ Garner, B. A. (2004). Black's Law Dictionary (8th Edition). USA Thomson West Publishing. p. 1144

үйл ажиллагаа гэж үздэг⁴. Монголын эрдэмтэн судлаачдын дунд “уучлал үзүүлэх”-ийг тайлбарлахдаа дараах үндсэн шинжээр тодорхойлох хандлага байна. Нэгдүгээрт энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн төр хайр энэрлээ үзүүлж буй явдал⁵. Хоёрдугаарт уучлал үзүүлэхдээ тухайн үеийн болон хувь хүний тодорхой нөхцөл байдлыг харгалзахаас өөрөөр нийтлэг журам тогтоосон болзолтой байх ёсгүй⁶. Гуравдугаарт эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээдэд л уучлал үзүүлж болно⁷. Эцэст нь иргэн уучлал хүсэх үндсэн эрхтэй байдгийг орхигдуулж болохгүй.⁸

Харин Монголын хуульч эрдэмтэд, Үндсэн хуулийн шүүхийн зүгээс энэ эрх мэдлийн хүрээ хязгаарын талаар тодорхой, нэгдсэн байр суурь илэрхийлээгүй байдаг бол АНУ-ын хувьд уучлал үзүүлэх эрх мэдлийг импечментээс бусад асуудлаар гүйцэтгэх засаглалын хязгааргүй, үнэмлэхүй эрх мэдэл гэж Дээд шүүх нь үзсэн байна⁹.

Эндээс үзэхэд уучлалын институт нь уучлал үзүүлэх эрх

мэдэл болон уучлал хүсэж буй этгээдийн эрхээр нөхцөлдсөн онцгой ойлголт бөгөөд нэг талаас энэ нь ард түмний салшгүй эрх¹⁰ нөгөө талаас алдаа эндэгдэл гаргасан аливаа хүн хоёрдох боломжоо эрэлхийлэх эрхтэй холбоотой байна.

Ерөөс уучлалыг өнгөрсөн алдааг уучлах, шударга бус явдлыг засах, олон улсын харилцааны хүрээнд найрсаг харилцаатай байдлаа илэрхийлэх, улс төрийн зорилгод хүрэхэд ч ашиглагдаж иржээ. Гэсэн хэдий ч уучлал үзүүлэх нь хэт дур зоргын, улс төрийн шинжтэй байна гэх шүүмжлэлийг араасаа байнга дагуулдаг.

2.1. Уучлалын төрөл

- **Бүрэн.** Тухайн хүний ял болон гэмт хэргийн бүх үр дагаврыг болзолгүйгээр чөлөөлнө. Монгол Улсад энэ хэлбэрийн уучлал түгээмэл тохиолддог.
- **Хэсэгчилсэн.** Тухайн хүний ялыг хэсэгчлэн чөлөөлнө. Ерөнхийлөгч ялыг хөнгөвчлөх (багасгах) боломжтой, өөрөөр хэлбэл оногдуулсан хорих ялын хугацааг багасгах анх оногдуулсан ялыг хөнгөн ялаар орлуулж болно.
- **Үнэмлэхүй.** Ямар ч нөхцөлгүйгээр чөлөөлнө.
- **Болзолт.** Уучлал хүссэн хүний биелүүлэх ёстой зарим нөхцөл нь уучлал хүчин төгөлдөр болохоос өмнө эсхүл уучлал үзүүлснээс хойш тодорхой хугацаанд заавал биелэгдэх ёстой. Тухайлбал,

⁴ Мөн тэнд. р.1144

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., х.175

⁶ Мөн тэнд х.175

⁷ Лүндэндорж Н. Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар. УБ., 2022. х.572

⁸ Мөн тэнд. х.572

⁹ Ex parte Garland, 71 U.S. 333 (1866) “...The power of pardon conferred by the Constitution upon the President is unlimited except in cases of impeachment. It extends to every offence known to the law, and may be exercised at any time after its commission, either before legal proceedings are taken or during their pendency, or after conviction and judgment. The power is not subject to legislative control.”

¹⁰ Nolo. (n.d.) Pardon. <https://www.nolo.com/legal-encyclopedia/pardons.html>

цагдаагийн байгууллагад гэмт хэргийг илрүүлэхэд туслах нөхцөлтэй байж болно. Өмнө нь гэмт хэрэг үйлдсэн хүн дахин гэмт хэрэг үйлдсэн гэх мэт тодорхой нөхцөл байдал үүссэн тохиолдолд зарим болзолт уучлал хүчингүй болдог.

Монгол Улсын хувьд уучлалын төрлийг Эрүүгийн хуулийн 6.14.1-д "Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг Өршөөл үзүүлэх тухай хуулиар, эсхүл уучлал үзүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гэмт хэрэг үйлдсэн хүний эдлэх ялыг бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх, эсхүл хорихоос өөр төрлийн ялаар дүйцүүлэн сольж болно." гэж зааж өгсөн байна.

Эндээс үзвэл Монгол Улсад дараах хэлбэрээр уучлал үзүүлж байна:

- Бүрэн
- Хэсэгчилсэн
- Хорихоос өөр төрлийн ялаар сольж хөнгөрүүлэх зэрэг төрөлтэй байна.

Болзолт уучлалын хэлбэрийг ашиглах нь ач холбогдолтой хэдий ч практикт хэрэглэгдэхгүй байна. Тухайлбал татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн хүнийг уучилсан шийдвэр гаргахдаа татвараа тодорхой хугацаанд төлсөн байх болзлыг уучлал үзүүлсэн шийдвэрт тусгаж өгөх боломжтой. Мөн хохирлоо барагдуулсан, хохирогчийг хохиролгүй болгосон байх зэрэг болзлыг авч үзэх шаардлагатай.

Энэ төрлийн уучлалыг "Уучлал үзүүлж ялтныг хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах" хэлбэрээр "2002 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан "Ялтанд уучлал үзүүлэхийг хүссэн өргөдлийг шийдвэрлэх журам-д зааж өгч байжээ (Хүчингүй болсон). Уг журамд дараах нөхцөлийг авч үзсэн байна. Үүнд:

1. Уучлал үзүүлж ялтныг хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах энэхүү хэлбэр нь гэмт хэрэгт үйлдэж хорих ял шийтгүүлсэн ялтанд хамаарч үйлчилнэ. Хөнгөн гэмт хэрэг хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдэд хэрэглэхгүй.
2. Уучлал хүсэх эрхээ эдэлж Ерөнхийлөгчид ялаас чөлөөлж өгөх, ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх хүсэлт, өргөдөл гаргасан хоригдолд энэ журмаар уучлал үзүүлнэ.
3. Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ хоригдлын үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюул, түүний шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, эрүүгийн хариуцлага ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөлүүд, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал, ялаас чөлөөлүүлэхийг хүссэн шалтгаан, шүүхээс оногдуулсан ялын хэмжээ,

түүнээс биеэр эдэлсэн болон эдлээгүй үлдсэн ялын хэмжээ, урьд гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, ялаас чөлөөлөгдөж байсан эсэх, хувийн зан байдал, засрал хүмүүжил, ял эдэлж байгаа хорих ангийн санал, ялтны гэр бүлийн эсхүл эцэг эхийн болон тэдний оршин сууж байгаа сум хорооны Засаг даргын тодорхойлолт зэргийг харгалзан уучлал үзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

4. Хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж уучлал үзүүлэх тухай зарлиг гаргах ба энэ нь хоригдлыг суллах үндэслэл болно"¹¹.

2.2.Уучлал үзүүлсний эрх зүйн ерөнхий үр дагавар

Монгол Улсад уучлал үзүүлсний дараа гарах эрх зүйн үр дагаврын талаар тодорхой зохицуулалт, нэгдсэн ойлголт дутмаг хэдий ч уучлал үзүүлснээр ял шийтгүүлсэн хүнийг гэм буруугүйд тооцож буй хэрэг биш гэсэн нэгдмэл ойлголт байдаг. Ерөнхийлөгчийн уучлал нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, нийгэмших чадвартай гэдгээ харуулсан хүмүүсийг өршөөж буйн илрэл буюу эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа явдал юм. Мөн уучлал үзүүлснээр гэмт хүрэг үйлдсэн этгээдийн талаарх бүртгэлийг арилгадаггүй байна. Харин уучлал үзүүлснээр тухайн этгээдийн алдсан зарим эрх болох сонгуульд санал өгөх, сонгогдох зэрэг эрхийг сэргээдэг. Хэсэгчилсэн уучлал буюу ял хөнгөрүүлсэн

тохиолдолд хэрэгтний иргэний эрх нь бүрэн сэргэдэггүй.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд уучлал үзүүлснээр эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээдийн алдсан иргэний дараах эрхийг сэргээдэг гэж үздэг¹².

Жишээ нь:

- санал өгөх эрх
- төрийн албан тушаалд нэр дэвших, ажиллах эрх
- тангарагтны бүрэлдэхүүнд ажиллах эрх,
- галт зэвсэг эзэмших эрх.
- АНУ-ын нутаг дэвсгэрээс албадан гаргах явдлаас сэргийлэх боломжтой байдаг.

Ерөнхийлөгч Обама хоёр дахь боломжийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч 1,715 хэрэгтнийг¹³ уучилж дээд амжилт тогтоосон байна. Америкийн Нэгдсэн улсад ихэнхдээ настай, өвчтэй эсвэл ижил төстэй хэргүүдтэй харьцуулахад ял нь хүндэдсэн этгээдэд уучлалыг үзүүлдэг бол Монгол Улсын хувьд Ерөнхийлөгчийн уучлал үзүүлсэн шийдвэрүүд нь Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт болох Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад багтдаггүй хэдий ч ил тод бус, гаргасан шийдвэртэй танилцах боломж байдаггүй, нэг талаас нээлттэй, нөгөө талаас нууц ч мэт нөхцөл байдлаас шалтгаан тодорхой статистик дүгнэлт гаргах боломжгүй

¹¹ Гантөмөр.Г., Лхагвамаа.Г. Уучлалын эрх зүйн зохицуулалтын асуудал. УБ., 2009. х.62.

¹² Nolo. (n.d.) Presidential Pardon Powers and Limits. <https://www.criminaldefenselawyer.com/resources/presidential-pardon-powers-and-limits.html>

¹³ Мөн тэнд.

байна.

2.3. Урьдчилсан уучлал ба үйлдэгдсэн эсхүл үйлдэгдэх гэмт хэрэг

Ерөнхийдөө уучлалыг эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээдэд буюу шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон хүнд үзүүлдэг. Гэхдээ уучлал үзүүлэх эрх мэдэл зөвхөн шүүхээр гэм буруу нь тогтоогдсон хүнд хамаарах уу? Өөрөөр хэлбэл шүүхээр гэм буруутай эсэх нь тогтоогүй хүнд урьдчилсан байдлаар уучлалыг үзүүлж болох уу? гэсэн асуулт байж болох юм. Түүхийн үүднээс авч үзвэл энэ хэлбэрийн уучлалыг Чингис хаан өөрийн гавьяат төрийн зүтгэлтнүүддээ 9 удаагийн алдаа эндэгдлээс хэлтрүүлэх байдлаар үзүүлсэн гэж үзэх үндэстэй. Хэрэв ардчилсан тогтолцоонд урьдчилсан уучлал байж болно гэж үзвэл шүүхээр шийдвэрлэгдээгүй, тэр ч байтугай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж эхлээгүй үйлдэгдсэн гэмт хэрэгт хамаарах уу? бүүр цаашилбал ирээдүйд үйлдэгдэх гэмт хэрэгт хамаарах уу? гэсэн сонирхолтой асуултууд урган гарч ирнэ.

Эдгээр асуултын тодорхой хэсэгт хариу болох үйл явдал Монгол Улсад болсон. Тодруулбал Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АНУ-ын иргэн Жастин Капла, Бүгд найрамдах Филиппин улсын иргэн Кристобал Ж.Дэвид, мөн улсын иргэн Хилармон В.Кажуком ЖР нарт татвар төлөхөөс зайлсхийх гэмт үйлдэлд уучлал үзүүлсэн нь уг гэмт

хэргийн хувьд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болоогүй, хэрэг давж заалдах шатанд байхад нь Ерөнхийлөгч шийдвэрээ гаргасан байна¹⁴. Өөрөөр хэлбэл шүүхээр гэм буруу нь тогтоогдоогүй байхад урьдчилсан байдлаар уучлал үзүүлсэн гэж үзэх бүрэн боломжтой. Нэмж дурдахад дээр дурдсан асуултуудын хүрээнд Үндсэн хуулийн цэц, Дээд шүүх тодорхой байр сууриа одоогоор илэрхийлээгүй байна. Урьдчилсан байдлаар уучлал үзүүлэх нь шүүн таслах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гүйцэтгэх засаглал хөндлөнгөөс оролцож буй эсэх асуудлаар нарийвчлан судлах шаардлагатай гэж үзэж байна.

Нэг асуудлыг нэмж дурдахад (урьдчилсан уучлалд хамаарахгүй ч гэсэн) Капла нарын хэрэг нь олон улсын харилцааны хүрээнд найрсаг харилцаатай байдлаа илэрхийлсэн тохиолдол болсон байх талтай. Тодруулбал "Филиппин Улсын Ерөнхийлөгчийн зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан иргэддээ уучлал үзүүлж өгнө үү гэсэн хүсэлтийг тавьж байсан бөгөөд АНУ-ын тойргийн шүүхээс Жастин Каплд уучлал үзүүлэх хүсэлтийг мөн ирүүлсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгч ч өөрийн улсын иргэн Дамдинд оногдуулсан цаазаар авах ялыг хэлтрүүлэх хүсэлтийг БНХАУ-ын даргад тавьж, хүсэлт амжилттай хэрэгжиж байсан"¹⁵.

¹⁴ УИХ-ын гишүүн Г.Уянгаас УИХ-ын дарга З.Энхболдод илгээсэн албан бичиг. 2016.04.06 11/2340. <http://www.mglnews.mn/content/read/63699.htm>

¹⁵ Ням-Өлзий.А. Ерөнхийлөгч Жастан Каплд уучлал үзүүлээ. 2015.02.26. <https://ikon.mn/n/eqd>

Улсынхаа иргэнд уучлал үзүүлэхийг бусад улсын Төрийн тэргүүнээс хүсдэг жишиг дэлхий нийтэд байдаг.

АНУ-ын хувьд уучлах эрх нь зөвхөн үйлдэгдсэн гэмт хэрэг буюу «хуульд мэдэгдэж байгаа» гэмт хэрэгт хамаарна¹⁶. Ирээдүйд гэмт хэрэг үйлдэх хориотой ч Дээд шүүх ерөнхийлөгчийг уучлах эрхээ хэдийд ч, шүүх ажиллагаа эхлэхээс өмнө буюу прокурор мэдэхээс өмнө хэрэгжүүлж болно гэж үзсэн.

- Ер нь уучлал үзүүлэх тухай албан ёсны баримт бичигт өршөөлд хамрагдсан гэмт хэрэг(үүд)-ийг, хэрэв яллагдагчаар татаагүй бол тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаагаар тодорхойлдог. Тухайлбал, Ерөнхийлөгч Никсон сөрөг хүчнээ тагнасан хэрэгт холбогдож, импечментийн асуудал яригдах үед өөрөө огцорсон бөгөөд түүний Дэд ерөнхийлөгч байсан Форд Ерөнхийлөгч болж Никсонд уучлал үзүүлсэн байдаг. «Ричард Никсоны 1969 оны 1-р сарын 20-ноос 1974 оны 8-р сарын 9-ний хооронд... үйлдсэн, эсхүл оролцсон байж болзошгүй холбооны бүх гэмт хэргийн төлөө» уучлал үзүүлжээ. Энэхүү уучлал нь Никсоныг Уотергейтийн дуулиантай холбоотой холбооны эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн юм¹⁷.

2.4.Өөрийгөө уучлах нь Үндсэн хуульд нийцэх үү?

Урьдчилсан уучлалыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх, шүүн таслах ажиллагаа явагдахаас өмнө уучлал үзүүлэх боломжтой байвал уучлал үзүүлэх эрхтэй субъект өөрийнх нь хийсэн үйлдэл ирээдүйд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өртөгдөж магадгүй гэдэг үндэслэлээр өөртөө уучлал үзүүлэх боломжтой юу гэсэн асуулт зүй ёсоор урган гарч ирнэ. Монгол Улсад энэ асуудлаар тодорхой тохиолдол байдаггүй хэдий ч ирээдүйд энэ асуудал яригдахыг үгүйсгэхгүй. АНУ-ын хувьд хуульчид, эрдэмтэн судлаачдын дунд яригддаг сэдэв төдийгүй зарим Ерөнхийлөгч нар тодорхой үйл явдалтай холбогдуулан өөртөө уучлал үзүүлэх эрх мэдэл нь Ерөнхийлөгч надад байдаг гэж ил тодоор сануулж байсан тохиолдлууд байдаг. Жишээ нь Ерөнхийлөгч Трамп твитертээ "«Олон хуульч эрдэмтдийн хэлснээр би өөрийгөө уучлах өршөөх бүрэн эрхтэй, гэхдээ би ямар ч буруу зүйл хийгээгүй байж яагаад уучилна гэж?» хэмээн жиргэжээ.

- Өнөөдрийг хүртэл ямар ч ерөнхийлөгч өөрийгөө уучлаагүй. Энэ асуудлыг хөндөж байсан ч (Никсон, Клинтон, Трампын засаглалын үед) ямар ч шүүх уг асуудлыг авч хэлэлцээгүй. Шүүхийн тохиолдол гарч байгаагүй тул өөрийгөө уучлах нь үндсэн хуульд

¹⁶ Ex parte Garland, 71 U.S. 333, 380 (1866).

¹⁷ Nolo. (n.d.) Presidential Pardon Powers and Limits. https://www.criminaldefenselawyer.com/resources/presidential-pardon-powers-and-limits.html?_gl=1*kd0oqo*_ga*MTcwMjl2Ml4xNjcwMzMzNDg2*_ga_RJLCGB9QZ9*MTY4NzE0MjI1NC4zLjEuM

нийцэх эсэх нь тодорхойгүй байна. Энэ асуудлын талаарх эрдэмтдийн байр суурь хуваагдмал байдаг.

- Ерөнхийлөгч өөрийгөө уучлах эрхтэй гэж маргаж байгаа хүмүүс Үндсэн хуулийн бичвэрийг онцолж тайлбараа хийдэг. Үндсэн хуульд ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх бүрэн эрхийн хязгаарыг холбооны гэмт хэрэг дотроос зөвхөн импичментийн хэрэг дээр уучлал үзүүлж болохгүй гэж тодорхой заасан байна гэж маргадаг.
- Нөгөө талдаа өөрийгөө уучлах нь ерөнхийлөгчийн үндсэн хуульд заасан хуулийг шударгаар биелүүлэх үүрэгтэй зөрчилддөг гэж зарим хүмүүс үздэг. Үндсэндээ Ерөнхийлөгч нэгэн зэрэг хуулийг шударгаар биелүүлж, мөн зөрчих боломжгүй. Ямар ч эрх мэдэл бусад эрх мэдлийн хязгаарлалтын хүрээнд оршдог. Энэ асуудал угаас үндсэн дүрэмтэй зөрчилдөж байна. Хэн ч өөрийнхөө хэргийг шүүж болохгүй гэм мэт үндэслэлийг тавьдаг.

2.5. Уучлалд хамрагдах субъект нь хэн байх вэ?

Монгол Улсын Үндсэн хуулийн 33.1.8 Ерөнхийлөгч уучлал үзүүлэх бүрэн эрхтэй, 16.14-т Монгол Улсын иргэд уучлал хүсэх эрхтэй гэж заасан байна. Үндсэн хуулийн дээрх заалтуудыг хууль тайлбарлах бичвэрийн онолын болон Үндсэн хуулийг бүхэллэг байдлаар унших

онолын үүднээс авч үзвэл уучлал үзүүлэх гэдэг нь хоёр талын харилцаа байхаар, ял шийтгэл эдэлж буй Монгол улсын иргэн уучлал хүссэн байх нь уучлал үзүүлэх урьдач нөхцөл байхаар, зөвхөн Монгол Улсын иргэн уучлал хүсэх эрхтэй байхаар уншигдаж болохоор байна. Гэхдээ ингэж тайлбарлавал өрөөсгөл тайлбар болох бөгөөд тус заалтуудын агуулга нь хүний үндсэн эрхийн нэг болох уучлал хүсэх эрх нь Монгол улсын иргэнд ч мөн адил хамаарна гэдгийг тунхаглан тодорхойлж өгсөн агуулгатайгаас бус монгол улсын иргэнээс бусад хүний уучлал хүсэх эрхийг хязгаарласан зохицуулалт гэж үзэхгүй юм. Учир нь бид хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш байх зарчмыг Үндсэн хуульд тусгаж өгсөн. Мөн Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын §3.6-д “Цаазаар авах ял шийтгүүлсэн хүн бүр уучлал хүсэх эрхтэй. Бүх тохиолдолд цаазаар авах ялыг өршөөж, уучилж, хөнгөрүүлж болно” гэж зааснаас үзэхэд уучлал хүсэх эрх хүн бүрд хамаатай төрөлх эрх гэж үзэх үндэстэй.

Мөн энд яригдах нэг сэдэв бол зөвхөн уучлал хүссэн этгээдэд Ерөнхийлөгч уучлал үзүүлэх ёстой юу? гэсэн асуулт юм. Нэг талаас уучлал хүсэж буй нь гэм буруугаа хүлээн зөвшөөрч буй хэлбэр гэж үзвэл уучлал хүссэн хүнийг уучилж болох талтай ч нөгөө талаас өөрийгөө гэм буруугүй гэж үзэж

байгаа хүн (Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр ямар нэгэн буруутай зүйл хийгээгүй учир надад уучлал үзүүлэх нь утгагүй хэрэг гэж үзсэн байна¹⁸), эсхүл шүүх алдаатай шийдвэр гаргасан, өрөөсгөл шударга бус явдлыг засах шаардага тулгарвал яах вэ гэсэн асуудал үүснэ. Ялтны өмнөөс ял эдэлж байгаа хорих анги, ялтны гэр бүл эсхүл хамтран ажиллагсад, найз нөхөд уучлалт хүссэн тохиолдолд Ерөнхийлөгч өөрөө хүсэлт гаргаагүй байна гэдэг шалтгаанаар шийдвэрлэхгүй байх нь үндэслэлгүй юм. Жишээ нь Ерөнхий сайд асан М.Энхсайханд уучлал үзүүлэх хүсэлтийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд гаргаж байсан¹⁹ бөгөөд У.Хүрэлсүх 2021 оны 08 дугаар сарын 05-нд уучлал үзүүлсэн шийдвэр гаргаж байсан²⁰.

Түүнчлэн Ерөнхийлөгчийн гаргасан уучлах шийдвэрт хяналт тавьдаггүй учраас өөрийгөө гэм буруугүй гэж үзэж буй хүмүүст уучлал үзүүлэх боломжтой. Мөн хамаатан садан, улс төрийн хамтрагчдаа ч уучлал үзүүлэх эрхтэй байхаар байна.

Мөн өөр нэг асуудал бол Монгол улсын эрүүгийн хуулиар, Монгол Улсын шүүхээс хариуцлага хүлээсэн хүнд Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрхтэй юу?

¹⁸ www.gogo.mn. Н.Энхбаяр уучлал гуйгаагүй. 2013.08.05. <https://gogo.mn/r/126753>

¹⁹ УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Ерөнхийлөгчид гаргасан хүсэлт. 2021.07.09/61. <https://impress.mn/p/713>

²⁰ News.mn. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх М.Энхсайханд уучлал үзүүлэхээр болжээ. 2021.08.05. <https://news.mn/r/2460099/>

Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 110 дугаар зүйлийн 1-д "Хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах гэмт хэрэг, цэргийн гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэг үйлдсэн хүний хэргийг тус шүүхээр шийдвэрлэн ял оногдуулсан бол таслан шийтгэх тогтоолыг биелүүлж буй улс тогтоолд заасан хугацаа дуусахаас өмнө тухай этгээдийг чөлөөлж болохгүй.", мөн зүйлийн 2-д "Зөвхөн тус Шүүх энэ хугацааг багасгах тухай шийдвэр гарах эрх эдлэх ба тухайн этгээдийн хүсэлтийг сонссоны үндсэн дээр энэ асуудлаар тогтоол гаргана."²¹73 гэжээ. Энэ тохиолдолд Монгол Улсын төрийн тэргүүний уучлал үзүүлэх эрх хязгаарлагдахаар байна.

Монгол Улс Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай, Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх, ялтан шилжүүлэх тухай 36 улстай гэрээ байгуулсан байна. Ялтан шилжүүлэн авсан тохиолдолд тухайн этгээдэд уучлал үзүүлэх асуудлыг Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 44.3.9-д²² Монгол Улсын хуулиар зохицуулахаар заасан боловч тухайлсан хууль одоогоор гараагүй байна. Хэрэв олон улсын

²¹ Гантөмөр.Г. Харьцуулсан эрх зүйн онол практикийн тулгамдсан асуудал: Гадаад орнуудын уучлал үзүүлэх эрх зүйн зохицуулалт, онцлог. Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол арга зүйн улирал тустын сэтгүүл. УБ., 2021 №1 (75). х.73

²² Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 44.3.9 зүйл. "Гадаад улсаас шилжин ирж энэ зүйлд заасны дагуу Монгол Улсад ял эдлэхээр болсон ял шийтгүүлсэн хүнийг хорих ялаас хугацааны өмнө суллах, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, өршөөл, уучлал үзүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой асуудлыг Монгол Улсын хуулиар зохицуулна."

гэрээнд уучлал үзүүлж болохгүй байхаар тусгасан тохиолдолд Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрх мэдэл хязгаарлагдах боломжтой байна.

3.Уучлал үзүүлэх эрх мэдэл нь засаглалын салаа мөчрийн алинд хамаарах вэ?

Ихэнх улс орны хувьд энэ эрх мэдлийг гүйцэтгэх засаглалд хамааруулан ойлгодог. Тухайлбал АНУ-ын Үндсэн хуульд «Ерөнхийлөгч... Импичментээс бусад тохиолдолд АНУ-ын холбооны гэмт хэрэг үйлдсэн этгээдэд уучлал үзүүлэх эрхтэй»²³ гэж заасан байдаг. Энэ бичвэрийг Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүх ерөнхийлөгчид хязгааргүй шахуу уучлал үзүүлэх эрх мэдлийг өгсөн төдийгүй, уучлал үзүүлэх эрх нь зөвхөн ерөнхийлөгчид хадгалагдах бөгөөд уучлал үзүүлэх тухай ерөнхийлөгчийн шийдвэрийг Конгресс эсвэл шүүх хүчингүй болгож болохгүй гэж тайлбарласан байна²⁴. Үүнээс үзэхэд энэ эрх мэдэл нь:

- зөвхөн гүйцэтгэх засаглалд хамаарна;
- хязгаарлалтын хүрээ нь импечмент, холбооны гэмт хэрэг байна;
- бусад засаглал Ерөнхийлөгчийн шийдвэрийг хянах, хязгаарлалт тавих боломжгүй гэж үзэж болохоор байна.

Харин Монгол улсын хувьд

уучлал үзүүлэх эрх мэдлийг Үндсэн хуулиараа Ерөнхийлөгчид олгосон байхбөгөөдЕрөнхийлөгчньгүйцэтгэх засаглалд хамаарах эсэх асуудлаар хоёрдмол байр суурийг Монголын эрдэмтэн судлаачид илэрхийлдэг. Энэ маргаантай асуудал нь Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн тэргүүн хэдий ч засгийн газрын тэргүүн байдаггүй. Мөн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн аль алинд бодитой нөлөө үзүүлэхүйц бүрэн эрхтэй, эдгээр засаглалын нэгдсэн ойлголт болох төрийг бүхэлд нь төлөөлдөг цорын ганц субъект болох талаасаа засаглалын аль ч салаа мөчирт хамаарахгүй гэх үзэл санаанаас үүдэлтэй байх талтай. Онолын үүднээс авч үзвэл гүйцэтгэх засаглалын хосолмол хэлбэр гэж байдаг. «Хосолмол гүйцэтгэх засаглал» гэдэг нь эртний уламжлалтай бөгөөд өргөн тархсан ойлголт юм. Хосолмол гүйцэтгэх засаглалд шууд бусаар сонгогдсон засгийн газрын тэргүүн буюу Ерөнхий сайд нь хууль тогтоох байгууллагад олонхын дэмжлэгтэй байж, засгийн газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бодлогыг тодорхойлдог бол Ерөнхийлөгч нь ард түмнээс сонгогдож төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэдэг. Гүйцэтгэх засаглалын тэргүүлж буй субъектүүдийн хоорондох эрх мэдлийн нарийн тэнцвэр нь харилцан адилгүй байж болно. Эрх мэдлийн тэнцвэрт байдлаас хамааран хосолмол гүйцэтгэх засаглалын зарим загвар нь ерөнхийлөгчийн,

²³ Constitution of the United States of America. II, § 2, cl. 1. (1787).

²⁴ Schick v. Reed, 419 U.S. 256 (1974)

нөгөө нь парламентын тогтолцоотой байдаг²⁵.

Үүнээс үзэхэд Монгол Улсын гүйцэтгэх засаглал хосолмол хэлбэртэй бөгөөд бүх ард түмнээс сонгогддог Монгол Улсын Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалд хамаарахаар байна. Түүнчлэн Төрийн эрх мэдэл хуваарилагдаж ирсэн цагаас эхлэн төрийн тэргүүн нь гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг хадгалж ирсэн байдаг²⁶.

Ерөнхийлөгч нь "хууль тогтоох", "гүйцэтгэх", "шүүх" эрх мэдлийн нэгдсэн ойлголт болох төрийг бүхэлд нь дотоод болон гадаадад бүрэн эрхтэй төлөөлдөг төрийн тэргүүн боловч эрх мэдэл хуваарилах онолын хүрээнд авч үзвэл "гүйцэтгэх эрх мэдлийн дээд албан тушаалтны байр суурьтай"²⁷ гэж нэрт эрдэмтэн Б.Чимид үзсэн байна.

3.1.Ерөнхийлөгчийн уучлалыг хүчингүй болгож болох уу?

Хэчнээн маргаантай байсан ч ерөнхийлөгчийн уучлалыг хүчингүй болгох боломжгүй. Монгол Улсад ар араасаа дараалсан олон маргаан дагуулсан уучлал үзүүлэх шийдвэрүүд гарч байсан боловч засаглалын бусад салаа болох Шүүх, Хууль тогтоох засаглалын зүгээс Ерөнхийлөгчийн шийдвэрийг хүчингүй болгох алхмууд хийгдэж байгаагүй байна. Харин Хууль тогтоох засаглалын

зүгээс Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрх мэдлийг хязгаарласан зохицуулалтыг Эрүүгийн хуульд тусгаж өгсөн. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 6.14.1-д уучлалын хэлбэрийг зааж өгөхдөө хорихоос өөр төрлийн ялаар дүйцүүлэн сольж болно гэж хязгаарласан байна. Эрүүгийн хуулийн 5.2.1-д ялын төрлүүдийг хүндээс хөнгөн рүү нь байрлуулсан дарааллын дагуу тухайн төрлийн ялаас хөнгөн өөр ялаар солих эрхийг хязгаарлаж зөвхөн хорих ялыг сольж болохоор зааж өгсөн нь уучлал үзүүлэх Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарласан гэж үзэхэд хүргэж байна.

Мөн Эрүүгийн хуулийн 6.14.2-д хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байхаар тусгаж өгсөн Ерөнхийлөгчид ямар төрлийн гэмт хэрэгт уучлал үзүүлж болохгүй гэдгийг шууд зааж өгсөн хязгаарлалтын зохицуулалт болсон байна.

АНУ-ын хувьд энэ асуудлыг Үндсэн хуульд уучлал үзүүлэх эрх мэдлийг хууль тогтоох (Конгресс) эсвэл шүүх эрх мэдэл (холбооны шүүх, түүний дотор Дээд шүүх)-д бус, гагцхүү гүйцэтгэх засаглалд өгсөн. Үндсэн хуулиар эрх мэдлийн хуваарилалтаар нэг засаглалд хадгалагдаж буй бүрэн эрхэд нөгөө засаглал нь халдаж болохгүй. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч хуулийг өөрчилж чадахгүйтэй адил Конгресс, болон шүүх Ерөнхийлөгчийн уучлалыг хүчингүй болгох боломжгүй²⁸ гэж үзсэн байна.

²⁵ Үндсэн хуулийг бүтээх практикийн гарын авлага: Гүйцэтгэх засаглал УБ., 2022. х.36

²⁶ Лүндээжанцан Д. Төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014. х.179

²⁷ Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. х.253

²⁸ U.S. V. Klein, 80 U.S. 128 (1871).

4. Уучлал үзүүлэх нь ач холбогдолтой юу?

Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрх мэдлийн ач холбогдол нь шүүхийн алдааг засаж залруулах, гэмшсэн, хүмүүжсэн хүмүүст боломж олгох, нийгэм дэх зохицол, эвлэрлийг дэмжих чадварт оршдог. Мөн гүйцэтгэх засаг эрүүгийн эрх зүйн шүүхийн тогтолцоонд хөндлөнгөөс оролцох механизм болж, нөхцөл байдлыг үнэлэн шаардлагатай үед ухаалаг хандаж, шүүх засаглалын шийдвэрт хөндлөнгөөс оролцох боломжийг Ерөнхийлөгчид олгодог.

Шүүхийн тогтолцооны алдааг засах чадварын тухайд шударга бус эсвэл ижил төрлийн хэрэгт ялыг хүнддүүлсэн, процедурын алдаа гарсан, эсвэл шийтгэгдсэний дараа шинэ нотлох баримт гарч ирсэн зэрэг нөхцөл байдалд асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог. Ингэснээр гүйцэтгэх засаглалаас шүүх засаглал дээр хяналт тэнцлийг хангах нэг арга хэрэгсэл болж, алдаатай шийдвэрийн улмаас ял шийтгүүлсэн, зүй бусаар эрүүгийн хүнд хариуцлага хүлээсэн байж болзошгүй хүмүүсийн эрхийг сэргээх механизм болдог.

Цаашилбал, энэ нь улс төрийн ач холбогдлыг өөртөө агуулдаг. Тодруулбал үндэсний эв нэгдэлд бодит эрсдэл учирсан үед эвлэрүүлэх, талуудын хооронд үүссэн ан цавыг эдгээх хэрэгсэл болгон ашиглаж болно. Монгол Улсын Ерөнхийлөгч нь эв нэгдлийг илэрхийлэх, хангах цорын ганц дээд албан тушаалтны хувьд чиг үүргээ хэрэгжүүлэхэд энэ институт чухал ач

холбогдолтой. Мөн уучлал цаашдын улс төрийн бодлогод өөрчлөлт орсны дохио болох, улс төрийн таатай уур амьсгал, ойлголцолд тууштай байгаагаа харуулах боломжийг гүйцэтгэх засаглалд олгодог. Мөн ерөнхийлөгчийн нэр хүнд, олон нийтийн дунд эзлэх байр сууриа дээшлүүлэх, улс төрийн хэрэгт нөлөөлөх боломжийг нээж өгдөг тул уг эрх мэдлийн хэрэгжилтийг улс төрийн үүднээс авч үзэх боломжтой байдаг.

Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрх мэдлийг хэрэгжүүлснээр шүүхийн тогтолцоонд чухал нөлөө үзүүлэх чадвартай буюу шударга бус явдлыг засаж залруулах, шүүх эрх мэдэл дээр хяналт тэнцлийг хангаж өгөх зорилготой хэдий ч шүүхийн тогтолцоонд үзүүлэх нөлөө нь шударга ёс, хууль, шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх, шүүхийн хараат бус байдал, олон нийтийн итгэлцэл зэрэг олон асуудал дээр ээдрээтэй нөхцөл байдлыг үүсгэдэг.

5. Уучлал нь шударга ёсны үзэл баримтлалд хэрхэн нөлөөлж байна вэ?

Хэдийгээр уучлал үзүүлэх эрх мэдэл нь шударга бус шийдвэрийг залруулах, алдаа эндэгдэл гаргасан хүнд уучлал үзүүлэх зорилготой боловч уг эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль, шүүхийн өмнө хүн бүр тэгш байх зарчимтай зөрчилддөг үү? шударга, тэгш хандаж чаддаг уу? гэсэн асуултыг араасаа дагуулдаг.

Нэг талаас хөрөнгө чинээ,

харилцан хамаарал, улс төрийн нөлөөлөл зэрэг хүчин зүйлээс шалтгаалжуучлал тэгш бус байдлаар хэрэгжих боломжтой. Нөлөө бүхий хүмүүс уучлалд хамрагдах магадлал өндөр байдаг гэж шүүмжлэх тал байдаг. Энэ нь уучлал үзүүлэх эрх мэдлийг тодорхой бус байдлаар хэрэгжүүлж, зарим хүмүүст давуу тал бий болгож байна гэсэн ойлголт түгээмэл байна. Уучлал үзүүлэхэд ийм зөрүүтэй байдлаар хандвал шударга тогтолцоонд итгэх иргэдийн итгэлийг бууруулах талтай.

Цаашилбал, уучлал үзүүлэх үйл явцын субъектив шинж чанар нь дураар тайлбар хийх, эсвэл нэг талыг барьсан шийдвэр гаргах болон үзэмжээрээ асуудлыг шийдвэрлэх элементийг өөртөө агуулдаг. Ерөнхийлөгч хэнд уучлал үзүүлэхийг тодорхойлох өргөн эрх мэдэлтэй бөгөөд ихэнх улсын Үндсэн хуульд уучлал үзүүлэх шийдвэрийг гаргах шалгуурыг тэр бүр тодорхой зааж өгдөггүй. Энэхүү ил тод бус, тодорхой удирдамж дутмаг байдал нь уучлал үзүүлэх үйл явцыг тууштай, шударга байдлаар хэрэгжүүлж байгаа эсэхэд эргэлзэх нөхцөл байдалд оруулна.

Мөн уучлал үзүүлэхдээ улс төрийн сэдлээр хандах боломжтой байгаа нь шударга ёс, эрх тэгш байдлыг хангах асуудлыг улам хүндрүүлэх талтай. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгч эрх мэдлээрээ дамжуулан ойрын хүрээлээ хамгаалах, улс төрийн бүлэглэлүүдийн хооронд зохицуулалт хийх эсвэл өөрийн ашиг сонирхлоо хангахад ашиглах

боломжтой. Улс төрийн үзэл баримтлал нь объектив шалгуураас дээгүүрт тавигдах нь хуулийн дагуу тэгш эрхтэй байх зарчмыг алдагдуулахад хүргэж болзошгүй. Ижил төстэй нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст улс төрийн тооцооллоос илүүтэй хэргийнх нь нөхцөл байдалд үндэслэн шударгаар хандаж байгаа эсэхэд гол асуудал оршино.

6. Дүгнэлт

Эдгээрасуудлуудыгшийдвэрлэх, шударга байдлыг дэмжихийн тулд уучлал үзүүлэх процесст тодорхой удирдамж, шалгуурыг бий болгох шаардлага байна. Ингэснээр шийдвэр субъектив бус харин объективхүчинзүйлдээрүндэслэсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ. Уучлал үзүүлэх процессын ил тод байдал, тухайлбал уучлал үзүүлэх шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд ил болгох нь шударга ёс, тэгш байдлын талаарх ойлголтыг бий болгоход хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Ерөнхийдөө ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх эрх мэдэл нь шударга бус байдлыг засаж залруулах боломжтой ч хүн бүрд хуулийн дагуу шударга, тэгш хандахад үзүүлэх үр дагаврыг анхааралтай авч үзэх шаардлагатай. Уучлал үзүүлэх эрх мэдэл, эрх мэдлийг шударгаар хэрэгжүүлэх хоорондын тэнцвэрийг бий болгох нь шударга ёсны тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд тусална.

Ном зүй

- I. Хууль тогтоомж
 1. Үндсэн хууль. 1992 он
 2. Монгол улсын ерөнхийлөгчийн тухай хууль. 1993 он
 3. Эрүүгийн хууль. 2015 он
 4. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
 5. Прокурорын тухай хууль. 2017 он
 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он
 7. Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дүрэм. 2018 он
 8. Монгол улсын иргэний үнэмлэхийн дүрэм монгол улсын засгийн газрын тогтоол. 2018 он
- II. Монгол хэл дээрх эх сурвалж
 1. Галбаатар.Л. Өршөөл болон уучлал үзүүлэх асуудлаарх Үндсэн хуулийн зохицуулалтын харьцуулсан судалгаа:Монгол Улсыннөхцөл байдал. Профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдаан. <https://legaldata.mn/b/306>
 2. Гантөмөр.Г. Харьцуулсан эрх зүйн онол практикийн тулгамдсан асуудал: Гадаад орнуудын уучлал үзүүлэх эрх зүйн зохицуулалт, онцлог. Гэмт явдалтай тэмцэх асуудал. Онол арга зүйн улирал тустын сэтгүүл. УБ., 2021 №1 (75). х.73
 3. Гантөмөр.Г., Лхагвамаа.Г. Уучлалынэрхзүйнзохицуулалтын асуудал. УБ., 2009. х.62.
 4. Лүндэндорж.Н. Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар. УБ., 2022. х.572
 5. Лүндээжанцан.Д. Төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014. х.179
 6. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., х.175
- III. Англи хэл дээрх эх сурвалж
 1. Constitution of the United States of America. II, § 2, cl. 1. (1787).
 2. Ex parte Garland, 71 U.S. 333, 380 (1866).
 3. Garner, B. A. (2004). Black's Law Dictionary (8th Edition). USA Thomson West Publishing. p.1144
 4. Nolo. (n.d.) Pardon. <https://www.nolo.com/legal-encyclopedia/pardons.html>
 5. Nolo. (n.d.) Presidential Pardon Powers and Limits. <https://www.criminaldefenselawyer.com/resources/presidential-pardon-powers-and-limits>.
 6. Schick v. Reed, 419 U.S. 256 (1974)
 7. U.S. V. Klein, 80 U.S. 128 (1871).
- IV. Цахим эх сурвалж
 1. Ням-Өлзий.А. Ерөнхийлөгч Жастан Каппад уучлал үзүүллээ. 2015.02.26. <https://ikon.mn/n/eqd>
 2. УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Ерөнхийлөгчид гаргасан хүсэлт. 2021.07.09/61. <https://mpress.mn/p/713>
 3. УИХ-ын гишүүн Г.Уянгаас УИХ-ын дарга З.Энхболдод илгээсэн албан бичиг. 2016.04.06 11/2340. <http://www.mglnews.mn/content/read/63699.htm>
 4. УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Ерөнхийлөгчид гаргасан хүсэлт. 2021.07.09/61. <https://mpress.mn/p/713>
 5. Үндсэн хуулийг бүтээх практикийн гарын авлага: Гүйцэтгэх засаглал УБ., 2022. х.36
 6. Чимид.Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. х.253
 7. News.mn. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх М.Энхсайханд уучлал үзүүлэхээр болжээ. 2021.08.05. <https://news.mn/r/2460099/>
 8. www.gogo.mn. Н.Энхбаяр уучлал гуйгаагүй. 2013.08.05. <https://gogo.mn/r/126753>

Хавсралт
Монгол Улс дахь уучлалтай холбоотой эрх зүйн зохицуулалт

№	Хууль тогтоомжийн нэр	Батлагдсан огноо / дугаар	Зүйл, заалт
1	ҮНДСЭН ХУУЛЬ	1992	33.1.8 Ерөнхийлөгч уучлал үзүүлэх бүрэн эрхтэй. 16.14 Монгол улсын иргэд уучлал хүсэх эрхтэй.
2	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ	1993	15.2 Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д зааснаар уучлал үзүүлнэ.
3	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ	2015	6.14.1.Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг Өршөөл үзүүлэх тухай хуулиар, эсхүл уучлал үзүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гэмт хэрэг үйлдсэн хүний эдлэх ялыг бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх, эсхүл хорихоос өөр төрлийн ялаар дүйцүүлэн сольж болно. 6.14.2.Энэ хуульд заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй. Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.
4	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ	2017	41.1.2.Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, Өршөөл үзүүлэх тухай хууль гарсан, уучлал үзүүлсэн, яллагдагч нас барснаас шүүхийн тогтоол гаргах бололцоогүй болсон бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шинээр илэрсэн нөхцөл байдлыг энэ хуульд заасан журмаар тогтооно. 44.3.9. Гадаад улсаас шилжин ирж энэ зүйлд заасны дагуу Монгол Улсад ял эдлэхээр болсон ял шийтгүүлсэн хүнийг хорих ялаас хугацааны өмнө суллах, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, өршөөл, уучлал үзүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой асуудлыг Монгол Улсын хуулиар зохицуулна.

5	ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬ	2017	• 50 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Ерөнхийлөгчтэй харилцах • 50.1.Ял шийтгүүлсэн этгээдэд үзүүлэх уучлалын асуудлаар дүгнэлт гаргана.
6	ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ	2017	• 155.1.5 ялтанд өршөөл, уучлал үзүүлсэн бол эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцож, хэргийг хаана • 193.1.3.өршөөл, уучлал үзүүлсэн бол албадлагын арга хэмжээг дуусгавар болсонд тооцож, хяналтын хувийн хэргийг хаана: • 252.1.2.өршөөл, уучлал үзүүлсэн бол хоригдлыг суллана.
7	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРЭМ	2018-1-5/02	• 17.1.1 Хуулийн хэлтэс Ерөнхийлөгчөөс уучлал үзүүлэхийг хүссэн хүсэлтийг хүлээн авч судлан, зохих ажиллагааг хийсний үндсэн дээр танилцуулга, шийдвэрийн төсөл боловсруулна
8	МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН ДҮРЭМ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	2018-12- 26/396	• 2.11. Шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялын хугацаа дууссан, хорих ялыг өөр төрлийн ялаар сольсон, хорих ялаас өвчний учир чөлөөлөгдсөн, өршөөл, уучлал үзүүлсэн, хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан, шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан тохиолдолд тухайн иргэнд иргэний үнэмлэхийг буцаан өгнө.

Шүүмжлэлт сэтгэлгээний ур чадвар эзэмшүүлэх ба энэ нь хуулийн оюутнуудын ур чадварт нөлөөлөх нь
/Acquisition of critical thinking skills that influences the skills of lawyer students/



Шихихутуг их сургуулийн
Ерөнхий эрдмийн тэнхимийн багш
Д.Одон

Агуулга

Оршил

Сэдвийг судлах үндэслэл

Судалгааны ажлын зорилго, зорилт

Сэдвийн судлагдсан байдал

Судалгааны арга, аргачлал

Судалгааны үр дүн

1-р хэсэг: Шүүмжлэлт сэтгэлгээний
ур чадвар гэж юу вэ?

2-р хэсэг: Шүүмжлэлт сэтгэлгээний
ур чадвар хуулийн салбарт
нөлөөлөх нь

Судалгааны хэсэг

Дүгнэлт

Ном зүй

Оршил

Өнөөгийн боловсролын болон нийгмийн олон талт мэргэжлийн салбарт шүүмжлэлт сэтгэлгээний ур чадвар буюу аливаа мэдээллийг шүүн тунгаан бодож, тухайн зүйлдээ бүтээлчээр хандаж сурах нь нэн тэргүүний эзэмшвэл зохих чадваруудын нэг болж ирсэн бөгөөд энэ нь ялангуяа хуулийн ангийн оюутнуудад англи хэлээр дамжуулан хэрхэн, яаж шүүмжлэлтэй, бүтээлч сэтгэгч чадвартай болох, үүнд нь туслах зорилготойгоор энэхүү өгүүллийг бичлээ. Аливаа гадаад хэл сурахад хүмүүс хэлний үндсэн ур чадварууд болох Унших, Бичих, Ярих, Сонсох зэрэг чадвар эзэмших шаардлагатай байдаг бөгөөд эдгээр нь ямар ч мэргэжил эзэмшсэн тухайн хүнд байх ёстой гол чадваруудын нэг юм.

Иймээс аливаа дээд боловсролын байгууллагууд болон их дээд сургуулиуд оюутан суралцагчиддаа 21 -р зууны чухал чадваруудыг эзэмшүүлэх, төлөвшүүлэх мөн үүний талаар сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай болохыг мөн цаашлаад оюутан залуусын энэ төрлийн ур чадвар нь тэдэнд мэргэжлийн түвшинд ахиц гаргах, хөгжихөд нь тус нэмэр болно гэж үзэж байна.

Түлхүүр үгс:

Хуулийн сургуулийн оюутнууд, шүүмжлэлт сэтгэхүй, ур чадвар

Судалгааны ажлын үндэслэл

Нийгмийн аливаа нэг нийтлэг төрх байдлаас өөрөөр сэтгэж, түүнд бүтээлчээр гаргалгаа, шийдэл гарган сэтгэх, нийгмийн болон хувь хүнд байх ёстой зайлшгүй ур чадваруудыг эзэмших нь өнөөгийн нийгмийн боловсрол төдийгүй бусад олон салбарт чухал байр суурь эзэлж байгаа бөгөөд тухайн хүн өөртөө төлөвшүүлэн бий болгоход хамгийн чухал зүйлсийн нэг юм. Ялангуяа хуульч мэргэжилийг эзэмшиж буй оюутан залуусын эзэмшвэл зохих хамгийн чухал зан чанаруудын нэг болох шүүмжлэлт сэтгэлгээ буюу асуудал шийдвэрлэх чадвар бөгөөд энэ нь аливаа асуудлыг хурдан шийдвэрлэх илүү бие даасан байдлыг бий болгоход тусалдаг ур чадвар буюу мэдлэг юм. Уг сэдвийн сонгон илтгэл бичих болсон гол шалтгаан болж буй зүйл нь өнөөгийн цаг үед аливааг шүүлтүүртэй хүлээн авах болон шүүмжлэлтэй сэтгэлгээ нэн чухал буйг хүмүүст таниулах, боловсролын байгууллагууд болон их дээд сургуулиуд энэ талын ур чадварыг суралцагчиддаа төлөвшүүлэх талаар хөтөлбөр боловсруулах нэн шаардлагатай болохыг илэрхийлэхийг зорьсон бөгөөд тэр дундаа ирээдүйд хуульч болох гэж буй оюутан бүхэнд нэн тэргүүнд эзэмших зайлшгүй шаардлага бүхий чадвар болох, мөн цаашлаад судалгаанд суурилсан

оюутан залуусын энэ төрлийн чадвар хэр хөгжиж буйг дүгнэн гаргахыг зорисон болно.

1 дүгээр бүлэг: Шүүмжлэлт сэтгэлгээ гэж юу вэ?

Шүүмжлэлт сэтгэлгээний талаар олон янзын тайлбар ухагдахуун байдаг бөгөөд тус бүрийг ойлгох нь чухал мөн тэдгээрийн зарим нь өвөрмөц утга илэрхийлэх нь байдаг ч нийтлэг ч талууд байдаг. Шүүмжлэлт сэтгэлгээний талаар Америкийн гүн ухаантан Жон Дьюи, (1910) «эргэн бодох сэтгэлгээ» - "reflective thinking" гэж нэрлэсэн нэр томъёог анхлан ашигласан байдаг.¹ "Шүүмжлэлт сэтгэлгээ гэдэг нь тодорхой бөгөөд тууштай шалгуураар хүлээн авсан мэдээллийг зөв үндэслэлтэй зохион байгуулах, түүнийгээ үнэлэх, шалгах чадвар юм. Тиймээс энэ нь аливаа баримт мэдээлэлийг тайлбарлах, өөрийн зүгээс хувийн дүгнэлт хийх санаа, зорилго, үзэл баримтлал, аргументэд дүн шинжилгээ хийх чадвартай байхыг илэрхийлдэг."² гэж үзжээ.

Бүтээлч, шүүмжлэлтэй ур чадвараас бүрдэх сэтгэн бодох чадварыг сонсох, ярих, унших, бичих зэрэг аливаа хэл эзэмшихэд шаардагддаг хэлний унаган чадвараас салгах аргагүй, хэлгүйгээр сэтгэх боломжгүй, хэл нь сэтгэн бодоход туйлын чухал бүрдэл хэсэг болдог. Шүүмжлэлтэй сэтгэх чадвар нь аливаа нийгэмд ажиллах чадвар, оршин тогтнох ур чадваруудын нэг юм.

¹ <https://plato.stanford.edu/entries/critical-thinking/#H1sl>

² <https://musa.news/mn/cose-il-pensiero-critico-non-e-quello-che-pensi-ma-come-pensi/>

Иймээс оюутан, суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээний чадварыг хөгжүүлэх нь англи хэлний хичээлийн үндсэн зорилгуудын нэг бөгөөд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад тодорхой хэмжээгээр хэрэглэгддэг чадвар юм. Шүүмжлэлт сэтгэлгээ нь сурагчдад асуулт тавих, ойлгох, дүгнэлт хийх, түүнийгээ өөрийн үнэлгээ өгч тайлбарлах, шүүн тунгаах, шийдвэр гаргах, тархины шуурга буюу оюуны довтолгоо хийх, туршилт хийх, асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээгээр янз бүрийн боломжуудыг байгаа эсэхийг судлах, бие даан сэтгэх, логик дүгнэлт хийх, дүн шинжилгээ хийх зэрэг танин мэдэхүйн олон чадварыг эзэмших боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл үүнийг аливаа сэдэв, агуулга, асуудлын талаар сэтгэгч эсвэл суралцагч өөрийн сэтгэхүйн чанарт тохируулан мэргэжлийн хүрээнд болон хувийн зүгээс дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх замаар сэтгэн бодох арга юм уу, ухамсарлан шинжлэх арга гэж үздэг. Өөрөөр хэлбэл, шүүмжлэлт сэтгэлгээ нь өөртөө чиглэсэн, өөрийгөө хянах, өөрийгөө засах сэтгэлгээ юм. Энэ нь үр дүнтэй харилцаа холбоо үүсгэх, асуудлыг шийдвэрлэх, мөн тухайн хүнд байдаг унаган сул талуудыг /өөрийгөө илэрхийлж чадахгүй байх, ичимхий, өөртөө итгэлгүй зан, бичгий болон харилцааны ур чадвар дутуу байх/ зэрэг даван туулах шаардлагатай олон чадваруудыг нь нээн илрүүлэн, сайнаар эргүүлэхэд тусладаг.

Шүүмжлэл сэтгэлгээний үгсийн гарал үүсэл, нэр томъёоны тухайд бид «Шүүмжлэх сэтгэлгээ»- гэдэг нь Этимологи ба толь бичгийн тодорхойлолтоос олж харвал: Шүүмжлэл сэтгэлгээний ойлголт нь эртний Грекийн язгуур угсаа, «critical» гэдэг нь этимологийн хувьд «kriticos» гэсэн үгнээс гаралтай. « (ялгамжтай шүүлт гэсэн үг) ба «критерион» (стандарт) гэсэн утгатай.³

Тухайн чадварыг эзэмшсэнээрээ заримдаа нийгмийн болон хүмүүсийн үзэл баримтлалаас таны үзэл баримтлалаас эсрэг байж болох ч энэ аливаа юмсыг бусдаас хараат бусаар сэтгэх чадвар гэж ойлгож болох юм. “Энэ нь өөрийн болон бусдын санаа, сэтгэлгээний үйл явцыг үнэлэх, дахин тайлбарлах үйл явц юм.” гэсэн үзэл байхад, “Шүүмжлэлт сэтгэлгээ нь аливаа зүйлийг (үзэл баримтлал, аргумент, мэдээлэл) хүлээн авах, үгүйсгэхийн оршил болгон ойлгож, үнэлэхийн тулд дүн шинжилгээ хийх, эсвэл хэсэгчлэн задлахыг агуулдаг.” гэж бас үзэж тодорхойлж байв. Өнөөгийн мэдээллийн их давалгаа буюу нийтээр цахимжсан цаг үед хүн бүр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлдэг болсон үүнээс аливаа мэдээллийг хэрхэн шүүн тунгааж үнэн зөв эсэх, үндэслэлтэй эсэх хэрхэн бодит байдалд нийцэж байгаа талаар шүүн тунгааж хүлээн авах нь багассан аливаа мэдээллийг шүүлтүүргүй хүлээн авч байгаа нь аливаа

³ The Etymology & Dictionary Definition of "Critical Thinking"

мэдээлэл, асуудалд шүүмжлэлт сэтгэлгээгээр хүлээн авах чадвар дутагдаж байгааг та бид харж байна.

Энэ нь бие даасан байдлын үндсэн тулгуур ур чадваруудын нэг бөгөөд шүүмжлэлт сэтгэлгээний гол үндэс нь аливаа асуудалд “Яагаад?” гэх асуултыг өөртөө тавьдаг байх нь чухал.

Шүүмжлэлт сэтгэлгээний төрөлд эзэмшвэл зохих чадварууд:

Шүүмжлэлтэй сэтгэх чадварыг эзэмшихийн тулд нэн тэргүүнд дараах ур чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай гэж үзэж болох юм.

1. Ажиглалт хийх

Шүүмжлэлтэй сэтгэлгээний нэг хэсэг нь аливаа асуудал, өгөгдлийн багцэсвэл текст аль нь ч бай ямар нэг зүйлийг сайтар судлах чадвар юм. Аналитик ур чадвартай хүмүүс мэдээллийг шалгаж, энэ нь юу гэсэн үг болохыг ойлгож, тухайн мэдээллийн үр дагаврыг бусдад зөв тайлбарлаж чаддаг.

2. Харилцаа холбоо

Ихэнхдээ та дүгнэлтээ ажил олгогчид эсвэл хэсэг хамт олонтойгоо хуваалцах шаардлагатай болдог. Санаагаа үр дүнтэй хуваалцахын тулд бусадтай харилцах чадвартай байх хэрэгтэй. Энэ тохиолдолд та бусадтай хамтран ажиллаж, нарийн төвөгтэй асуудлын шийдлийг олохын тулд үр дүнтэй харилцах хэрэгтэй болно.

3. Бүтээлч байдал

Шүүмжлэх сэтгэлгээ нь ихэвчлэн бүтээлч байдал, шинэчлэлийг агуулдаг. Та харж байгаа мэдээллээс хэв маягийг олж харах эсвэл урьд өмнө хэний ч бодож байгаагүй шийдлийг олох хэрэгтэй байж магадгүй юм. Энэ бүхэн нь бусад бүх арга барилаас өөр хандлагыг авч чаддаг бүтээлч байдал хамаардаг.

4. Чөлөөт сэтгэлгээ

Шүүмжлэлээр бодохын тулд та аливаа таамаглал, дүгнэлтийг хойш тавьж, зөвхөн хүлээн авсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийх чадвартай байх хэрэгтэй. Та бодитой байж, санааг аль нэг талыг баримтлахгүйгээр дүгнэх хэрэгтэй.

5. Асуудал шийдэх

Асуудлыг шийдвэрлэх нь асуудалд дүн шинжилгээ хийх, шийдлийг бий болгох, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний амжилтыг үнэлэх зэрэг шүүмжлэлтэй сэтгэлгээний өөр нэг чадвар юм. Ажил олгогчид зүгээр л мэдээллийн талаар шүүмжлэлтэй хандаж чаддаг ажилчдыг хүсдэггүй. Тэд бас бодитой шийдлийг гаргаж чаддаг байх хэрэгтэй.

Өнөөгийн нийгэмд олон янзаар түүн дотроо эзэмшивэл зохих шаардлагатай ух чадваруудыг олон талаар дүрслэн тодорхойлсны нэг бол зөөлөн болон хатуу ур чадвар / Hard and Soft skills/ гэж нэрлэгдээд байгаа ур чадварууд нилээн өргөн хэмжээнд яригддаг ба тэднийг ажил

оллогчид, бизнесийн байгууллагууд ажилд орох үндсэн шалгууруудын нэг ч болгосон байдаг. *Зураг 1. Valamis studio -hard-skills-vs-soft-skills*

Эдгээр нь англи хэлний хичээл дээр төдийгүй бусад салбарт хэрэглэгддэг нэн тэргүүний чадварууд бөгөөд үүний талаар гадаад хэлний



хичээлээр дамжуулан заах арга барилын хүрээнд сурах бичгүүдэд ч мөн адил дурдагдсан байдаг ба дараах байдлаар шүүмжлэлт сэтгэлгээний эзэмшвэл зохих чадваруудыг хичээлийн сурах бичгүүдэд тусгасан байдаг. Үүнд:

Унших болон Бичих чадвар олгох сургалтын эх хэрэглэгдэхүүнээс дурдвал⁴:

- Ангилах, төрөлжүүлэх -Classifying
- Дахин илэрхийлэх дурдах -Restating
- Давуу сул талуудыг тодорхойлох- Identifying pros and cons
- Туслах, нэмэлт мэдээллийг тодорхойлох -Identifying supporting information
- Эх сурвалжыг үнэлэх -Evaluating sources
- Үзэл бодлоо батлах -Justifying your opinion
- Бодол санаагаа зөв тодорхойлох -Identifying point of view

⁴ Colin. S., Ward., Margot F., Gramer., Q Skills for success -reading,listening

- Бодит байдал болон үзэл бодлыг ялган тодорхойлох- Identifying facts and opinions
- Санаа бодлоо дараалалтай гаргах, илэрхийлэх- Putting ideas in order
- Дүгнэлтэнд хүрэх -Drawing conclusions
- Тойм байдлаар санааг эмхлэх -Organizing ideas with a rough outline
- Санаа бодлоо үнэлэх , шинжлэх -Analyzing and evaluating ideas
- Сэдэв, санааг урьчилан таамаглах -Predicting topic and ideas
- Гол санааг нэгтгэн дүгнэх -Summarizing main ideas
- Учир шалтгаан, үр дүнг шинжлэх - Analyzing cause and effect

Харин Сонсох болон Ярих чадвар олгох хичээлийн хүрээнд:

- Харьцуулах, эсрэгцүүлэх- Comparing and contrasting
- Нэмэлт мэдээллээр хангах -Providing support for suggestion
- Чухал зүйлээ шийдэх -Deciding what is important
- Тайлбарлах -Interpreting
- Эрэмбэлэх -Ranking
- Шүүн тунгаах -Making judgement
- Шинэ санаа, оноо гаргах -Generating ideas
- Үзэл бодлоо чартанд цэгцлэх- Organizing ideas in chart
- Paraphrasing-найруулан өөрчлөх
- Synthesizing-нэгтгэх
- Hypothesizing-таамаглах

Англи хэлний хичээл дээр тухайн оюутан үзэж судласан хичээл, агуулгатай тодорхой хугацаанд танилцаж, дадлага эзэмшсний дараа хичээл бүрт хамаарах мэдлэгийг бататган өгөгдсөн даалгавар, дасгал ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ шүүмжлэлт сэтгэхүй -Critical thinking чадвар эзэмшдэг. Манай Шихихутуг их сургуулийн хувьд оюутнууд Академик англи хэлний хичээлийн 1 - ээс 4 хүртэлх түвшинг эхний 1 болон 2 дугаар курст үзэж судладаг ба тухайн хичээлээс Унших, Бичих, Яриа, Сонсох дадал хичээл бүр дээр хамаарах ур чадварыг эзэмшдэг. Жишээ нь: EAP хөтөлбөрийн Q- Skills for Success “Reading and Writing” буюу унших ба бичих чадвар олгох хичээлийн хүрээнд тухайн оюутан нэгж хичээл болгон дээр доорх чадварыг хичээлтэйгээ холбон хамааруулан эзэмшдэг.

Хүснэгт 1 - Шүүмжлэлт Сэтгэлгээний стратеги

Critical thinking strategy EAP -111	
Unit 1 Classifying- мэдээллийг ангилах	Unit 5 Evaluating source- Эх сурвалжыг үнэлэх
Unit 2 Restating- дахин илэрхийлэх	Unit 6 Justifying your opinion - Үзэл бодлоо батлах
Unit 3 Identifying pros and cons- Давуу сул талуудыг тодорхойлох	Unit 7 Identifying point of view- Бодол санаагаа зөв тодорхойлох
Unit 4 Identifying supporting information Туслах, нэмэлт мэдээллийг ойлгох, тодорхойлох	Unit 8 Identifying cause and effect- Учир шалтгаан, үр дүнг тодорхойлох

Дээр дурьдагдсан ур чадваруудаас харахад суралцагч үзэж судласан хичээл бүр дээр хамаарагдах хэлний чадваруудыг эзэмшиж түүнийгээ амьдрал, практикт хэрэгжүүлэх шаардлага гарч ирдэг ба энэ нь цаашлаад тэдний мэргэжлийн хүрээнд өргөнөөр хэрэглэгдэх чадварууд байгаа нь харагдаж байна. Жишээ нь: Бичгийн хичээл дээр оюутан бичгийн харилцаанд зайлшгүй шаардлагатай бичгийн нэг төрөл болох бодол санаа илэрхийлсэн параграф буюу эх, цогцолбор бичих шаардлага гардаг бөгөөд үүнийг бичихийн тулд гол санаагаа гаргах, түүнийгээ баримтат эх үүсвэрүүдээр баяжуулах, шаардлагатай ишлэл зүйлтүүдийг дурдах зэрэг шалгуурууд шаардагддаг бөгөөд оюутнууд тухайн даалгаврыг хийж гүйцэтгэхийн тулд бие даан болон багийн, хамтын ажиллагаагаар гүйцэтгэхдээ харилцааны болон мэдээллийн эх сурвалжыг хайх шаардагдах техникийн мэдлэг ур чадвар эзэмшиж байдаг. Иймээс мэргэжлийн хүрээнд хуулийн салбарын хүрээнд энэхүү нийгмийн ур чадвар хэрхэн түгээмэл тохиолддог түүнийг яаж хэрэглэх талаар үзэх нь шаардлагатай болж байна.

2 -р бүлэг Хуульч мэргэжилтэн хүний эзэмшвэл

зохих ур чадварууд гэж юу вэ?

Шүүмжлэлт сэтгэлгээний ур чадвар хуулийн салбарт нөлөөлөх нь

Хуульч мэргэжлийн төдийгүй бусад мэргэжилд ч хэрэг болох ур чадваруудад техникийн өргөн мэдлэг, аман болон бичгийн өндөр харилцаа, ярилцлага хийх, төсөл боловсруулах, хэлэлцээр хийх, асуудал шийдэх, ажлын болон цагийн менежменттэй байх зэрэг орох бөгөөд эдгээр нь тухайн

хүнд мэргэжлээрээ ч тэр, карьераа ч хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой зүйлс юм. Мөн бусад мэргэжлийн орчин, ажлын нөхцөл байдалд шилжих боломжтой мэргэжлийн ур чадвар байдаг тэдгээрийг ч тухайн хүн хөгжүүлэх шаардлага гарч ирж байгаа нь өнөөгийн нийгмийн нэгэн шинж юм. Ур чадвараа байнгын хөгжүүлэх нь чухал үйл явц бөгөөд, учир нь хамгийн туршлагатай хуульчдад хүртэл хурдацтай хөгжиж буй нийгмийн шаардлагат нийцсэн илүү сайжруулах талбар эсвэл шинэ ур чадвар эзэмших хэрэгцээ ажил байдлаас үүдэн гарах нь бий. Жишээлбэл, үйлчлүүлэгчтэй идэвхитэй ярилцлага хийн, харилцаа тогтоох нь нь хуульч хүний ажлын туршид хөгжүүлэх чадваруудын нэг юм. Үйлчлүүлэгчтэй үр дүнтэй ярилцлага хийх чадварыг тань хүмүүстэй харьцах туршлага, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх туршлага, мөн түүнчлэн харилцааны үндсэн мэдлэгтэй байна гэсэн үг юм. Ерөнхийдөө хуулийн сургуулийн оюутнууд мэргэжлийн түвшинд сэтгэж, сурч эзэмших ёстой үндсэн чадвараас гадна хууль эрх зүйн үндсэн ур чадваруудыг заавал эзэмших шаардлагатай. Тэднээс түгээмэл арван ур чадваруудыг дурдвал :

1. Шүүмжлэх сэтгэлгээ- Critical thinking
2. Шүүмжлэн унших- Critical reading
3. Шүүмжлэлтэй сонсох- Critical listening
4. Хэргийн товч танилцуулга -Case briefing
5. Тэмдэглэл хөтлөх- Note taking
6. Тоймлох -Outlining
7. Бичгийн ур чадвар - Writing skills
8. Амжилтанд хүрэхийн тулд зохион байгуулах- Organizing for success
9. Тэнцвэрийг хадгалах- Maintaining balance
10. Хамтран ажиллах, манлайлах- Collaborating and leading


Хууль хүн болон энэ салбараар мэргэшсэн хүн зөвхөн хуулийн талаар өндөр мэдлэгтэй байхаас гадна аливаа асуудалд шүүмжлэлтэй сэтгэж үндэслэл, болон бодит байдалд тулгуурласан байх нь хамгийн чухал бөгөөд аливаа асуудлыг оновчтой шийдвэрлэх шийдлийг олж чаддаг байх нь нэн тэргүүний чухал зүйл юм. Эдгээр чадварууд нь хуульч хүн зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай чадваруудын бөгөөд үүний дунд асуудал шийдвэрлэх чадвар буюу шүүмжлэлт сэтгэлгээний чадвар багтаж байгаа нь шүүмжлэлтэй сэтгэдэг байна гэдэг нь хуульч хүний хамгийн чухал байх ур чадвар болж буйг харуулж байна.

Судалгааны арга

Энэхүү судалгааг манай Шихихутуг их сургуулийн 1-2-р дугаар ангийн оюутнуудаас өөрсдийн ур чадвараа хэрхэн үнэлж байгаа байдал ялангуяа ямар ур чадвар тэдний мэргэжлийн хүрээнд хэрэгцээ шаардлагатай байгааг

тодруулах үүднээс асуулгын аргаар тоон болон эмперик судалгааг авсан юм. Энэхүү сэдвийн хүрээнд хүмүүсийн шүүмжлэлт сэтгэлгээний талаар судалгаа авсан бөгөөд уг судалгаанд нийт 100 гаруй хүн оролцсон бөгөөд үүний дунд оюутан болон энгийн иргэд оролцсон. Судалгааг холимог аргаар авсан болно. Судалгаанд оролцогчидын ихэнх хувь нь хуулийн сургуулийн оюутан байгаа бөгөөд нийт дөрвөн их сургуулийн оюутан үүнд хамрагдсан. Энгийн иргэд гэдэгт ажил эрхэлж буй хүмүүс хамаарч байна.

График 1: Судалгаанд хамрагдсан иргэд нийгмийн статусаар нь /тоогоор/




Шүүмжлэлт сэтгэлгээ гэж таны бодлоор юу вэ? талаар нээлттэй асуумж явуулахад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан бөгөөд нийт хариултуудыг нэгтгэн үзэн хамгийн олон санал авсан хариултуудыг орууллаа.

1. Аливаа зүйлийг үнэлэн шүүн тунгаах-
2. Өөрт таалагдахгүй байгаа зүйлийг шүүх
3. Бусдын хараагүй зүйлийг харах
4. Болохгүй байгаа зүйлийг бодож сэтгэх, үгүйсгэж няцаах
5. Бусдын хэлж байгаа үг, хийж байгаа ажил, санаа санаачлагыг эхлээд бүрэн сонсож өөрийн дүгнэлтийг бодит үнэнтэй холбон дүгнэж үзэл бодлоо хэлэх
6. Гоё муухай ямар ч хамаагүй зүйлийг ингэж шүүмжлэх гоё байсан ч муухай болгоод л шүүмжлэх
7. Тодорхой нэг асуудлын хүрээнд гарч болзошгүй үр дагавар болон үнэн зөв эсэхээс үл хамааран өөрийн үзэл санаааг илэрхийлэн үндэслэлтэй санаанд хүрэхийг хэлнэ


8. Бусдын болон өөрийнхөө алдаа дутагдалаа мэдэх
 9. Өөрийгөө, өөрийн бодол, үйлдэлээ эргэцүүлэх
 10. Шүүмжлэлт сэтгэлгээ бол илүү сайжрах үндэс
 11. Аливаа зүйлийг өөрийнхөө байр сууринаас бодож, тэрийгээ илэрхийлэх
 12. Бусдын хийсэн зүйлийг илүү сайжруулах тухай зөвлөх
- гэж өөр өөрсдийн бодлоор хариулсан бөгөөд үүнээс зарим нь шүүмжлэлт сэтгэлгээ гэдгийг сөрөг зүйл гэж дүгнэж байгаа бол харин нөгөө талаараа энэ байх ёстой асуудлыг дүгнэж буй чухал зүйл гэж үзэж байгааг харж болохоор байна.

График 2: Шүүмжлэлт сэтгэлгээний хүрээнд аливаа мэдээллийг хэрхэн дүгнэдэг байдлаар нь




Дээрх графикаас үзэхэд судалгаанд оролцогчидын шүүмжлэлтэй сэтгэх чадвар нь боломжийн хэмжээнд хөгжсөн байгааг харж болохуйц юм.

График 3: Шүүмжлэлтэй сэтгэх чадварын дараах бүрдэл чадваруудаас алийг нь илүү ашигладаг талаар



Энэ үзүүлэлтээс харахад шүүмжлэлт сэтгэлгээний чадварууд дундаас ажиглалт хийх чадварыг хүмүүс илүү их ашиглаж байгаа нь ажиглагдаж байна. Хамгийн бага байгаа нь бүтээлч байдал байгаа нь хүмүүс энэ чадвараа илүү хөгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж болох юм.

График 4: Ажиглалт хийх чадвараа үнэлэх нь



Үүнээс дүгнэхэд хүмүүс ажиглалт хийх чадвараа маш сайн гэж хариулт өгөх нь хангалтгүй байгаа нь хөгжүүлэх шаардлага байна гэж үзэж болох юм.

График 5: Харилцах чадвараа дүгнэх нь




Судалгаанд оролцогчид бусадтай харилцах чадвараа нь дундаж гэж үнэлсэн нь өөрийгөө илэрхийлэх чадвар нь бага хөгжсөн байна гэж үзэж болно.

График 6: Бүтээлч байдлын нөлөө



Судалгаанд оролцогчидын нийтлэг хариултаас үзвэл бүтээлч байдал нь ажилын бүтээмж, чанарт маш их нөлөөлдөг бөгөөд үүнээс энэхүү чадвар нь маш чухал чадвар гэдгийг харж болох юм.

График 7: Чөлөөт сэтгэлгээний давуу тал




Үүнээс үзэхэд судалгаанд оролцогчидын хамгийн их санал өгсөн давуу талууд нь юмсыг олон талаас нь дүгнэж сурах болон илүү өргөн хүрээнд бодож, сэтгэж сурах давуу талуудыг бий болгодог гэж үзсэн байна.

График 8: Асуудал шийдвэрлэх




Энэхүү дүнгээс үзэхэд асуудлыг шийдвэрлэхдээ тухайн асуудлын шийдлийг хамгийн түрүүнд хайдаг гэж хариулсан байдлаас үзэхэд асуудлаа бусадтай ярилцахаас илүү өөрөө тунгаан түүнийхээ шийдлийг олохыг илүүд үздэг болохыг харж болох юм.

График 9: Шүүмжлэлт сэтгэлгээг үнэлэх нь /тоогоор/



Шүүмжлэлтэй сэтгэлгээ нь судалгаанаас үзэхэд өдөр тутмын болон ажил мэргэжлийн амьдралд чухал нөлөө бүхий чадвар бөгөөд энэхүү чадвар нь судалгаанд оролцогчидын хувьд зайлшгүй эзэмших шаардлагатай гэж үзэж байна гэж дүгнэж болох юм.

График 10: Хуульч ба шүүмжлэлт сэтгэлгээ /тоогоор/



Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь нь маш чухал гэж үзэж байгаа нь хуульч болон энэхүү мэргэжлээр суралцаж буй оюутан залуусын шүүмжлэлтэй сэтгэх чадварыг сайжруулах шаардлага их байгааг харуулж байгаа бөгөөд хуульч хүний эзэмшсэн байх чадваруудын нэг гэдгийг мөн илтгэж байна.

Дүгнэлт

Дээрх судалгаанаас үзэхэд шүүмжлэлтэй сэтгэх чадвар нь хуулийн сургуулийн оюутны хувьд маш чухал чадваруудын нэг бөгөөд өнөөгийн нийгэмд ихээхэн нөлөө бүхий ур чадваруудын нэг хэмээн дүгнэж болохоор байна. Мэдээллийн эрин зууны өнөө үед аливаа мэдээлэлд шүүмжлэлтэй сэтгэлгээгээр хандаж бие даасан хараат бус иргэн болж төлөвших нь хамгийн чухал болоод байна. Иймээс шүүмжлэлт сэтгэлгээг оюутан, суралцагч хөгжүүлснээр аливаа асуудалыг бодит зөв шийдвэрлэх, түүнд тохирох зөв гаргалгааг олж сурахад туслах цаашлаад энэ нь мэргэжлийн талбарт ахиц дэвшил гаргахад зайлшгүй хэрэгцээт уг чадвар болж байгаа төдийгүй өөр олон төрлийн ур чадварыг эзэмшихэд гүүр болж өгөх ур чадвар юм.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд бид хичээл сургалтийг энэ чиглэлээр заан чиглүүлж байгаагийн хувьд мөн суралцаж буй оюутнуудын хувьд шүүмжлэлтэй сэтгэж сурах нь нэн түрүүнд эзэмших чадваруудын нэг гэж дүгнэж байна. Мөн энэхүү чадвар нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад давуу тал болох чадвар бөгөөд аливаа асуудалд үнэн бодитой шийдвэр гаргах, үндэслэлтэй дүгнэлт хийх гэж зэрэг олон зүйлд онцгой хувь нэмэр болохуйц ур чадвар болохыг олон талаас батлан харуулахыг зорилоо. Иймээс хувь хүний ур чадварт онцгой хувь нэмэр болох чадвар гэж дүгнэж байна.

Ном зүй

Цахим эх сурвалж

1. Arias-Rodríguez, G. L. (2014). Reading through ESP in an undergraduate law program.
2. PROFILE Issues in Teachers' Professional Development, 16(1), 105-118.
3. Arias-Rodríguez, G. L. (2017). Students' Language Skills Development through Short Stories.
4. Hkala, 22(1), 103–118. <https://doi.org/10.17533/udea.ikala.v22n01a07>
5. Astleitner, H. (2011). Teaching Critical Thinking Online.
6. Medina, R. (2012). Critical thinking Inside Law Schools: An Outline
7. <https://mn.warbletoncouncil.org/pensamiento-critico-7778>
8. <https://mn.gov-civil-viseu.pt/ultimate-guide-critical-thinking>
9. <https://mn.warbletoncouncil.org/pensamiento-critico-2794>
10. <https://musa.news/mn/cose-il-pensiero-critico-non-e-quello-che-pensi-ma-come-pensi/>
11. <https://sites.google.com/site/twentyfirststcenturyskills/evaluation>
12. <https://courses.lumenlearning.com/suny-esc-educationalplanning/chapter/critical-thinking-2/>
13. <https://www.collaw.edu.au/learn-with-us/our-programs/practical-legal-training-programs/coursework/lawyers-skills?fbclid=IwAR2T4iMLOXMLNm9MLJG29sJJJeQY5dKA81gHDhEszUAubQru1ntYBjFmirc>
14. <https://plato.stanford.edu/entries/critical-thinking/#Hist>

НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ



Шихихутуг их сургуулийн Нийтийн
эрх зүйн тэнхимийн багш
Г.Хонгор

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16.14-т “Монгол Улсын иргэд ... хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” болохыг тунхаглажээ. Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн үүрэг нь “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлж хэрэг, маргааныг хянан хэлэлцэж шийдвэрлэх” зэрэг Үндсэн хуулийн зохицуулалтаар илэрдэг. Иргэн болон хуулийн этгээд өөрийн субъектив¹ эрх нь зөрчигдсөн тохиолдолд шүүхээр хамгаалуулах эрхтэй байдаг.

¹ Субъектив эрх гэдэг нь хууль бусад хэм хэмжээгээр тогтоосон буюу зөвшөөрсөн, эрх зүйн харилцааны оролцогч талуудаас хууль зүйн дагуу эдлэх боломж юм гэж үздэг. Ийм боломжийг эрх зүйн харилцаанд оролцогч тал буюу субъект хүсэл зоргоороо буюу үзэмжээрээ эдэлдэг болохоор субъектив эрх гэж нэрлэдэг.

УИХ-аас 2016 онд баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийг 18 дугаар зүйлийн 3 дах хэсэгт хуульчлан² өгсөнөөр захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн иргэн ба хуулиар тусгайлан эрх олгосон байгууллага нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн оролцогч³ болон хэрэг маргаанд оролцох эрхтэй болсон.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд хандах эрх нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх, нийтийн ашиг сонирхлыг зөрчиж буй эсэхэд шүүхээс хяналт тавих, улмаар эрх мэдлийг тэнцвэржүүлэхэд онцгой ач

² ЗХШХШТХ 18.3 Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараахь шаардлагыг хангасан байна:

18.3.1. нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;
18.3.2. дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх

³ ЗХШХШТХ 3.1.3 “нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг

холбогдолтой байдаг.⁴

Нийтийн эрх ашгийг хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хөндөхийн өмнө Нийтийн эрх ашиг /public interest/ гэх нэр томъёоны тухай тайлбар хийх хэрэгтэй болно. Өөрөөр хэлэхэд хуулиар хамгаалагдаж буй тэрхүү ашиг сонирхол нь өөрөө ямар ойлголт болохыг эхлээд тодруулах шаардлагатай. Нийтийн эрх ашиг гэх ойлголт нь өргөн утга агуулгаар илэрхийлэгдэх ба нарийвчлан тодорхой заах боломжгүй ойлголт юм.

Тухайлбал Америкийн эрх зүйд өргөн хэрэглэгддэг Блекийн эрх зүйн тайлбар тольд “нийтийн эрх ашиг” гэдэг нь

1. Хүлээн зөвшөөрөх, хамгаалахад хүргэдэг олон нийтийн ерөнхий сайн сайхан байдал,
2. Олон нийт энэхүү эрх ашигт нэгдэж, нэн ялангуяа төрөөс зохицуулалтыг шаарддаг⁵

Харин Барроны эрх зүйн тайлбар тольд “нийтийн эрх ашиг” гэдгийг нийгэмд бүхэлд нь хамгийн их хэрэгцээтэй бөгөөд нийт хүн амын сайн сайхан гэж юу болохыг шүүгч, засаг дарга зэрэг хувь хүмүүс, эсвэл хууль тогтоогчид гэсэн бүлэг хүмүүс субъектив байдлаар тодорхойлдог.⁶ Энэ тодоройлолт нь практик дээр “нийтийн эрх ашиг”

⁴ Нээлттэй нийгэм форум. Нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Шүүхийн практик. УБ., 2020. 5х

⁵ Bryn A. Garner(ed), Blacks dictionary, 4th ed.(Minnesota: West Publishing Co., 1979) дам ишлэв

⁶ Steven H.Gifis, Law dictionary, 4th ed(New Yourk : Barrons Educational Servives, 1996) дам ишлэв

гэдгийг хэн тодорхойлдог болохыг илүү дэлгэрэнгүй байдлаар гаргасан байна.⁷

Англо – Саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд “нийтийн эрх ашиг” гэдэг асуудлыг ихэвчлэн шүүх хянаж, шийдвэрлэсэн байна.

Дэлхийн улс орнуудад эрх зүйн бүл, улс төрийн үзэл баримтлал, төрийн онолын янз бүрийн чиг урсгалуудаас хамаарч Нийтийн ашиг сонирхол гэх ойлголт өөр өөр тодорхойлдог. Англи-Саксоны эрх зүйн системтэй улсын хууль зүйн шинжлэх ухааны бүтээлүүдэд үздэг нийтийн ашиг сонирхол хэмээх ойлголтын агуулга, мөн чанарыг авч үзэхэд тэргүүлэх байр сууринд дараах гурван онолын концепци байдаг байна. Үүнд:

1. Нийтийн ашиг сонирхлын либерал концепци
2. Нийтийн ашиг сонирхлын төр төвтэй концепци
3. Нийтийн ашиг сонирхлын ардчилсан ёсны концепци⁸ байдаг байна. Эдгээрийг дэлгэрүүлэн үзвэл:

Нийтийн ашиг сонирхлын либерал концепци

Нийтийн сайн сайхан нь “үл үзэгдэх гар”-ын тусламжтайгаар үүсдэг бөгөөд хувийн давуу тал, ашиг тусыг зорилгоо болгосон хувь этгээдүүдийн ашиг сонирхол

⁷ Хууль зүйн Үндэсний хүрээлэн. Нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. УБ., 2013

⁸ Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь. Эрдэм шинжилгээний өгүүллэг. УБ., 20,,

нь нийтийн ашиг сонирхлын эх үүсвэр хэмээн үздэг.⁹ Энэхүү үзэл баримтлалын төрийн онолын түвшинд боловсруулсан хүн бол Фрайхэрр фон Штайн гэж үздэг бөгөөд тэрээр нийтийн асуудлыг бүх иргэдийн асуудал болгохын тулд хувь этгээдийн ашиг сонирхлыг ашиглах учиртай ба тэдгээрийн бие даасан үйл ажиллагааг улсын эсхүл үндэстний сайн сайхан болгох ёстой гэж үзэж байсан байна.¹⁰

Нийтийн ашиг сонирхлын төр төвтэй концепци

Либерал концепцийн эсрэг төр төвтэй концепци байх ба онолын эх үүсвэрийг Гегель тавьжээ. Иргэний нийгэмд янз бүрийн хийгээд өөр хоорондоо эсрэгцсэн, хэрэгцээ шаардлагад чиглэсэн хувийн ашиг сонирхлууд оршин байдаг гэж үзжээ. Мөн түүний үзсэнээр бол нийт гэдэг бол ямарч утгаар төр байх бөгөөд философийн үүднээс авч үзвэл энэ нь туйлын ашиг сонирхол юм.

Төрийн бүхийл институт зарчмын хувьд нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох, мөн төлөөлөх эцсийн субъект болдог.¹¹

Нийтийн ашиг сонирхлын ардчилсан ёсны концепци

Онолын томоохон төлөөлөгч

⁹ Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь. Эрдэм шинжилгээний өгүүлэл. УБ., 20..

¹⁰ Anders Fisahn., Der Begriff des oeffentlinchen interesses im Fachplanungs – und Natursch Bielefeld., 4 дэх тал. дам ишлээ

¹¹ Anders Fisahn., Der Begriff des oeffentlinchen interesses im Fachplanungs – und Natursch Bielefeld., 5 дэх тал. дам ишлээ

Ханс Кельзен "Төр гэдэг бол хууль тогтоомж. Гэхдээ бүх хууль тогтоомж бол төр биш. Харин төрийн гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагууд хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хэм хэмжээг бий болгосон хууль тогтоомж бол төр гэсэн үг" гэсэн байна. Засгийн газар болон түүний харъяаны апаратрууд жум ёсны дугуу үүссэн эрх, эрх чөлөөш баталгаажуулах ёстой ч энэ нь хуульгүйгээр боломжгүй. Зөвхөн Парламентаас баталсан ерөнхий-хийсвэр зохицуулалттай хэм хэмжээ (хууль) л рэхийг батлагаажуулдаг. Тиймээс нийтийн сайн сайхан, нийтийн ашиг сонирхлыг парламентын бүтээсэн ерөнхий хийсвэр хэм хэмжээ л илэрхийлэн хамгаалдаг байна.¹²

Гэвч төр нь нийтийн ашиг сонирхлыг ямар ч тохиолдолд бүхэлд нь хамгаалж чаддаг уу? Гэвэл үгүй юм. Зарим тохиолдолд нийтийн захиргааны байгууллага нийтийн ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй, ялангуяа нийтийн ашиг сонирхол өөр хэн нэгний ашиг сонирхолтой зөрчилдсөн тохиолдолд алийг нь чухал гэж үзэж хамгаалах шаардлагатай вэ? гэдэгт зөв гаргалгаа хийж чадахгүй байх тохиолдол үүсдэг. Энэ тохиолдолд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах эрх бүхий этгээдэд төрөөс гадна нийгмийн янз бүрийн нийгэмлэг (холбоод) -ыг хамруулах байдлаар эрх зүйн зохицуулалт хийж өгөх нь тун оновчтой гэдгийг

¹² Kelsen, Reine Rechtslehre, S.117

ардчилсан-плюралист концепци зөвшөөрдөг байна.¹³

Харин Ром -Германы эрх зүйн системтэй улсуудад энэ нь хууль тогтоогчоос ихээхэн хамааралтай асуудал буюу хууль тогтоогч нь нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлээгүй тохиолдолд үл гүйцэлдэнэ.¹⁴

Мөн "Төрөөс хүлээн зөвшөөрсөн хууль зүйн зохицуулалт бүхий нийгмийн ашиг сонирхол бол нийтийн ашиг сонирхол байна" гэсэн дүгнэлтийг Оросын холбооны улсын эрдэмтэд хийжээ.¹⁵

Нийтийн ашиг сонирхол гэх ойлголт нь хуулийн хэлэнд өргөн хэрэглэгддэг хэдий ч хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт болохыг хууль зүйн шинжлэх ухааны олон тооны эх сурвалжид өгүүлжээ.¹⁶ Гэхдээ юуны өмнө нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах хууль зүйн асуудал гэдэг нь тодорхой юм.

Нийтийн ашиг сонирхол гэдгээр хүний үндсэн эрхийг хязгаарлах тохиолдол бүрийг нийтээр хүлээсэн төрийн эрхэм зорилгоор зөвтгөж болно. Юу чухам бүх нийтийн хууль ёсны ашиг сонирхол вэ гэдгийг

аливаа ардчилсан нийгмэд төрийн ямар нэгэн тунхагласан зорилгоос ургуулан гаргаж болохгүй.¹⁷

Тухайлбал "Бүх нийтийн аюулгүй байдал, нийтийн эг журам, нийтийн эрүү мэнд, ёс суртахуун, хүний үндсэн эрх, эрх чөлөөг санхин хамгаалах" үүднээс бишрэн шүтэх эрх чөлөөг хязгаарлаж болно гэж заасан байдаг.¹⁸

НИЙТИЙН ЭРХ АШИГ ГЭХ ОЙЛГОЛТЫГ ХУУЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ ХҮРЭЭНД, ХЯЗГААРЛАГДМАЛ СУБЪЕКТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТУХАЙД ДЭЛГЭРҮҮЛЭН ҮЗВЭЛ

Нийтийн эрх ашиг гэж юу болох түүний агуулгад юу хамаарах асуудал эрдэмтэд, судлаач нарын анхааралд байнга байж, улс орнуудын Захиргаан хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүх, Эрүүгийн хэргийн шүүх, Үндсэн хуулийн шүүхүүдийн анхаарлыг татсаар байдаг асуудал билээ.

Дэлхий дахинд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн хоёр хэлбэр байдаг. Үүнд: (1) Нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаарддаг болон (2) уг зөрчлийг шаарддаггүй тогтолцоо багтана. Монгол Улсын хувьд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар заалт нь нэхэмжлэгч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын

¹³ Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь. Эрдэм шинжилгээний өгүүлэг. УБ.,20,,

¹⁴ О.Зандраа. Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах асуудал. Гарын авлага. УБ.,2012.53 дах тал

¹⁵ Ш.Цогтоо. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ.,2021.199 дах тал

¹⁶ Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь. Эрдэм шинжилгээний өгүүлэг. УБ.,20,,

¹⁷ Ш.Цогтоо. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ.,2021.200 дах тал

¹⁸ Ш.Цогтоо. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ.,2021.201 дах тал

зөрчлийг сэргээлгэх шаардлагыг тодорхойлохгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн зохицуулалт юм.¹⁹

Монгол Улсын хувьд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дугаар заалт нь нэхэмжлэгч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчлийг сэргээлгэх шаардлагыг тодорхойлохгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхлын хүрээнд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн зохицуулалт юм.

Энэ төрлийн зохицуулалт нь өөрийн давуу болон сул талыг агуулдаг. Эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, иргэний нийгмийг чадавхжуулах болон нийтийн хяналтын тогтолцоог хөгжүүлэхэд энэ төрлийн зохицуулалт эерэг үр дүнтэй. Харин нийтийн ашиг сонирхол нэрийн дор түүний эсрэг нэхэмжлэл гаргах, улс төрийн болон бусад явцуу ашиг сонирхлоор ашиглавал ардчилал, эрх мэдэл харилцан хяналт-тэнцэлтэй байх, шүүхийн хараат бус, бие даасан байдалд зарим талаар сөрөг үр дагаврыг үүсгэж болзошгүй байдаг.²⁰

Манай Улсын хувьд нийтийн эрх ашиг гэх нэр томъёо Захиргааны ерөнхий хуульд арван нэгэн²¹ удаа,

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд долоо²² удаа Иргэний хуульд нэг²³ удаа, Эрүүгийн хуульд таван²⁴ удаа, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд дөрвөн²⁵ удаа, Төрийн албаны тухай хуульд нэг²⁶, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэг²⁷ удаа, Өрсөлдөөний тухай хуульд хоёр²⁸ удаа, Газрын тухай хуульд нэг²⁹ удаа, Нийтийн сонсголын тухай хуульд гурван³⁰ удаа, Төмөр замын тээврийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Прокурорын тухай хуульд тус тус нэг удаа хэрэглэгдсэн байна. Харин Монгол Улсын Үндсэн хуульд “Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол”, “Хүүхдийн ашиг сонирхол”, “Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхол”, “нийт иргэн, улсын ашиг сонирхол”, “Төрийн ашиг сонирхол” гэсэн хүрээнд тусгагдсан байна.

²² ЗХШХШТХ-ийн 18.3, 20.3, 46.3, 52.5.5, 62.1.1, 106.3.10, 118.3 дах хэсэг

²³ ИХ-ийн 101.4 дэх хэсэг

²⁴ ЭХ-ийн 1.1, 2.5.1, 5.4.1, 20.1-20.14, 23.1-23.7 дах хэсэг

²⁵ НАНБХАСЗ, АСЗУСТХ-ийн 1.1, 3.1.1, 3.1.3, 6.4 дэх хэсэг

²⁶ ТАТХ-ийн 37.1.2 дах хэсэг

²⁷ ААНТЗТХ-ийн 1.1 дэх хэсэг

²⁸ ӨТХ-ийн 11.2, 13.4 дэх хэсэг

²⁹ ГТХ-ийн 40.1.2 дах хэсэг

³⁰ НСТХ-ийн 7.1, 5.1.3, 7.1.2 дах хэсэг

¹⁹ Нээлттэй нийгэм форум. Нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Шүүхийн практик. УБ, 2020. 5х

²⁰ Нээлттэй нийгэм форум. Нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Шүүхийн практик. УБ, 2020. 6х

²¹ ЗЕХ-ийн 4.2.6, 5.1, 10.4.2, 28.1.1, 28.1.2, 48.2.2, 49.3.3, 49.3.5, 56.3, 62.2, 73.1.7 дах хэсэг

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд

Нийтийн эрх ашгийн маргааны тухайд:

1. Хүрээлэн байгаа орчин
2. Хүүхдийн эрх
3. Нийтийн эрүүл мэнд
4. Нийтийн өмчийг хамгаалах асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар

Нийтийн эрх ашигийг төлөөлөх эрх бүхий этгээд гэж : Хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд байх бөгөөд Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх 1 дүгээр шаардлага

Дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх 2 дугаар шаардлагыг хангасан субъект нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуульчилсан байна.

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж буй асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй³¹ гэсэн хангалттай сонирхол илэрхийлсэн байх 3 дугаар шаардлагыг тус тус хангасан байхыг хуульчилсан байна.

Дүгнэвэл "Нийтийн эрх ашиг" гэх ойлголт нь хүрээлэн буй орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд

нийтийн өмчийг хамгаалах асуудал ба нэхэмжлэгч этгээд нь захиргааны хууль бус үйл ажиллагааны явцад хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээд эсхүл хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд буюу төрийн бус байгууллага байна.

Дээрх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хамаарах асуудал нь иргэн бүрт хуулиар олгогдсон субьектив эрхийн асуудлыг олон тооны этгээдүүдэд чиглэсэн буюу олонлог байдлаар авч үзсэн гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхээр хамгаалагдаж байгаа бүхий л маргаан хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн байдаг. Иргэний /хүний/ эрхийг хөндөх хамгийн өндөр магадлал бүхий субъект гол төлөв төр, захиргааны байгууллага, шүүх, тэдгээрийн албан тушаалтныг гэж тооцдог. Жам ёсны болон позитив эрхийн аль нь ч халдагад өртөх магадлалтай буюу хөндөгдөх боломжтой. Нэг иргэний хууль ёсны эрх, ашиг сонирхол нь нийтийн эрх, ашиг сонирхол болох нь зайлшгүй. Гэтэл нийтийн эрх ашгийг гэх ойлголтыг зөвхөн дээрх дөрвөн асуудлыг хуулийн хүрээнд авч үзсэн нь өөрөө явцуу ойлголт гэж дүгнэн үзэж болохоор байна.

Жишээ болгон хрээлэн буй орчны маргааны төрлүүдийг дэлгэрүүлэн авч үзвэл:

Хүрээлэн байгаа орчин гэдэг ойлголтонд Байгаль орчныг хагаалах

³¹ ЗХШХШТХ 52.5.5

тухай хуулиар хамгаалагдсан эрх ба Эрүүгийн хуулиар хориглогдсон үйлдэлийг ойлгож байна. Тухайлбал БОХТХ-д дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ гээд

- Газар, түүний хөрс
- Газрын хэвлий, түүний баялаг
- Ус
- Ургамал
- Амьтан
- Агаар гэсэн объектуудыг нэрэлсэн байна

Мөн Эрүүгийн хуульд Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг бүлэгт дээрх хамгаалагдсан объектод холбогдсон гэмт хэргийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хуульд заасан ял оногдуулахаар заасан байна. Тухайлбал : Байгаль орчныг бохирдуулах, Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох, химийн хорт аюултай хог хаягдлыг хууль бус эргэлтэд оруулах, Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэнд оруулах зэрэг бие даасан арван төрлийн гэмт хэргийг хуульчилсан байна. Энэ утгаараа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг нь шууд утгаараа хүн амын эрүүл мэнд, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, өнөөгийн болон ирээдүй хойч үеийнхний эрүүл аюулгүй орчин амьдрах эрхийг хамгаалахад чиглэгдсэн байна.

Нэхэмжлэгч этгээдийн тухайд:

Хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд байх бөгөөд түүнд тавигдах шаардлага нь :

1. Нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх

2. Дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх

3. Маргаж буй асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх гэсэн /ЗХШХШТХ 52.5.5/ 3н шаардлагын хүрээнд нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хянан үзэж байна. Хуульд заасан эдгээр шаардлагуудаас Хангалттай сонирхол илэрхийлсэн байх гэсэн шаардлагыг судлан үзвэл:

"хангалттай сонирхол илэрхийлсэн байх" гэсэн томъёолол нь тухайн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй ТББ-ын өөрийнх нь эрх, ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардахгүйгээр нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгох нь зүйтэй гэдэг дээр хууль тогтоогчийн үзэл санаа нэгдэн баталсан байна. . Мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан хоёр шаардлагыг нэхэмжлэгч төрийн бус байгууллага хэрхэн хангаж буйгаа нэхэмжлэлдээ тусгах, тус нэхэмжлэлийг гаргах ямар ашиг сонирхол байгааг тусгах нь ЗХШХШТХ 52.5.5 дахь заалтын "хангалттай сонирхол илэрхийлсэн байх" зохицуулалттай холбогдоно гэсэн санааг хууль тогтоогч

илэрхийлсэн байна.³²

Мөн “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хуульд заасан хоёр үндсэн шаардлагыг хэрхэн хангаж буй талаар нэхэмжлэлдээ тодорхой дурдаж өгөх нь ЗХШХШТХийн 52 дугаар зүйлийн 52.5.5 дахь заалтын “хангалттай сонирхол илэрхийлсэн байх” гэсэн шаардлагыг хангасан эсэхийг тогтооход үйлчлэх ёстой гэсэн санаа хэмээн дүгнэж болох юм” гэж хууль тогтоогчид үзсэн байна.³³

Объектив буюу захиргааны шийдвэрийн үйлчлэл тодорхой субъектийн эрхийн зөрчил үүсгэсэн эсэхээс үл хамааран хуулиар маргах эрх олгогдсон этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй тохиолдолд шүүх тэрхүү этгээд тухайн асуудлаар “маргах шаардах эрхтэй” эсэхийг субъектив хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу судалж, шалгах шаардлагагүй, уг маргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны үр дүнд хэн нэгэн этгээдийн эрх ашиг сэргэсэн, хамгаалагдсан байх биш, харин захиргааны үйл ажиллагаан дахь хуулийн зөрчил арилсан байх явдал байдаг.³⁴

ХБНГУ-ын хуульч Нийс (Niese) “Хэрэв захиргааны шүүхийн зорилго нь захиргааны үйл ажиллагааны объектив эрхийн хяналтыг

хэрэгжүүлэхэд чиглэгдэх юм бол захиргааны байгууллагаас хууль зөрчин гаргасан акт, шийдвэрүүд нь зөвхөн шүүхийн шийдвэрээр л засагдах боломжтой болно. Энэ байдал нь захиргаа, шүүх хоёрын харилцаа үндэсээрээ өөрчлөгдөх байдалд хүргэнэ. Өөрөөр хэлбэл, захиргааны шүүх нь дээд шатны захиргааны байгууллага болж хувирах юм. Ингэснээр захиргааны шүүхийн зорилго нь хувь этгээдийн субъектив эрхийг хамгаалах бус, харин захиргааг хууль ёс сахиулахад чиглэгдэх болно” гэж хэлсэн байна.³⁵

Нийтийн ашиг сонирхлын маргааны хувьд нэхэмжлэгчийн субъектив эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн эрхийг шүүх дүгнэх, улмаар энэ (субъектив эрх нь зөрчигдөөгүй) үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэхгүй³⁶ байх ёстой гэжээ.

Зарим улсын жишээ

Бусад улс орны туршлага, эрх зүйн зохицуулалтаас үзэхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг үндсэн хуулиараа баталгаажуулсан улс ч байна. Тухайлбал Өмнөд Африкийн Бүгд найрамдах Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 3-ын “а” болон “б”-д зааснаар иргэн нь нийтийн эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх, амьжиргааны түвшин, байгаль орчин, соёлын өв, түүнчлэн төр,

³² Шүүхийн шийдвэрийн судалгаа.ННФ.,УБ.,2022. Цуврал 8. 95х

³³ Мөн тэнд

³⁴ Ц.Цогт. Захиргааны эрх зүйн өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл.УБ.,2016.37 дах тал

³⁵ Мөн тэнд 71 дэх тал

³⁶ П.Баттулга, Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. УБ.,2018. 12 дах тал

автономит бүс болон орон нутгийн өмчийг хамгаалах талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж заажээ.³⁷

Харин Холбооны Бүгд найрамдах Герман улсын шүүх нийтийн эрх ашгийг төлөөлөх этгээд гэж тусгайлан зааж өгөөгүй байна. Учир нь ХБНГУ-ын Үндсэн хуульд "Хэн нэгэн өөрийн эрхийг нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд хандах эрхтэй" гэж заасан нь обьектив эрхийн хяналтыг хэрэгжүүлэхийг шүүхээс зөвшөөрөөгүй харин субъектив эрхийн хяналтыг³⁸ хэрэгжүүлдэгтэй холбоотой гэж судлаачид үзэж байна. Гэсэн ч ХБНГУ-д иргэдийн болон төрийн бус байгууллагын шаардлагаар төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой нийгэмлэг, холбоодод нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлагдмал хүрээнд буюу Байгалийн нөөцийг хамгаалахтай холбоотой асуудал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хууль, амьтны эрхийг хамгаалах асуудлаар зарим муж улсуудад нэхэмжлэл гаргах эрхийг олгосон байна.

Ингэж тодорхой хүрээгээр хязгаартай нээсэн нь Засгийн

газрын төрийн хөтөлбөртэй уялдаж байгаагаас гадна хэтэрхий өргөн хүрээнд нээх нь шүүхийг улс төрийн ашиг сонирхлын талбар болохоос сэргийлэх, өнөөдрийн агшинд шүүхэд хийсвэр ачаалал нэмэхээс сэргийлсэн

Дүгнэлт:

Судлаач нар өөрийн судалгааны ажилдаа "Нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийг илүү мэдээлэлтэй, туршлагатай, асуудлыг улсуурьтайгаар харж чадах, асуудалд илүү ойр байдаг тэрхүү хэсэг буюу төрийн бус, мэргэжлийн байгууллагад нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар захиргааны хэргийн шүүхэд хэрэг хэлэлцүүлэх боломжийг нээснээрээ нийтийн ашиг сонирхол хангагдах баталгааг илүү нэмэгдүүлсэн байна³⁹ гэх зэргээр дүгнэн бичсэн байна.

Шүүх нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдалд ач холбогдол өгөхөөс илүүтэй хуульд заасан хэлбэрийн шаардлагыг гол шалгуур болгож төрийн бус байгууллагын нэхэмжлэл гаргах эрхийг тодорхойлж байгаа нь харагдаж байна.

Нийтийн ашиг сонирхолыг шүүхэд төлөөлөн хамгаалах хүрээг ЗХШХШТХ - аас гадна салбарын бусад хуульд тусгах эсхүл уг хууль

³⁷ П.Баттулга, Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2018. 13 дэх тал

³⁸ Хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөөгүй хэн нэгэн бусдын өмнөөс нэхэмжлэл гаргах боломжгүй гэж тайлбарладаг

³⁹ П.Баттулга, Т.Мөнх-Эрдэнэ. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Шүүхийн шийдвэрийн эмхэтгэл. УБ., 2018. 9 дэх тал

дахь хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай. Тухайлбал нийтийн үйлчилгээ, хэрэглэгчийн эрх ашигийг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээний салбарт нийтийн эрх ашгийг төлөөлөх зэрэг нэхэмжлэлийн шаардлагын хүрээг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

Нэхэмжлэгч этгээдэд тавигдаж буй хангалттай сонирхол илэрхийлсэн байх шаардлагыг шүүх хэрэглэхдээ нэг мөр ойлгож хэрэглэх шаардлагатай байна. ЗХШХШтХ-

ийн 52.5.5 дахь "хангалттай сонирхол илэрхийлсэн байх" гэж заасныг Захиргааны хэргийн шүүхүүд харилцан адилгүй хэрэглэж байх тул нэхэмжлэгч / Төрийн бус байгууллагад/ талд тодорхой бус /өөр, өөр төрлийн/ шаардлага тавигдахад хүрч байна. Иймд тус ойлголтыг Улсын дээд шүүх албан ёсоор тайлбарлаж нийтийн эрх ашигийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж буй субъектүүдийн эрх ашгийг хамгаалах шаардлага тулгарч байна.

СЭТГЭЦЭД УЧИРСАН ГЭМ ХОРЫН ТУХАЙ



Шихихутуг их сургуулийн Хувийн
эрх зүйн тэнхимийн багш
Б.Оюун-Эрдэнэ

Хураангуй: Хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд тэрнээс учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь хуулиар хамгаалагдсан буюу Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрх мөн. Харин Иргэний хуульд сэтгэл санааны хохирол, түүнийг хэрхэн үнэлэх тухай зохицуулаагүй тул сэтгэл санааны хохирлыг судлагдахуун болгож судлах, хууль зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий болж байна.

Түлхүүр үг: Гэм хор, хохирол, эдийн бус баялаг, сэтгэц, эдийн бус хохирол

Агуулга

Оршил

1. Иргэний эрх зүйн гэм хорын тухай
2. Эдийн бус хохирол /сэтгэц/-д учирсан хохирлын тухай
3. Зарим гадаад орны харьцуулалт Дүгнэлт /Санал/
Ном зүй

Оршил

Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлүүдийн нэг бол гэм хор учруулахаар иргэний эрх зүйн харилцаа үүсэж болдог. Уг харилцаа нь гэрээний үүрэгтэй холбоогүйгээр бусдын хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол болон эд хөрөнгөд хууль бусаар хохирол учруулсан этгээд учруулсан гэм хороо хариуцан арилгадаг зохицуулалттай. Хуулиар хамгаалагдсан эрх ашигт эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд¹, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгийг хамруулан авч үзэх ба үүнд хэн ч ба хууль бусаар халдаж болохгүй зохицуулалт нь хууль болон эрх зүйн суурь зохицуулалт юм. Салбар эрх зүй болгоноор эдгээр эрх, ашиг сонирхлыг хамгаалж байдаг.

Иргэний эрх зүйд эд хөрөнгийн хохирлыг тухайн эд хөрөнгө хэрхэн гэмтэж, эвдэрсэн, хэр хохирол учирсныг мөнгөөр үнэлж, хохирлыг арилуулах боломж байдаг. Тухайн хөрөнгийг шинээр солих, өөр ижил төрлийн шинжтэй зүйлээр орлуулах гэх мэт. Харин эдийн бус баялаг буюу сэтгэл санаа, сэтгэцэд, нэр төр, тэр бүү хэл амь насанд учирсан хохирлыг хэрхэн тооцож, түүний хэрхэн барагдуулах нь одоог хүртэл маргаантай, асуудалтай байгаа юм.

Сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргуулахтай холбоотой маргаан

¹ 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан.

нь бусдын буруутай, хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас үүсдэг. Ялангуяа бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас сэтгэл санааны хохирол дагалдан гарах нь элбэг тохиолддог. Харин бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас бусад байдлаар учирсан эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэж байгаа эсэхтэй холбоотой судалгаа, мэдээлэл Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргадаг шүүн таслах ажиглагааны аль ч оны тайланд тусгагдаагүй байна. Энэ нь Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хор гэж зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдлыг тооцохоор хязгаарлагдмал хүрээнд зохицуулсантай холбоотой² гэж үзэж байна.

Хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд тэрнээс учирсан сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрх нь хуулиар хамгаалагдсан буюу Үндсэн хуулиар олгогдсон иргэний үндсэн эрх³ мөн. Харин Иргэний хуульд сэтгэл санааны хохирол, түүнийг хэрхэн үнэлэх тухай зохицуулаагүй тул сэтгэл санааны хохирлыг судлагдахуун болгож судлах, хууль зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий болж байна.

1. Иргэний эрх зүйн гэм хорын тухай

Иргэний эрх зүй харилцаа нь иргэний хуульд заасан 8 үндэслэлээр үүсэх бөгөөд тэдний дийлэнх нь хэлцэл болон гэм хор учруулахаар үүсдэг. Иймээс гэм хор гэж юу болохыг тодорхойлох нь зүйтэй байх.

Үүрэг үүсэх үндэслэл нь гэрээний ба гэрээний бус гэж ангилдаг. Гэрээний бус үүрэг нь хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа ба зөрчлийн улмаас үүсэх үүргийн харилцаа гэж хуваагдах бөгөөд гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь зөрчлийн улмаас үүсэх үүрэгт хамаардаг. Энэ нь Иргэний хуулийн хоёрдугаар дэд хэсэг, тавин хоёрдугаар бүлэгт зохицуулсан. Амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг эдийн бус гэм хорын хохирол гэж үздэг бол материаллаг шинжтэй буюу эд хөрөнгийн бодит үнэ, алдагдал, олох ёстой байсан орлого нь эд хөрөнгөд учирсан гэм хорд тооцогддог⁴ байна.

Гэм хор⁵ гэдгийг хууль зүйн үүднээс нь "хохирогчийн эд хөрөнгийн буюу материаллаг бус баялгийг⁶ багасгах, устгах, хөндөх замаар илэрхийлэгдэх, материаллаг хохирол. Гэм хор ба хохирол гэсэн нэр томъёо нь өөр хоорондоо яг нийцдэггүй ба гэм хор нь нийлээд

² Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуурал 4, УБ., 2022, 15 дах тал.

³ Монгол Улсын Үндсэн хууль., Арванзургадугаар зүйл.

⁴ Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV, УБ., 2016, 54 дэх тал.

⁵ Англи хэлнээ "Harm"

⁶ Амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд зэрэг

өргөн хүрээтэй ба эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг аль алиныг нь багтаадаг.⁷ Зарим судлаачид гэм хор нь иргэний эрх зүйн хариуцлага үүсэх нэг нөхцөл. Гэм хор нь тухайн харилцаанд өртөгдөж буй субъектийн амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөн явдлаар илэрдэг материаллаг ба материаллаг бус гэм хор гэж ангилдаг⁸. Материаллаг гэм хорд эд хөрөнгийг эвдэлсэн, сүйтгэсэн, хорогдуулсан гэх зэрэг орох бол материаллаг бус гэм хорд хүний амь насыг хохироосон, эрүүл мэндэд халдсан, сэтгэцийн байдлыг хэвийн биш болгосон, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг орно гэж үздэг.

Иргэний хууль тогтоомжид эдийн бус хохирол хэмээх ойлголтын тухай томъёолоогүй харин эдийн бус гэм хор гэж томъёолсон байдаг. Харин хохирлын талаар тодорхойлон тусгасан боловч хор уршиг хэмээх ойлголт, нэр томъёог⁹ тусгаагүй.

Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.3-т "Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно." гэснээс үзвэл хохирол гэдэгт хохирогчоос зөрчигдсөн эрхээ

сэргээхэд буюу эрх зөрчигдөхөөс өмнөх байдалд эргүүлж оруулахад шаардагдах зардал болон эрх зөрчсөний улмаас алдсан орлогыг буюу олох ёстой байсан орлогыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-д хохирол болон хор уршиг гэсэн хоёр ойлголтыг ялгаатайгаар тодорхойлсон. Эрүүгийн хуульд гэмт хэргийн улмаас шууд учирсан үр дагаврыг хохирол; гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршиг¹⁰ гэж тодорхойлсон.

Зарим судлаачдын зүгээс Иргэний хуульд зохицуулсан сэтгэл санааны асуудлыг сэтгэл санааны гэм хор биш харин сэтгэл санааны хохирол гэж томъёолох нь үндэслэлтэй гэж үзсэн. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд "Эдийн бус гэм хорыг арилгах" гэсэн эдийн бус баялагтай холбоотой ерөнхий зохицуулалт боловч уг зохицуулалтын агуулга нь зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг зөрчсөний улмаас үүсэн харилцааг зохицуулах заалт учир үүнд сэтгэл санааны болон сэтгэцэд учирсан хохирлыг тооцож барагдуулах нь учир дутагдалтай юм.

Дээрх зохицуулалтаас үзвэл эдийн бус гэм хорын тухай хуульд ерөнхий зохицуулалт байгаа хэдий ч үндсэн агуулга, зарчим, үзэл санаа

⁷ Хууль зүйн нэвтэрхий тоь бичиг, С.Нарангэрэл, УБ., 2021, 88 дах тал.

⁸ Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт нийтлэл, Ш.Үнэнтөгс, 2015.

⁹ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 19 дэх тал.

¹⁰ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1, 2 дах хэсэг

нь эдийн бус баялагийн хохирлыг¹¹ бүхэлд нь хамруулж чадахгүй байгаа нь зарим эдийн бус хохирлыг хариуцан арилгах хуулийн үндэслэл дутмаг байгаа юм. Мөн Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-т “эдийн бус гэм хорыг арилгуулахаас хохирогч шаардах эрхтэй” гэж тодорхойлсон ч эдийн бус гэм хорд юуг багтааж ойлгох талаар хуульд тусгайлан заагаагүй байна.

Эдийн бус хохирол тур дундаа бусдын хууль бус үйлдлийн улмаас бусдад учирсан сэтгэл санааны буюу сэтгэцэд учирсан хохирлыг зөв тодорхойлох хэрэгтэй. Сэтгэл санааны хямрал гэдэг нь бусдын хууль бус үйлдлийн үр дүнд үүсэх сэтгэл санааны, оюуны зовлон, шаналлыг хэлэх бөгөөд үүнд уй гашуу, сэтгэл гонсойх, уур уцаар төрөх, бахархал үгүй болох, ичих, олон нийтийн доромжлолд өртөх, цөхрөл зэрэг хамаарах ба дээрх хямрал нь сэтгэл санааны хохирол болно¹² гэж үздэг байна.

2. Эдийн бус хохирол /сэтгэц/-д учирсан хохирлын тухай

Эдийн бус хохирол буюу сэтгэцэд болон сэтгэл санаанд учирсан хохирлыг тодорхойлохын өмнө сэтгэц мэдрэлийн өвчин, эмгэг гэдэг юу вэ гэдгийг томъёолох шаардлага тулгарч байна.

Аливаа гэмтлийг шинжлэх

ухааны үүднээс бие махбодын болон сэтгэл санааны¹³ гэж хоёр ангилдаг байна. Бие махбодын гэмтэл нь олон төрлийн шалтгаантай үүсдэг ба ихэвчлэн өөрөөс шалтгаалсан болон өөрөөс шалтгаалахгүй буюу бусдын нөлөөгөөр мөн гэнэтийн буюу давагдашгүй хүчний нөлөөгөөр үүсдэг. Тухайлбал, авто осолд орох, хүн цохисны улмаас бие эрхтэн хугарах, бяцрах, тархи толгойндоо гэмтэл авах зэрэг. Харин сэтгэл санааны гэмтлийн хувьд сэтгэл санааны хүчтэй нөлөө үзүүлдэг өөрчлөлт нь хүний амьдралын дадал үйлдэл буюу ойр дотнын хэн нэгнээ алдах, ганцаараа үлдэх гэх мэт амьдралын өөрчлөлт нь тухайн хүндээ сэтгэл санааны гэмтэл болж байдаг.

Эрүүл мэнд гэж хүн зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, сэтгэц, оюун санаа, нийгмийн сайн сайхан¹⁴ байдлын цогц бүрдлийг хэлнэ. Эндээс харахад эрүүл мэндийг биеийн болон нийгмийн, сэтгэцийн эрүүл мэнд гэж гурван бүрэлдэхүүнд хуваан авч үзэж байна.¹⁵ Сэтгэцийн эрүүл мэнд гэсэн ойлголтыг ихэнх хүмүүс сэтгэцийн өвчин эмгэгтэй холбон ойлгодог харин сэтгэцийн эрүүл мэнд гэдэг нь маш өргөн хүрээний ойлголт юм.¹⁶ Тухайн хүний сэтгэл хөдлөл, оюун санаа, бие махбод, хувь хүний

11 Материаллаг бус бүх хохирол. Тухайлбал, бие эрхтний болон сэтгэцийн хохирол, хэвийн амьдрах боломж, хүнд эмчилгээний зовлон шаналал гэх мэт.

12 Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 21 дэх тал.

13 Л.Жавхлан, “Сэтгэл санааны хохирлыг тооцож чаддаггүй” Нийтлэл, УБ, 2019.

14 Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт

15 Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 22 дэх тал.

16 Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 22 дэх тал.

хувьд ямар нэг эмгэггүй байхыг хэлдэг. Гэтэл бусдын учруулсан эдийн болон эдийн бус хохирлын улмаас сэтгэл санааны хямралтай байгаа хүнийг эрүүл хүн гэж үзэх үү эсхүл түр зуурын стресс¹⁷ гэж үзэх үү гэдгийг бид анзаарах шаардлага үүснэ. Тухайн хүн ямар гэмтэл авснаас шалтгаалан сэтгэл зүйн өөрчлөлт хэр хугацаанд үргэлжлэх нь тогтоогддог.

Сэтгэл санааны хямралд өртсөн этгээдэд сэтгэлийн хөдөлгөөн сөрөг хэлбэрээр илрэх ба гашуудах, нойргүйдэх, сэтгэлээр унах, сэтгэлийн шаналал, зовлонтой байх, цөхрөх, айх, ичих, уурлах, сэтгэлийн түгшүүртэй болох, санаж, мартаx зэрэг хэв шинжээр илэрнэ¹⁸. Иймд сэтгэл санааны хохирол нь бие махбодод хохирол учрахтай адил сэтгэцийн гэмтэл үүсгэдэг бөгөөд бие махбодын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд 497.1-т "Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй" гэж зохицуулсан ба үүнд тусгасан эрүүл мэнд гэсэн зохицуулалт нь хүний бие махбодод учирсан хохирол юм. Сэтгэцэд гэдэг нь сэтгэл санаанд учирсан

хохирлыг шаардахаар зохицуулсан байна. Шүүх гэм хорын хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэд хэдэн урьдчилсан нөхцөлийг хангасан эсэхийг шалгах ба энэ нь онолын үүднээс гэм хорын үндсэн шинж юм. Үүнд: Гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь санаатай болон болгоомжгүй байдлаар илэрдэг. 2. Хамгаалагдсан эрхийн зөрчил буюу хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхол, эд хөрөнгөд халдсан байх. 3. Эдгээрийн хоорондын шалтгаант холбоо байхыг шаарддаг.

Хүний эрүүл мэндэд учирсан хохирлыг тооцох аргачлал байдаг. Гэхдээ үүнийг хүний бие махбодын гэмтлээр хязгаарласан байдаг.¹⁹ Үүний улмаас сэтгэл санааны хохирлыг хэрхэн шаардах буюу хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд²⁰ сүүлд нэмэлт өөрчлөлт оруулан зохицуулсан. Гэмт хэргийн үйлдэл болон хууль бус үйлдлийн улмаас хүний сэтгэл санаанд тодорхой хэмжээний цочрол, айдас түгшүүрт автаж, энэ нь аажмаар зан төлөвт сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайн гэмт хэргийн улмаас алдсан үнэт зүйлсийнхээ хэмжээгээр хүний сэтгэл зүй, сэтгэц нь гэмтдэг байна. Сэтгэл санаа буюу сэтгэцийн өөрчлөлт нь хүний амьдралын дадал үйлдэл буюу сэтгэлийн гэмтэл болон үлддэг байна. Сэтгэл санааны хямрал хохирогчид учирсан эсэхийг тогтооход нэлээд

17 Гэнэтийн болон санамсаргүй, аливаа тааламжгүй явдлаас болж сэтгэл санаа, бие махбод доройтон хямрахыг ойлгоно.

18 Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 23 дэх тал.

19 П.Сайнзориг, Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай асуудлыг орхигдуулж болохгүй, Нийтлэл., УБ, 2021.

20 Энэ нэмэлт өөрчлөлт нь 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих юм.

хүндрэлтэй байхаас гадна үүнийг сэтгэл зүйч, мэргэжлийн сэтгэцийн эмчийн тусламжтайгаар тогтоох нь ихээхэн үр дүнтэй юм.

Сэтгэц²¹ гэдгийг хууль зүйн үүднээс нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т "Сэтгэцийн эрүүл мэнд" гэж хүн сэтгэцийн эмгэггүй байхын зэрэгцээ нийгэм болон хүрээлэн байгаа гадаад орчинтойгоо дасан зохицож хэвийн амьдрах, ажиллах, суралцах, нийгэмд зохих байр сууриа эзлэн хувь нэмрээ оруулж чадахуйц байдлыг" гэж тодорхойлсон байна. Сэтгэцийг түр зуурын²² болон эмгэг²³ гэж хоёр ангилдаг.

Сэтгэл санааны буюу сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хангах нь Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг баталгаажуулах үзэл баримтлал, иргэний эрх зүйн хохирол арилгахаас өмнөх байдалд эрхийг сэргээх үндсэн зарчимд тус тус нийцнэ.²⁴ Иргэний хуулийн 228-230, 497, 511 дүгээр зүйл заалт нь гэм хорын ерөнхий болон эдийн бус гэм хорын зохицуулалт бөгөөд хохирсон этгээд нь учирсан хохирлоо шаардах эрхтэй юм.

Хохирол нь тухайн зөрчигдсөн эрхийг зөрчигдөхөөс өмнөх байдалд оруулах, нөхөн сэргээх бөгөөд өмнөх

байдалд сэргээх боломжгүй үед мөнгөөртооцож барагдуулах юм. Юун түрүүнд хохирсон этгээдийн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчсөн байх шаардлагыг хангах ба шаардах эрх үүссэнээр хохирлыг арилгах тухай яригдах ба Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-д "Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно." гэж зохицуулсан байна.

Харин Иргэний хуульд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт орсноор сэтгэцэд учирсан хор уршгийг шаардаж болохоор зохицуулсан. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т "Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана" гэсэн нь сэтгэл санаанд учирсан хохирлыг гагцхүү мөнгөөр тодорхойлох шаардлага үүсэж байгаа юм.

Хүний сэтгэл санааны байдлыг мөнгөөр үнэлэх нь нэг талаас учир дутагдалтай юм. Бие махбодод учирсан хохирлыг мөнгөөр үнэлж болно. Тухайлбал, гар хугарсан гэж үзвэл гарыг эдгэрэх хугацаанд шаардагдах эмчилгээний зардал, түүнээс учирсан бусад зардлуудыг тодорхойлсноор хохирлыг тооцон шаардаж болно. Харин тухайн үйлдлийн улмаас сэтгэцэд учирсан

²¹ Монгол хэлний тайлбарт: Сэтгэн бодох явц, сэтгэн бодох чадвар

²² Нийгэм, сэтгэл зүйн шалтгааны улмаас хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл түр хямарсан байдлыг хэлнэ.

²³ Өвчний олон улсын ангиллын "сэтгэц, зан үйлийн эмгэгүүд" бүлэгт заасан оношилгооны хэмжүүрээр оношилж болох бүх өвчнийг ойлгоно.

²⁴ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 30 дах тал.

хохирлыг хэрхэн тооцож мөнгөн дүнгээр шаардах нь бас эргэлзээтэй бөгөөд дээр дурдсанчлан мэргэжлийн сэтгэл зүйч болон эмч нарын дүгнэлтийг үндэслэх нь зүй ёсных байх. Мөн энэ асуудал дээр тухайн гэм буруутай этгээдийн хууль бус үйлдлийн улмаас хохирогч нас барсан тохиолдолд гэм хор болон хохирлыг асуудлыг тодорхойлох нь нэлээдгүй хүнд. Хүний амь насыг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй. Гэхдээ нэгэнт гэм буруутай этгээд нь учруулсан хохирлыг арилгах үүрэгтэй бөгөөд энд оршуулгын зардал зэрэг шууд учирсан хохирлыг тооцон шаардана.

Мөн Иргэний хуульд орсон сүүлийн нэмэлт өөрчлөлтүүдийн агуулгыг харвал нийгмийн дундаж наслалтыг тогтоон нас барсан этгээдийн наслалтыг тогтоож, цаашид хэдэн жил амьдрах боломжтой, амьд байх хугацаандаа хэр хэмжээний бүтээмжтэй, хэдий хэмжээний орлого олох боломжтой байсан зэрэг өргөн хүрээний асуудлыг тогтоон хохирогч этгээд шаардаж болох зохицуулалтыг оруулсан.

Сэтгэцэд учирсан хохирлыг тооцон арилгахдаа хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр үнэлж болох монгол хүний дундаж наслалтаас хохирсон этгээдийн насны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлж, зөрүү үүссэн жилээр

нь тооцож үнэлэх суурь үнэлгээг²⁵ гаргасан байна. Энэ бол суурь доод үнэлгээ бөгөөд шүүхээс жишиг тогтоох асуудал одоог хүртэл яригдаж байгаа юм. Мөн энэхүү зохицуулалт дээр тухайн гэмт хэргийн улмаас бүтэн өнчин болсон тохиолдолд суурь үнэлгээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцон гаргах юм.

Эдийн бус хохирол буюу сэтгэл санаа, сэтгэцэд учирсан хохирлыг тооцох суурь үнэлгээ буюу хамгийн доод үнийг тогтоох нь тухайн хохирлыг барагдуулах буюу шүүхээс тооцож гаргах боломж нээгдэж буй юм. Өмнө нь амь нас хохирсон хэргийн хохирол болон бусад эдийн бус баялагийг тооцон гаргах аргачлал байхгүйгээс энэ төрлийн маргаан шийдвэрлэгдэхгүй орхигддог байсан.

Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ний өдрийн 15 дугаар тогтоолд "Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол" гэдэгт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд, Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйгээр учруулсан гэм хорыг ойлгоно", түүнчлэн "Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т "...эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн

²⁵ П.Сайнзориг, Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход явцтай ч асуудлыг орхигдуулж болохгүй, Нийтлэл., УБ, 2021.

төлнө” гэж заасан ба “...хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовуурь шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй” гэж тайлбарласан байдаг ба шүүх өнөөдрийг хүртэл дээрх хууль хэрэглээний зөвлөмжийн дагуу хууль хэрэглэж²⁶ ирсэн.

Сэтгэл санааны хямрал, түүнд учирсан хохирлыг тооцох аргачлалыг Хууль зүйн дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яамнаас баталж, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгээс сэтгэл зүйд учирч буй хямралын зэргийг тогтоож зөвхөн шүүх нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлно.²⁷ Сэтгэл санаанд учирч буй хор уршгийг мөнгөөр үнэлж барашгүй. Гэхдээ энэ асуудлыг орхихдуулж болохгүй юм.

3. Зарим гадаад орны харьцуулалт

Эдийн бус гэм хор тэр дундаа сэтгэл санааны гэм хорыг асуудлыг харьцуулан судлан авч үзэхдээ ХБНГУ, Япон болон Европын зарим нэг орнуудыг харьцуулан судаллаа.

1. ХБНГУ

ХБНГУ нь манай улстай ижил эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс бөгөөд манай улс анх Иргэний хуулийн үзэл баримтлалыг боловсруулахдаа ХБНГУ-ын Иргэний хуулийн үзэл баримтлалыг

жишиг боолгон боловсруулсан байдаг. Үүнд эдийн бус гэм хорын асуудал ч хамаарах юм. Тус улс нь Иргэний кодексдоо нэлээдгүй нэмэлт өөрчлөлт оруулсан ба үүний багагүй хэсэг нь эдийн бус гэм хорын асуудал багтаж байгаа юм.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 847 дугаар зүйлд бие махбодод гэмтэл учруулсны улмаас сэтгэл санаа зовж шаналсны нөхөн төлбөрийг гаргуулах талаар зохицуулж ирсэн. Гэхдээ хууль хэрэглээний хувьд хэрэв хохирогч гэм хор учруулагчийн хууль бус үйлдлийг нотолж чадахгүй тохиолдолд гэм хор учруулагчаар нөхөн төлбөр төлүүлэхгүй байх эрх зүйн үр дагавар үүсэж байсан²⁸ гэвч уг зүйл заалт нь хүчингүй болж 253 дугаар зүйлийн 2 дахь²⁹ зохицуулалтаар илүү өргөн хүрээнд зохицуулах болсон байна.

ХБНГУ-ын хувьд сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг шүүхийн практик хэрэглээний явцад жишиг байдлаар тогтоосон байдаг. Гэхдээ сэтгэл санааны хохирлыг үнэлэхдээ шүүх шууд үзэмжээр шийдэж байгаа гэсэн үг биш.³⁰ Сэтгэл санааны хохирлыг эдийн хохирол учирснаас үл хамааран гаргуулахаар тусгахдаа тодорхой хамгаалагдсан

²⁶ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 70 дэх тал.

²⁹ “Бие махбодид халдсан эрүүл мэндийг хохироосон, эрх чөлөө эсвэл бэлгийн амьдралаа бие даан тодорхойлох эрхэнд халдсан шалтгаанаар хохирлыг нөхөн төлөх нөхцөлд хөрөнгийн бус хохирлыг шударгаар үнэлэн мөнгөн төлбөр ноогдуулж болно.” ХБНГУ-ын Иргэний хууль /Кодификацийн бүрэн эх/, УБ., 2017, 49 дэх тал.

³⁰ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 73 дэх тал.

²⁶ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 39 дэх тал.

²⁷ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 40 дэх тал.

эрх, ашиг сонирхлыг хязгаарлаж тусгасан. Учир нь бүхий л нөхцөлд сэтгэл санааны хохирлыг шаардах боломжгүй юм. Ингэхдээ бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдал зэрэг гэж тоочих зарчмын дагуу шаардах эрхийн хүрээг хязгаарласныг анхаарах шаардлагатай байна³¹ гэж судлаачид үздэг байна.

ХБНГУ-ын дээд шүүхийн шийдвэрүүдээс үзвэл өвчин шаналал, гэмтэл учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нь хоёр зорилготой.³² Нэгдүгээрт нөхөн төлбөр нь нийгмийн амьдралд оролцох, аз жаргалтай байх боломжоо өвчин шаналлаас болж алдсан хүмүүст чиглэгдэх, хоёрдугаарт тухайн гэмтэл нь аль хэсэгт байгаагаас хамаарч мөн нөхөн төлбөрийн хэмжээ ялгаатай. Тухайлбал, гар хугарсан бол 1000-12500 евро, хөл хугарсан бол 2500-12500 евро, нүдээ алдсан бол 12000 ба түүнээс дээш евро, түүнчлэн сар бүрийн тэтгэмж, хоёр хөл ажиллагаагүй болсон бол 12000 ба түүнээс дээш евро гэх мэт. Мөн асрах, нөхөн сэргээх, гэмт хэргийн хохирогч тахир дутуу иргэний амьдрах боломж буурсан бол тэтгэвэр олгох, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүл, оршуулгын зардал, гэр бүлийн гишүүдэд олгох нөхөн төлбөр, хохирогчийн урьд өмнө хийж байсан ажлыг өөрчлөхөд олгох төлбөр,

туслалцаа зэрэг зардлыг нөхөн олгохоор³³ зохицуулсан.

2. Япон улс

Японы орчин үеийн эрх зүйн тогтолцоо нь 19 зууны дунд үеэс Франц, Германы эрх зүйн тогтолцоог дуурайх байдлаар бүрэлдэн тогтож, 20 зууны дунд үед АНУ-ын шахалтаар дахин хэлбэрийн болон агуулгын хувьд зарим байдлаар өөрчлөгдсөн байдаг. Үүнээс үзвэл зарим судлаачид холимог төрлийн эрх зүйн тогтолцоотой гэж үздэг.

Иргэний эрх зүй дэх гэм хорын эрх зүйн хувьд Франц буюу эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсын үзэл баримтлалыг хүлээн авч, нутагшуулсан гэж үздэг.³⁴ Япон улс нь Иргэний хуулийнхаа гэм хорын эрх зүйн зохицуулалтыг анх боловсруулах явцдаа Франц, Латин Америкийн улсуудын Иргэний хуулиудыг судалж байжээ. Мөн ХБНГУ-ын гэм хорын эрх зүйн зохицуулалтууд ч нөлөөлсөн байдаг. Иргэний хуулийг боловсруулахдаа Япон улсын судлаач, эрдэмтэд эдийн бус алдагдлын хувьд гэм хорын төрлийг хөгжүүлэхээс илүү хохирлыг үнэлж, тооцоолох дээр анхаарсан байдаг.

Сэтгэл санааны хохирол түүнийг нөхөн төлүүлэх шаардах эрхийн үндэслэлийг Иргэний хуулийн

³¹ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 74 дах тал.

³² Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2019, 35 дах тал

³³ Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, УБ., 2019, 39 дэх тал

³⁴ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 67 дах тал.

710³⁵, 711³⁶ дүгээр зүйлд тус тус хуульчлан зохицуулсан байдаг. Харин эдгээр зохицуулалт дээр тулгуурлан хохирлын хэмжээг хуулиараа зохицуулж өгсөн байдаг. Эдийн бус хохирлын шинж чанараас хамаараад түүний хэмжээг тооцоолох, нотлох асуудал нь нэлээдгүй ярвигтай бөгөөд сэтгэл санааны хохирол шиг яв цав нотлох боломжгүй асуудал дээр тусгайлсан зохицуулалт хэрэгтэй гэж үзэх нь бий.³⁷ Япон улсын хувьд ч энэ нөхцөл байдалтай уялдуулан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолохдоо Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 248 дугаар зүйлд³⁸ зааснаар шийдвэрлэдэг³⁹ байна.

Дээрх агуулгаар Япон улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө гэм хор учруулагчийн үйлдэлд шийтгэл байдлаар тодорхойлохыг хүлээн зөвшөөрдөггүй.⁴⁰ Хохирогчийн

эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, хохирлын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх, нөхөх байдлаар хүлээн зөвшөөрөх хандлага илүү давамгайлж байна.

АНУ-ын муж бүр нь нөхөн төлбөрийн талаар өөр өөр зохицуулалттай тусгай хууль гарган хохирлын хэмжээг тодорхойлдог. Энгийн хохирлын хэмжээг 1-5 дахин ихэсгэх, зарим муж нь 300,000-5 сая ам.доллар⁴¹ гэж зохицуулсан байна.

Франц⁴² улс нь хохирлын хэмжээг хэрхэн тооцох тухай хүснэгт гаргасан байдаг бөгөөд шүүх сэтгэл санааны хохирлын хэрэг маргааныг шийдвэрлэхдээ тэрхүү хүснэгтийг ашиглан хохирлын хэмжээг тооцон шийдвэрлэдэг байна. Тухайлбал, 25 настай эрэгтэй хүн гэмтэж, улмаар хэвийн амьдрах чадвараа 30 хувиар алдсан бол хохирлын хэмжээ нь 100 мянган евро⁴³ байх зэргээр хуульчилсан байна. Үүнтэй ижил төсөөтэй шийдвэрлэдэг улс цөөнгүй байдаг байна.

Улс бүрийн өөрийн гэсэн онцлог, нийгмийн амьдралын хэв маягаас хамааран хохирлыг хэмжээ харилцан адилгүй байх ба үүнийг тооцох нийтлэг үндэслэл нь тухайн улс орны эдийн засгийн нөхцөл байдал, иргэдийнх нь орлогын дундаж үзүүлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн, хөдөлмөр эрхлэлт, дундаж наслалт зэргийг зайлшгүй харж үзэх хэрэгтэй юм.

⁴¹ Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт, Суурин дүн шинжилгээ, УБ., 2013., 12 дах тал.

⁴² Харьцуулсан эрх зүй, Гарын авлага, УБ, 2013., 66 дах тал

⁴³ П.Сайнзориг., Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй, Нийтлэл., УБ, 2021.

³⁵ Эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх нь: "Бусдын бие махбод, эрх чөлөө болон алдар хүндэд гэм хор учруулсан тохиолдол болон бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан аль ч тохиолдолд 709 дүгээр зүйлд заасны дагуу хохирлыг хариуцах үүрэгтэй этгээд нь эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй."

³⁶ Гэр бүл, дотнын хүний хохирлыг нөхөн төлүүлэх нь: "Бусдын амь насыг бусниулсан тохиолдолд хохирогчийн эцэг эх, хань ижил болон хүүхдэд эд хөрөнгийн хохирол учраагүй байсан ч бусад хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй."

³⁷ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 78 дах тал.

³⁸ Хохирлын хэмжээг тогтоох нь: "Хохирол үүссэн байдлыг тогтооход хохирлын шинж чанараас шалтгаалан түүний хэмжээг нотлоход илт хүндрэлтэй бол шүүх талуудын мэтгэлцээний бүрэн агуулга болон нотлох баримтын үнэлгээний үр дүнд үндэслэн, тохирох хохирлын хэмжээг тогтоох эрхтэй."

³⁹ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 78 дах тал.

⁴⁰ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 4, УБ., 2022, 80 дах тал.

Дүгнэлт

Гэм хорын эрх зүйд ихэнхдээ бусдын бие махбод, эрүүл мэндэд учруулсан зовлон шаналал, өвдөлт гэсэн утгаар хууль, ном сурах бичиг, судалгаанд дурдагддаг. Харин дээрх ойлголтоос тусдаа сэтгэл санаа болон сэтгэцийн хувьд зовох, шаналах, хямралд өртөх өөр шинжүүд бий болж байна. Дээрх сэтгэцэд учирсан хохирлыг шаардах нь тухайн хүнд учирсан бодит нөхцөл байдлыг тооцон гаргахаас илүү ярвигтай бөгөөд хуулийн ийм зохицуулалт өнөөг хүртэл байхгүй байгаа нь энэ төрлийн хэрэг маргаан шийдвэрлэгдэхгүй, орхигдуулж байсан нь харагдаж байна. Үүнээс улбаалан хэдэн хүн сэтгэл санаагаар хохирч үлдсэнийг тооцон гаргах хэцүү.

Олон улсын хандлагыг судалж үзвэл гэм хорын эрх зүйд хэрэглэгддэг зовлон, шаналал, өвдөлт хэмээх ойлголтоос тусдаа сэтгэл санааны хямрал, сэтгэцэд учирсан зовлон, шаналал хэмээх ойлголт нь бие даасан судлагдахуун гэж үзэх хандлагатай болсон. Сэтгэл санааны хямрал хэмээх ойлголтыг

бүр тодотгон сэтгэл санаа, оюуны гэмтэл гэж тодорхойлох ба сэтгэл санааны хямрал нь энгийн стресстэй харьцуулшгүй бөгөөд сэтгэл санааны хямралд өртсөн этгээд нойрны дутагдалд орох, хоол, унд идэж уух дуршилгүй болох, оюун санаа нь төвлөрөхгүй байх, байнгын уур уцаартай байх зэрэг олон шинжүүдээр илэрдэг. Үүнээс үүдэн сэтгэц, мэдрэлд нөлөөлөх, цаашлаад сэтгэц, мэдрэлийн өвчин тусах, эмгэгтэй болох магадлал ч нэмэгддэг болохыг мэргэжлийн судлаач, шинжээчид үздэг байна.

Манай улсын хувьд сэтгэцэд учирсан хохирлыг хэрхэн тооцох талаар хараахан нэгдсэн ойлголтод хүрч амжаагүй байгаа ч хуулийн нэмэлт өөрчлөлтөөрөө энэ асуудлыг анхаарч авч үзэж байгаа нь харагдаж байна. Хохирсон этгээд буюу нэхэмжлэгч этгээдийн сэтгэл санаа, сэтгэцэд учирсан хохирлоо хэрхэн тооцож, ямар баримтыг үндэслэн тодорхойлох зэрэг нь учир дутагдалтай байгаа бөгөөд үүнийг боловсронгуй болгох хуулийн зохицуулалт зайлшгүй хэрэгцээтэй байгаа юм.

Ном зүй

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Иргэний хууль, 2002 он
3. Эрүүгийн хууль, 2015 он
4. ХБНГУ-ын Иргэний хууль /Кодификацийн бүрэн эх/, 2017 он
5. Япон улсын Иргэний хууль, 1896 он
6. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар: Гэрээний бус үүрэг IV. 2016 он
7. С.Нарангэрэл- Хууль зүйн нэвтэрхий толь бичиг. 2021 он
8. Шүүхийн шийдвэрийн судалгаа, Цуврал 4, 2022 он
9. Харьцуулсан эрх зүй гарын авлага-2013 он
10. Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгааны тайлан, Гэмт хэргийн улмаас учирсан хохирол. 2019 он
11. Гэмт хэргийг улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт, Суурин дүн шинжилгээ. 2013 он
12. Ш.Үнэнтөгс- "Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт". Нийтлэл 2015 он
13. П.Саинзориг: "Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй". Ниитлэл 2021 он
14. Л.Жавхлан- "Сэтгэл санааны хохирлыг тооцож чаддаггүй" Нийтлэл 2019 он

ҮРЧЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



Өмгөөлөгч
А.Батбаатар

Хураангуй: 1999 оны 06 дугаар сарын 11-ны өдөр Гэр бүлийн тухай хууль үйлчилж эхэлсэнээс хойш үрлэн авагчийн хүсэлт холбогдох материалыг үндэслэж хүүхэд үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэх болсон. Уг заалтын дагуу Монгол улс нь 20 жилийн хугацаанд зөвхөн баримтад тулгуурлаж үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж ирсэн. Хүүхдийн сэтгэл зүй болон үрчлэн авагчийн бодит нөхцөл байдлыг судлан үздэггүй байсан. 2018 онд Иргэний улсын бүртгэлийн тухай хууль батлагдан гарсанаар гэр бүл нийгмийн асуудал хариуцсан ажилтан үрчлэлтийн дүгнэлт гаргаж, уг дүгнэлтэд үндэслэж хүүхэд үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь тодорхой хэмжээнд дэвшил авчирсан хэдий ч үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөх, хууль тогтоомжийн давхцал, зөрчил нэмэгдсэн болно.

Өнөөгийн нөхцөлд хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байхгүйн улмаас үрчлэгч

болон үрчлүүлэгч нар нь социал орчноос ifacebook зарl болон, төрөл, садны хүнээр дамжиж мэдээлэл авах, төрөх эмнэлэг, хорооны нийгмийн ажилтнуудаас холбон мэдээлэл солилцсоны үндсэн дээр төрийн байгууллагаас гадуур хүүхэд үрчлэлтийн талаар хоорондоо тохиролцдог, уг тохиролцоогоо баталгаажуулж бүртгүүлэхийн тулд л төрийн байгууллагад хандаж байгаа хууль бус ажиллагааны шалтгаан нөхцлийг тогтоож, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг зорьсон.

Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт практикт тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг гарахад нөлөөлж буй шалтгаан үндэслэлийг тодруулах улмаар тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, зөрчлийг арилгахтай холбоотой санал, дүгнэлт дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг:

МУҮХ-Монгол Улсын Үндсэн хууль
ГБтХ-Гэр бүлийн тухай хууль
ХЭтХ-Хүүхдийн эрхийн тухай хууль
ХХтХ-Хүүхэд, хамгааллын тухай хууль
ИХ-Иргэний хууль
ХНХЯ - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГИХАЭА-Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба
ГБХЗХГ-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГБХЗХХ-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс

УДИРТГАЛ:

Сэдвийг сонгосон үндэслэл:

Монгол Улс нь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор даруй 30 гаруй жилийн хугацаа өнгөрч байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-т "Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заасан. Уг зохицуулалтын хүрээнд Монгол Улс нь Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу дараах конвенцуудад нэгдэн орсон. Үүнд:

1. Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, 1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр уг конвенцод нэгдэн орсон¹. Мөн Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцод 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурж 1998 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр уг конвенцод нэгдэн орсон² бөгөөд энэ үеэс эхлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц

дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж зохицуулсны дагуу³ Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дах хэсэгт заасны дагуу Монгол Улс тухайн гэрээгээр хүлээн зөвшөөрсөн арга энэ хуульд заасны дагуу заавал биелүүлэхээ олон улсын хэмжээнд зөвшөөрсний дагуу гэрээнд нэгдэн орж Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг⁴ соёрхон баталснаар уг конвенцийг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх үүрэг хүлээсэн болно.

Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцод улс бүр хүүхдийг өөрийн төрөлх гэр бүлийн асрамжид байх боломжийг бүрдүүлэх талаар зохих арга хэмжээг тэргүүн зэрэгт тавьж ажиллах шаардлагатайг онцлон тодорхойлж, харин өөрийн төрөлх улс оронд тохиромжтой гэр бүл олдохгүй байгаа нөхцөлд хүүхдийг байнгын гэр бүлийн давуутай талыг олгох боломжийн үүднээс улс хооронд үрчлэх үрчлэлтийн систем байж болохыг хүлээн зөвшөөрсөн.

Монгол Улс нь Гаагийн конвенцод нэгдсэнээс хойш 25 жилийн хугацаанд Гаагийн конвенцоор хүлээсэн үүргийнхээ дагуу үрчлэлтийн харилцааг зохицуулсан 11 хууль, 5 эрх зүйн акт, холбогдох стандарт, бодлогын баримт бичгүүдийг боловсруулан баталсан хэдий ч хэдий ч хөрсөн дээр энэ зохицуулалт нь хэлбэр

¹ Legalinfo.mn

² Хүний эрх, үр нөлөөтэй удирдлага сурвалж бичиг, УБ., 2011 он, 192 дахь

³ Legalinfo.mn

⁴ Legalinfo.mn

төдий оршиж, үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг бодитоор хамгаалж, хянаж чадахгүй байна. Үүний тод жишээ нь НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсад өгсөн удаа дараагийн зөвлөмж, дүгнэлтүүд болно. Тухайлбал:

НҮБ-ын хүүхдийн эрхийн хороо 2009 болон 2010 онуудад Монгол Улсын гурав болон дөрөв дэх удаагийн илтгэлийг хэлэлцээд 2010 оны 1 дүгээр сард дүгнэлт, зөвлөмжийн ирүүлсэн. Үүнд: Хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, дотоодын үрчлэлтийн систем холбоотой үрчлэлтийн дараах хяналт, механизмыг бүрдүүлэх чиглэлээр зөвлөмж өгсөн хэдий ч Монгол Улс өнөөг хүртэлх хугацаанд зөвлөмжийг огт хэрэгжүүлээгүй болно.

Дотоод үрчлэлтээр хүүхдийг гэр бүлийн орчинд амьдрах эрхийг нь хүндэтгэж, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хэрэгжүүлдэг. Гэвч зөвхөн үрчлэлтийг бүртгэхээс бусад бүх үе шат хуулийн зохицуулалтгүй хэвээр байгааг анхаарах.

Дотоод үрчлэлтийн механизм үрчлэн авагч эцэг, эхэд тавигдах шалгуур, үрчлэгчийн гэр бүлд судалгаа хийх, хараат бус дүгнэлт гаргах нийгмийн ажлын үйлчилгээ, үрчлэгчдийг сургалтанд хамруулах, үрчлэгдсэн хүүхдийн байдалд хяналт тавьж үнэлгээ хийх зэрэг үе шатууд огт шийдвэрлэгдээгүйд харамсаж буйгаа илэрхийлсэн байна.⁵ Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн

эрхийн конвенцийн хэрэгжилтийн тухай Монгол Улсын 5 дугаар тайланд өгсөн 2017 оны дүгнэлт, зөвлөмжид Хүүхэд үрчлэлтийн практик хангалттай дэвшил гараагүйд харамсаж буйгаа илэрхийлж дараах арга хэмжээнүүдийг яаралтай авахыг шаардсан. Үүнд:

1. Өмнөх зөвлөмжүүдийг бүрэн биелүүлэх.
2. Үрчлэлтийн явцад хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчим хамгийн чухлыг анхаарах, ялангуяа хүүхдийг үрчлүүлэх шаардлагатай эсэхийг болон үрчилж авч байгаа эцэг эхийн талаар үнэлгээ хийхдээ энэ журмыг хатуу баримтлах
3. Үрчлэлтэд хяналт тавих, үрчлэлтийн мөрөөр ажиллах гэх мэт үрчлэлтийн бүхий л явцад ил тод байдлыг хангах шаардлагатайг илэрхийлсэн⁶.

Судалгаанаас үзэхэд: 2000 оноос эхлэн үрчлэлтийн бүртгэл хийгдсэнээс хойш нийт 42851 хүүхэд үрчлэгдсэнээс сүүлийн 10 жилийн дунджаар жилд 1057 хүүхэд үрчлэлт хийгдэж байгаа учир хүүхэд үрчлэх, үрчлүүлэх хэрэгцээ шаардлага нийгэмд байна.

Уг шаардлага нь нэг талаар: Нийгмээс болон өөрөөс хамаарах янз бүрийн шалтгаанаар буюу хүсээгүй жирэмслэлт, мөнгөтэй болох зорилгоор хүүхдээ үрчлүүлэх, хүүхдээ тэжээн тэтгэх боломжгүй, хүүхдийн асрамжийн асуудалд маргаан гаргахгүй үүднээс эцэг,

⁵ НҮБ-ын ХЭХороо, Хүүхдийн Эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи дүгнэлт, зөвлөмж, УБ хот, 2010 он

⁶ НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо, Монгол Улсын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт зөвлөмж, УБ хот, 2017 он, 8 дахь тал

эхдээ үрчлүүлэх, гадаад улс оронд хараар амьдарч байгаа иргэд хүүхэдтэйгээ хамт амьдрах зорилготойгоор бичиг баримт хуурамчаар үйлдэж үрчлэлт хийлгэж байгаа бол нөгөө талаар: байгалийн жамаар бие физиологийн хувьд хүүхэдтэй болдоггүй, хүүхэдтэй болсон ч хүүхэд тогтдоггүй, ганц хүүхдэдээ хань болгох зорилготой тэтгэвэр, тэтгэмж, одонгийн мөнгө болон хүүхдийн мөнгө авах зорилготой, өөрийн ач, зээ нарыг үрчлэн авах тохиолдлууд байгаа хэдий ч төрийн зүгээс иргэд хүүхэд үрчлэн авах чинь хүсэл зорилготой эсэх, үрчлүүлж буй этгээд хүүхдээ мөнгөөр худалдаж буй эсэх, үрчлэн авагч нь хуульд заасан шаардлагыг хангаж чадаж байгаа эсэх, үрчлэлтийн өмнөх үйл явц бүртгэл, мэдээллийн систем хангалтай эсэх, үрчлэлт хийгдсэний дараа хүүхдийн эрхийг зөрчиж буй эсэх, үрчлэгдсэн хүүхэд хүчирхийлэлд өртөж буй эсэх, түүнд хэрхэн хяналт тавьж байгаа эсэх, үрчлэлтийг хүчингүйд тооцож буй шалтгаан нөхцөлийг судлан зөв дүгнэлт өгч чадаж буй эсэх, үрчлэлт хийж буй субъект, үрчлэлтийг хүчингүйд тооцож буй субъектийн хоорондын бүртгэлийн уялдаа холбоог хангаж чадаж буй эсэх асуудлууд тодорхойгүй байна.

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжуудаар зохицуулж, түүнтэй холбоотой эрх зүйн орчин бүрдүүлж, хүүхэд хамгааллын талаархи бие даасан хууль үйлчилж төрөөс

баримтлах эрх зүйн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж байгаа хэдий ч «Хүүхдийн эрх, үрчлэлтийн процесс»-ыг олон улсын хууль тогтоомжид нийцүүлэх хэрэгцээ шаардлага бий болохын зэрэгцээ дотоод дахь үрчлэгдсэн хүүхдийн эрх зөрчигдөх, янз бүрийн шалтгаанаар үрчлэлтийг хүчингүйд тооцуулж, хүүхдэд хоёр дахь өнчрөлийг мэдрүүлсэн асуудал гарсаар байгаа нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж байна. Тухайлбал:

- Дагаж мөрдөж буй хуулийн зохих зохицуулалт нь амьдрал практикт үүсээд байгаа тулгамдсан, шийдвэрлэвэл зохих асуудлыг зохицуулах боломжгүй байгаа шалтгааныг судалж, илрүүлэн гаргах
 - Хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ байхгүй нь улмаас үрчлэгч болон үрчлүүлэгч нар нь социал орчингоос \facebook зар\ болон, төрөл, садангийн хүнээр дамжиж мэдээлэл авах, төрөх эмнэлэг, хорооны нийгмийн ажилтнуудаас холбон мэдээлэл өгч байгаа цаад шалтгааныг судлах, цаашлаад төрийн байгууллагаас гадуур хүүхэд үрчлэлтийн талаар хоорондоо тохиролцдог, уг тохиролцоогоо баталгаажуулж бүртгүүлэхийн тулд л төрд хандаж байгаа хууль бус ажиллагааны шалтгаан нөхцлийг тогтоож, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох
- Дээрх шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд байгаа учир

уг асуудлуудад судалгаа шинжилгээ хийх замаар асуудлын шалтгааныг нээн илрүүлж, одоо байгаа эрх зүйн орчинд үнэлгээ өгч харьцуулах замаар үрчлэгдсэн хүүхдийн эрхийг хангах, хамгаалах олон талт зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Дээрх шаардлагын үүднээс хүүхдийн эрх, ашгийг хамгаалахын тулд үрчлэлтийн процессыг олон улсын гэрээ болон хууль тогтоомжид нийцүүлэх, үүднээс уг сэдвийг сонгон авсан болно.

Сэдэв: Үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтад тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Улсын хэмжээнд 2000–2022 он хүртэлх хугацаанд жилд дунджаар 1938 хүүхэд үрчлэлт бүртгэгдсэн байна. Үүнээс онцлоход 2005 онд улсын хэмжээнд хамгийн их үрчлэлт хийгдсэн байх ба 3797 үрчлэлт Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

2005 оны үрчлэлтийн тоон үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулахад 2000–2004 оны дундаж /1483/-с даруй 2314 –р илүү бүртгэл хийгдсэн байгаа болно. Иймд дээрх үйл явдлыг төрөөс хэрэгжүүлсэн тодорхой бодлого, үйл ажиллагаатай холбон үзэх үндэслэл бий болсон нь тус онд батлагдсан Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн тухай хууль юм. Монгол Улсын хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар 2005 онд анхны хуулийг санаачлан баталж байсан боловч уг хууль нь төдийлөн урт хугацаанд хэрэгжээгүй байх ба өнөөдрийг хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох асуудлыг 2023 оны 01-р сарын 05-ны өдөр батлагдсан /дугаар 11/ журмаар зохицуулж байна.

График 1.1

2022 оны байдлаар улсын хэмжээнд 21 байгууллагын 31 асрамжийн


2022 оны байдлаар Асрах төвд хамрагдаж буй хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл:



төв үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллагуудад нийт 1045 хүүхэд хамрагдаж байгаагаас 527 нь эрэгтэй, 530 нь эмэгтэй хүүхэд амьдарч байна⁷.

⁷ ХГБХГ-ын 2022 оны тайлан, мэдээ

График 1.2




Асрах төвд хамрагдаж байгаа нийт 1045 хүүхдийг насны байдлаар нь ав үзэхэд 0-5 насны хүүхэд 16%, 6-10 насны хүүхэд 28,5%, 11-14 насны хүүхэд 26%, 15-18 насны хүүхэд 23,7%, 18-аас дээш насны хүүхэд 5,5%-г тус тус эзэлж байна.⁸

Дээрх 31 төвд бүртгэлтэй 1045 хүүхдээс хагас болон бүтэн өнчин хүүхэд 79 хүүхэд байгаа бол үлдсэн 966 хүүхэд нь эцэг, эхтэй хүүхдүүд байна.⁹

График 1.3

143



Нийслэлд 2023 оны байдлаар Хүүхдийн асрамж халамжийн нийт 17 байгууллагын 27 төв бүртгэлтэй байгаа ба үүнээс 10 байгууллага нь үрчлэлт хийдэг бол 7 байгууллага нь¹⁰ асрамж, халамжийн үйлчилгээг дагнан үзүүлдэг байна.

⁸ ХГБХГ-ын 2022 оны тайлан, мэдээ

⁹ ХГБХГ-ын 2022 оны тайлан, мэдээ

¹⁰ НХГБЗХГ-ын 2022 оны мэдээ

График 1.4

Нийслэл дэх Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдийн хүүхдийн тоо судалгаа 2023 оны байдлаар



Нийслэлд бүртгэлтэй 17 хүүхдийн асрамж, халамжийн төвд нийт 876 хүүхэд бүртгэлтэй байгаагаас Нийслэлийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст бүртгэгдсэн үрчлэгдэх боломжтой хүүхдийн тоо 2 байна.¹¹

ХГБХГ-ын хүүхэд үрчлэлтийн сүүлийн 5 жилийн тоон мэдээлэл:

График: 1.5

Улсын хэмжээнд 2018-2022 онд хийгдсэн үрчлэлтийн тоо



Улсын хэмжээний 21 асрамжийн газрын 31 асрах төвөөс сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 17 хүүхэд үрчлэгдсэн байна¹².

2022 онд 31 асрах төвд 1045 хүүхэд, нийслэлийн 27 асрах төвд 876 хүүхэд байгаагаас нийслэлийн байгаа 27 төвөөс ердөө 3 хүүхэд үрчлэлт хийгдсэн байна.¹³

Улсын хэмжээний 21 асрамжийн газрын 31 асрах төвөөс сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 1057 хүүхэд асрах төвд хамрагдаж байгаагаас

¹¹ НХГБЗХГ-ын 2022 оны мэдээ

¹² ХГБХГ-ын 2022 оны тайлан, мэдээ

¹³ ХГБЗХХ-ын 2022 оны тайлан, мэдээ

жилд дунджаар нийт хүүхдийн 1.6 хувь буюу жилд 3-4 хүүхэд үрчлэлт хийгдсэн тоон үзүүлэлт гарч байгаа нь хангалтгүй байна.

Дэлхий нийт 2000 оноос эхлэн асрамжийн газарт хүүхэд байлгах аас илүүтэйгээр үрчлэлт хийлгэх нь гэр бүлийг орлох хамгийн сайн хувилбарт систем гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч Монгол Улсад эсрэгээр аль болох асрамжийн газарт хүүхдүүдийг байлгаж байгаа нь хүүхдийн эрхийг хангаж хамгаалж байна гэж үзэхэд учир дутагдалтай байна.

График 1.6

Улсын хэмжээнд асрах төвүүдэд хамрагдаж байгаа хүүхдүүдийн үрчлэгдэх боломжгүй шалтгааныг тодруулж үзвэл



145

Дээрх мэдээллийг баталгаажуулах зорилгоор дүүргийн болон Нийслэлийн хүүхэд гэр бүл, залуучуудын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас үрчлэгдсэн хүүхдүүдийн талаарх хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, эцэг, эхтэй эсэх мэдээлэл хүсэхэд энэ чиглэлийн мэдээллийн сан байдаггүй талаар Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” 2023 оны 05 дугаар сарын 9-11-ний өдрийн хооронд болсон UNICEF-ийн 3 өдрийн хөтөлбөрийн хүрээнд фокус ярилцлагын аргаар авагдсан судалгаанд хариулсан болно.

Судалгаанаас үзэхэд: 2000 оноос эхлэн үрчлэлтийн бүртгэл хийгдсэнээс хойш нийт 42851 хүүхэд үрчлэгдсэнээс сүүлийн 10 жилийн дунджаар жилд 1824 үрчлэлт хийгдэж байгаа учир хүүхэд үрчлэх, үрчлүүлэх хэрэгцээ шаардлага нийгэмд байна.

Уг шаардлага нь нэг талаар: Нийгмээс болон өөрөөс хамаарах янз бүрийн шалтгаанаар буюу хүсээгүй жирэмслэлт, мөнгөтэй болох зорилгоор хүүхдээ үрчлэх, хүүхдээ тэжээн тэтгэх боломжгүй, хүүхдийн асрамжийн асуудалд маргаан гаргахгүй үүднээс эцэг, эхдээ үрчлүүлэх, гадаад улс оронд хараар амьдарч байгаа иргэд хүүхэдтэйгээ хамт амьдрах зорилготойгоор бичиг баримт хуурамчаар үйлдэж үрчлэлт хийлгэж байгаа бол нөгөө

талаар: байгалийн жамаар бие физиологиин хувьд хүүхэдтэй болдоггүй, хүүхэдтэй болсон ч хүүхэд тогтдоггүй, ганц хүүхдэдээ хань болгох зорилготой тэтгэвэр, тэтгэмж, одонгийн мөнгө болон хүүхдийн мөнгө авах зорилготой, өөрийн ач, зээ нарыг үрчлэн авах тохиолдлууд байгаа хэдий ч төрийн зүгээс үрлэгч нар нь хүүхэд үрчлэн авах чинь хүсэл зорилготой эсэх, үрчлүүлж буй этгээд хүүхдээ мөнгө болон элдэв зээлийн өрийг дарж хүүхдийг үрчлэн авч буй эсэх, үрчлэн авагч нь хуульд заасан шаардлагыг хангаж чадаж байгаа эсэх, үрчлэлтийн өмнөх үйл явц бүртгэл, мэдээллийн систем хангалтай эсэх, төрийн байгууллагуудын мэдээллийн систем бүртгэлийн уялдаа холбоо нь үрлэгч болон үрчлэн авагч иргэдийн хэрэгцээнд нийцэж чадаж буй эсэх асуудлууд тодорхойгүй байна.

Судалгаанаас үзэхэд: Нийт үрчлэгдсэн хүүхдүүдийн 1.6 хувь нь Асрамжийн газраас үлдсэн 98.4 хувь нь сошиал орчноос (facebook зар) болон, төрөл, садны хүнээр дамжиж мэдээлэл авах, төрөх эмнэлэг болон хорооны нийгмийн ажилтнуудаас холбон мэдээлэл авах зэргээр төрийн байгууллагаас гадуур хүүхэд үрчлэлтийн талаар хувийн харилцаа тогтоож тохиролцдог, уг тохиролцоогоо баталгаажуулж бүртгүүлэхийн тулд л төрийн байгууллагад хандаж байгаа хууль бус ажиллагааны практик тогтсон байна. ӨХ: Хуулиас гадуур эцэг, эх

харилцан тохиролцож урьдчилан хүүхдийг үзэж, хүүхдийн сэтгэл зүй болон бусад нөхцөлийг огт харгалзан үзэхгүйгээр ямар далд санаа агуулж байгааг тогтоохгүйгээр бараа авч буй мэт хоорондоо харилцан тохиролцож буй нийтлэг практик тогтсон байна.

Үрлэгч болон үрчлүүлэгч нарын хоорондын төрөөс гадуур хийсэн хувийн тохиролцоог хууль бус гэж үзэж буй дараах үндэслэлүүд байна. Үүнд

1. Хүн худалдаалах болон бусад төрлийн үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор үрчлэлтийн талуудын хооронд холбоо тогтоохыг хориглосон, хүүхэд бол бараа биш болно гэсэн үзэл баримтлалтай холбоотой.
2. Хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, түүний үндсэн эрхийг хүндэтгэх шаардлагатай.
3. Хүүхэд үрчлүүлэхийг зөвшөөрсөн гэдэг үндэслэлээр зүй бусаар элдэв төлбөр шан харамж шаардах нөхөн олговор өгөх, зэрэг хууль бус практик тогтохоос урьдчилан сэргийлэх зорилготой
4. Эрх зүйн болон нийгэм сэтгэл зүйн хувьд үрчлэгдэх боломжтойг тогтоох ёстой.

Сошиаль орчинд зараар тохирч байгаа нь хүүхдийн талаарх тайлан бэлдэж хүүхдийг үрчлүүлэх боломжтой эсэхийг тогтоох ажиллагааг огт хийгдэхгүй алгасдаг болно.

Харин үрчлэн авах гэж буй эцэг, эх нь үрчлэх эрхтэй буюу боломжтой гэж тогтоох ажиллагаа хийж нөхцөл байдлын үнэлгээ гаргасны зөвшөөрөл олгох асуудал орхигддог.

Эцэст нь хүүхэд болон эцэг, эхийн талаарх тайланд үндэслэж хамгийн сайн нөхцөлтэй эцэг, эхийн тайлан дундаас сонголт хийж хүүхдийн тайланг тохируулж тохирлын шийдэл гаргах зохицуулалт Монгол Улсад байхгүй тул дээрх бүх үйл явцыг алгасаж зараас болон эмнэлэг, нийгмийн ажилтануудаас хүүхэд үрчилж авахдаа тодорхой хэмжээний мөнгө өгдөг, өрийг нь дардаг үнэт зүйл авч өгдөг, төрөхөөс нь өмнөх орон сууц хөлслөх гэрээ байгуулсан тохиолдолууд байгаа нь хүүхдийг дээд эрх, ашиг сонирхолыг ноцтой зөрчсөн хууль бус процесс болно.

Хүүхэд үрчлэх талаар сошиаль орчинд зар тавьж буй уг асуудал нь хууль бус гэдгийг мэдэхгүйтэй холбоотойгоос гадна, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа дутагдалтай байгаагын илрэл мөн.

Уг асуудлууд гараад байгаагийн цаад шалтгааныг судлан үзвэл дараах асуудлууд орхигдсонтой холбоотой байна: Үүнд

1. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх хүсэлтэй эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ Монгол Улсад байдаггүй
2. Үрчлэлтийн өмнөх болон явц дундын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан Монгол улсад байдаггүй

3. Асрамжийн газраас үрчлэгдэх хүүхэд байхгүйтэй холбоотой байна

Тухайлбал: 3.1 Үрчлэгдэх хүүхдийн болон асрамжийн газрын талаарх хүүхдийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй учир асрамжийн газруудад сүүлийн 5 жилийн хугацаанд 17 хүүхэд үрчлүүлсэн байна. 17 байгууллагын 31 төв нийт 1057 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж байгаа боловч үрчлэгдэх хүүхдийн талаарх мэдээлэл өгөх нь хомс байна. Асрамжийн газарт үрчлэгдэх хүүхэд байхгүй гэх дараах үндэслэлүүд байна. Үүнд:

- i. Асрамжийн газарт байгаа хүүхдүүдийн хувьд бие бялдар болон сэтгэлгээний хувьд хоцрогдолтой, эрүүл мэндийн хувьд шаардлага хангахгүй нь зэрэгцээ хагас өнчин болон эцэг эхтэй, асрамжийн газрууд гэр бүлд чиглэсэн халамжийн үйлчилгээрүү чиглэсэн учир үрчлэлт хийдэггүй нийт 7 байгууллага байна.
- ii. Гадаадын иргэдээс үрчлэн авсан хүүхдээ эрүүл мэндийн шалтгааны улмаас шүүхийн журмаар үрчлэлтийн хүчингүйд тооцуулж буцаан өгсөн 2 тохиолдол гарсан байна.

Энэ асуудал нь үрчлэгдэх хүүхдийн талаарх бэлдсэн тайлан мэдээлэл хангалтгүй, асрамжийн газарт байгаа хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулдаг асуудал

хангалтгүй, шаардлага хангахгүй байгаагийн илрэл мөн.

Хүүхэд үрчлэлтийн талаарх мэдээллийн нэгдсэн сан байхгүй учир асрамжийн газруудаас үрчлэгдэх хүүхдийн талаарх мэдээллийг хүлээн авч хэвшсэн буруу тогтолцоо байна. Учир нь асрамжийн газраас ирсэн мэдээлэлд баталгаажуулалт хийдэггүй учир асрамжийн газрууд үрчлэгдэх хүүхэд байхгүй эсхүл хэт цөөн хүүхдийн мэдээллийг явуулж хэвшсэн байна.

Шийдлийн хувьд: ХНХЯ, ХГБЗХГ шат шатандаа үрчлэлттэй холбоотой мэдээллийн дата сантай боллох шаардлагатай байна.

Уг байгууллагын мэдээллийн санд дараах мэдээллүүдийг нэгтгэн шалгаж бүртгэлжүүлдэг байх. Үүнд:

1. Үрчлэгч болон үрчлүүлэгчийг нарыг холбосон иргэдэд үйлчлэх нэгдсэн сайт бий болгох. Уг сайтаар дамжиж хүүхэд үрчлэн авах хүсэлтэй эцэг эхчүүдийн хүсэлтийг бүртгэж баталгаажуулах, хүүхдээ үрчлүүлэх хүсэлтэй иргэдийн мэдээлэл болон хүүхдийн талаарх нэгдсэн мэдээллүүд болон хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий мэдээлэл сургалтууд, үрчлэлтийн үйлчилгээний мэдээлэл, хууль зүйн зөвлөгөө тусалцааны мэдээлэл зэргийг багтаах.
2. Хүүхэд үрчлэх хүсэлтэй эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, сургалтыг бий болгох.
3. Асрамжийн газруудад нэгдсэн

шалгалт хийж хүүхэд бүрийн талаарх эцэг, эхтэй эсэх, хагас өнчин эсэх, хамгийн сүүлд хүүхэдтэй холбоотой байгаа эцэг, эх болон төрөл садны хүний мэдээлэл, хаяг, утасны дугаар, анх асрамжийн газарт ирсэн үеийн эрүүл мэндийн нөхцөл, эрүүл мэндийг нэгдсэн үйлчилгээнд хамруулсан байдал, давтамжит хугацаа, хөнгөлттэй болон үнэ төлбөргүй эрүүл мэндийн болон даатгалын үйлчилгээнд тогтмол хамруулсан байдал, хүүхдийн сэтгэл зүйн хөгжил зэргийг шалган баталгаажуулсан мэдээллүүдийг багтаах, асрамжийн газрын санхүүжилт болон хүүхдийн хөгжил төлөвшлийн шалгалт, асрамжийн газарт байгаа хүүхдүүдийн шалтгаан нөхцөлийг хянаж баталгаажуулдаг байх шаардлагатай байна.

4. Асрамжийн газарт байгаа хүүхдүүд эрүүл мэндийн цогц үйлчилгээг болон сэтгэл зүйн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Дээрх зохицуулалтыг бий болгосноор дараах ач холбогдолтой. Үүнд:

- Асрамжийн газраас судалгаа авах бус өөрсдийн дата сангаар дамжиж бодит мэдээллийг шалган авч хэвшсэнээр гадаад болон дотоодод үрчлэгдэх боломжтой хүүхдүүдийн жагсаалтаас харж үрчлэлтийн

бүртгэл мэдээлэл хийхэд нээлттэй болсноор үрчлэгч болон үрчлэн авагч нарт үрчлэлтийн үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлэхэд ач холбогдолтой болно.

- Сошиал орчноос \facebook зар\ болон, төрөл, садны хүнээр дамжиж мэдээлэл авах, төрөх эмнэлэг, хорооны нийгмийн ажилтнуудаас холбон мэдээлэл авах зэргээр төрийн байгууллагаас гадуур хүүхэд үрчлэлтийн талаар хувийн харилцаа тогтоож тохиролцдог, уг тохиролцоогоо л баталгаажуулж бүртгүүлэхийн тулд л төрийн байгууллагад хандаж байгаа хууль бус ажиллагааг арилах, цаашлаад уг асуудлыг холбож зуучилдаг ашиг олдог ажиллагаа, хүүхдийн наймааны асуудал зогссоноор үрчлэлт хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэж, хүүхдийн үндсэн эрх хангагдах ач холбогдолтой болно.

Цаашлаад хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангаж хамгаалагч улс орон болсноор олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүнд өсөх, Гаагийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж, хууль эрх зүйн зохицуулалтаараа үрчлэгдсэн хүүхдийн дээд эрх ашиг сонирхлыг хангаж өгөх зэрэг ач холбогдолтой болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Нэг: Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Гэр бүлийн тухай хууль 1999 он
3. Иргэний хууль 2002 он
4. ИХШХШтХ 2002 он
5. Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
6. Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он
7. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль 2018 он
8. Харьяатын тухай хууль 1995 он
9. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль 2010 он
10. ХЗДХС, НХХСайдын 2001 оны 100/32 тоот хамтарсан тушаал,
11. Монгол улсын харъяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журам,
12. Үрчлэлтийн дараа хяналт тавих гурван талт гэрээ.

Хоёр: Ном, сурах бичиг

1. Ц.Алтанцэцэг: Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй УБ хот., 2007 он
2. А.Дугармаа, Ц.Алтанцэцэг: Монгол Улсын Гэр бүлийн эрх зүй гарын авлага УБ хот, 2007 он
3. А.Батбаатар: Монгол Улсын гэр бүлийн эрх зүй, УБ хот., 2007, 2021 он

Гурав: Цахим хаяг

1. Legalinfo.mn
2. Legaldata.mn
3. <https://www.hcch.net/en/states/hcch-members>
4. <https://www.1212>

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ БА ӨӨРИЙНХӨӨ ЭСРЭГ
МЭДҮҮЛЭГ ӨГӨХГҮЙ БАЙХ ЭРХ**



Шихихутуг их сургуулийн
магистрант Б.Өнөбат

***“Үндсэн хуулиар олгогдсон
өөрийнхөө эсрэг мэдүүлэг
өгөхгүй байх туйлын эрхэд
хөндлөнгийн хэн боловч дур
мэдэн халдаж болохгүй”***

Хураангуй:

Хүний эрх, эрх чөлөө гэдэг нь төрөхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг нийгмийн дотор заавал эдлэх боломж мөн. Эрх чөлөө гэж хүний эдлэх ёстой бөгөөд хүнээс хаалт хэрэм босгон салгаж үл болох боломжийг хэлдэг¹.

Тухайлбал: 16 дугаар зүйлийн 14-т “Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг

мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”² гэсэн байна.

Дээрх эрхийг Монгол Улсын иргэн гэмт хэрэг үйлдэж сэжиглэгдсэн яллагдагчаар татагдсан, иргэний хэрэгт хариуцагчаар татагдсан хэн боловч юуны түрүүнд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй энэхүү эрх нь ямар ч процесс ажиглагааны аль ч үед элдэв болзолгүйгээр шууд үйлчлэх бүрэн боломжтой эрх юм.

Энэхүү өгүүллээр өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн хэрэжиж байгаа болон гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээд уг эрхээ бүрэн эдлэх нөхцөл боломжтой байгаа эсэхийг өгүүлэв.

Ардчилсан нийгмийн нэгэн чухал үнэт зүйл бол хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх явдал мөн. Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах баталгааг төр хариуцдаг. Тиймдээ ч төр нь хүний халдашгүй байдал болон Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудад заасан хүний эрхийг хангах хамгаалах эрх зүйн

¹ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” УБ 2008 он 89 дэх тал

² Монгол улсын Үндсэн хууль, УБ 1992он

орчныг бүрдүүлэх нь ардчилсан нийгмийн үнэт зүйлийг сонгодог утгаар нь хэрэгжүүлэх нь төрийн эрхэм үүрэг болж байна. Тиймээс энэхүү өгүүлэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн хэрэгжилт ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аливаа хүн тухайн эрхээ баталгаатай эдлэх хууль эрх зүйн таатай нөхцөл бүрдсэн эсэхийг онол, хийгээд статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж уг эрхийн хэрэгжилтийг тодорхойлох нь энэхүү өгүүллийн зорилго оршиж байна.

Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх гэдэг нь аливаа гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээд тухайн гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, уг гэмт хэрэгт холбогдолгүй болохоо нотлох, мэдүүлэг өгөхөөс татгалзахыг хэлдэг. Тус эрх байгаа суурь шалтгаан нь "нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох" зарчим баталгаатай хэрэгжих нэгэн болзол болсон дээрх зарчмыг бодитой амьдралд хэрэгжүүлэхэд нөхцөл болдог онцлогтой эрх билээ.

Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх нь 1934 онд АНУ-д гарсан нэгэн тохиолдлын үндсэн дээр үүссэн юм. Тус тохиолдлоос шалтгаалан АНУ өөрийн Үндсэн хуульдаа дээрх эрхийг хэрэгжүүлэх баталгаа болгон тусгаж

өгсөн ба үүнээс үүдэн дэлхийд оршин тогтнож буй улс орнууд Үндсэн хуульдаа нэмэлт оруулсан байдаг. Тус хэргийн тухайд товч авч үзвэл:

Хэргийн товч утга:
Рэймонд Стюарт гэх цагаан арьст тариачин 1934 оны 3 сарын 30-ны өдөр алагдсан. Мөрдөн байцаагчид хүн амины хэргийг дээрмийн сэдэлтээр үйлдсэн гэж үзсэн байдаг. Шериф Эдкок нь аймхай, хулчгар этгээд тус хэргийг үйлдсэн гэдэгт итгэлтэй байсан бөгөөд мөрч нохойгоор хэрэгтнийг мөрдсөн ч хүйтэнд нохой ямар нэг мөр олсонгүй. Хэрэг үйлдсэн этгээдийг таних, илрүүлэх ямар нэг бодит нотлох баримт байгаагүй бөгөөд цагдаа нар Рэймонд Стюартын тариалангийн талбайд амьдарч байсан 30 настай хар арьстан Эд Брауныг тус хэргийг үйлдсэн байж болох юм гэж таамаглал дэвшүүлжээ.

Ингээд Эд Брауныг буруутгасан шигээ Артур Элингтон болон Хенри Шайлд нарыг мөн сэжигтнээр татаж, баривчилсан байна. Мөрдөн шалгалтын дүнд "хэргээ сайн дураар хүлээсэн" (confession) гэх үндэслэлээр хүний амь хөнөөсөн хэрэгт хоёр хүнийг буруутгасан бөгөөд хэргийн ганц нотолгоо нь тэднээс авсан мэдүүлэг байлаа. Ингэхдээ байцаалтыг хүч хэрэглэж явуулсан байна.³

³ Шүүхийн ерөнхий зөвлөл "Шүүх эрх мэдэл сэтгүүл" Эрх зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан шүүхийн шийдвэр буланд нийтлэгдсэн кейсээс хураангуйлан авав.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны товч

Цагдаа нар Браун нарыг 1934 оны 3 сарын 30-ны өдөр үйлдэгдсэн хүн амины хэрэгт буруутгаж баривчилсан. Ингээд тэднийг 1934 оны 4 сарын 4-ний өдөр шүүхэд шилжүүлсэн бөгөөд анхан шатны шүүх дээр шүүгдэгчдийг зөвхөн тэдний хэргээ хүлээсэн мэдүүлэг дээр үндэслэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзсэн.

Шүүх хуралдааны үеэр шүүгдэгчид хэргээ хүлээсэн нь худлаа бөгөөд эрүүдэн шүүгдсэн болохоо мэдүүлсэн нь тус болоогүй юм. Тус хэрэг бүхэлдээ гэрлийн хурдаар шийдэгдсэн. Хэргээ хүлээсэн талаар 4 дүгээр сарын 2-нд шүүхэд мэдэгдсэн бөгөөд, шүүхээс тангарагтны шүүгчдийг 4 дүгээр сарын 3-нд томилж, тангарагтны шүүгчид 4 дүгээр сарын 4-нд ялын төлөвлөгөө гаргаж, шүүх хурал 4 дүгээр сарын 5-нд эхэлсэн бөгөөд 4 дүгээр сарын 6-нд шүүгдэгчийг хүн амины хэрэг үйлдсэн гэм буруутай гэж шийдсэн юм.

Шүүгдэгчид АНУ-ын Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлт зөрчигдсөн үндэслэлээр Миссисипи муж улсын Дээд шүүхэд давж заалдсан бөгөөд тус шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. Миссисипи муж улсын Дээд шүүх шийдвэртээ дараах үндэслэл гаргасан. Үүнд:

1. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх /хэргээ хүлээх/ эрх нь эрх зүйн зайлшгүй байх процессын чухал асуудал биш.

2. Нотлох баримтыг танилцуулсны дараа хэрэг хүлээлгэсэн нотлох баримтыг анхан шатны шүүх хасаагүй алдаа нь шүүгдэгчийн амьдрал, эрх чөлөөг эрх зүйн зайлшгүй байх процессын эрх зүйгүйгээр хязгаарлахад нөлөөлөхгүй бөгөөд шүүхийн гаргасан алдаа нь үндсэн эрхийг зөрчсөнд тооцогдохгүй.

Өөрөөр хэлбэл, энэ хэргийн асуудал нь зөвхөн хүч хэрэглэж өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгүүлсэн нь хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж шийдвэрлэхэд хангалттай, хууль ёсны нотолгоо болох уу? гэдэгт байгаа юм. Миссисипи мужийн шүүх хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт авагдсан нотлох баримтыг хууль ёсны, зохих ёсоор цуглуулсан эсэхийг асуугаагүй буюу энэ талаар "мөрдөн шалгаагүй" нь шүүхийн үйл ажиллагаа бүрэн бус, хангалтгүй явагдсан гэж үзэхэд хүргэж байгаа юм.⁴

Шүүн хэлэлцсэн нь

Миссисипи муж улсын Дээд шүүхээс "Twining v. New Jersey" хэргийн дагуу "Муж улсын шүүх дээр өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг зөвшөөрөхгүй байх асуудлыг Холбооны Үндсэн хуулийн аль ч хэсгээр баталгаажуулаагүй" гэж маргасан. Мөн "Snyder v. Massachusetts" хэргийн дагуу АНУ-ын Дээд шүүхээс өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх дархан эрхийг

⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл "Шүүх эрх мэдэл сэтгүүл" Эрх зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан шүүхийн шийдвэр буланд нийтлэгдсэн кейсээс хураангуйлан авав.

хязгаарлаж болох бөгөөд төрийн гэрчийн хувиар яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгч болно гэж дүгнэсэн” гэжээ.

Үүнийг АНУ-ын Дээд шүүхээс хүлээн аваагүй бөгөөд дээрх үндэслэлүүдэд “Гэхдээ өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх дархан эрхийг төр хязгаарлах эрхийн асуудал нь уг асуудалтай холбоогүй. Иш татсан мэдэгдэлд дурдсан асуудал нь шүүхийн үйл ажиллагааны үе шатанд мэдүүлэг өгөх шаардлагатай гэрчийн тухай юм. Эрүүдэн шүүж хэрэг хүлээлгэх нь тусдаа, өөр асуудал. Түүнчлэн шүүхийн процедурыг зохицуулах бодлогоо тодорхойлох эрхтэй хэдий ч төрийн үйл ажиллагааны эрх чөлөө нь эрх зүйн зайлшгүй байх процессын шаардлагаар хязгаарлагдана” гэжээ.

Гэм буруу, ял шийтгэл нь эрх зүйн зайлшгүй байх процессын чухал ач холбогдолтой хэсэгт нийцэхгүй байгаа тул хүчин төгөлдөр бус бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ямар нэг байдлаар зохих ёсоор явагдсан гэж үзэх үндэслэл болохгүй байна” гэж дүгнэжээ.

Шийдвэр

АНУ-ын Дээд шүүхийн бүх шүүгчийн санапаар “хүчээр хэрэг хүлээлгэсэн нь Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлт дэх эрх зүйн зайлшгүй байх процессын заалтыг зөрчсөн” гэж үзэж Миссисипийн Дээд шүүх болон анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон шүүгдэгчдийн

гомдлыг хангаж шийдвэрлэсэн. Шийдвэрийн үндсэн агуулга нь ямар ч тохиолдолд сэжигтэн, яллагдагчийн хэргээ хүлээсэн мэдүүлгийг хүч хэрэглэж, хууран мэхлэх зэргээр ямар ч хэлбэрээр хүсэл зоригоос нь гадуур авсан бол шүүх дээр нотолгооны шинжээ алдана гэдэг зарчмын өөрчлөлтийг гаргажээ.

Үр нөлөө, ач холбогдол

“Миссисипийн эсрэг Брауны хэрэг” нь эрх зүйн зайлшгүй байх процессын Үндсэн хуулийн баталгааг зөрчих үед холбооны шүүх эрүүгийн хуулийн процессыг зохицуулах харьяаллыг тогтоосон. Ингэснээр сэжигтэн, яллагдагч, шүүгчид хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж авсан ямар ч мэдүүлэг нь нотолгооны чадвараа алдана гэдэг жишгийг тогтоож эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг хангаж хамгаалахад том дэвшил болсон юм.⁵

Харин Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олох болсон үндсэн шалтгаан нь:

1930-аад оны сүүл үе 1940 оны эхэн үед манайд өрнөсөн их хэлмэгдүүлэлтийн үр дүнд гэм буруугүй нийт 31742 хүн хэлмэгдсэн бөгөөд тэдгээрийн 20262 хүн буудан алах, 11446 хүн хорих буюу нутаг зааж суулгах ялаар шийтгэсэн байдаг.⁶

⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүх эрх мэдэл сэтгүүл” Эрх зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан шүүхийн шийдвэр буланд нийтлэгдсэн кейсээс хураангуйлан авав.

⁶ ТЕГ-ын тусгай архив Ф-МБ. №16, 220 дахь тал

Мөрдөн байцаах, шүүн таслах онцгой бүрэн эрхт комиссыг 1937 оны 10 дугаар сараас 1939 оны 4 дүгээр сарын 4-22 нд татан буугдах хүрглээ 51 хуралдаж 27785 улс төрийн хэрэгтний хэргийг авч хэлэлцэж 20099 хүнийг буудан алах, 5739 хүнийг хорих ялаар шийтгэжээ. Зөвхөн нэг удаагийн хурлаар 1278 бөөнөөр нь буудан хороох шийдвэрийг гаргаж байсан байна.

1942 оны 2 дугаар сарын 24 нд МАХН-ийн төв хорооны тэргүүлэгчдийн онцхурлаас гаргасан тогтоолд "...дайсан этгээд нарыг эрхтэнд нь гэмтээлгүйгээр зодох ба занчиж болох эрх, зөвшөөрлийг Дотоод явдлын яамны сайд нөхөр Шагдаржавын өөрийн хариуцлагад хатуу даалган өгсүгэй гээд энэхүү аргыг зөвхөн төвд хэрэглэхийг зөвшөөрсүгэй..." гэж заасныг хэрэгжүүлэн хүмүүсийг зодох, хүмүүсийг занчих, өөрөөр хэлбэл эрүүдэн шүүж хэргийг өөрөөр нь хүлээлгэж байсан нь зөвлөлтийн эрдэмтэн Вышинскийн "хэргээ хүлээж мэдүүлэх нь хамгийн дээд зэргийн нотолгоо /нотолгооны хаан/ мөн"⁷ гэсэн бүдүүлэг онол манайд биеллээ олж байсны бодит илрэл юм. 1992 онд хууль тогтоогчид өмнөх үеийнхний алдаа дутагдлыг дахин гаргахгүй гэсэн үзлээр өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг үндсэн хуульдаа оруулсан байх ч боломжтой юм.⁸

Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх нь Монгол Улсын өнөөдрийн буюу 2023 оны байдлаар ямар түвшинд хэрхэн хэрэгжиж байгаа талаар товч тэмдэглэх нь уншигч ганд оновчтой мэдээлэл болох буй за.

Манай монгол улс нь 1992 онд Үндсэн хууль батлагдсантай холбогдуулж Эрүүгийн хуулиа ч түүнд нийцүүлэх хэрэгцээ шаардлага гарсан байдаг. Ийнхүү 2002 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баталсан байдаг. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээр хангагдах нөхцөл боломж, хуулийн зохицуулалтыг авч үзвэл, 2002 оны Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэгт "гэрч хохирогч шинжээч хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт болон шүүхэд худал мэдүүлэг өгвөл" хүлээлгэх хариуцлагыг тусгасан байдаг. Үүнтэй уялдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэргийн оролцогч болон бусад оролцогч нарын эрх үүргийг 5 дугаар бүлэг болон 6 дугаар бүлэгт тусгаж өгсөн байдаг. Тус хуульд сэжигтэн гэх ойлголт яллагдагч гэх ойлголт байсан төдийгүй гэдний эрх үүргийг тусгасан нарийн зохицуулалтууд тусгагдсанаар Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хүрээнд өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй холбосотойгоор ямарваа нэгэн процессийн зөрчил болон уг эрхийг зөрчсөн асуудал гардаггүй байсан.

⁷ "Хууль дээдлэх ёс сэтгүүл" УБ., 2008он №3 (22) 10 дахь тал

⁸ "Хууль дээдлэх ёс" сэтгүүл УБ., 2012он 7дахь тал

Харин 2015 онд батлагдсан Эрүүгийн хууль болон 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээр хангагдах нөхцөл боломж тус эрхийг хэрхэн зохицуулсан тухай авч үзвэл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд «сэжигтэн» –г эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч байхаар уг хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь хэсэгт тодорхойлсон байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэж хуульд заасан үндэслэлээр сэрдэгдсэн, хууль ёсны эрх ашиг, сонирхлос хамгаалуулах, хууль зүйн туслалцаа авах эрхтэй субъект юм. Гэтэл хүнийг гэмт хэрэгт сэрдэж эхэлсэн үеэс, цаашилбал эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэхийн өмнө гэмт хэрэгт холбогдсон хүнээс ямар статусаар мэдүүлэг авах нь ойлгомжгүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т хүний халдашгүй байдал болон өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх үндсэн эрхийг баталгаажуулсан байдаг.⁹ Гэтэл өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд сэжигтнээр тооцох, сэжигтнээс мэдүүлэг авах ажиллагаа зохицуулагдаагүй бөгөөд хэрэгт сэрдэгдэж буй хүнээс гэрчийн мэдүүлэг авах нь түүний үндсэн эрхийг ноцтой зөрчиж буй

үйлдэл болж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны «сэжигтэн»-ий статус, эрх үүрийг тодорхойлоогүй нь үндсэн хуульд харшилж байна. Мөн Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжтэй харшилж байна. Мөн гэрчээр мэдүүлэг өгч буй этгээд өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргээр зүйлчлэх эсэх асуудал нь эргэлзээтэй бөгөөд хууль зүйн хийдлийг бий болгож байна.

Статистик мэдээлэлд хийсэн шинжилгээ

2022 онд хийгдсэн судалгаагаар Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахын өмнө гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээдээс гэрчээр мэдүүлэг авсан 8750 тохиолдол байгаагаас 6217 буюу 71 хувьд нь "тухайн сэрдэгдэж буй этгээдийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах үндэслэл бүхий бусад нотлох баримт авагдсан байхад мөрдөгч нар гэрчийн мэдүүлэг авсан" байгаа нь хамгийн ихээр анхаарал татаж байна.

Дээрх тоон үзүүлэлтийг мөрдөх байгууллагаар нь ангилж үзвэл Цагдаагийн байгууллагын мөрдөгч гэрчийн мэдүүлэг авсан 8021 хүний 6104 буюу 74.4 хувь, Авлигатай тэмцэх газар 717 хүний 106 буюу

⁹ Ханс Зайделийн сангаас гаргасан "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар" УБ., 2009он 94 дэхь тал

14.7 хувь. Гагнуулын байгууллагын мөрдөгч 12 хүний 7 буюу 58.3 хувийг тухайн сэрээгдэж буй этгээсийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах үндэслэл бүхий бусад нотлох баримт авагдсан байхас мөрдөгч нэр гэрчийн мэдүүлэг авчээ.

Дээрх гэмт хэрэгт сэрээгдэж буй этгээд болох 6217 хүнээс 6102 буюу 98.2 хувь нь гэрчээр мэдүүлэг өгөхөө эмгөөлөгч оролцуулахгүйгээр мэдүүлэг өгчээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хүнийг сэжиг таамаг төдий баримтад үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэж, улмаар сэжигтнээр тооцон, хилийн хориг тавих, байллан баалт, барьцаа авах, цаашилаа 14 хоног сэжигтнээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, хүний эрхэд халдаг байдлыг 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хязгаарлаж, уг хуулийн Гучин нэгдүгээр бүлэгт сэжигтнийг ямар тохиолдолд дуудан ирүүлэх, мөн «гэрч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, эмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхийг тусгасан нь шинэлэг зохицуулалт болсон.

Шинэчлэн батлагдсан эрүүгийн хууль тогтоомж хэрэгжээд 5 жил

гаруй хугацаа өнгөрч байгаа боловч мөрдөгч, прокурорүүд хуулийн дээрх заалтуудыг одоог хүртэл нэг мөр хэрэгжүүлж хэвшээгүй. Гэмт хэрэгт сэрээгдсэн хүнээс «өөрийнх нь эсрэг гэрчийн мэдүүлэг авахыг гэмт хэрэг илрүүлэх арга болгон ашигладаг» хуучны сэтгэлгээ хэвцмэл арга барилаас бүрэн салаагүй болох нь дээрх статистикийн дүнгээс харагдаж байна.

«Тухайн хүнийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж, Яллагдагчаар татах үндэслэл бүхий бусад нотлох баримт хэрэгт авагдсан» байхад гэрчийн мэдүүлэг авч байгаа нь Монгол Улсын Олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 14 дүгээр зүйлийн 3 (g) хэсэгт заасан «өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй байх».

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан «...өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно» гэх, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 4, 1.8 дугаар зүйлийн 3, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.4 дүгээр зүйл, 30.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус хэрэгжүүлээгүй, хүний эрхийн ноцтой зөрчил гэж үзэхээр байна.

Дүгнэлт, санал

Хүн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй гэж Монгол Улсын Үндсэн хуульд заажээ. Уг эрх нь гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүү шүүлтэд өртөхөөс хамгаалсан эрх гэдгийг өнөө цагийн эрдэмтэд дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрч байна. Харин уг эрх нь зөрчигдөж эхэлбэл Монгол улс нь олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

Монгол Улсад 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд сэжигтэн гэх этгээдийн эрх үүргийг тусгаж өгөөгүй нь өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөрчихөд хүргэж байна. Хэрэг бүртгэлтийн шат буюу Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэх хүртэлх хугацаанд гэмт хэрэг үйлдсэн байж болох этгээдээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан гэрчийн эрх үүргийг танилцуулж түүнээс гэрчийн мэдүүлэг авч байна. Ингэхдээ түүнд Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагыг сануулж байгаа нь гэмт хэрэгт холбогдсон хүн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байхын аргагүй нөхцөл байдалд орж байна.

Иймд мөрдөгч, прокурор нь хэргийн талаар нотолбол зохих байдлыг зөвхөн хуулиар зөвшөөрсөн арга хэрэгслээр тогтоож, мөрдөн

шалгах ажиллагааны явцад гэмт хэрэгт сэрдэгдэж буй хүний хуулиар олгогдсон буюу Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 14 дүгээр зүйлийн 3 (g) хэсэгт заасан «өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй байх», Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан «...өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно» гэх заалтыг чанд сахих мөн гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэрдэгдэж буй этгээдэд Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулахаас өмнө буюу Хэрэг бүртгэлтийн шатанд огтоос мэдүүлэг авахгүй байх нь хүн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх гэсэн үндсэн эрхээ эдлэх нөхцөл болох учиртай билээ.

Иймд дээрх эрхийг баталгаатай эдлүүлэх нөхцөл боломжийг хангах цорын ганц гарц нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж буй мөрдөгч нар мэргэжил, ур чадвар, хийгээд хүний эрхийн өндөр мэдрэмжтэй байх нь хамгийн үр нөлөөтэй шийдэл болоод байна. Уншигч танд хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж хүний эрх зөрчигдөж хэрхэвч болохгүй гэсэн товч утга санааг илэрхийлэхийг хүслээ.

Ашигласан материал

Хууль, хуульчилсан актууд:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992он
2. Эрүүгийн хууль 2002он
3. Эрүүгийн хууль 2015он
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002он
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль 2017он
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц

Ашигласан ном, сэтгүүлүүд:

1. Чимид Б. "Үндсэн хуулийн мэдлэг" УБ., 2008он
2. Совд Г. "Монгол улсын Үндсэн хууль ба Хүний эрх УБ., 1999он
3. Совд Г. "Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар" УБ., 2000он
4. Шүүхийн ерөнхий зөвлөл. "Шүүх эрх мэдэл сэтгүүл" №15
5. Хууль дээдлэх ёс сэтгүүл УБ., 2012он

Цахим хуудас:

1. www.legalinfo.mn- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
2. www.judcouncil.mn – Шүүхийн Ерөнхий зөвлөлийн цахим хуудас
3. www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html – ХБНГУ-ын эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим хуудас
4. www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/ru/ru065en.pdf- ОХУ-ын эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим хуудас
5. www.oecd.org – Япон улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим хуудас
6. www.legislationline.org – Дэлхийн улс орнуудын эрүүгийн болон Үндсэн хуулийн нэгдсэн цахим хуудас

ТӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН, ТҮҮНИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ



Шихихутуг их сургуулийн
магистрант
Б.Сэлэнгэ

Хураангуй: Энэхүү өгүүллээр төрийн албаны маргаан тэр дундаа ажлаас халагдсан болон чөлөөлөгдсөнтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх, эмпирик судалгаа, шинжилгээ хийх замаар маргаан гарах шалтгаан, төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тодорхойлсон болно. Шинжилгээнд асуулгын судалгааны болон баримт бичгийн судалгааны аргуудыг ашиглав.

Түлхүүр үг: төрийн албаны маргаан, төрийн жинхэнэ албан хаагч

Abstract: This research paper aims to analyze decisions that have been made regarding the disputes related to the labor relations of the public services and to determine some reasons for the disputes and the level of implementation of laws and regulations on the public

services through empirical research and analysis. The questionnaire and document research methodologies are used in the analysis.

Keywords: Disputes on civil services, public administrative servants

Удиртгал: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах,.. эрхтэй...”, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т “төрийн алба хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, “Төрийн албаны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ” гэж заасан нь төрийн албаны үйл ажиллагааг үр дүнтэй, оновчтой удирдан зохион байгуулахтай холбоотой харилцааны үндсийг бүрдүүлсэн зохицуулалт болжээ.

Төрийн албаны олон талт харилцааны нэг нь төрийн байгууллага ба төрийн албан хаагчдын хооронд үүссэн төрийн албатай холбоотой маргааны тухай асуудал юм. Төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа нь төрийн жинхэнэ албан

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992.

² Төрийн албаны тухай хууль. 2019.

тушаалд тохирох иргэнийг сонгон шалгаруулахаас эхлэн түүнийг албанаас чөлөөлөх буюу халах хүртэл хугацааны турш үргэлжлэн хэрэгждэг. Энэхүү хугацааны турш Төрийн жинхэнэ албан хаагч албан үүргээ гүйцэтгэснээр түүнд цалин хөлс олгох, хэвийн аюулгүй орчинд ажиллах, албан үүргээ сайн гүйцэтгэсэн бол шагнаж урамшуулах, хангалтгүй болон зохих түвшинд гүйцэтгээгүй бол сахилгын шийтгэл оногдуулах зэрэг бусад олон төрлийн харилцаа дагалдан гарч хэрэгжиж байдаг.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр бүлэг тусгайлан зохицуулж өгсөн. Сүүлийн хориод жил төрийн жинхэнэ албан хаагчийг ажилд сонгон шалгаруулж авах, ажлаас түр чөлөөлөх, халах гэсэн заалтуудыг үндэслэн төрийн албаны төв байгууллага болох төрийн албаны зөвлөлд гомдол тасралтгүй ирсээр байна.

Ялангуяа улс төрийн сонгуулийн дараа, эрх баригч нам солигдсон тохиолдолд ажлаасаа хууль бусаар халагдсан тухай гомдлууд Төрийн албаны зөвлөл, захиргааны хэргийн шүүхэд их ирдэг байна. Төрийн албаны Зөвлөлийн гаргасан мэдээллээс үзэхэд сонгуулийн дараа жилд тус байгууллагад ирсэн нийт санал, гомдлын дотор ажлаас үндэслэлгүйгээр халагдсан тухай гомдол 80 гаруй хувь эзэлдэг хэмээн тайландаа илтгэсэн байна.

Төрийн албатай холбогдсон гомдол маргааны тоо жил ирэх тусам нэмэгдэж, захиргааны байгууллагын хууль бус шийдвэрийн улмаас төрийн албан хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх болсон. Төрийн албаны Зөвлөл болон захиргааны хэргийн шүүхэд ирсэн өргөдөл гомдлыг төрлөөр нь ангилбал төрийн албатай холбоотой гомдол өндөр хувь эзэлдэг байна. Жишээлбэл: 2022 оны "Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн 1638 хэргийн 335 хэрэг буюу 20.4 хувийг төрийн албаны маргаан эзэлсэн байна³. (Монгол улсын шүүхийн 2022 оны шүүн таслах ажиллагааны тайлан, 2022).

Иймд төрийн жинхэнэ албан хаагчтай холбоотой үүсэж буй маргаан, түүний төрөл, уг маргааныг хянаншийдвэрлэх ажиллагаа, түүний онцлог, төрийн албатай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн байдал зэрэгт судалгаа хийх шаардлага бий болсон нь энэхүү сэдвийн үндэслэл, асуудал юм. Үүнээс Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлаас халагдсан, чөлөөлөгдсөнтэй холбоотой маргааны тухай явцууруулан авч судалсан болно.

Үндсэн хэсэг. Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлж, маргаан


³ (Монгол улсын шүүхийн 2022 оны шүүн таслах ажиллагааны тайлан, 2022).

гаргах, түүнийг хүлээн авч шийдвэрлэх хугацаа, дараалал, хянан шалгах комиссын эрх үүрэг, хариуцлагыг зохицуулсан байдаг.

Төрийн албатай холбоотой маргааныг нэг-т; төрийн албаны маргааны урьдчилан хянан шийдвэрлэж буй өнөөгийн байдал, хоёр-т; шүүхээс маргаан шийдвэрлэж буй өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, гурав-т; төрийн албаны маргаантай холбоотой тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам гэсэн агуулгын хүрээнд судаллаа.

Нэг. Төрийн албаны маргааны урьдчилан хянан шийдвэрлэж буй өнөөгийн байдал. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны тайлангаас харахад төрийн албатай холбоотой маргаан хянан шалгах комиссын 33 дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, эрх бүхий албан тушаалтны 23 шийдвэрийг Төрийн албаны тухай хууль тогтоомж болон төрийн жинхэнэ албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэж, хүчингүй болгов. Түүнчлэн эрх бүхий албан тушаалтны 10 шийдвэр хууль зүйн үндэслэлтэй болохыг тогтоожээ.

2019-2022 онд үүсгэсэн маргаан болон маргаан шийдвэрлэлтийн тоон үзүүлэлт.



Маргаан хянан шалгах явцад зөрчил арилсан, шүүхэд хандсан, тухайн албан тушаалд гомдол гаргагч өөрөө Төрийн албаны тухай хууль, тогтоомж зөрчиж хууль бусаар томилогдсон нь тогтоогдсон, гомдлоосоо татгалзсан, харьяаллын бус маргаан болохыг тогтоож гомдол гаргагчид зохих хариуг хуулийн хугацаанд хүргүүлэх замаар маргаан бүхий 20 гомдлыг шийдвэрлэсэн. 2022 онд маргаан бүхий захиргааны 63 актыг гаргасан албан тушаалтнаар ангилж үзвэл: 12 шийдвэрийг төрийн улс төрийн албан тушаалтан, 42 шийдвэрийг төрийн захиргааны албан тушаалтан, 9 шийдвэрийг төрийн тусгай албан тушаалтан гаргажээ⁴.

⁴ Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан. 2022 он.

Маргаан бүхий захиргааны актыг гаргасан албан тушаалтан



Хоёр. Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэсэн төрийн албаны маргааны өнөөгийн байдал.

Ажлаас үндэслэлгүй халагдаж 2022 онд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон хэргийн хариуцагч⁵



Дээрх зураглалаас үзэхэд:

- Сайд 6
- Яамны төрийн нарийн бичгийн дарга 7
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга 55
- Тамгын газрын дарга 13
- Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн дэргэдэг агентлаг, газрын дарга 82
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, тэдгээрийн тэргүүлэгчид, дарга 3
- Бусад 8 байна⁶.

⁵ <http://www.judiciary.mn/>

⁶ Шүүхийн ерөнхий зөвлөлийн жилийн тайлан, УБ., 2022 он.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад сонгуулийн жилийн дараагаар төрийн албаны маргаан харьцангуй нэмэгдэж байгаа нь сонгуулийн өмнө, хойно хийгддэг томилгоо болон Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж, улмаар яам агентлагууд бүтцийн өөрчлөлтөд орсон, орон тоо хасагдсан гэх нэрийдлээр төрийн албан хаагчдыг ажлаас чөлөөлдгөөс үүдэлтэй гэж дүгнэж болохоор байна.

Төрийн жинхэнэ албан хаагч албан үүргээ хангалтгүй биелүүлснээс болж ажлаас халагдах, сахилгын шийтгэл хүлээхээс гадна, төрийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, төрийн байгууллага татан буугдах, хооронд нь нэгтгэн зохион байгуулсантай холбоотойгоор төрийн жинхэнэ албан хаагчийг ажлаас чөлөөлөх, сэлгэх зэрэг асуудлаас үүдэн төрийн албаны маргаан их гарч байна.

Түүнчлэн сонгуулийн дараагийн жил төрийн албатай холбоотой хэрэг, маргаан өсөх хандлагатай нь ажиглагддаг. Энэ нь Засгийн газар шинэчлэгдэн байгуулагдах, яам, агентлагийн бүтэц, зохион байгуулалт, төрийн албан хаагчдын орон тоо, ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдөх зэрэг үндэслэлээр халаа сэлгээ хийдэгтэй холбоотой.

2016 онд захиргааны хэргийн шүүхэд төрийн албаны маргаантай 100 хэрэг хянан шийдвэрлэгдэж байсан бол тухайн сонгуулийн жилийн дараагийн жил буюу 2017 онд энэ тоо 197 болж, бараг 2 дахин

өссөн дүнтэй харагддаг. Мөн 2020 оны сонгуулийн жилийн дараагийн жил буюу 2021 онд өмнөх жилээсээ 2 дахин өссөн байх жишээтэй. 2018 онд улсын хэмжээнд төрийн албаны маргаантай 139 хэрэг, 2019 онд 133 хэрэг хянан шийдвэрлэгдсэн байхад, 2020 онд энэ тоо 203, 2021 онд 297, 2022 онд 400 болж тус тус огцом өссөн байна. Үүнээс Төрийн байгууллагын ажил олгогчийн буруугаас ажлаас үндэслэлгүй халагдаж шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон хэргийн тооны хувьд 2022 оны байдлаар нийт 341 хэрэг байна⁷.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр 2021-2022 онуудад хянагдсан төрийн албаны маргаан бүхий нийт 60 захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, магадлал, үүнээс хяналтын журмаар гомдол гаргасан 32 захиргааны хэргийн тогтоолд дараах судалгаануудыг хийлээ. Дээр дурдсан 2021-2022 онд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх төрийн албатай холбоотой шийдвэрлэсэн 6054 захиргааны хэргийг магадлалаар шийдвэрлэсэн байна⁸.

Үүнээс аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 32 шийдвэр буюу 52,5 хувийг хэвээр үлдээж, 16 шийдвэр буюу 26,6 хувийг өөрчилж, 12 шийдвэр буюу 19,6 хувийг нь хүчингүй болгож

⁷ Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тайлан. УБ., 2022 он.

⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн жилийн тайлан. УБ., 2022 он.

шийдвэрлэсэн байна. Үүнийг задалж үзвэл 16 шийдвэрт өөрчлөлт оруулснаас, 2 хэргийг нотлох баримт буруу үнэлсэн, 14 хэргийг хууль буруу хэрэглэсэн гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулсан байна. Харин анхан шатны шүүхийн 12 шийдвэрийг хүчингүй болгосноос нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг буюу бүхэлд нь хангасан 1 хэрэг, анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан 9 хэрэг, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон 1 хэрэг, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 1 хэрэг байна. Дээрх 60 захиргааны хэргийг маргааны төрлөөр нь авч үзэхэд ажлаас халсан маргаан 37 буюу 61,6 хувиар нэгдүгээрт, сонгон шалгаруулалттай холбоотой маргаан 13 буюу 21,6 хувиар хоёрдугаарт орж байна⁹.

Маргааныг ажлаас халсан, албан тушаал бууруулсан, сонгон шалгаруулалт, сахилгын шийтгэл хүлээлгэсэн, бусад гэсэн 5 төрөлд ангилсан. Бусад гэсэн төрөлд сум, баг, дүүргийн Засаг даргын нэхэмжлэлтэй буюу Засаг даргаас огцруулсан маргаан болон Монгол Улсын Тэргүүн шадар сайдын нэхэмжлэлтэй ТАЗ-д холбогдох маргаануудыг оруулсан болно.

Нийт 43 захиргааны хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, 6 захиргааны хэрэгт нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, үлдсэн 11 захиргааны хэрэгт нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Үүнээс ажлаас

халсан нийт 3 маргаан байснаас 28 буюу 75,6 хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, ажлаас халсан шийдвэрийг хууль бус хэмээн хүчингүй болгож, ажилд нь эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговрыг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Харин 4 захиргааны хэрэгт нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн боловч нэхэмжлэлийн гол шаардлага буюу ажилд эгүүлэн тогтоолгох шаардлагыг нь хангасан байна. Үлдсэн 5 захиргааны хэргийн хувьд ажлаас халсан нь хууль зүйн үндэслэлтэй, хууль зөрчөөгүй байна гэж шийдвэрлэсэн байна.

Ийнхүү ажлаас халсан шийдвэрийг хууль бус хэмээн хүчингүй болгож, ажилд эгүүлэн тогтоож шийдвэрлэж байгаа нь нэг талаас үнэхээр удирдах албан тушаалтан өөрийн үзэмжээр, хууль бусаар ажлаас халсан байхад, нөгөө талаас төрийн байгууллага, түүний удирдах албан тушаалтан буюу дарга нь ажлаас халсан шийдвэр гаргахдаа тухайн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтыг огт хэрэглэхгүй байх, буруу хэрэглэх явдлаас хамаарч байна. Иймээс төрийн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн тухай маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр төрийн байгууллага түүний удирдах албан тушаалтны шийдвэрийг хууль бус гэж тооцсон агуулгаар ихэвчлэн гардаг байна.

⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн жилийн тайлан. УБ., 2022 он.

Мөн түүнчлэн ажлаас төрийн жинхэнэ албан хаагч халагдсан чөлөөлөгдсөнтэй холбоотой төрийн албаны маргааныг хэрхэн шийдвэрлэсэн, захиргааны акт гаргахдаа ямар ямар хуулийн зүйл заалтыг ашиглаж шийдвэрлэснийг хүснэгтэд оруулж нарийвчлан авч үзье.

Дээрх судалгаанаас үзэхэд Төрийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, 46.2.5, 47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалтад заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлсөн, халсан захиргааны актын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний практик, бусад нөлөөлөх хүчин зүйлсийг судлан дүн шинжилгээ хийж, төрийн албанаас халж, чөлөөлөх дээрх хууль зүйн үндэслэлийг нэгдмэл байдлаар ойлгож, хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх зайлшгүй шаардалага бий болж байгаа юм¹⁰.

Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн тоо, түүнд төрийн албаны маргаантай хэргийн эзлэх хувь хэмжээний харьцуулалт

	2018	2019	2020	2021	2022
Шийдвэрлэсэн нийт хэрэг	891	961	1106	1187	1439
Төрийн албаны маргаан	139	133	203	295	400
Нийт хэрэгт эзлэх хувь	15.6%	13.8%	18.4%	24.9%	27.8%

Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэгт төрийн албаны маргаантай хэргийн эзлэх хувь дунджаар 16 орчим хувь буюу газрын маргаантай хэргийн дараа ордог байсан бол сүүлийн 2 жилд эрс өсч 26 орчим хувьд хүрч хамгийн их гарсан маргаан болжээ¹¹.

2004 оноос захиргааны хэргийг давж заалдах шатны журмаар Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим хянан шийдвэрлэж байсан бөгөөд 2015 онд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулагдан үйл ажиллагаа явуулсан. 2019-2023 онд захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр хянагдсан хэргийн үзүүлэлтээс харахад 3 жилийн хугацаанд хянагдсан 1000 хэргийн 25 хувь нь газрын маргаан, түүний дараагаар 18 хувь буюу 175 хэрэг төрийн албаны маргаан эзэлж байгаа нь анхан шатны журмаар шийдвэрлэгдэж буй захиргааны нийт хэрэгт төрийн албаны маргааны эзлэх хувиас илүү байна.

Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй төрийн албан хаагчийн маргаантай хэргээс харахад ихэвчлэн Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1-д заасан хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /3 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн үндэслэлээр төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас халсан, 48 дугаар зүйлийн 48.1.4-т заасан төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах

¹⁰ <http://www.shuukh.mn/>

¹¹ <http://www.judoinstitute.mn/>

сахилгын шийтгэл ногдуулсан, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог зарласан, сонгон шалгаруулалт явуулсан, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4-т зааснаар төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, орон тоо, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн шалтгаанаар албан тушаалын орон тоо хасагдсан үндэслэлээр албан тушаалаас чөлөөлсөн, төрийн албан хаагчийн эрхзүйн байдлыг тусгайлан зохицуулдаг салбарын хуулийг баримтлан төрийн албанаас халсан, сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэртэй холбоотой маргаан шийдвэрлэгдэж байна.

Түүнчлэн төрийн тусгай албан хаагчдын эрхзүйн байдлыг салбарын хуулиар нарийвчлан зохицуулдагтай уялдан салбарын хуулиар төрийн албан хаагчийг албанаас халсан тохиолдол ч байна. Энэ тохиолдолд шүүх шийдвэрлэхдээ төрийн жинхэнэ албан хаагчийн эрх байдлыг зохицуулсан Төрийн албаны тухай хуулийн заалтыг баримтлах эсэхэд өөр өөрөөр дүгнэж шийдвэрлэжээ.

Жишээ: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 286 дугаар шийдвэрт "гаалийн улсын байцаагч нь төрийн тусгай албан хаагч буюу төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд ... төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа эхлэх, дуусгавар болгохтой холбоотой харилцаа болон уг албан тушаалыг эрхэлсний

төлөө үндсэн болон нэмэгдэл баталгаагаар хангагдах нөхцөлийг Төрийн албаны тухай хуулиар тодорхойлно. Мөн Гаалийн ерөнхий газрын даргын 2018 оны 222 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.14-т "ажилтныг албан тушаалаас нь бууруулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халахдаа Гаалийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 45-48 дугаар зүйлд заасан үндэслэлээр шийдвэрлэхээр" тусгажээ. Гэтэл төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгохдоо түүний эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлсон хуулийг баримтлалгүй, "гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх үүргийг тодорхойлох, ... –тэй холбогдсон харилцааг зохицуулсан" Гаалийн тухай хуулийг дангаар нь баримталсан нь буруу" гэж дүгнэсэн байна.

Төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөх эрх бүхий этгээд, түүнд зөвлөх чиг үүрэгтэй этгээд эрх зүйн мэдлэг дутмагаас хуулийг буруу хэрэглэсэнтэй холбоотой маргаан нэлээдгүй байна.

Дүгнэлт. Энэхүү сэдвийн хүрээнд төрийн албатай холбоотой маргаан тэр дундаа ажлаас халсан, чөлөөлөгдсөнтэй холбоотой маргаан, уг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлыг судлав. ТЖАХ-тай холбогдсон асуудлаар гарсан маргаан нь захиргааны эрх зүйн маргаанд хамаардаг. ТЖАХ-тай холбогдсон асуудлаар гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь бусад төрлийн маргааныг шийдвэрлэх ажиллагаанаас онцлогтой. Учир нь уг маргаан нь тухайн захиргааны актыг гаргасан албан тушаалтны шууд харьяалах дээд шатны захиргаа бус, харин хөндлөнгийн хараат бус, бие даасан байгууллага болох ТАЗ, түүний салбар зөвлөл хянан шийдвэрлэдэгт оршино.

Төрийн албатай холбоотой маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд шүүхийн шийдвэрийн биелэлтийн асуудал чухлаар тавигдаж байна. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн шүүхийн эцсийн үр дүн болсон "шүүхийн шийдвэр" –ийг биелүүлэхгүй, үл тоох захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнууд байсаар байна. Иймд шүүхийн шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох шаардлагатай.

Төрийн албаны маргаан буюу ТЖАХ ажлаас халагдсан чөлөөлөгдсөнтэй холбоотой гарсан маргаан их байгаа нь дараах хэд хэдэн зүйлээс шалтгаалж байна гэж

үзэж байна. Үүнд:

- Төрийн албан хаагчийн зөрчигдсөн эрхийг хамгаалж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн биелэлт нь "хангалттай" байдаггүй.
- ТЖАХ-ид холбогдуулан хууль бус шийдвэр удаа дараа гаргаад байгаа албан тушаалтантай хариуцлага тооцдоггүй. Ялангуяа хууль бус үндэслэлээр ажлаас халсан шийдвэрийг нь холбогдох байгууллагаас хүчингүй болгосоор байтал дахин хууль бус шийдвэр гаргаж ажлаас халах тохиолдол гарсаар байдаг.
- Улс төрийн шинжтэй. Захиргааны хэргийн шүүх төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг хянах хуулийн зохицуулалттай хэдий ч төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа нь улс төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанаас сайтар зааглагдаж, хязгаарлагдаж чадаагүй. Өөрөөр хэлбэл улс төрийн байгууллага, албан тушаалтан, улсын төрийн бодлого төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд нөлөөлж, оролцож байгаагаас төрийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа нь улс төрийн өнгө аястай гарч, үүний улмаас төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх зөрчигдөж, хуулиар олгогдсон төрийн албан хаагчийн баталгааг эдэлж чадахгүй байна.

- Төрийн албан хаагчтай холбоо бүхий асуудлыг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор тогтоосон хэм хэмжээний актууд буюу дүрэм, журам, зааврын алиныг нь тухайн тохиолдолд хэрэглэхийг мэдэхгүйгээс мөн маргаан нэлээд гардаг байна.

Санал:Төрийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4, 46.2.5, 47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалтад заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлсөн, халсан захиргааны актын хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний практик, бусад нөлөөлөх хүчин зүйлсийг судлан дүн шинжилгээ хийж, төрийн албанаас халж, чөлөөлөх дээрх хууль зүйн үндэслэлийг нэгдмэл байдлаар ойлгож, хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна:

- Төрийн захиргааны албан хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4-т заасан "өөрийн санаачилгаар" гэх үндэслэлээр ажлаас чөлөөлөх үндэслэл нь зөвхөн албан хаагчийн сайн дурын үндсэн дээр, өөрийн хүсэл зоригийн дагуу гаргасан хүсэлт байхыг ойлгож хэрэглэх;
- Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасан бичгээр гаргасан захиргааны

актад тавигдах шаардлагын нэг болох "Захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах" шаардлагыг хангах хүрээнд чөлөөлөгдөх хүсэлт гаргасан албан хаагчийн хүсэлтийг тушаалын үндэслэх хэсэгт дэлгэрэнгүй оруулж хэвших;

• төрийн захиргааны албан хаагчид ажлын байрны дарамт, шахалт үзүүлэх, хүч хэрэглэх зэргээр өргөдлийг нь бичүүлэх, ээлжийн амралттай байх хугацаанд ажлаас нь чөлөөлөх, төрийн албанаас түр чөлөөлөгдөх өргөдөлөө өгөөгүй байхад чөлөөлсөн тохиолдол цөөнгүй байгаа нь судалгааны явцад нотлогдож байгаа тул захиргаа шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн мэдэгдэх, сонсох ажиллагааг явуулах үүргээ биелүүлэх, захиргааны дотоод хяналтын системийг сайжруулах шаардлагатай байна.

• "энэ хуульд заасан бусад үндэслэл" гэдэгт Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д заасан "Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан...48.1.3-т заасны дагуу "төрийн албанаас халах";

65 дугаар зүйлийн 65.9-д заасан “Энэ хуулийн 65.8-д заасныг зөрчсөн албан тушаалтныг төрийн албанаас халах үндэслэл болно” гэснийг хамааруулж ойлгох;

- Төрийн албаны тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д зааснаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас халах” болон 49.2-т зааснаар “Төрийн албаны тухай хуулийн 62.1.2, 62.1.3-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг зөрчиж төрийн албанаас халахыг хориглох;
- Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.4-д заасан “энэ хуульд заасан бусад үндэслэл”, 49 дүгээр зүйлийн 49.1-д заасан “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэх хоёр үндэслэлийг ялгамжтай хэрэглэх.
- Төрийн захиргааны албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, халах шийдвэр гаргахдаа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдүүдэд урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах зарчмын дагуу мэдэгдэх, сонсох ажиллагаа явуулах, тайлбар, саналыг авах замаар шийдвэрийн бодит үндэслэлийг тогтоох ажиллагааг заавал хэрэгжүүлэх;
- Шийдвэрийн үндэслэл болсон

үйл баримтыг нотолгооны эх сурвалжид үндэслэж үнэлсний үндсэн дээр шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг ялгамжтай зөв хэрэглэх;

- Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдүүдэд шийдвэр гаргахтай холбоотой мэдээллийг урьдчилж өгөх, шийдвэрийн үндэслэл, нотолгоотой холбоотой тайлбар хүсвэл тайлбарлаж өгөх захиргааны үүргийг хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Гаргасан шийдвэрээ хуульд заасан хэлбэрээр хуульд заасан хугацаанд мэдэгдэх.
- Захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь төрийн албан хаагчийн оролцоог боломжтой бүх хэлбэрээр хангах;
- Эрх ашиг нь хөндөгдөж буй албан хаагчид шийдвэрийн үндэслэл болж буй үйл баримтын талаар нотлох баримт, холбогдох баримт бичгийг гаргаж өөрийгөө хамгаалах нөхцөл боломжоор бүрэн хангах;
- Захиргааны актад шийдвэрийн бодит үндэслэл болон хууль зүйн үндэслэлийг тодорхой дурьдаж байх;
- Захиргааны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлыг хэнд хандан ямар хугацаанд гаргах эрхтэй болох талаар захиргааны актад заавал тусгах.

Эх сурвалжийн жагсаалт.

Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

Төрийн албаны тухай хууль. УБ., 2019

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2016

Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч хянан шийдвэрлэх журам. УИХ –ын 2019 оны 20 дугаар тогтоолын хавсралт

Эрдэнэцогт.А, Монгол Улсын захиргааны процессын эрх зүй. УБ.,2006

Одгэрэл.П, Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2008

Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг, Ханнс-Зайделийн сан, УБ., 2004

Төрийн албаны тухай: эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ.,2011

Х.Батсүрэн, Л.Өлзийжаргал, “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт, тулгамдсан асуудал” Шударга ёсны хэмжүүр сэтгүүл, 2 дугаар улирал.УБ., 2011

Д.Халиунга, “Хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухайд...” Шударга ёсны хэмжүүр сэтгүүл, УБ. 2013.06 сар. дугаар 02/11

www.legalinfo.mn

www.csc.gov.mn

www.judcouncil.mn

www.judoinstitute.mn

www.shuukh.mn

www.admincourt.gov.mn

ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛЫН ЭРГЭН ТОЙРОНД



Шихихутуг их сургуулийн
магистрант Н.Болдбаатар

Өнөөдөр манай улсад дахиад л Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг саналыг УИХ, Засгийн газар гаргаж, иргэдийн дунд болон олон нийтийн мэдэллийн хэрэгслээр байнга яригдаж байна. Үндсэн хуулийн нэр барьж төрийн өндөр албан тушаалд өргөмжлөгдөөд эрх тушаал эзэлмэгц эргээд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт ярьж, Монгол төрийн үндэс болсон Үндсэн хууль руугаа дайрч эхэлдэг нь гэм биш, харин бүр зан зуршил болж байгаа нь маш харамсалтай. Үүнийг манай гавъяат хуульч, анхны ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригчдын нэг Б. Чимэд агсан ийм авир гаргаж байгаа төрийн дээд албан тушаалтнуудад хандан "Амар байна уу гэсэн биш, гай болов"¹ гэж өгөөдсөн нь бий.

Манай улсад нэг биш удаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийж байсан түүхтэй. 1996-2000 оны

сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд парламентад суудалтай (олонхи, цөөнх) гурван намын бүлэг "үгсэн" Үндсэн хуульд оруулсан "нэмэлт, өөрчлөлт" буюу "дордуулсан долоон заалт"-уудад "давхар дээл"-ний асуудал орсон байсан. Үүнийг Б.Чимэд агсан "Засаг төр нь ард түмнээ залилан мэхэлж болохгүй шүү дээ!"² гэж онцгойлон анхааруулж байжээ. Тэрээр "Уг нэмэлт, өөрчлөлт сайжруулсан" бол ч яриад байх юм алга. Гэтэл хүний эрхийг хангах гол баталгаа, өөрөөр хэлбэл, засаг төрийн байгууллагын зүгээс хүний эрх зөрчихөөс сэргийлэх гол үндэслэл болсон төрийн эрх мэдэл хуваарилах зарчимд нийцэхгүй байгааг одоо хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болсон. Ялангуяа Парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг "үнээ, тугал нийлүүлсний" адил хольж хутгасан нь цөөн гишүүнтэй парламент, харьцангуй олон гишүүнтэй Засгийн газар хоёрын харилцан хяналт тавьж, сөрөн зогсож, тэнцвэржих зарчимд үнэхээр харшилж байна"³ гэж бичиж байсан. Мөн төрийн либерал онол, эрх мэдлийг хуваарилах онолыг үндэслэгч Ш.Монтескьегийн "Парламент, Засгийн газар хоёрыг нийлүүлбэл эрх чөлөөний тухай ярилтгүй, ... нэгэнт эрх чөлөөгүй нөхцөлд шударга шүүх оршихгүй"⁴ гэсэн ишлэлийг татсан байдаг.

¹ Б.Чимэд "Үндсэн хуулийн үзэл баритлал. Нийтлэг асуудал" нэгдүгээр дэвтрийн 178 дахь тал.

² Мөн тэнд. 192 дахь тал.

³ Мөн тэнд.

⁴ Мөн тэнд 191 дэх тал.

Парламент, Засгийн газар хоёрын бүрэлдэхүүнийг хольж, улмаар нам, төрийн ажил үйлсийг хутгах үндсийг тавьсан, мажоритари зарчмыг үгүйсгэсэн, парламентын тасралтгүй, байнгын ажиллагааг сулруулсан зэрэг өдгөө нэлээд мэдрэгдэж байгаа өөрчлөлтийн сөрөг талыг тэрээр урьдчилан харж, мэдэрсэн байдаг. “Газрын ойр, гайны бага дээр нь” гэдэгчлэн засаж залруулаасай, “дахин ийм юм бүү тохиолдог гэж л залбирахаас өөр яах билээ”⁵ гэж Б.Чимэд агсан дуу алдсан байдаг.

Ийнхүү Б.Чимэд агсан бурхны орноос сануулга, анхаарал сануулга өгсөөр байтал урьд гаргаж байсан алдаагаа давтан 2022 оны 8-р сарын 15-ны өдөр Цэц нь Парламент ёсны орчин үеийн “хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололт” Ерөнхий сайдын засгийн газрын гишүүдээ томилох өөрийн “онцгой бүрэн эрх” гэгчийг иш үндэс болгон, тогтоол гаргасан байдаг. Энэ тогтоол нь Ерөнхий сайдад “онцгой бүрэн эрх” гэгчийг олгон, бүр Үндсэн хууль болон түүний шүүх нь төрийн эрх мэдлийг хязгаарлах, ард түмний эрхийг хамгаалах цорын ганц гол үүрэгтэйгээ умартан, “хууль тогтоох”, “гүйцэтгэх” эрх мэдлүүд ахиад нэгтгэж, УИХ-ийн гишүүддээ “давхар дээл” өмсүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Цэцийн энэ тогтоолд “төрийн эрх мэдэл хуваарилах” онолыг үгүйсгээд, шинээр ерөнхий сайдын “онцгой бүрэн эрх” гэдэг Үндсэн хууль болон түүний зарчмаас дээд

хүчин чадалтай категорийг оруулж ирсэн байдаг.

Ингээд 2022 оны 8-р сард УИХ-аас ээлжит бус чуулганыг сэмхэн зарлан хуралдуулж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт нь дахин оруулж, “Үндсэн хуульт ёс” -ны суурь зарчим болох төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг зөрчин, дахин УИХ-ын гишүүдэд “давхар дээл” өмсөгчихлөө. Английн ардчилсан үзэлтэн Жон Лильберн төр бол хүний “заяагдсан” эрх, эрх чөлөөг хангахын тулд муу зүйл, хорлолын эх уурхай болсон төрийг хязгаарлах ёстой гэж тодорхойлсон. ... төрийн гурван эрх мэдлийг янз бүрийн байгууллага хүмүүс хэрэгжүүлсэн тохиолдолд дур зоргыг устгаж, удирдлагын өөрийн нь бат бэх байдлыг хангаж чадна. Тэрээр “Засгийн газар, шүүх төдийгүй мөн парламент ард түмний зарц байх ёстой”⁶ гэжээ. Харин манай улсад төрийн эрх мэдэлд хүрсэн бүхэн эрх мэдэлд шунаж, ард түмэн төрийн эрх мэдлийн эх сурвалж болохыг умартан, бүгд л “хязгааргүй эрх мэдэл”-ийн төлөө явж байна. Манай эрдэмтэн судлаачид нийгмийн хөгжил гэдгээр түрүү барьж, бүхнийг өөрчлөн гэсэн зарчим байж болохгүй. Үндсэн хуулийн тогтвортой байдал болон түүний цаг үетэй нийцүүлэн өөрчлөн шинэчлэх шаардлага хоёрын хоорондын зохицлыг зөв олох нь эрх зүйн хөгжлийн хамгийн чухал бас эмзэг асуудал юм гэдэгтэй бүгд санал нэгддэг.

⁵ Лүндээжанцан.Д. Монгол дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014. 33 дахь тал.

⁶ Мөн тэнд. 192 дахь тал.

Б.Чимэд агсан Монгол улсын Үндсэн хууль бол "... засаг төрийн дур зоргыг хязгаарласан, шударга ёсны төлөө ... улсын гол хууль мөн"⁷ гэж тодорхойлсон байдаг. Харин манайд эсрэгээрээ ерөнхий сайдынхаа эрх мэдэл, "дур зоргыг" бүр "онцгой" болгон нэмэгдүүлээд байна. Монголын төр, ард түмэн, Монголын түүх "онцгүй, бүрэн эрхэт комисс"-ын гэдэг "онцгой" нэгний эмэгнэл, хэмэгдүүлэлтийг мартаагүй байгаа. Ер нь ерөнхий сайдын эрх мэдэл бага уу? Бид ерөнхий сайд нарын дур зоргоороо хийж, улс орон, ард түмэнд маш их хор хохирол учруулсан "Дубайн" гэрээ, "Эрдэнэтийн" гэрээнүүдийг мартаагүй байх гэж найдъя. Хэрэв энэ гэрээнүүд хүчингүй болоогүй тэр чигээрээ үйлчилж байсан бол монголчууд бид "ковидын цар тахал"-ыг яаж давах байсан, одоо Монгол улсын маань эдийн засаг ямар байхыг төсөөлөх аргагүй байна.

Энэ зөрчигдөөд байгаа төрийн эрх мэдэл хуваарилах зарчим дээр тогтож тайлбар хийе. Манай улс нэгдэн орсон Хүний эрхийн тунхаглалын 16 дугаар зүйлд "... Үндсэн хууль нь бусад хууль, төр засгийн дүрэм, журмаас дээгүүр тавигдаж, тэдгээрийн эх сурвалж байж, хувь хүмүүсийн эрх, эрх чөлөөний баталгаа болох ёстой. Учир нь Үндсэн хууль нь ... төрийн эрх мэдлийг оновчтой хуваарилсан, бичгээр баталгаажуулсан эх

бичвэр юм"⁸ хэмээжээ. АНУ-ын Үндсэн хуулийг үндэслэгчдийн нэг Т. Жефферсон "Төрийн эрх мэдлийн бүрэн эрх нь засаг төрийн байгууллагуудын хооронд аль нэгнээ хууль ёсны эрх мэдлээ хэтрүүлж чадахгүйгээр, харилцан үр нөлөө бүхий хянаж, бие биенээ тогтоон барьж байхаар зохион байгуулагдах ёстой"⁹ гэжээ. Америкийн улс төр судлаач А.Вандербилт эрх мэдлийг хуваарилах нь чөлөөт удирдлагын хамгийн чухал зарчим гэж тэмдэглэсэн байдаг. Хувь хүний эрх чөлөө, иргэншлийн дэвшил нь төрийн эрх мэдлийн гурван салаа бүгд энэ зарчмыг хэрэгжүүлж чадсан нөхцөлд л хүрч чадна¹⁰ гэдгийг тэрээр баталжээ. Францын төр судлаач М.Дюверже "Үндсэн хуулийн бүх заалтуудыг бүх засаглагчид дагаж мөрдөнө. Засаглагчид Үндсэн хуульд өөрчлөлт хийх эрхгүй, харин түүнд бүх үйл ажиллагаа нийцүүлнэ" гээд Үндсэн хуулийн энэ онцгой шинжийг "Үндсэн хуулийн үлэмжийн чанар"¹¹ гэж нэрлэжээ. Д.Гангаабаатар "Үндсэн хуулийн эрх зүй" гэдэг гомондоо "... ҮХ-ийн бичвэрт илт тусгагдаагүй төрийн эрх мэдэл хуваарилах зарчим ч ҮХ-ийн эрх зүйн эх сурвалжид тооцогддог"¹² гэж тэмдэглэсэн байна. Төрийн эрх мэдлийн хуваарилалт Үндсэн хууль орших баталгаа гэдэг аксиом өдгөө

⁸ Хүний эрхийн тунхаглал.

⁹ Лүндээжанцан Д. Монгол дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014. 45 дэх тал.

¹⁰ Мөн тэнд. 49 дэх тал.

¹¹ Лүндээжанцан Д. Монгол дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2014. 59 дэх тал.

¹² Гангаабаатар Д. Үндсэн хуулийн эрх зүй. 54 дэх тал.

⁷ Б. Чимэд "Үндсэн хуулийн үзэл баримтлал. Нийтлэг асуудал" нэгдүгээр дэвтрийн 101 дахь тал.

нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үндэслэл болсон тул тухайн улс оронд үндсэн хуульт ёс хэрэгжиж байгаа эсэхийг шалгах нэг гол шалгуур болсон байна.¹³

УИХ, Засгийн газар, шүүх гэсэн төрийн гурван эрх мэдэл хуваарилах зарчмын үндсэн дээр өөрсдөө байгуулдаг. Хэрэв энэ зарчмыг үгүйсгэж байгаа бол хууль тогтоох эрх мэдэл УИХ өөрөө бусад төрийн эрх мэдлүүд оршин байх үндэсгүй. Дэлхий дахинаа төрт ёсны үндэс суурь гэж үздэг энэ зарчмыг үгүйсгэснээрээ УИХ оршин байх хууль эрх зүйн үндэсээ үгүйсгэлээ. Энэ зарчмын үндсэн дээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван эрх мэдлийг бий болгодог бөгөөд энэ зарчим даян дэлхийн Үндсэн хуульт төрүүдийн эрх зүйн эх өв, сурвалж болдог юм.

Одоо хууль тогтоох эрх мэдэл буюу УИХ дээр тогтож ярьа. Ардчилсан ёсны зарчим гэдэг бол парламент бусад эрх мэдэлтэй харьцуулахад давуу эрхэдэлнэ гэсэн хэрэг биш, нөгөө талаас төрийн бүх эрх мэдэл Үндсэн хуульд захирагдах бөгөөд олонхийн саналаар ч парламент нь Үндсэн хуулийг давж гарах эрхгүй байдаг¹⁴. Парламент ёс гэдгийг яаж тодорхойлсон байдгийг авч үзье. ОХУ-ын хууль, эрх зүйн нэвтэрхий толинд "Парламент ёс бол төрийн эрх мэдлийг хуваарилах, хууль дээдлэх зарчимд тулгуурлан

байгуулагдсан бүтэц бөгөөд нийгэмд нийгмийн шударга ёс бий болгох, хөгжүүлэх зорилгоор хууль тогтоох, хяналтын эрх бүхий парламент нь тэргүүлэх үүрэгтэй байх, төрийн дээд эрх мэдлийг зохион байгуулах онцгой ардчилсан тогтолцоо юм"¹⁵ гэсэн байна. Энэ тодорхойлолтоос парламент ёс буюу өөрөөр хэлбэл парламент нь эрх мэдэл хуваарилах, хууль дээдлэх ёс гэсэн зарчмууд тулгуур дээр үндэслэн бий болж, байгуулагддаг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл УИХ өөрөө, өөрийнхөө оршин байх хууль эрх зүйн үндэс сууриа үгүйсгэлээ. Товчоор УИХ өөрөө, өөрийгөө үгүйсгэлээ. Монголын төрт ёсыг үгүйсгэлээ. Дэвшилтэт хүн төрөлхтний оюун санаа эх өвийг үгүйсгэлээ.

УИХ нь засгийн газраа нэгтгээд шингээчихсэн, Үндсэн хуулийн Цэцийн үйл ажиллагаа нь үндсэн хуулийнхаа шүүхийн дэлхийн жишиг үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон. Ийм нөхцөлд төрийн бүх бүрэн мэдэл УИХ-д л төвлөрсөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Манай монголчууд ярьдгаар "эврээ ургахаараа (манай энэ тохиолдолд эрх мэдэл нь хэмжээ хязгааргүй болохоороо) эхийгээ мөргөх" гэдэг болж байна. Бүр эрх дарх нь хязгааргүй болохоороо эхийгээ мөргөөд бүр алах дээрээ тулдаг юм байна. Томас Жеффорсон «АНУ-ын тусгаар тогтнолын тунхаглал»-д хүнд салшгүй эрх байдаг бөгөөд түүнийг хамгаалахын тулд төр

¹³ Ч. Өнөрбаяр. Хууль дээдлэх ёс.

¹⁴ Р.Меллингхофф. Үндсэн хуулийн шүүх улс төр, ердийн шүүхийн тогтолцооны зөрөлдөөний тал-барт. Монголын төр, эрх зүйн сэтгүүл. УБ., 2004. 25 дахь тал.

байгуулагдсан гэдгийг тунхагласан. Тунхаглалд тусгаснаар хүний жам ёсны эрх нь төртэй холбоотой хувь хүний субъектив эрх болж хувирсан. Төрийн энэ сургаал нь хүний эрхийг төр л хангах ёстой гэж үзсэн цоо шинэ үзэл санаа байсан. Энэ үзэл санаа нь бүх дэлхийн нийтээрээ хүлээн зөвшөөрч мөрддөг болсон эрхэм дээд үзэл санаа юм. Манай улс энэ үзэл санааг уг нь Үндсэн хуулиндаа "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна."¹⁶ гээд биччихсэн байдаг.

Ш.Монтескье "Хуулийн амин сүнс" гэдэг номондоо "Хэрэв хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгдвэл эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд хууль тогтоогчид дарангуйлагч хуулийг тогтоож, дарангуйлал үүснэ"¹⁷ гэсэн нь биелэлээ олж байх шиг. Ийм нөхцөл хүний эрх, эрх чөлөө, ардчилал болон бусад Монгол улсын Үндсэн хуулийн зарчмуудын хэрэгжилтийн тухай ярих хэрэггүй, ер нь тэдгээрийг ярьж, дурсаад хэрэггүй болсон. Эдгээр эрхэм дээд Үндсэн хуулийн зарчмууд хөөрхийс хий хоосон зүйл, тунхаг болжээ. Англи-Германы философич Р.Дарендорф "1989 оны дараахь: Ёс суртахуун, хувьсгал, иргэний нийгэм. Европ дахь хувьсгалын талаархи эргэцүүлэл" гэдэг бүтээлдээ «Хувь хүн бүр энгийн хэрэгцээ хангаж чадахгүй, айдас хүйдэстэй амьдарч байхад үндсэн хуулиар олгогдсон эрх нь

хоосон амлалт, бүр эрх мэдэлтүүд нь эрх ямбаа хаацайлах гэсэн арга заль хэвээр байна»¹⁸ гэж бичсэн нь манай улсад ийнхүү биелж байх шиг.

Төрийн эрх мэдэл хуваарилах зарчмаас гадна төрийн эрх мэдлийг хязгаарлах бусад механизмууд ард түмний олон зуун жилийн тэмцлийн дүнд бүрэлдэн бий болсон байдаг. 18-р зуунд Өрнөдийн философич, хуульчид «төр засгийн хамгийн сайн хэлбэр нь иргэдэд тодорхой, хамгийн их ойлгомжтой хуулиар удирдах ёстой» гэсэн санааг дэмжиж, дур зоргоороо, хэмжээгүй эрхт, дарангуйлах үзэл санааг бүх нийтээр буруутгаж, үгүйсгэсэн байдаг. А.Гамильтона, Дж. Мэдисона болон Дж. Джей нар "Холбооны төрийг дэмжигч" гэдэг бүтээлдээ Америкт анхны Үндсэн хууль батлагдсаны дараа Америкийн төлөөлөгчдийн танхим «хуулийн үр нөлөө нь нийгмийн бүх давхаргад биш, зөвхөн өөрсдөдөө болон найз нөхөддөө шууд нөлөөлөх» хууль батлах боломжийг хаасан байдаг.¹⁹ Энэ үзэл санаа тухайн үедээ Англи, Пруссийн хууль эрх зүйн сургаалд бүрэн тусгалаа олжээ. Энэ үзэл санаа нь одоо бүх улсууд дэлхий нийтээрээ хууль тогтоох байгууллагууд мөрддөг «бүх нийтийн хэрэглээний ерөнхий хуулиуд»-ын зарчим болсон бөгөөд

¹⁶ Дарендорф Р. Современный социальный конфликт. Очерк политики свободы. М., "Российская политическая энциклопедия" (РОССПЭН), 2002. С. 64.

¹⁹ Федералист. Политические эссе А. Гамильтона, Дж. Мэдисона и Дж. Джея: Пер. с англ./Под общ. ред. Н. Яковлева.—М.: Издательская группа «Прогресс»-«Литера», 1994. С. 381.

¹⁶ Монгол улсын Үндсэн хууль.

¹⁷ Монтескье Ш. "Хуулийн амин сүнс". УБ., 2022. 14 дэх тал.

нийтээрээ мөрддөг байдаг. Манайд УИХ нь Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулаад “өөрсдийгөө”, гишүүдээ сайдад томиллоо. Монгол улсын засаг төр, УИХ хаана, ямар цаг үед амьдраад байна аа? Уг нь дэвшилтэт хүн төрөлхтний жишгээр гээд гол эх хуулиндаа биччихсэн байгаа.

Одоо бүр өөрсдийнхөө тоог нэмэхээр санаархаж байна. Төрийн эрх мэдлийн эх сурвалж ард түмний эрхийг хүндэлж, үндсэн хуульт ёсны үзэл баримтлалаа мөрдмөөр байна. Хэдэн “гишүүн” тэжээхийг тэднийг тэжээх АРД ТҮМНИЙ сонгох эрхэнд үлдээ л дээ. Энэ болон бусад олон Үндсэн хуультай холбоотой асуудлуудыг УИХ-ын сонгуультай зэрэгцүүлэн ард нийтийн санал асуулга замаар л шийдчих ёстой. Италийн сэтгэгч Марсили Падуанский “Энх тайвныг хамгаалагч” гэдэг бүтээлдээ ард түмнийг төрийн эрх мэдлийн эх сурвалж, дээд хууль тогтоогч гэж нэрлэсэн байдгийг сануулъя. Уг нь Үндсэн хууль бол төрийн эрх мэдлийг хуваарилан, хязгаарлаж, ард түмний эрх, эрх чөлөөг л хамгаалах гол үүрэгтэй нийгмийн гэрээ. Английн философич, социологич Г. Спенсер “Ард нийтийн санаа хүсэл, асуудалд анхаардаггүй, улмаар «хор хөнөөл» авчрах хууль тогтоомжийг баталдаг ард түмний төлөөлөгчдийн шударга бус байдал «хууль тогтоогчдын нүгэл, хилэнц» болон ... олон тооны хязгаарласан үйлдлүүд нь ард түмнээс сонгогдсон институцээс

гаралтай гэдгээр зөвтгөгдөх боломжгүйг”²⁰ анхааруулсан байдаг.

Асуудлын гол нь хууль тогтоох эрх мэдэл УИХ-ын ард түмний эрхэнд халддаг хууль бус үйлдлийн эх сурвалж хаана байна. УИХ-ын гишүүд, ТАХ, ард түмний хууль эрх зүйн мэдлэг чадвар дундаас доош байгаад асуудал байна гэж судлаач миний хувьд харж байна. Эндээс УИХ-д нэр дэвшигчдийн хувьд нас, мэдлэг чадвар, боловсролын мөн эх орондоо амьдарсан хугацаа зэрэг босго тавих шаардлагыг бодитоор бий болгож байна. Ж.Локкын “Ард түмэн хувь хүн, байгууллагад эрх мэдлийг олгодог төдийгүй бас эргүүлж авдаг байх ёстой”²¹ гэсэн үгийг энд ишэлье. Дараагийн асуудал нь Үндсэн хуулийг судалдаг хууль зүйн шинжлэх ухааны баримталж байгаа үзэл баримтлал нь хоцрогдсонтой холбоотойгоор Үндсэн хуулийн талаарх мэдлэг, мэдээлэл муу байна.

Монгол улсад хууль эрх зүйн сургуулиудад “Үндсэн хуулийн эрх зүй” гэдэг хичээлийг заадаг. Энэ хичээлээр ерөнхийдөө Үндсэн хуулийн эх сурвалж болдог хүн төрөлхтний түүхэн хөгжлийнхөө туршид төрийн эрх мэдлийг хязгаарлах, түүний дур зоргоос ард түмний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн олон үнэт зүйлс, зарчмуудыг дөнгөж дурьдаад, харин одоо мөрдөж байгаа бичмэл Үндсэн

²⁰ Спенсер Г. Личность и государство. СПб., “Вестник знания”, 1908. С. 13-14.

²¹ Локк Дж. Сочинения: в 3-х т. М., 1985. Т. 1. С. 182.

хуулиа тайлбарлаж танилцуулахад чиглэгдсэн байдаг. Оксфордын улс төрийн шинжлэх ухааны профессор Л.Зидентоп "Европын ардчилал" гэдэг номондоо Үндсэн хуулиудыг мөсөн уултай зүйрлэсэн бөгөөд тэдгээрийн хамгийн чухал ач холбогдолтой, том хэсэг нь усан дор нуугдаж байдаг. Тэдгээрийг судалж үзэхэд «Тухайн Үндсэн хуулийн бичмэл текстэд заасан зарчим, заалтыг ойлгоход маш хялбар мэт байдаг ч харин текстийг хүчин төгөлдөр Үндсэн хууль болгодог, бүр эсрэгээрээ үнэ цэнэгүй болгож чадах эрх зүйн үнэт зүйлс, зарчим, зан заншлыг судлах нь илүү хэцүү байдаг»²² гэсэн байна. Тэгэхээр бид Үндсэн хуулиа судлахын тулд "мөсөн уул"-ын оройг биш харин усанд байгаа тэр чухал, том хэсгийг судлах ёстой болж байна. Өнөөдөр энэ "мөсөн уулын" доод том, их ач холбогдолтой хэсгийг судалдаг "конституционализм" буюу "Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал" гэдэг шинэ үндсэн хууль судлалын салбар шинжлэх ухаан үүсэж, хөгжөөд нэгэн зуун аль хэдийн өнгөрсөн байна.

Г.Ж.Берманы "Барууны хуулийн уламжлал: үүсэн бүрэлдэх эрин үе" гэдэг номондоо бичсэнээр Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал нь төр бий болохтой зэрэгцэн бий болсон бөгөөд харин энэ нэр томъёог шинжлэх ухааны эргэлтэд 18-р зууны төгсгөл 19-р зууны эхэн үед нэвтрүүлсэн гэж бичжээ.²³ Энэ үзэл

баримтлал нь хууль дээдэлдэг, ардчилсан төртэй холбоотой ойлголт юм. Энэ бол орчин үеийн төрийн эрх зүйн оршин тогтнох чухал шинж чанаруудын нэг гэж үздэг. Түүний үнэт зүйлсэд хүн, түүний эрх, эрх чөлөө, нийгэм соёлын хүрсэн түвшин болон тухайн цаг үеийн шаардлагаас үүдсэн хувь хүний үүрэг, хариуцлага; үндэсний, ард түмний, төрийн болон хувь хүний бүрэн эрхт байдал; ард түмний засаглал буюу ардчилал; парламентаризмын бүх бүрэлдэхүүн хэсгүүд, юуны түрүүнд хууль дээдлэх, төрийн эрх мэдлийн хуваарилах зарчмууд; өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрөх, хамгаалах; үзэл суртлын олон талт байдал, улс төрийн олон ургальч үзэл болон бусад зүйлүүд ордог. Эдгээр тэргүүлэх үнэт зүйлсийг албан ёсны болгож, хуульчлах замаар хууль эрх зүйн дээд хүчин чадалтай хэм хэмжээ болох Үндсэн хуулийг боловсруулан гаргадаг.

Үндсэн хуулийн эрх зүйн орчин үеийн Оросын шинжлэх ухааны төлөөлөгчдийн үзэж байгаагаар Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалыг дараахь зүйлийг агуулсан цогц үзэгдэл гэж тайлбарладаг: а) нийгмийн үндсэн үнэт зүйлийг тусгасан үндсэн хуулийн үзэл санаа, категори; б) иргэд, нийт хүн амын үндсэн хуулийн ухамсар; в) дээр дурдсан элементүүдийн норматив бүтэцтэй илэрхийлэл болдог үндсэн хуулийн хэм хэмжээ, акт, институцүүд; г) үндсэн хуулийн хэм хэмжээг

²² Зидентоп Л. Демократия в Европе. М., Логос, 2001. С. 37-38.

хэрэгжүүлэх үйл явц, төлөв байдал болдог үндсэн хуулийн дэг журам. Б.Н.Топорнинын “Эрх зүйн толь бичиг”-т Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалыг өргөн, явцуу утгаар нь ойлгож болно гэж заасан байдаг. Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал нь өргөн утгаараа үндсэн хуулийн онол, тодорхой улс орон, бүлэг улс орон, дэлхийн хамтын нийгэмлэгийн үндсэн хуулийг баталж, хэрэгжүүлсэн түүх, практик юм. Явцуу утгаараа ардчилсан үндсэн хууль, ардчилсан үндсэн хуулийн онолд тусгагдсан хүн төрөлхтний улс төр, эрх зүйн үндсэн үнэт зүйлс, тэдгээрийн агуулга, хэлбэр, арга, хэрэгжилтийн талаарх мэдлэгийн цогц систем юм.

ОХУ-ын эрдэмтэн Л.В. Сони́на “ОХУ-д Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал нь улс төр, эрх зүйн дэглэм болох нь” гэдэг докторын бүтээлдээ “Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал нь нийтийн (эрх зүйн) үзэл сурталтай харьцуулахад нийгмийн ухамсар, оюун санааны давхаргад гүн гүнзгий нэвтэрч, үүнээсээ үндэслэсэн хууль ёсны болж, нэн шаардлагатай шинжлэх ухаан болохоо хүлээн зөвшөөрүүлэх үе шатыг даван туулсан, нийгэм, төрийн үндсэн хуулийн загварын үндэс суурь юм. Үндсэн хуулийн үзэл санааг хууль ёсны болгох нь тэдний төрийн эрх мэдлийн зөвшөөрөл биш, харин ард түмэн, хувь хүн, олон нийтийн ухамсар үзэл санааг хүлээн зөвшөөрч, хувь хүн, бүлгийн зан үйлийн үр дүнтэй өдөөгч, сэдэл

болгон хувиргах явдал юм»²⁴ гэжээ тодорхойлжээ.

Өнөөдрийн дэлхийн жишгээр аливаа улсын Үндсэн хуультай холбоотой асуудлыг авч үзэхдээ Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалын призмээр харж шалгаж, тайлбарласны дараа л шийдлийг нь хайдаг байна. Манайд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт ярьдаг хүмүүс дээрх үзэл баримтлалын дагуу Үндсэн хуульдаа дүн шинжилгээ хийсэн хүн байна уу? Гаргасан бол дүн шинжилгээгээ ард түмэндээ ил тодоор зарлаж, танилцуулах хэрэгтэй байна. Үндсэн хууль судалгааны энэ үзэл баримтлалыг мэдэхгүй, мэдсэн ч үл огоорсны улмаас Монгол улсын Үндсэн хуульд тусгасан үзэл баримтлалаасаа эхлээд 30-аад жил явуулсан үйл ажиллагаа нь бүрэн дампуурсан субъект бол төрийн гурван салааны нэг болох Үндсэн хуулийн шүүх буюу Цэц юм.

Үндсэн хууль нь төр, ард түмний хооронд байгуулсан нийгмийн гэрээ юм. Энэ гэрээгээр төр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах гол үүргийг хүлээдэг. Манай Үндсэн хуульд зааснаар хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлыг хэлэлцэхгүй зөвхөн төрийн байгууллага, түүний дээд албан тушаалтнуудтай холбоотой болон тэдгээрийн шийдвэр, хэзээ ч зохиогдож байгаагүй ард нийтийн санал асуулга болон сонгуулиудтай

24 Сони́на, Л. В. Конституционализм в Российской Федерации как политико-правовой режим : автореф. дис. ... канд. юрид. наук. Екатеринбург, 2001. С. 7.

холбоотой асуудлыг хянан шийдвэрлэхээр заасан, мөн Үндсэн хуулийг тайлбарлах Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг эрхийг олгоогүй байдал Цэцийн үүрэг чиглэлд маш ойлгомжгүй байдлыг үүсгэн "хулгайн ан" хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Хамгийн гол нь Цэцээс гарч байгаа шийдвэр нь хамгийн эмэгнэлтэй. Шийдвэр нь зөвхөн Үндсэн хуулийн заалтыг заасан тав, арван мөр. Хүн тэндээс уншаад, ухаад ойлгох юу ч үгүй. Харин ардчилал, хууль дээдлэх ёс хөгжсөн орнуудын Үндсэн хуулийн шийдвэр нь Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал буюу үндсэн хуулийг бий болгосон үнэт зүйлсээс, эх сурвалжаас нь шийдвэр гаргаж байгаа асуудлыг авч үзэж тайлбарлаж, эцсийн шийдвэрт хүрдэг байна. Иймээс Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр хэдэн арван хуудсаар тоологдох бөгөөд энэхүү гаргасан шийдвэр, тэр бүү хэл энэ шийдвэрийн талаарх тусгай санал хүртэл Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалд тухайн төрийн оруулсан хувь нэмэр болон энэ үзэл баримтлалыг баяжуулан хөгжүүлж байдаг. Ер нь Үндсэн хуулийн шүүх нь улс төрийн томилгоогоор биш харин Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалыг судалдаг, таниулдаг, сурталчилдаг, баяжуулан хөгжүүлж, төрийн ирээдүйн хөгжлийн чиг баримжааг тодорхойлох үүрэгтэй эрдэм шинжилгээний хүрээлэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалыг төлөвшүүлэхэд өнөөгийн дэлхийн жишгээр Үндсэн хуулийн шүүх, хяналтын байгууллагууд ихээхэн үүрэг гүйцэтгэж, бүр цаашдын хөгжлийн нь тодорхойлоход өөрийн хувь нэмрээ оруулдаг болсон байна. В.А.Кряжков "ОХУ-ын Үндсэн хуулийн соёл Үндсэн хуулийн шүүхийн шударга ёсны толинд" гэдэг бүтээлдээ ОХУ-ын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, эрх зүйн байр суурь, тайлбарын үр дүнд дараахь зүйлийг хангаж ажилладаг гэж бичжээ. 1) ОХУ-ын Үндсэн хуулийн нормативын тайлбар хийж; 2) ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нь хууль тогтоох үйл явцад оролцож (шүүмжлэгчийн байр сууринаас хууль тогтооход); 3) олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээг Оросын эрх зүйн тогтолцоонд тайлбарлах, хэрэгжүүлэх; 4) Үндсэн хуулийн сургаалыг баяжуулж, зөвхөн ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн бодит шийдвэр, хууль эрх зүйн байр сууринд төдийгүй үндсэн хуулийн шүүгчдийн тусгай саналд үндэслэдэг байна.²⁵ Ерөнхийдөө дээд шүүхийн байгууллага, ялангуяа Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн байр суурь нь хууль дээдлэх ёсны сургаал, түүнийг хууль зүйн амьдралд хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болж байна гэж хэлж болно. Үүний зэрэгцээ эргэх харилцаа ч

²⁵ Кряжков, В. А. Конституционная культура в зеркале правосудия Конституционного Суда Российской Федерации // Журн. конституц. правосудия. 2008. № 3. С. 4.

байна. Энэ нь эрх зүйн шинэтгэл, идэвхийг хөгжүүлэхэд хамгийн чухал сургааль, хууль зүйн хэрэгсэл болох төрийн эрх мэдлийн эрх зүйн байдалд нөлөөлөх, үндэсний эрх зүйн болон хууль зүйн практикийг нэгтгэх, тэдгээрт байгаа олон нийтэд үр нөлөөтэй, үнэ цэнэтэй байгаа нийтлэг үнэт зүйлсийг олж, тогтоож, батлах явдал юм.

1996-2000 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Үндсэн хуулинд "нэмэлт, өөрчлөлт"-ийг хийж, УИХ-ын гишүүдэд "давхар дээл" өмсгөсөн байсныг дээр дурьдсан. Энэ өөрчлөлтийг хийхдээ улс төрийн бусад олон нам, ард түмэнд урьдчилан таниулж, санаа бодлыг нь авалгүйгээр гэнэт "маналзуулаад" өөрчилсөн нь яав ч зөвтгөх аргагүй юм гэж шүүмжлүүлж байсан. Цэц энэ өөрчлөлтийг хянан хэлэлцээд процедурын алдаатай хэмээн хүчингүй болгосон. Гэтэл хэсэг Цэцээс хугацааны дараа дахин сэргээсэн бөгөөд үүнийг 2000 онд УИХ-ын өөр бүрэлдэхүүн/МАХН олонх болсон/ үедээ 1999 он/АН олонх байсан/-ы Үндсэн хуулийн цэцийн хүчингүй болгосон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үг үсгийн зөрөөгүйгээр дахин баталж, процедурын зөрчлийг зассан дүрээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Нэг асуудлыг хэсэгхэн хугацааны дараа нь эсрэгээр шийдснийг Б. Чимэд агсан "дэндүү болхи үйлдэл"²⁶ гэж шүүмжилж байсан. Энэ маш зөөлөн шүүмжлэл

юм. УИХ энэ дээрх 1999 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан энэ үйлдлээ "нийгмийн захиалга"²⁷ гэж зарласан. 2022 оны 8-р сард УИХ энэ "дэндүү болхи үйлдэл"-ээ давтлаа.

Үндсэн хуулийн шүүхүүд үйл ажиллагаагаараа ардчилсан нийгэмд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлээд зогсохгүй төрийн инстүүцүүд нэг нэгнээсээ харилцан хамааралтай, тэнцвэртэй, тогтвортой байхын зайлшгүй урьдчилсан нөхцөлийг хангадаг юм. Тиймээс чөлөөт ардчиллын үндсэн дэг журмыг хүндэтгэх явдал нь хууль тогтоогчийн үүрэг бөгөөд, үндсэн хуулийн шүүхийн хяналтгүйгээр энэ нь хоосон мөрөөдөл юм.²⁸ Ямар ч шүүх шударга ёсыг тогтоож, шударга байдлыг яг хуулийг хэрэглэж баталгаажуулах ёстой. Ш. Монтескьюгийн хэлсэнчлэн «Бүгд найрамдах улсын засгийн газрын мөн чанар нь шүүгч хуулийн үсгээс хазайхгүй байхыг шаарддаг»²⁹ гэж тэмдэглэсэн байдаг. Тэгэхээр манай улсын Үндсэн хуулийн цэц нь шударга ёсны зарчмыг биш ямар нэгэн захиалгаар, Үндсэн хуулиа зөрчөөд ч хамаагүй "захиалга"-ыг биелүүлдэг "газар" болсон. Ийм жишээ олон бөгөөд ард түмэн аль хэдийн итгэл алдарчээ.

Эдгээр Цэцтэй холбоотой асуудлуудыг дүгнэвэл Үндсэн

²⁷ Мөн тэнд.

²⁸ Karl Doehring, The special Character of the Constitution of Federal Republic of Germany as a Free Democratic Basic Order 6 1988. P 35.

²⁹ [http://socserv2.socsci.mcmaster.ca/econ/ugcm/3il3/montesquieu/spirit of laws.pdf](http://socserv2.socsci.mcmaster.ca/econ/ugcm/3il3/montesquieu/spirit%20of%20laws.pdf)

²⁶ Б.Чимэд "Үндсэн хуулийн үзэл баритлал. Нийтлэг асуудал" нэгдүгээр дэвтрийн 192 дахь тал.

хуулинд байгаа Цэцийн заалтуудыг бүр үзэл баримтлалын түвшинд, бүр үндэсээр нь шинэчилж, дэлхийн жишгээр өөрчлөн хуульчилж, зохион байгуулах шаардлага нэн тэргүүнд тулгараад байна. Төрийн эрх мэдлийн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлүүд нийлсэн, энэ түүхэн хугацаанд дээрээс нь Үндсэн хуулийн шүүх нь цэцийн хууль эрх зүйн болон удирдлага чиглэл, зохион байгуулалт, гишүүдийн мэдлэг чадварын түвшинг харахад үйл ажиллагаа явуулах чадвар, чадамжгүй байгаа нь манай төр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд хүртэл аюул учруулах хэмжээнд хүрчээ гэж дүгнэхээр байна. Дубайн гэрээ, Эрдэнэт үйлдвэрийн хувьчлалын асуудлыг дээр дурдсан. Хяналтгүй төрийн хязгааргүй эрх мэдэл, ард түмнээ, түүний эрх ашгийг үл тоодог дэрэнгүй зан юу хийж, юу авчирч чаддагийн жишээ. Цаашид эрх мэдлээ тэлээд байгаа нь Монголын газар нутгийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөрөө "нийтийн өмч" гэж зарласнаараа далимдуулан газар нутгаа хэсэгчлэн болон бүгдийг зарчих зорилго байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Энэ Үндсэн хуулийн заалтыг "Зөвхөн Монголын ард түмний өмч" гэж даруйхан сэргээн өөрчлөх шаардлагатай байна. Үндсэн хууль бол төр, ард түмний хооронд байгуулсан нийгмийн гэрээ гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг. Иймээс энэ гэрээнд "нийтийн" гэдэг үг орж ирэх үндэслэл байхгүй. Дараагийн

анхаарал татаж байгаа зүйл бол "нийтийн" гэдэг ойлголт нь иргэний эрх зүйн ойлголт бөгөөд Үндсэн хуулиа "бүр доош нь хийгээд", иргэний эрх зүйтэй хутгасан байна. Манай төрд Үндсэн хуулиа ийнхүү "доош хийж, дорд үзэх" үзэх эрхтэй хүн байх ёсгүй.

Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна уу? гэвэл байна. Цэцийн асуудлаас аваад бүр тулгамдсан асуудлууд байна. Гэхдээ ямар өөрчлөлт хийх вэ гэдгээ тогтоох асуудал чухал юм.

Одоо манай улсад "Зөвлөлдөх санал асуулгын тухай" хуулиар зөвлөлдсөн нэр хэмээж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр жаахан шоудаад л, улсын төсвийг хий дэмий үрээд, зарим тохиолдолд бүр мэдэгдэхгүйгээр УИХ Монголын ард түмний "оюун санааны өмч" болох Үндсэн хуульд халдах, нэмэлт, өөрчлөлт оруулах "виз" авч байна. Энэ хуулиар "тохиолдлын зарчмаар түүвэрлэн сонгосон иргэд"-ийг оролцуулж байгаа нь Үндсэн хуульд ёсны үзэл баримтлалын суурь зарчим болох "дээд эрх мэдлийн цорын ганц хууль ёсны тээгч буюу төрийн бүрэн эрхт байдлын эх үүсвэр бол ард түмэн" гэж тунхагласан ард түмний бүрэн эрхт байдлын зарчим, мөн Үндсэн хуулийн "Монгол Улсад засгийн БҮХ эрх ард түмний мэдэлд байна" гэсэн заалтыг зөрчсөнийг тайлбарлах нь илүүц юм. Б.Чимэд агсан "Үндсэн хуулийн оршилд, Монголын ард түмэн бид гэж

эхэлдэг нь санамсаргүй зүйл биш юм” гэж тэмдэглэж байсан. “Монгол улсын шинэ Үндсэн хууль бол үндэснийхээ оюуны чадавхид түшиглэн, бодит нөхцөлөө харгалзан уламжлал шинэчлэлийн жам ёсыг тусгасан үзэл баримтлал бүхий ард түмний өөрсдийнх нь бүтээл туурвил мөн” гэсэн байдаг. Энэ нь Монгол улсын Үндсэн хууль нь Монголын ард түмний оюун санааны эх өв, өмч болохыг тодотгосон тодорхойлолт юм. Үндсэн хуулийн жаран наймдугаар зүйлийн 2-т “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар УИХ-ын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно...”³⁰ гэж заасан байгаа бөгөөд Ард нийтийн санал асуулгын тухай хууль ч өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа.

Уг УИХ-аас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхдээ “зөвлөлдөх” гэдэг “гажуудсан, хуурамч” ардчиллын заль мэхийг хэрэглэхгүйгээр, харин дэвшилтэт хүн төрөлхтөний хэрэглэдэг “зөвшилцөл” гэдэг үйл явцыг ямар нэгэн гажуудал, завхралгүйгээр зохион байгуулж, эсрэг тал болох ард түмнийхээ санал хүсэлд ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандаж, харилцан буулт хийж, эцэст нь бүх талуудын хүлээж авахуйц боломжтой хувилбарыг сонгоод, эцсийн энэ хувилбарыг “ард нийтийн санал асуулга”-аар шийдээд явбал манай төрийн тунхагласан

ардчилсан, хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх, шударга байх зэрэг зарчмуудад нийцэж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх асуудлаа ард түмэнтэйгээ хамт олох нь ойлгомжтой юм. Олон улсад зөвшилцлийн энэ механизмыг ардчиллын мөн чанарын нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ аргыг улс төр, нийгмийн хүмүүсийн амьдралын бүхий л салбарт хэрэглэдэг нийтлэг арга механизм болсон байдаг. Одоо яригдаж байгаа сонгуулийн холимог тогтолцооны нөхцөлд “зөвшилцөл” бол төрийн, тэр тусмаа Засгийн газрын үйл ажиллагааны өдөр тутмын практик үйл ажиллагаа болох нь тодорхой. Үүнд монголчууд бид суралцах ёстой.

Ер нь манай улсад төрийн байгууллагуудаас Үндсэн хуулиа зөрчсөн хууль, тогтоол шийдвэрүүд их гарч байна. Монгол улсын Засгийн газраас “Хүүхдийн мөнгө олгох” журам гаргахдаа Үндсэн хуулийн тэгш байдлын зарчмаа зөрчин ард иргэдээ нийгмийн байдал, хөрөнгө чинээгээр нь ялгаварлан хүүхдийн мөнгийг олгоод явж байна. Энэ журам нь Үндсэн хууль төдийгүй манай улс нэгдэн орсон “эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” болон бусад олон улсын гэрээ конвенцуудыг зөрчсөн үйлдэл юм. Зөвхөн Өмнөговь аймагт л “Уул уурхайн хишиг” гэж тараадаг. Мөн ТАХ нь бусад аймгуудаас өндөр цалин, хангамжтай байх юм. Манай улс Үндсэн хуулиндаа “нэгдсэн” улс гэж тунхагласан биш билүү. Энэ

³⁰ Монгол улсын Үндсэн хууль.

асуудлууд жижиг юм шиг харагдаж байгаа ч засаж залруулахгүй бол төр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд тулж очиход маш ойрхон гэдгийг ард түмэн, төр засаг анхаарах цаг болсныг анхааруулан дурдмаар байна.

Дээр дурдсан Цэцийн асуудлаас гадна манай Үндсэн хуульд шийдлээ хүлээсэн олон асуудал байгааг үгүйсгэхгүй. Франц улсын Үндсэн хуулийн адилаар Ерөнхий сайдаас бусад засгийн газрын гишүүн УИХ-ын гишүүн байж болохгүй гэсэн заалтыг оруулах нэн шаардлагатай байна. Цаашид сонгуулийн тогтолцоо, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн талаар (хотын болон сумуудыг нэгтгэх), Ерөнхийлөгчийг УИХ-аас сонгох, Үндсэн хуулийн монгол улсын газар нутгийг нийтийн өмч байхаар заасан нэмэлт, өөрчлөлтөө засах гээд маш олон асуудлууд байна. Эдгээр асуудлын шийдлийг ардчилал буюу ард түмний засаглалтай хамтраад гол асуудлуудаа "ард нийтийн санал асуулга" буюу "шууд ардчилал"-аар шийдээж явна гэж итгэж байна.

Манай оронд бий болсон улс төрийн эдгээр ээдрээтэй асуудал үүссэн шалтгаануудад иргэдийн нийгэм, улс төрийн "идэвхгүй" байдал ихээхэн нөлөөлдгийг ард түмэн бид хүлээн зөвшөөрөх ёстой. Ард түмэндээ Английн философич Фергюсон «Хэн нэгэн идэвхгүй, байгаа байдалтайгаа эвлэрсэн хүмүүсийг удирдахаар болсон хүн өөрийнхөө эрх мэдлээ тасралтгүй

өргөжүүлэх болно. Шинэ хууль, төрөөс авч буй арга хэмжээ бүхэн ... түүний эрх мэдлийг бэхжүүлж, тэрээр цорын ганц чухал хүн, айдас, хүндэтгэлийн объект болж, олон нийтийн өмнө ил гарч ирдэг»³¹ гэсэн үгийг сануулмаар байна. Германы философич, социологич Ю.Хабермас хувь хүний эрх чөлөө нь бусад бүх хүмүүсийн эрх чөлөөтэй сөрөг байдлаар, харилцан хязгаарлалтаар төдийгүй хувь хүн бүр хууль боловсруулах үйл явцад өөрийн оролцоогоо ухамсарлахтай холбоотой байдаг. «Чөлөөт ба тэгш эрхтэй нийгэмд хүн бүр өөрсдөдөө холбоотой хуулиудын зохиогч гэж ойлгох хэмжээнд хууль боловсруулах процесст оролцох чадвартай байх ёстой»³² гэж үзсэн байдаг. Энэхүү хандлага нь улс төрийн үйл явцад иргэд идэвхтэй оролцож, хүн бүрийг эрх баригчид нь сонсоно гэсэн итгэл үнэмшилтэй болж, харилцан буулт хийх замаар харилцан хүлээн зөвшөөрч болохуйц шийдлийг гаргаж чадна гэж үздэг байна.

Францын сэтгэгч А.Токвиль "Америк дахь ардчилал" номондоо «Бид ардчилсан байгууллагуудыг аажмаар нэвтрүүлж, ойлгох хэрэгтэй бөгөөд, эхлээд ард түмнийг эрх чөлөөнд бэлтгэж, дараа нь ашиг тусыг нь хүртэх боломж олгодог санаа, мэдрэмжийг бүх иргэдэд суулгаж өгөх хэрэгтэй гэсэн санааг орхигдуулбал баячууд, аристократ,

³¹ Фергюсон А. Опыт истории гражданского общества. М., "Российская политическая энциклопедия" (РОССПЭН), 2000. С. 374.

³² Хабермас Ю. Вовлечение другого. Очерки политической теории. СПб., Наука, 2001. С. 196.

ядуучуудын хэн ч эрх чөлөөтэй болохгүй»³³ гэж сэтгэгч тэмдэглэсэн байдаг. Тэрээр боловсрол, мэдлэг, мэдээллээр дамжуулан хийж болох ёс суртахуун, улс төр, хууль эрх зүйн ухамсрыг тодорхой түвшинд хүргэж байж л ардчилал хөгждөг болохыг олж харсан байна. Судлаач миний хувьд энэ нийтлэл маань та бүхний хууль эрх зүйн мэдлэгт жаахан ч гэсэн нэмэр болно гэж найдаж бичлээ.

Ер нь одоо манай улсад Үндсэн хуульд шууд нэмэлт өөрчлөлт хийхэд дараахь хүчин зүйлүүдийн улмаас боломжгүй гэсэн (сонгуулийн тогтолцоонооноос бусад асуудлаар) дүгнэлтийг хэлье. 1) УИХ-д нэг нам дэндүү давамгай байгаа (Төрт ёсны түүхэнд төрийн эрх мэдэл нэг хүн болон нэг субъектэд төвлөрсөн үед өөрсдийнхөө эрх мэдлийнхээ төлөө ард түмний эрх, эрх чөлөөг золиослох өндөр магадлалтай гэж үздэг). 2) УИХ нь Засгийн газраа өөртөө нэгтгэсэн, Цэц Үндсэн хуулийн шүүхийн үүргээ биелүүлэх чадамжгүй байгаа. Иймээс төрийн гурван эрх мэдлийн харилцан хяналт болон ард түмний зүгээс эдгээр эрх мэдлүүдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байгаа. Төрийн эрх мэдлийн гурван салаа нь нэг нэгэндээ тавих хяналт, тэнцвэрт байдал алдагдсанаас УИХ-ын эрх мэдлийг хязгаарлах арга, механизм өнөөдөртөө зохих ёсоор ажиллах боломжгүй байгаа. 3) Монголын ард түмэн ядуу байгаа. Манай улсад зах

зээлийн биш хуваарилалтын эдийн засаг ноёрхож байна. Ядуу, төрөөс шууд эдийн засгийн хамааралтай хүмүүс төртэй нэг түвшинд харилцаж чаддаггүй. 4) Манай ард түмний мэдлэг боловсролгүй, идэвхгүй, хариуцлагагүй, арчаагүй залхуу байдал. Британийн нийгмийн бодлогын үндэс суурийг тавьсан Бевериджийг халамжийн бодлогод төрийн тулгарах ёстой таван бузар муугийн эхний ба гол зүйл нь халамжийг шүтэх явдлыг сөрөн зогсох гэж нэрлээд, үлдсэн дөрөв нь өвчин, бичиг үсэг үл мэдэх, заваан арчаагүй байдал, үл тоомсорлох, хэнэггүй байдал гэж онцлоод, төрийн гол хүчин чармайлыг тэдгээрийг арилгахад чиглүүлэх ёстой³⁴ гэж зарласан байдаг. Манай төр өнөөдөр Бевериджийн санааг шууд хулбарлаад хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ийм нөхцөлд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналаа УИХ ард түмэнтэйгээ "зөвшилцөж" тохироод, УИХ-ын сонгуультайгаа хамт ард нийтийн санал асуулгаар шийдэх саналаа дахин тавимаар байна. Д.Лүндээжанцан багш үндсэн хуульд өөрчлөлт оруулах нарийн төвөгтэй механизм нь Үндсэн хуулийг дур зоргоор, эсхүл "гудамжны хэрүүл шуугианаар" биш харин зөвхөн хууль тогтоогчид жинхэнэ ардчиллын арга хэрэгслээр өөрчлөх ёстойг харуулдаг гэж дурдсан байдаг.

Ард түмний дээдлэн шүтэж

³³ Токвиль А. де. Демократия в Америке. М., 1992. С. 237.

³⁴ Social Insurance and Allied Services. Report by Sir William Beveridge // Bulletin of the World Health Organization. No 78 (6), 2000. P. 848.

явах нэгэн гол шүтээн байхгүйгээр үндэсний эв нэгдэл, тусгаар улс оршин тогтноход бэрхтэй юм.

Ийм шүтээн бол солигдоод байдаг байдаг удирдагч, төрийн эрх мэдлийн гурван салаанд хуваагдсан өөр өөр үзэл баримтлалтай намуудын алин ч биш, гагцхүү Монголын төрт ёс, түүх, соёлын уламжлал онцлог болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг эх өв, сурвалжаа болгосон Монгол Улсын Үндсэн хууль, хүн төрөлхтний хүлээн зөвшөөрдөг Үндсэн хуульт ёсны үзэл баримтлал юм. Энэ Үндсэн хуулиа зөвхөн

Монголын ард түмний оюун санааны халдашгүй, дархан өмч хэмээн хүлээн зөвшөөрч, нийтээрээ, нэн ялангуяа төрийн өндөрлөгүүд, дээд албан тушаалтангууд ард нийтээр шийдүүлэхгүйгээр өөрсдийн дур зоргоор нэмэлт, өөрчлөлт хийхгүй байж, сүсэглэн дагаж, чанд чанга сахин мөрдөх нь чухал байна. Үндсэн хуулийг тайлбарлан таниулах нь шинжлэх ухааны үнэн зөв хандлага онцгой чухал ач холбогдолтойг эрх зүйт төрийг төлөвшүүлсэн улс орнууд нотолж байгааг анхаарахгүй орхиж боломгүй байна.

ANALYSES OF SPEECH ACT IN CONSTITUTIONAL LAW



Shihihutug University, Department of
General Education
Narangerel.L Ph.D

Abstract

Speech acts are basic or minimal units of human communication that is called illocutionary acts. In other words, speech act serves a function in communication. Some examples of these are promises, commands, apologizes, requests ... etc. This theory had its origin derived philosophy of language. Speech act theory developed by philosopher J.L. Austin. Later John Searle extends the speech act theory that Austin introduced. When a speaker utters an utterance in appropriate context with certain intentions, he performs illocutionary acts.

As for functions of law, it regulates human's actions, are expressed through language. Speech acts has been recognized as being able to produce and create legal forces it is played in legislative texts. Legislative language is considered as directive speech acts that impose obligations,

instruct prohibition, confer rights and grant permissions. This research is speech act study aimed at examining function and indicators of prohibitive speech acts in the legislative language especially constitutional text.

Keywords: speech act, performatives, illocutionary force, prohibition, directive speech act,

we use speech act analysis for defining

pragmatic meaning in legislative discourse, in particular speech acts in the Mongolian

we use speech act analysis for defining

pragmatic meaning in legislative discourse, in particular speech acts in the Mongolian

we use speech act analysis for defining

pragmatic meaning in legislative discourse, in particular speech acts in the Mongolian

1. INTRODUCTION

Speech act theory developed by philosopher J. L. Austin, he introduced this theory in 1962 in his well-known book of 'How Do Things With Words'. Austin says that when a speaker utters a utterance he may performs some actions in saying something. For example:

"I give and bequeath my watch to my brother."

"I bet you sixpence it will rain tomorrow."

He divides speech act into three types 1/Locutionary act: is the basic act of utterance or producing a meaningful expression. When someone produces the utterance, that utterance is called locutionary act. For example someone said "it is rain outside!", the utterance itself "it is rain outside!" that called locutionary act. 2/ Illocutionary act: is the act of the utterance. It is the act which is performed by saying the utterance. 3/ Perlocutionary act: is the effect of the utterance on the hearer, depending on specific circumstances. This is the effect on the hearer of what the speaker says.

Then John Searle improved version of speech act theory that is used by researchers. Searle suggested that the basic unit of linguistic communication is speech act.

Law regulates people's action that are expressed only through language. Other words, language play important role and law does not exist without language. There are two primary functions of law; first, is the ordering of human relations, second, the restoration of social order when order breaks down (Danet.B 1980.). Legal language contains a number of unusual features that are related to terminology, vocabulary, linguistic structure and stylistics. Speech act theory is relevant to the law that it is concentrated on performative feature. Many law statements are performatives.

Prohibition is studied by J.L.Austin, J.Searle and Bach and Harnish from different perspectives. They classified prohibition under category of directives that speaker tries to influence the hearer to do something. According to the J.L.Austin listed prohibition within exercitive speech acts. Trosborg.A defines the language of law it is considered as directive speech acts, that is to grant permissions, impose obligation, confer rights and prohibitions. Another words directive speech act is an illocutionary act that aims to influence behavior of addressees. Illocutionary act with illocutionary force¹ is expressed performative verbs.

MATERIALS AND METHOD

The author of the present study usually follows J.Searle and Trosborg's perspectives. The reason why the author chooses Mongolian Constitution (hereinafter referred to as MC)as data source is crucial in a country which is to regulate for the governmental powers, the legal system, and the rights of citizens in the nation. Therefore, based on the literature reviewed, researchers have found that there is a dearth in the study of prohibitive speech act. Speech act of prohibition is imposed obligation people to forbid doing something. Language of the law, participants are legislatures and citizens and there is asymmetrical relationship which

¹ In speech-act theory, illocutionary force refers to a speaker's intention in delivering an utterance or to the kind of illocutionary act the speaker is performing. Also known as illocutionary function or illocutionary point.

exists between them. In this case, legislatures has power to make rules for citizens to obey.

In Mongolian language, regulation of behavior by means of prohibitions, performative verb or illocutionary denegation is used and

1. Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд тухан хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг **ХОРИГЛОНО**. (Removal of a judge a court of any instance shall be prohibited except in cases he/she is relieved at his/her own request or removed on the grounds provided for in the Constitution and law on the judiciary and by a valid court decision.)

/Article 51.4 of the constitution of Mongolia/

This statement is a form of directive type that it is used to forbid listener.

In following case, prohibition can be carried out through construction that is the negative word **үл**.

2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж **ҮЛ БОЛНО**. (No person shall be discriminated

against on the basis of ethnic origin, language, race, age, sex [gender], social origin and status, property and assets, employment occupation and official position, religion and conscience, conviction and opinion, and education.)

/ Article 14.2 of the constitution of Mongolia/

3. Улсын Их Хурал ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж **ҮЛ БОЛНО**. (The State Great Hural (Parliament) shall not affect any amendments or changes to the Constitution within the six months prior to the regular general elections.)

/ Article 69.3 of the constitution of Mongolia/

In example 4, prohibition is expressed modal verb and modality is way in which a speaker can express his attitude towards a situation in communication. Also, it is expressed that intention of banning amendments to the Constitution within six months before the election of the legislative body. The utterance is in narrative form, with word 'үл болно'.

4. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож **БОЛОХГҮЙ**. (The President,

the Prime Minister, the members of the State Great Hural (Parliament), the members of the Government (Cabinet ministers), or the officials of the State, political parties or other public organizations, citizens or anyone else, shall not interfere with the discharge of judicial duties by the judges.)

/ Article 49.2 of the constitution of Mongolia /

This article is expressed that meaning of direct prohibition of interference in judicial proceedings. The utterance is revealed in a negative form, with the word 'болохгүй'.

5. *Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө. (The President shall not be Prime Minister, a member of the State Ikh Hural or a member of the Government and shall not concurrently hold any other posts and pursue any occupation not relating to his duties assigned by law. If the President holds another office or post he/she shall be relieved of it from the date on which he/she is taken oath).*

/ Article 31.8 of the constitution of Mongolia /

According to the study, prohibition refers protection of the right of person or organization, on the other hand, to obligate the reader to refrain from the act.

In speech act of prohibition, utterance's formalized as statement and negative form and that is expressed performative verb 'хориглоно', particle 'үл' and performative modal 'болохгүй'. Other words, these are indicator of prohibitive speech act. Intention of speaker is mean to forbid doing something. Modal verbs are preferred than performatives in the current research. Therefore, modal verbs are predominate as indicators of speech acts in English. There isn't imperative in law language because distance between legislature and citizens who are never direct addressed. Future studies may be concerned with analysis of communicative functions within various domains of legal English.

REFERENCES

In english

1. Austin. John L, "How To Do Things With Words", Harvard University Press, 1962.
2. Bach. Kent. Speech Acts and Pragmatics. Blackwell Guide to the Philosophy of Language. 2003
3. Cao, D. Legal speech acts as intersubjective communication action. Interpretation, Law and the Construction of Meaning. Springer Netherlands. 2007.
4. Dennis. K Linguistics and Legal Discourse: An Introduction. International Journal for the Semiotics of Law Vol. VII no. 19 (1994).
5. Searle, John.R. 'Expression and Meaning', Cambridge University Press /Studies in the Theory of Speech Acts/, 1981
6. Searle, John.R. A Taxonomy of illocutionary acts. Language in Society 5. 1976
7. Searle, John.R. and Vanderveken, D. Foundations of Illocutionary Logic. Cambridge University Press. 1985
8. Trosborg. Anna, An analysis of legal speech acts in English Contract law., Journal of Linguistics., № 6, 1991.
9. Trosborg. Anna, Statutes and contracts: An analysis of legal speech acts in the English language of the law., Journal of Pragmatics, 1995.

In mongolian

1. Зэгиймаа, Ч. Прагматик хэлшинжлэл, УБ., 2010.
2. Монгол Улсын Үндсэн хууль (1992

АНУ-ЫН ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬ GUN LAW IN THE UNITED STATES



Шихихутуг их сургуулийн
Ерөнхий эрдмийн тэнхимийн багш
С.Батболд

Энэ нийтлэл нь холбооны улсын зэвсгийн тухай хуулийн талаар өгүүлнэ.

АНУ-д буу олж авах эрхийг холбооны хэд хэдэн дүрмийн дагуу хуулиар зохицуулдаг. Эдгээр хуулиудад галт зэвсэг, сум, галт зэвсгийн хэрэгслийг үйлдвэрлэх, худалдаалах, эзэмших, шилжүүлэх, бүртгэл хөтлөх, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг зохицуулдаг. Эдгээр хууль журмыг төрийн байгууллагууд болон Холбооны Улсын Архи, Тамхи, Галт Зэвсэг, Тэсрэх Бодисын Товчоо (АТГТ)-ноос хэрэгжүүлдэг. Холбооны бууны тухай хуулиас гадна бүх муж улсын засгийн газар болон зарим орон нутгийн засаг захиргаа галт зэвсгийг зохицуулдаг өөрийн гэсэн хуультай байдаг. Зэвсэг хадгалах, авч явах эрхийг АНУ-ын Үндсэн Хуулийн Хоёр дах Нэмэлт Өөрчлөлтөөр хамгаалдаг. АНУ-ын Дээд шүүхээс хувь хүн нь гэр дотроо өөрийгөө хамгаалах гэх мэт

уламжлалт хууль ёсны зорилгоор цэрэгт алба хаахтай холбоогүйгээр зэвсэг биедээ авч явах, хадгалах эрхийг хамгаална гэсэн шийдвэр гаргах хүртэл холбооны шүүхийн тодорхойшийдвэрүүддутагбайсан. Колумбийн дүүрэг Хеллерийн эсрэг (2008). Үүний дараа Дээд шүүх Чикагогийн эсрэг Макдоналд (2010)-ын шүүх хуралдаанд Хоёр дахь нэмэлт өөрчлөлтийг Арван дөрөв дэх нэмэлт, өөрчлөлт оруулах журмын заалтад тусгаж, улмаар муж улсын болон орон нутгийн хууль тогтоомж, түүнчлэн холбооны хууль тогтоомжид хамаарна гэдгийг баталжээ. Нью-Йорк мужийн Винтов & Гар бууны Холбоо, Бруенийн эсрэг (2022) шүүх хуралдаанаар Нью-Йоркт нуун далд зөөвөрлөх тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог «үүсгэж болно» гэж үзэн, хувь хүнээс зохих шалтгаан эсвэл онцгой хэрэгцээ шаардсан нь үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн.

Зэвсэгтэй холбоотой Холбооны улсын томоохон хууль тогтоомжууд

Холбооны улсын бууны тухай хуулиудыг дараахь хууль тогтоомжуудаас олж харж болно. Үүнд:

- Үндэсний галт зэвсгийн тухай хууль (ҮГЗТХ) (1934): Автомат буу, богино хошуут хагас автомат, ангийн буу, хүнд зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, бууны дуу

намсгагч, өнгөлөн далдалсан эсвэл гар аргаар хийсэн галт зэвсэг зэрэг II зэрэглэлийн зэвсгийг үйлдвэрлэх, шилжүүлэхэд татвар ногдуулж, бүртгэхээр заасан.

- 1938 оны Холбооны Улсын Галт зэвсгийн тухай хууль (ХГЗТХ): Буу үйлдвэрлэгчид, импортлогчид болон галт зэвсгийн худалдаа эрхэлдэг хүмүүс Холбооны Улсын Галт зэвсгийн лиценз (ХГЗЛ)-тэй байхыг шаарддаг. Галт зэвсгийг тодорхой ангиллын хүмүүст, тухайлбал, хүнд ял шийтгүүлсэн хүмүүст шилжүүлэхийг хориглоно.
- 1968 оны Олон нийтийн гэмт хэрэгтэй тэмцэх, аюулгүй гудамжны тухай хууль (1968): Улс хооронд гар буу худалдаалахыг хориглож, гар буу худалдаж авах насыг 21 нас болгож нэмэгдүүлсэн.
- 1968 оны Бууны хяналтын тухай хууль (БХТХ): Тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэгч, борлуулагч, импортлогчдоос бусад муж хоорондын галт зэвсгийг шилжүүлэхийг ерөнхийд нь хориглох замаар галт зэвсгийн худалдааг зохицуулахад голчлон анхаардаг.
- Галт зэвсэг эзэмшигчдийг хамгаалах тухай хууль (ГЗЭХТХ) (1986): 1968 оны Бууны хяналтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, хэсэгчлэн хүчингүй болгосон. Хууль батлагдсан өдрөөс хойш үйлдвэрлэсэн

автомат галт зэвсгийг энгийн иргэдэд худалдаалахыг хориглосон. Автомат галт зэвсгийг шилжүүлэхдээ холбооны Архи, тамхи, галт зэвсэг, тэсрэх бодисын товчооны зөвшөөрөл авах шаардлагатай.

- Илрүүлэх боломжгүй галт зэвсгийн тухай хууль (1988): 3.7 унцаас бага металлын агууламжтай галт зэвсгийг үйлдвэрлэх, импортлох, худалдах, тээвэрлэх, хүргэх, эзэмших, шилжүүлэх, хүлээн авах зэрэг үйлдлүүдийг цөөхөн тохиолдлоос бусад үед гэмт хэрэгт тооцдог.
- Буу зэвсэггүй Сургуулийн Бүсийн тухай Хууль (1990): Сургуулийн бүс гэдгийг мэддэг атлаа үндэслэлтэй шалгаантайгаас бусад нөхцөлд зөвшөөрөлгүй иргэдийг галт зэвсэг эзэмшихийг хориглодог.
- Брэди Гар бууны хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1993): Худалдагч болон байрнаас хамааран ихэнх галт зэвсэг худалдан авагчид суурь шалгалтыг шаарддаг.
- Холбооны Улсын Зэвсгийн Хориг (1994–2004): Довтолгооны зэвсэг болон томоохон хүчин чадалтай сумаар буудах төхөөрөмж шиг харагдах хагас автомат зэвсгүүдийг хориглосон. Хуулийн хүчинтэй хугацаа 2004 онд дууссан.
- Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын аюулгүй байдлын

тухай хууль (2004): Хууль сахиулагчид болон өмнө нь хууль сахиулах байгууллагад ажиллаж байсан хүмүүст АНУ-ын аль ч хууль тогтоомжоор, аль нэг муж улсын болон орон нутгийн хууль тогтоомжийг үл харгалзан, галт зэвсэг далд авч явах эрхийг олгосон.

- Зэвсгийн хууль ёсны худалдааг хамгаалах тухай хууль (2005): Галт зэвсгийн үйлдвэрлэгчид болон тусгай зөвшөөрөлтэй борлуулагчдын борлуулсан бүтээгдэхүүнээр нь гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд санамсаргүй үйлдэл хэмээн тооцож үйлдвэрлэгч болон борлуулагчдад хариуцлага хүлээлгэхээс сэргийлдэг.
- Хоёр талын Аюулгүй Нийгэмлэгийн тухай хууль (2022): 21-ээс доош насны худалдан авагчдад насанд хүрээгүй хүмүүсийн бүртгэлийг оруулахын тулд суурь шалгалтыг өргөжүүлж, илүү олон худалдагчаас FFL-тэй байхыг шаардаж, улсын хямралаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг санхүүжүүлж, зэвсгийн наймаа, зальдах замаар зэвсэг худалдан авалтыг цаашид гэмт хэрэгт тооцож, «найз залуугийн цоорхойг (Найз залуугийн цоорхой гэдэг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж, хуучин эсвэл одоогийн дотно хамтрагчид гэсэн утгатай.)» хаадаг.

Одоогийн зохицуулалтын тойм

Орган зайлсан, урьд нь болон одоо 1 жилээс дээш хугацаагаар ял оногдуулсан, шийтгүүлсэн, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад албадан хэвтэн эмчлүүлсэн хүмүүсийг эрхийг нь сэргээснээс бусад тохиолдолд галт зэвсэг худалдан авахыг хориглоно. Дөчин дөрвөн муж улсын үндсэн хуулинд АНУ-ын Үндсэн хуулийн хоёрдугаар нэмэлт өөрчлөлттэй төстэй заалт байдаг бөгөөд энэ нь зэвсэг хадгалах, эзэмших эрхийг хамгаалдаг. Калифорни, Айова, Мэрилэнд, Миннесота, Нью Жерси, Нью Йоркт энэ заалт үл хамаарах ч Нью-Йоркт иргэний хуулиар тогтоосон Хоёр дахь нэмэлт өөрчлөлттэй бараг ижил нэгэн заалт байдаг. Түүнчлэн АНУ-ын Дээд шүүх МакДональд Чикагогийн эсрэг (2010) шүүх хуралдаанд хоёр дахь нэмэлт өөрчлөлтөөр гэртээ өөрийгөө хамгаалах зорилгоор зэвсэг хадгалах, авч явах хамгаалалт нь муж улсын засгийн газар болон тэдгээрийн улс төрийн дэд хэсгүүдийн эсрэг үйлдэл гэж үзсэн байна. Нью-Йорк мужийн Хагас автомат болон Гар Бууны Холбоо байгууллагад Бруентэй холбоотой асуудлаар Дээд шүүх муж улсууд нуун далдлах тээвэрлэх зөвшөөрөл олгохдоо «зохистой шалтгаан» эсвэл «тусгай хэрэгцээ» шаардаж болохгүй гэж шийдвэрлэсэн.

Түүх

Дараагийн жилүүдэд бууны тухай хууль тогтоомжтой холбоотой чухал үйл явдлууд болсон.

1791 онд АНУ-ын Хүний Эрхийн тухай хуулийн төслийг соёрхон баталсан. Үүнд багтсан АНУ-ын Үндсэн хуулийн хоёр дахь нэмэлт өөрчлөлтөөр «Сайн зохицуулалттай цэрэг арми нь чөлөөт улсын аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай ба ард түмний зэвсэг хадгалах, авч явах эрхийг зөрчиж болохгүй» хэмээн заасан.

1934 онд Ерөнхийлөгч Франклин Рузвельтийн засаг захиргааны үед хориотой үеийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор Галт зэвсгийн үндэсний хууль (ҮГЗТХ)-д гарын үсэг зурсан. 1920-1933 оны хооронд АНУ-д хүн амины гэмт хэргийн тоо жил ирэх тусам нэмэгдэж хоригийг хуульчилсан нь хүсээгүй үр дагаврын жишээ болсон бөгөөд эрэлт ихтэй бүтээгдэхүүнийг хууль бус болгох нь хүчирхийлэл дагуулах болсон. ҮГЗТХ нь АНУ-д бууны хяналтыг хэрэгжүүлэх анхны холбооны хууль гэж тооцогддог бөгөөд II ангиллын зэвсгийг үйлдвэрлэх, шилжүүлэхэд 200 долларын татвар ногдуулдаг байсан нь 2022 онд ойролцоогоор 3,942 доллартай тэнцэх болсон. Мөн бүрэн автомат, богино хошуутай хагас автомат буу, хүнд зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, дуу намсгагч, өнгөлөн далдалсан буюу гар аргаар хийсэн галт зэвсгийг бүртгэхийг үүрэг болгосон. 1933

онд хоригийг хүчингүй болгоход зохион байгуулалттай гэмт хэргээр дэмжигдсэн архины монополь дуусгавар болж энэ хэмжээгээр хүн амины хэргийн гаралт үлэмж буурсан. Үнэн хэрэгтээ, «... [Хориг хүчингүй болсоны дараа] хүн амины хэрэг арван нэгэн жилийн турш жил бүр тасралтгүй буурч байсан.

1938 онд Ерөнхийлөгч Франклин Рузвельт 1938 оны Холбооны Галт зэвсгийн тухай хууль (ХГЗТХ)-д гарын үсэг зурснаар буутай холбоотой бүх бизнесүүд Холбооны Галт зэвсгийн лицензтэй (ХГЗЛ) байх ёстой болсон.

1939 онд АНУ-ын Дээд шүүх АНУ-ын Миллерийн эсрэг шүүхээр заргалдсан хэргээр дамжуулан 1934 оны Үндэсний галт зэвсгийн тухай хуулиар Конгресс улс хооронд тайрмал ангийн бууг сайн зохицуулалттай цэргийн үр дүнд ямар ч үндэслэлгүй гэж үзэн худалдаалахыг зохицуулах боломжтой гэж шийдвэрлэжээ.

1968 онд Жон Кеннеди, Роберт Ф.Кеннеди, Мартин Лютер Кинг, Ерөнхийлөгч Линдон Б.Жонсон нарын аллага зэрэг улс төрийн аллага үйлдэгдсэний дараа Конгрессийг 1968 оны Бууны Хяналтын тухай Хууль (БХХ)-г гаргахыг шахав. (БХХ). Энэ нь ХГЗТХ-г хүчингүй болгон орлож, бөмбөг, мина, гранат болон бусад тэсрэх бодис гэх мэт «хөнөөх хэрэгслийг» зохицуулж, бүрэн автомат бууны тодорхойлолтын хамрах хүрээг өргөжүүлж, үйлдвэрлэсэн эсвэл

импортолсон бууг бүртгэлжүүлэхийг шаардаж, цэргийн загварын зэвсгийн импортыг хориглож мөн ХГЗЛ -ээс гар буу худалдан авах насны доод хязгаарыг 21 болгож тогтоосон. Мөн БХХ-иар гэмт хэрэгтэн болон сэтгэцийн өвчтэй хүмүүст галт зэвсэг худалдахыг хориглосон.

1986 онд өмнөх бууны тухай хууль тогтоомжийн эсрэг Галт зэвсэг эзэмшигчдийг хамгаалах тухай хууль (ГЗЭХТХ) (1986) Рональд Рейганы засаг захиргааны үед батлагдсан бөгөөд буу эзэмшигчдийн хамгаалалтыг хуульчилсан. Энэ нь дилерийн бүртгэлийг улсын бүртгэлд оруулахыг хориглож, АТГТ-ийн жил бүр хийх хязгаарлагдмал хяналт шалгалт хийж (олон зөрчил илрээгүй тохиолдолд) лицензтэй дилерүүдэд өөрийн мужид «бууны үзэсгэлэнд»-нд галт зэвсэг худалдах боломжийг олгож, сум худалдах, шилжүүлэх зохицуулалтыг сулруулсан. Гэхдээ ГЗЭХТХ нь 1986 оны 5-р сарын 19-ний өдрөөс хойш үйлдвэрлэсэн бүрэн автомат бууг иргэний эзэмшилд шилжүүлэхийг хориглож, дуу намсгагч хэсгүүдийг багтаахын тулд «дуу намсгагч» гэсэн тодорхойлолтыг шинээр гаргасан.

1993 онд Рональд Рейганыг хөнөөх оролдлогын үеэр тахир дутуу болсон Цагаан ордны хэвлэлийн нарийн бичгийн дарга Брэдигийн нэрэмжит гар бууны хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хуульд Билл Клинтоны ерөнхийлөгчийн үед гарын үсэг зурсан юм. Энэхүү хуулиар нь буу худалдан авсан

тохиолдолд үндсэн шалгалтыг явуулах ёстой бөгөөд Холбооны Мөрдөх Товчооноос эрүүгийн хэргийн суурь шалгалтын системийг бий болгох шаардлагатай байв.

1994 онд Билл Клинтоны ерөнхийлөгчийн үед Хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах тухай хуульд гарын үсэг зурсан бөгөөд үүнд Холбооны **довтолгооны** зэвсгийг хориглох, AR-15 загварын бүрэн автомат буу, дайзандаа 10-с дээш сумтай, хориглогдсон өндөр хүчин чадалтай сум гэх мэт цэргийн зориулалттай тусгай зэвсгийг үйлдвэрлэх, худалдах, эзэмшихийг хатуу хориглосон. Өмнө нь хууль ёсоор эзэмшиж байсан зэвсгүүдийг хориглосон нь энэ хуулийн загалмайлсан эцэг нь болсон ба хоригийн хугацаа нь 2004 оны 9-р сард дуусгавар болсон.

2003 онд Канзасын төлөөлөгч Тодд Тиартын санал болгосон Тиартын нэмэлт өөрчлөлтөөр АТГТ-ийг галт зэвсгийн мэдээллийн сангаас зөвхөн хууль сахиулах байгууллага эсвэл эрүүгийн мөрдөн байцаалтын ажиллагаатай холбогдуулан прокурорт мэдээлэл гаргахыг зөвшөөрөхөөр хязгаар тогтоосон.

2005 онд Жорж Буш ерөнхийлөгчийн үед Зэвсгийн хууль ёсны худалдааг хамгаалах тухай хуульд гарын үсэг зурсан. Энэ хуулиар буу үйлдвэрлэгчдийг холбооны болон муж улсын иргэний нэхэмжлэлд тухайн компанийн хийсэн буутай холбоотой

гэмт хэргийн хохирогч болсон хүмүүсээс гомдол гарган дуудахаас хамгаалсан.

2008 онд Дээд шүүх Колумбиа дүүргийн Хеллерийн эсрэг хэргийг хянан хэлэлцээд «Цэрэгт алба хаахтай холбоогүй галт зэвсэг эзэмших хувь хүний эрх» гэж үзэн хоёр дахь нэмэлт өөрчлөлтөөр Вашингтон ДС-д гар буу хэрэглэхийг хориглосон шийдвэрийг цуцалсан юм. Гэхдээ Дээд шүүх «зэвсэг авч явах эрх нь хязгааргүй биш бөгөөд буу эзэмших эрхийг үргэлжлүүлэн зохицуулна» гэж заасан.

2010 онд Дээд шүүх МакДональдын Чикагогийн эсрэг хэргийг хянан шийдвэрлэхдээ Хоёр дахь нэмэлт өөрчлөлтийг хамааруулсан тул мужуудын эсрэг хэрэгжинэ гэж үзсэн.

2016 онд Дээд шүүх Каэтаногийн Массачусетсийн эсрэг хэргийг хянан шийдвэрлэхдээ «Хоёр дахь нэмэлт өөрчлөлт нь даацтай зэвсгийг бүрдүүлдэг бүх хэрэглүүр, тэр дундаа үүсгэн байгуулагдах үед байхгүй байсан зэвсгийг ч хамрах болно» гэж шийдвэрлэсэн.

2022 онд Дээд шүүх Нью-Йоркийн хагас автомат буу ба гар бууны холбоо, нэгдлийн Бруений эсрэг хэргийг «Хоёрдах болон Арван Дөрөвдүгээр нэмэлт өөрчлөлтүүд нь хувь хүний гэрээсээ гадуур өөрийгөө хамгаалах зорилгоор гар буу авч явах эрхийг хамгаалсан» гэж шийдвэрлэсэн.

Хоёр дахь нэмэлт өөрчлөлт

АНУ-д зэвсэг хадгалах, авч явах эрхийг АНУ-ын Үндсэн хуулийн хоёрдугаар нэмэлт өөрчлөлтөөр хамгаалдаг. Ийм төрлийн эрхийн мөн чанарын талаар маргаантай мэтгэлцээн өрнөж байсан ч АНУ-ын Дээд шүүхийн Колумбын дүүргийн Хеллер (2008)-н эсрэг хэрэг болон Макдоналд (2010)-н Чикагогийн эсрэг хэрэг гэсэн хоёр хэрэг гарах хүртэл холбооны шүүхийн эрхийг тодорхойлсон тодорхой шийдвэрүүд дутмаг байсан.

Колумбийн холбооны дүүрэгт гар буу хэрэглэхийг хориглосон шийдвэрийг хүчингүй болгосон Хеллерт хувийн хэрэгцээнд зориулж буу эзэмших хувь хүний эрхийг нь баталгаажуулсан. Хеллерийн шийдвэрийн талаарх шүүхийн олонхийн саналд Хоёр дахь Нэмэлт Өөрчлөлт нь «хуульд захирагддаг, хариуцлагатай иргэдийн гал голомт, гэр орноо хамгаалахын тулд зэвсэг хэрэглэх эрхийг» хамгаалсан гэж үзсэн.

Гэсэн хэдий ч, Дээд шүүхийн шүүгч Антонин Скалиа олонхийн саналыг илэрхийлэхдээ Хоёр дахь нэмэлт өөрчлөлт нь хязгааргүй эрх биш гэж бичсэн.

Ихэнх эрхийн нэгэн адил Хоёр дахь нэмэлт өөрчлөлтийн эрх нь хязгааргүй биш юм. Энэ нь ямар нэгэн байдлаар, ямар ч зорилгоор ямар ч зэвсгийг хадгалах, авч явах эрх биш юм: Жишээлбэл, далд зэвсгийг хориглох заалтыг нэмэлт

өөрчлөлт оруулах буюу төрийн аналогийн дагуу баталсан. Шүүхийн саналаас үүдэн гэмт хэрэгтэн болон сэтгэцийн өвчтэй хүмүүст галт зэвсэг эзэмшихийг удаан хугацаагаар хориглосон, сургууль, төрийн барилга гэх мэт эмзэг газарт галт зэвсэг авч явахыг хориглосон хуулиудад эсвэл зэвсгийг арилжааны зорилгоор худалдах нөхцөл, шалгуурыг тогтоосон хуульд эргэлзээ төрүүлэх ёсгүй.

Эсэргүүцсэн дөрвөн шүүгчдийн үзэж байгаагаар олонх нь Хоёр дахь нэмэлт өөрчлөлтийн өмнөх жишгийг эвдсэн ба нэмэлт өөрчлөлт нь хувь хүний эрхэд төдийгүй цэргийн албаны хүрээнд хамаарах байр суурийг баримталсан хэмээн маргалдсан.

Хүний эрхийн тунхагтай холбогдуулан McDonald-н хэргийн хувьд Дээд шүүхээс хувь хүний зэвсэг эзэмших эрхийн баталгаа нь зөвхөн холбооны хууль тогтоомжид бус муж улсын болон орон нутгийн бууны хяналтын хуулиудад бас хамаарна гэж шийдвэрлэсэн.

2022 онд Нью-Йорк Мужийн Хагас Автомат Буу ба Гар Бууны Холбооноос Бруены эсрэг хийсэн шүүх хурлын үеэр өөрийгөө хамгаалах зорилгоор олон нийтийн өмнө буу авч явах эрхийг хоёр дахь нэмэлт өөрчлөлтөөр хамгаална гэж Дээд шүүх шийдвэрлэсэн. Өмнө нь Холбооны Улсын Давж Заалдах Шатны Шүүхээс энэ асуудлаар зөрчилтэй шийдвэр гаргаж байсан. Жишээлбэл, АНУ-ын Долдугаар

тойргийн давж заалдах шатны шүүх 2012 онд «Дээд шүүх нэмэлт өөрчлөлтөөр өөрийгөө хамгаалах зорилгоор зэвсэг авч явах эрхийг олгоно гэж шийдвэрлэсэн. Гэвч Аравдугаар тойргийн шүүх 2013 онд «Иргэний галт зэвсэг авч явах эрх чөлөөг нь далд хэлбэрээр хязгаарладаг манай улсын өргөн практикийг харгалзан энэхүү үйл ажиллагаа нь хоёрдугаар нэмэлт өөрчлөлтийн хамгаалалтууд хуулийн хүрээнд хамаарахгүй учраас эрх олгохгүй гэж үзсэн байна. Саяхан есдүгээр тойргийн шүүх 2016 онд гаргасан Перутагийн Сан Диего Мужийн эсрэг шийдвэртээ Хоёр дахь нэмэлт өөрчлөлт нь буу эзэмшигчдийн галт зэвсгийг олон нийтийн газар нуун дарагдуулан авч явах эрхийг баталгаажуулахгүй гэж үзжээ.

Эрх бүхий хүмүүс

Дараахь хүмүүс АНУ-ын нутаг дэвсгэрт галт зэвсэг эзэмших, эзэмших эрхтэй боловч цаашид нэмэлт хязгаарлалтууд хамаарна.

Үүнд:

- АНУ-ын иргэд
- АНУ-ын иргэн биш ч үндэстэн хүмүүс
- АНУ-ын хууль ёсны байнгын оршин суугчид («ногоон карт» эзэмшигчид бас багтана)
- АНУ-д хууль ёсоор дүрвэгчээр хүлээн зөвшөөрөгдсөн холбоотнууд (эсвэл гадаадын иргэд).
- Цагаачлалын бус визээр АНУ-д хууль ёсоор нэвтэрсэн гадаадын

иргэд (эсвэл гадаадын иргэд) дараах үл хамаарах зүйлүүдийн аль нэгэнд хамаарах тохиолдолд:

1. Хууль ёсны ан агнуур, спортын зорилгоор АНУ-д хүлээн зөвшөөрөгдсөн
2. АНУ-ын аль ч мужаас олгогдсон хууль ёсны ан агнуурын лиценз эсвэл зөвшөөрөлтэй
3. АНУ-ын Засгийн газарт итгэмжлэгдсэн гадаадын засгийн газрын албан ёсны төлөөлөгч, эсхүл АНУ-д төв байр нь байрладаг олон улсын байгууллагын дэргэдэх Засгийн газрын төлөөлөгчийн газар, эсхүл тухайн гадаадын иргэн магадлан итгэмжлэгдсэн өөр улс руу явах юм уу буцах замдаа байгаа албан ёсны төлөөлөгч
4. Гадаадын засгийн газрын албан тушаалтан эсвэл Төрийн департаментаас томилсон гадаадын хүндэт зочин
5. Албан ёсны хууль сахиулах ажлаар АНУ-д нэвтэрч буй найрсаг гадаадын засгийн газрын гадаадын хууль сахиулагч
6. Энэ нь шударга ёсны ашиг сонирхолд нийцэх бөгөөд АНУ-ын хуулийн 18-р зүйлийн § 922(y)(3)(c)-ын дагуу олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулахгүй байх тул татгалзах өргөдөл нь АНУ-ын Ерөнхий прокуророос татгалзсан хариу авсан.
7. Хүлээн авсан галт зэвсэг нь хууль ёсны спортын зорилгоор байснаас бусад тохиолдолд АНУ аль нэг мужийн оршин суугч биш

этгээд

Муж болгонд хэн буу эзэмшиж болох талаар өөрийн гэсэн хууль тогтоомжтой бөгөөд буу эзэмшихийг зөвшөөрөх суурь шаардлагууд нь төрөл бүрийн муж, холбооны улсуудад байна. гэмт хэрэгт буруутгагдсан хүмүүс, оюун санааны хүнд өвчтэй буюу гажигтай хүмүүс, холбооны улсын нисэхийг хориглосон жагсаалтад орсон хүмүүс, зэрэг тодорхой бүлэг хүмүүсийн талаар маргаан үргэлжлэн оршсоор байгаа. Энэ муж хэсгүүд дэх хууль нь өөр өөр байгаа ба хуулийн хэрэгжүүлэлт нь эргэлзээтэй байгаа.

Хориглогдсон хүмүүс

1968 оны Бууны хяналтын тухай хуулиар тодорхой ангиллын хүмүүсийг галт зэвсэг, сум худалдаж авах, худалдах, ашиглах, эзэмших, хүлээн авах, тээвэрлэх, авч явах, эзэмших, солилцохыг хориглосон байдаг. Хориглогдсон хүмүүсийн жагсаалтад:

- Аль нэг шүүхээс «нэг жилээс дээш хугацаагаар гэмт хорих ялаар шийтгүүлсэн» гэмт хэрэг үйлдсэн этгээд;
- Шүүхээс оргон зайлсан этгээд;
- Аливаа хяналттай (21 U.S.C. § 802-д кодлогдсон Хяналттай бодисын тухай хуулийн 102-р хэсэгт тодорхойлсон) бодисыг хууль бусаар хэрэглэгч эсвэл түүнд донтсон этгээд;
- Сэтгэцийн согогтой гэж шүүхээр шийдвэрлэгдсэн, эсхүл аливаа сэтгэцийн байгууллагад албадан

шилжүүлсэн этгээд;

- Хууль бус оршин байгаа гадаадын иргэн (өөрөөр хэлбэл АНУ-д хууль бусаар байгаа аливаа хүн).
- Цагаачлалын бус визээр хууль ёсоор гадаадын иргэнээр хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд 18 нас хүрээгүй. U.S.C. § 922(y)(2);
- Зэвсэгт хүчнээс нэр төргүй нөхцлөөр халагдсан;
- АНУ-ын харьяатаас татгалзсан (өөрөөр хэлбэл, гадаадын иргэн болсон);
- дотны хамтрагч, түүний хүүхдийг дарамтлах, мөшгих, заналхийлсэний улмаас хориглосон шүүхийн шийдвэр гарсан этгээд; эсвэл
- гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн

Эдгээр ангиллыг АТГТГ маягт 4473 - Галт зэвсгийн Арилжааны Бүртгэлийн үндсэн хянах маягт дээр жагсаасан болно. АНУ-ын Яллах комиссын мэдээлснээр, жилд ойролцоогоор 5,000-6,000 хориглогдсон хүн галт зэвсэг авсан буюу хадгалсан хэргээр ял эдэлдэг. 2017 онд 25.2 сая гаруй суурь шалгалтыг хийсэн.

Үйлдвэрлэгчид

АНУ-ын хуулийн дагуу өөрийн бизнесийн үйл ажиллагааны явцад буу, зэвсгийн эд анги үйлдвэрлэдэг, эсвэл дахин худалдахаар бууг өөрчилдөг аливаа компани эсвэл зэвсгийн дархан галт зэвсэг үйлдвэрлэгчийн лицензтэй байх ёстой.

Эх сурвалж

- «Холбооны Галт зэвсгийн тухай хуулийн хураангуй». АНУ-ын Хууль зүйн яам. 2021-01-19.
- «Холбооны бууны хяналтын хууль тогтоомж». 2013-11-14.
- «Гэмт хэргийн хяналт: Холбооны хариу арга хэмжээ». 2013-11-14.

ХУУЛИЙН ТАЙЛБАР

КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР



Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
А.Доржготов

КОМПАНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР: Үргэлжлэл. Түрүүч нь “Шихихутуг” сэтгүүлийн 2015, 2018, 2019, 2021, 2022 оны дугааруудад нийтлэгдсэн болно.

26 ДУГААР ЗҮЙЛ. КОМПАНИЙН ЗАРЛАСАН БОЛОН ГАРГАСАН ХУВЬЦАА

- 204
- 33.1 Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ.
 - 33.2 Зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ.
 - 33.3 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хувьцаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно.
 - 33.4 Гаргасан хувьцааны тоог компанийн балансад төрөл бүрээр нь тусгана.
 - 33.5 Аль нэг төрлийн зарласан хувьцааны тоо нь тухайн төрлийн хувьцааны гаргасан тоо болон тухайн хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хөрвүүлэхэд шаардагдах хувьцааны тооны нийлбэрээс багагүй байна.
 - 33.6 Компаниас гаргасан хувьцаа нь түүнийг компани худалдан авах буюу эргүүлэн авах, эсхүл бусад төрлийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх хүртэл эргэлтэд байна.
 - 33.7 Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авсан тохиолдолд уг хувьцааг зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцно.
 - 33.8 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь энэ хуулийн 33.7-д заасан хувьцааг дахин гаргаж болно.

Тайлбар:

Энэ зүйлд компанийн зарласан хувьцаа, гаргасан хувьцааны тус тусын ойлголтыг тодорхойлж, түүнийг гаргах арга, нөхцөлийг журамлан тогтоожээ.

Мөн хувьцаанд хөрвөх үнэт цаас, хувьцаа эргэлтэнд байх, хувьцааг гаргаагүйд тооцох үндэслэл, хувьцааг дахин гаргах эрх зүйн үндэслэлийг зохицуулж байна.

1. Зарласан хувьцаа. Компанийн дүрмээр гаргахаар тогтоосон энгийн ба давуу эрхийн хувьцааны тоог зарласан хувьцаа гэнэ.

2. Гаргасан хувьцаа. Компанийн зарласан хувьцаанаас хувьцаа эзэмшигчид худалдан авч эзэмшсэн хэсгийг гаргасан хувьцаа гэнэ.


3. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол:



205

Зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг Төлөөлөн удирдах зөвлөл (хувьцаа эзэмшигчдийн хурал) тогтооно. Компанийн дүрэмд өөрөөр зааж болно. Тухайлбал, уг эрхийг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурал тогтоохоор зааж болох юм.

4. Үнэт цаасыг хөрвүүлэхэд шаардагдах хувьцааны тооны нийлбэрээс багагүй байх шаардлагатай. Энэ нь хувьцаанд үнэт цаасыг хөрвүүлэхэд гаргасан хувьцааны тоо нь тухайн төрлийн гаргасан хувьцааны тоо болон үнэт цаасанд хөрвүүлэх хувьцааны тооны нийлбэрээс бага байж болохгүй.



5. Компаниас гаргасан хувьцаа эргэлтэд байх. Компаниас гаргасан хувьцаа эргэлтэд байх нөхцөлийг хуулийн 33.6 дахь заалтад тодорхойлжээ. Ийнхүү хувьцаа эргэлтэд байх хугацаа нь:

- а) Гаргасан хувьцаагаа компани өөрөө худалдан авах буюу эргүүлэх авах;
- б) Хувьцааг төрлийн үнэт цаасанд хөрвүүлсэн;
- в) хувьцааг эд хөрөнгөд шилжүүлсэн.

Эдгээр тохиолдолд компанийн хувьцаа эргэлтээс хасагдана.

6. Гаргаагүй хувьцаа гэж тооцох. Компани зарласан хувьцааг гаргаагүй гэж тооцох үндэслэл нь компани өөрийн гаргасан хувьцааг худалдан авсан тохиолдлыг ойлгоно. Энэ нь зарласан хувьцаагаа гаргасан боловч тухайн компанийн хувьцаагаа эргүүлэн худалдан авсан бол тухайн хувьцаа байхгүй гэсэн үг. Иймээс түүнийг хувьцаа гаргаагүйтэй адилтган үзэхийг "гаргаагүй хувьцаа гэж тооцох"-оор тогтоожээ.

7. Хувьцааг дахин гаргах. Компани өөрийн хувьцааг худалдан авснаар хувьцааг зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцсон хувьцааг дахин гаргаж болно гэж хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д заажээ. Энэ талаар компанийн компанийн дүрэмд өөрөөр заасан бол дүрэмд заасны дагуу шийдвэрлэгдэнэ. Компанийн дүрэмд компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан тохиолдолд түүнийг дахин гаргахыг хориглосон байж болно. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болох юм.

27 ДҮГЭЭР ЗҮЙЛ. КОМПАНИЙН ЭНГИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

34.1 Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

34.1.1 хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх.

34.1.2 давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсөний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах.

34.1.3 Компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.

34.2 Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 38 дугаар зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

- 34.3 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг энэ зүйлд заасан бусад журмын дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.
- 34.4 Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн эзэмшиж болох энгийн хувьцааны тоог хязгаарлаж болохгүй.
- 34.5 Энгийн хувьцааг компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно.
- 34.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хуулиар хязгаарлаж болно.

Тайлбар:

Хуулийн 34 дүгээр зүйлд компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг тодорхойлжээ. Энэ зүйлд хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох, эзэмшсэн хувьцааныхаа тоотой хувь тэнцэх санал өгөх, тогтоосон хэмжээний ногдол ашиг авах, компанийг татан буулгах үед хувь хүртэх, хувьцаа түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах зэрэг эрхийг зохицуулжээ.

207

Энгийн хувьцаа эзэмшигчийн эрх.

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар санал өгөх эрхтэй.
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг төлсний дараа, компаниас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашиг авна.
- Компани татан буугдсаны дараа эд хөрөнгийг худалдаалснаас олсон орлогоос ногдох хувиа зээлдүүлэгч болон давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн дараагаар авдаг.
- Хувьцаат компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдаж авах эрхтэй.
- Хязгаарлагдмал хариуцлагатай компани энгийн хувьцаа эзэмшигч хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
- Эзэмшиж болох энгийн хувьцааны тоог дүрмээр хязгаарлаж болохгүй.
- Энгийн хувьцаа хөрвөхгүй.

Давуу эрхийн хувьцаа, бусад үнэт цаасанд хамааралтай.

Энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхэд дараах онцлогтой байдаг.

1. Хувь тэнцүүлсэн санал. Энгийн хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй. Хэлэлцэж байгаа бүх асуудлаар санал өгч,

асуудлыг талаар шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцдог. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлын ирц бүрдүүлэхдээ, мөн хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөхдөө аль алинд нь "өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүү" байдаг.

2. Ногдол ашиг авах. Энгийн хувьцаа эзэмшигч компанийн ашгаас хуваарилсан ногдол ашгийг авах эрхтэй. Энэ эрхээ хэрэгжүүлэх онцлог нь:

- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараа үлдэх хэсгээс ногдол ашиг авна.
- Энгийн хувьцаа эзэмшигчийн авах ногдол ашгийн хэмжээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хэрэв уг зөвлөл байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авна.

3. Хувь хүртэх. Энэ нь компанийг татан буулгах үед хэрэгжүүлэх боломжтой байдаг. Компанийг татан буулгах тохиолдолд түүний бүх өр төлбөрийг төлж барагдуулсаны дараа, түүний үлдсэн хөрөнгийг худалдаж олсон орлогоос хувь хүртэх эрхтэй. Хувь хүртэх эрх нь мөн хувь тэнцүүлсэн хэмжээгээр тодорхойлогдоно.

4. Тэргүүн ээлжинд худалдан авах эрх. Энгийн хувьцаа эзэмшигчийн эрхийн нэг онцлог бол тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй байдаг оршино.

- Хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд бататган заасны гадна тухайн компанийн дүрмээр тодорхойлогддог. Энэ заалт нь компаниас нэмж гаргах хувьцаа, нэмж гаргах хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг тодорхойлж байна. Ийнхүү тэргүүн ээлжинд худалдан авах эрх нь эзэмшиж байгаа хувьцааны тоонд "хувь тэнцүү" тоогоор хязгаарлагдана.
- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцаа эзэмшигч мөн хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй байдаг. Энэ нь хуулийн 34.3 заалтын ёсоор компанийн дүрэмд өөрөөр заагаагүй нөхцөлд хэрэгжих боломжтой.

5. Болохгүй, үл болно. Хуулийн 34.4, 34.5-д энгийн хувьцаа эзэмшигчийн эрхтэй холбоотой хориг тогтоож "болохгүй, үл болно" хэмээн томъёолсон байна. Эдгээр хязгаарлалт нь:

- Энгийн хувьцаа эзэмшигчийн эзэмшвэл зохих энгийн хувьцааны тоог компанийн дүрмээр хязгаарлаж болохгүй.
- Энгийн хувьцааг хөрвүүлж үл болно. Тухайлбал, тухайн компанийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхгүй. Мөн компанийн бусад үнэт цаасанд хөрвүүлэхгүй. Эдгээртэй холбоотойгоор зохицуулалтыг

ийм байдлаар томьёолжээ.

6. Санал өгөх эрхийг хязгаарлах. Энгийн хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хязгаарлаж болно. Энэ заалт нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар санал өгөх эрхийг хязгаарлаж болно. Ийнхүү энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг хязгаарлах зохицуулалтыг Компанийн тухай хууль тогтоомжид зааж болно.

28 ДУГААР ЗҮЙЛ. КОМПАНИЙН ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

- 35.1 Бүх төрлийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.
- 35.1.1 эрх бүхий байгууллагаас тогтоосон давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжид авах;
- 35.1.2 энэ хууль, компанийн дүрэм болон тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох;
- 35.1.3 компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хуримтлагдсан ногдол ашиг болон өөрийн эзэмшлийн хувьцааны татан буулгалтын үнийг авах.
- 35.2 Компанийн дүрэм, эсхүл тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгана.
- 35.2.1 татан буулгах үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлөх төлбөр, түүнийг төлөх журам, дэс дараалал;
- 35.2.2 хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, давуу эрхийн нэг хувьцаанд ногдох саналын тоо;
- 35.2.3 давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх бол түүний нөхцөл;
- 35.2.4 давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшилд байгаа давуу эрхийн хувьцаагаа компанид эргүүлэн худалдаж авахыг шаардах нөхцөл.
- 35.3 Компани нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн болон эргүүлэн худалдаж авах үүрэг бүхий давуу эрхийн хувьцааг худалдаж авсны дараа энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авах, түүнд ногдол ашиг өлөх эрхтэй болно.
- 35.4 Энэ хуулийн 47.3-т заасан нөхцөлд компани нь давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашгийг компанийн дүрэмд заасан хэмжээ болон хугацаанд төлнө.
- 35.5 Компанийг татан буулгах тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчид ногдох хөрөнгийг олгохоос өмнө дарааллын дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчид татан буулгалтын үнэ, төлөгдөөгүй ногдол ашиг төлнө.

- 35.6 Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах тохиолдолд саналын эрхтэй оролцоно.
- 35.6.1 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахдаа түүний эрхийг хязгаарласан заалтыг оруулж байгаа бол.
- 35.6.2 компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаа, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөрөнгөд хөрвүүлж байгаа бол.
- 35.7 Компанийн дүрэмд дээгүүр хувь тогтоогоогүй бол энэ хуулийн 25.6-д заасан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.
- 35.8 Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хувьцаа эзэмшигчдийн хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчийг дараах тохиолдолд саналын эрхтэй оролцуулахаар компанийн дүрэмд зааж болно.
- 35.8.1 энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөгчийг оруулж болохоор компанийн дүрэмд заасан бол.
- 35.8.2 давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол.
- 35.9 Компани нь давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг хувьцаа эзэмшигчийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Тайлбар:

Компанийн хуулийн 35 дугаар зүйлд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг заан бататгасан байна. Энэ заалтаар давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжинд авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох тохиолдол, өөрийн эзэмшлийн хувьцааны татан буулгалтын үнийг авах, давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэрт тусгагдвал зохих асуудлууд, давуу эрхийн хувьцаанд төлөх ногдол ашиг, түүнийг төлөх журам зэргийн зохицуулалт тусгагджээ.

Давуу эрхтэй хувьцаа. Урт хугацаат санхүүжилтийн нэг арга хэлбэр юм. Зээлийн ба хувьцаат капитал (хөрөнгө оруулалт)-ын аль альных нь шинж чанарыг агуулсан байдаг. Банкны зээл, бондын хүүтэй адил анхнаас нь тогтоосон тогтмол ногдол ашигтай гэж хэлж болно. Түүнийгээ энгийн хувьцааны ногдол ашиг хуваарилахаас өмнө авах эрхтэй. Мөн уян хатан буюу хөвөгч байдлаар ногдол ашгийг тогтоож болно. Энэ тохиолдолд зах

зээл дээрх зээлийн хүүгийн хэмжээтэй уялдуулан тогтоодог ба ихэвчлэн Засгийн газрын үнэт цаасны хүүтэй уялдуулан тогтоодог байна.

Давуу эрхтэй хувьцаа эзэмшигчийн эрхэд хамаарах онцлог нь:

1. Компани татварын дараах цэвэр ашгаас эхлээд давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг, дараа нь энгийн хувьцааны ногдол ашгийг олгоно.
2. Компани дампуурсан буюу татан буугдсан тохиолдолд хөрөнгө хуваарилалтыг энгийн хувьцаа эзэмшигчийн өмнө авах эрхтэй.
3. Саналын эрхгүй байдаг.

Давуу эрхтэй хувьцааны давуу тал:

а) ногдол ашиг хуримтлагдах чанар. Энэ нь хэрэв компани бэлэн мөнгөний хомсдлоос шалтгаалаад тухайн жилдээ ногдол ашгийг өгөөгүй бол дараа жилд хоёр жилийн ногдол ашгийг нөхөн төлнө.

б) нэмэгдэл ашгаас хувь хүртэх боломжтой. Давуу эрхийн хувьцааг зарим үед ийм шинж чанартай гаргаж болдог.

Давуу эрхтэй хувьцааны сул тал: Давуу эрхтэй хувьцааны эрэлт бага байдаг. Учир нь хөрөнгө оруулагчид бонд эсхүл энгийн хувьцааг ашигтай гэж үздэг. Энгийн хувьцаатай харьцуулахад ногдол ашиг хязгаарлагдмал байдаг. Бас компанийг удирдах тодорхой асуудлыг шийдвэрлэхэд саналын эрхгүй байх тул удирдлагыг хэрэгжүүлэхэд нөлөөлөл хязгаарлагдмал.

1. **Ногдол ашиг.** Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч ногдол ашиг тэргүүн ээлжинд авна. Ер нь давуу эрхийн хувьцаа эзэмшихийн ач холбогдол нь ногдол ашиг авах явдал бөгөөд тогтоосон ногдол ашгийг тэргүүн ээлжинд авахад оршино. Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг хугацаандаа олгогдоогүй тохиолдолд хуримтлагдах ба түүнийг нөхөн олгоно.

Хуулийн "эрх бүхий байгууллагаас тогтоосон" гэж томъёолсоныг Компанийн тухай хуульд заасан тухайн асуудлыг шийдвэрлэх эрхтэй компанийн байгууллага гэж ойлгогдож байна. Тухайлбал, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна." гэж, мөн ногдол ашгийн хэмжээг тогтоон төлөх журмыг батлах эрхтэй байна.¹

Хуралд саналын эрхтэй оролцох. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох тохиолдол байж болно. Саналын эрхтэй оролцох эрхийг Компанийн тухай хууль тогтоомж, тухайн компанийн дүрмээр тус тус тодорхойлогддог. Мөн давуу эрхийн хувьцаа гаргах тухай компанийн шийдвэрт "давуу эрхийн хувьцаа гаргах эрхийн талаар" тогтоон заах шаардлагатай байдаг.

Татан буулгалтын үнэ. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн нэг чухал эрх бол компанийг татан буулгасны дараа хувьцааны татан буулгалтын үнийг авах асуудал байдаг. Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд "татан

¹ Компанийн тухай (шинэчилсэн найруулга) Монгол улсын хуулийн 59, 62 дугаар зүйл.

буулгаж байгаа компанийн эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах тухай” зохицуулалтын дагуу хэрэгжих учиртай.

Зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсаны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах дарааллын дагуу хэрэгжүүлдэг.

а) Энд давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй хуримтлагдсан ногдол ашиг;

б) давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ;

с) эргүүлэн худалдан авах давуу эрхийн хувьцааны төлбөр. Эдгээрийг авах эрхтэй.

Компанийг татан буулгах тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигчид дээрх эрхийг энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох хөрөнгө олгохоос өмнө тогтоосон дарааллын дагуу хэрэгжүүлдэг.²

Дүрэм ба шийдвэрт тусгана. Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эдэлбэл зохих эрхийн талаар дараах зүйлийг тусгана. Мөн компанийн дүрэмд давуу эрхийн хувьцаа гаргах хийгээд давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эдэлбэл зохих эрх, үүргийг тодорхойлон журамлах ёстой.

Компанийн баримт бичигт тусган зохицуулбал зохих давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эрх нь:

а) давуу эрхийн хувьцаа эзэмшигчид компанийг татан буулгах үед төлөх төлбөр, түүнийг төлөх журам, төлбөрийг хэрэгжүүлэх дараалал зэргийг тодорхой тусган заах ;

б) Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, журмын талаар тусган заах;

с) Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцсон тохиолдолд давуу эрхийн нэг хувьцаанд ногдох саналын эрхийг тогтоон тодорхой болгох;

д) Давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх эсэх. Хэрэв энгийн хувьцаанд хөрвүүлэх бол түүнийг хэрхэн хөрвүүлэх нөхцөлийг тодорхойлсон байх ;

е) Компанийн давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдан авах тухай асуудал. Өөрийн эзэмшилд байгаа эргүүлэн худалдан авахыг хувьцаа эзэмшигч шаардах эрх, түүний шаардах нөхцөл, шаардлагыг биелүүлэх журмыг тодорхойлон заах нь зохистой байдаг.

Эдгээрийг компанийн дүрэм, эсхүл давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэрт тусгасан байх үүргийг хуулиар тогтоосон гэж үзэж болно.

Хувьцаанд ногдол ашиг төлөх эрх нээгдэх. Энэ ойлголтыг давуу эрхийн хувьцаа бүхий компанид хамааруулан томъёолов. Учир нь энэхүү эрх нь давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эрхтэй шууд уялдаатай байдаг.

² Компанийн тухай (шинэчилсэн найруулга) Монгол улсын хуулийн 35.5-т “татан буулгалтын үнэ, төлөгдөөгүй ногдол ашгийг төлнө” гэж томъёолон заажээ.

Компани тэргүүн ээлжинд дараах үүргийг биелүүлэх шаардлагатай. Үүнд:

- Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн.
- Эргүүлэн худалдан авах үүрэг бүхий давуу эрхийг худалдан авсан.

Эдгээр үүргээ биелүүлсэний дараа энгийн хувьцааг эргүүлэн худалдан авах, энгийн хувьцаанд ногдол ашиг төлөх эрх компанид нээгдэнэ.

Ногдол ашиг төлөх хугацаа. Давуу эрхийн эрхийн хувьцааны ногдол ашгийг компанийн дүрэмд заасан хугацаа, хэмжээгээр төлнө. Компани давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах нөхцөл нь:

а) ногдол ашиг төлсөний дараа компани төлбөрийн чадвартай байх

б) Компани нь эргүүлэн худалдан авах үүргийн давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх. Эдгээр нь компани давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах нөхцөл болно.³

Саналын эрхтэй оролцох. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох тохиолдлыг хуулийн 35.6-д заасан байна. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь саналын эрхээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох тохиолдол нь компанийн дүрмийн өөрчлөлттэй холбоотой.

Компанийн дүрэмд давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан заалт оруулж байгаа тохиолдолд саналын эрхтэй оролцох эрхтэй. Энэ тохиолдол компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, компанийн дүрмийг шинэчлэн найруулах үйл ажиллагаатай хамааралтай.

Эдгээр өөрчлөлтийн төсөлд компанийн дүрэмд заасан давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эдэлбэл зохих эрхийг хязгаарлах заалт оруулсан бол саналын эрхтэй оролцоно. Мөн давуу эрхийн хувьцаа эзэмшигч компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох тохиолдол нь компанийг өөрчлөх байгуулах, давуу эрхийн хувьцааг хөрвүүлэх ажиллагаанд хамаарна.

Компанийг өөрчлөн байгуулах явцад :

а) давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлж байгаа;

б) давуу эрхийн хувьцааг бусад төрлийн үнэт цаасанд шилжүүлж байгаа;

с) давуу эрхийн хувьцааг бусад хөрөнгөд шилжүүлж байгаа;

Эдгээр тохиолдолд саналын эрхтэй оролцоно. Асуудлыг шийдвэрлэхдээ хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ. Хуулийн 35.7-д зааснаар "компанийн дүрэмд дээгүүр хувь тогтоогоогүй бол" гэдгийг эдгээр асуудлыг шийдвэрлэх тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхээс илүү өндөр хувиар шийдвэрлэхээр компанийн дүрэмд зааж болно гэх ойлголтоор хэрэглэж болох юм.

³ Компанийн тухай (шинэчилсэн найруулга) Монгол улсын хуулийн 47 дугаар зүйлд уг нөхцөлийг заажээ.

Хувьцаат компанид саналын эрхтэй оролцох. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигч саналын эрхтэй оролцох тохиолдлыг хуулийн 35.8-д заасан байна. Энэ заалтын агуулга, бүтцээс үзэхэд дараах байдлаар тайлбарлан хэрэглэх боломжтой гэж үзнэ. Үүнд:

а) Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцуулах боломжтой.

б) Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хувьцаа эзэмшигчдийн хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчийг саналын эрхтэй оролцуулахаар компанийн дүрэмд заасан байх ёстой.

в) Компанийн дүрэмд ийнхүү зааж болох эрх зүйн үндэслэл нь: Энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчид өөрсдийн төлөөллийг төлөөлөн удирдах зөвлөлд оруулж болохоор компанийн дүрэмд заасан.

г) Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй, саналын эрхтэй оролцох зэрэг тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тус тус компанийн дүрэмд тусган хэрэгжүүлж болно.

Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудал, энэ талаар тогтоох дүрмийн зохицуулалт энгийн хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал байдаг. Энэ асуудлыг тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэгдэнэ. "Дийлэнхи олонхи" гэдгийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн 66-аас доошгүй хувиар шийдвэрлэнэ гэж ойлгож хэрэглэнэ.

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ